



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(12 дахь жилдээ)

2013/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(12 дахь жилдээ)

2013/02

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2013/02(42)
Улсын бүртгэлийн дугаар 244
12 дахь жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор /ХЭҮК-ын гишүүн/
Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах референт/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн
зохиогчийн үзэл бодол болно.

АГУУЛГА

НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

<i>Ж.Бямбадорж (PhD), профессор</i> Монгол Улс дахь эрүү шүүлтгийн нөхцөл байдал	5
<i>Б.Оюун-Эрдэнэ (PhD), дэд профессор</i> Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийлэл.....	12
<i>Д.Бямбажав (PhD)</i> Хүний эрх ба компанийн нийгмийн хариуцлага	23
<i>Г.Агар-Эрдэнэ (Докторант)</i> “Өмчлөх эрхийн сэтгэлгээний түүхэн асуудал.....	30
<i>Л.Банзрагч (Докторант)</i> “Хууль зүйн туслалцаа авах эрхийн зарим асуудал	49
<i>Б.Алтантуяа, С.Ганчимэг</i> Хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоо бүрдүүлэх нь	53
<i>Б.Эгшиглэн</i> Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендэр хүмүүсийн талаар хэвлэлээр тусгаж буй байдал.....	70

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

<i>Орчуулсан Ө.Ундрах</i> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Үндэсний урьдчилан сэргийлэх механизмын хоорондын холбооны өөрчлөгдөх шинж: Тэнцвэрийг олох нь	78
--	----

ЗОЧНЫ ЯРИА

Хүний Аюулгүй байдлын судалгааны төвийн тэргүүн, Элчин сайд Л.Эрдэнэчулуунтай хийсэн ярилцлага	107
---	-----

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРҮҮ ШҮҮЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга,
Хууль зүйн ухааны доктор, профессор,
Монгол Улсын гавьяат хуульч

Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс 2001 онд байгуулагдсан үеэсээ эхлэн хуулийн байгууллагуудын хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг чадваржуулах, байгууллага хоорондын уялдаа холбоог нягтруулах болон эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор эрүү шүүлтээс ангид байх эрхийн асуудлаар санал, зөвлөмж өгч, хамтарсан санамж бичиг байгуулж, тус эрхийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт хийсээр ирсэн.

Комиссоос жил бүр Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг Улсын Их Хуралд өргөн барьж хэлэлцүүлдэг билээ. Тэрхүү илтгэлийн хүрээнд эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх төрийн үүргийн хэрэгжилтийг тодорхой судалгаа, баримт, нотолгоотойгоор дүгнэн, санал зөвлөмж өгсөөр ирсэн. 2003, 2004, 2006, 2010, 2012 онд УИХ-д өргөн барьсан илтгэлүүдэд эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулах, төрийн зүгээс олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ авах талаар зөвлөмж гаргаж байв.

Эрүү шүүлтээс ангид байх эрхийн хэрэгжилтийг сайжруулах, зөрчил дутагдлыг арилгахад хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй үндэсний хууль тогтоомжийн заалтыг олон улсын хэм хэмжээ, стандарт, шаардлагад нийцүүлэх, олон улсын гэрээний заалтуудыг үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил хэрэгжүүлэх, тэдгээрийг зөрчихгүй байх, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлж, таслан зогсоох, гэм буруутай этгээдэд хариуцлага тооцох нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг үнэлэх үндсэн үзүүлэлт болдог.

“Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг” Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас эрх зүйн шинэчлэлийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэхтэй холбоотой харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох, эрх чөлөө хязгаарлах байрны нөхцөлийг сайжруулах, хууль сахиулагчийн эрх хэмжээг тодорхой болгох

чиглэлээр олон дэвшилттэй арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа хэдий ч практикт эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээлэл тасрахгүй байна.

Комисс эрүү шүүлттэй холбоотой гомдол, мэдээллийг судлан үзвэл дийлэнх нь цөөхөн хэдэн хүний тухайлбал, зарим мөрдөн байцаагч нарын ур чадвар, хандлага, хоцрогдсон арга барилаасаа салж чаддаггүй байдлаас шалтгаалж байна. Дээр нь орчин үеийн шаардлага хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хэрэг илрүүлэх, мөрдөн байцаах байгууллагуудыг хангаж чадаагүй нь бас нөлөөлж байна. Комиссоос санаачлан эрүү шүүлттэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нилээд үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагийн нэг бол эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангах, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг Хүний эрхийн Үндэсний Комисс, Авилгатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн байцаах хэлтэс, УЕП-ын дэргэдэх Мөрдөн байцаах алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар гэсэн 6 байгууллага хамтран зохион байгуулахаар 2011 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 2 дахь удаагаа Санамж бичигт гарын үсэг зурсан билээ.

Өнөөдөр бидний уулзалтын үндсэн зорилго бол Санамж бичгийн хүрээнд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага тус бүрдээ ямар ажил зохион байгуулсан, ямар арга хэмжээ авсан талаараа харилцан мэдээлэл солилцож, цаашид ямар ажлыг хамтарч зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах явдал юм.

Хэнийг ч, хэзээ ч, ямар ч нөхцөлд эрүүдэн шүүх, хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхгүй хэмээн Хүний эрхийн түгээмэл тунхаглал¹-

¹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 2-ны өдөр

ын 5 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт²-ын 7 дугаар зүйлд заасныг харгалзан, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 1975 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батласан Хүнийг эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг нь доромжлон харьцаж шийтгэхээс хамгаалах тухай тунхаглалын дагуу 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц³” /цаашид эрүүдэн шүүхийн эсрэг конвенц гэх/-ийг батлан гаргасан байна.

Энэхүү Конвенцод Монгол Улс 2000 онд нэгдэн орсон бөгөөд ингэснээр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, эрүү шүүлтийг таслан зогсоох, эрүү шүүлт тулгасан хэнд боловч эрүүгийн хариуцлага тооцож байх үүргийг хүлээх болсон билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь заалтад “...Хэнд боловч эрүү шүүлт тулгаж ... болохгүй.” хэмээн эрүү шүүлтээс ангид байх эрхийг баталгаажуулан тунхагласан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглосон заалтыг хуульчилсан бөгөөд сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг өгөхийг шаардах, түүнтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, нэр төрийг нь гутаан доромжлохыг хориглосон билээ.

Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн агуулгаас харвал “эрүүдэн шүүх” гэж хэн нэг хүн буюу гуравдахь этгээдээс мэдээ, сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гуравдахь

хүчин төгөлдөр болсон. Монгол улс 1968 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр соёрхон баталсан.

² Монгол Улс 2000.11.02-нд нэгдэж орсон.

³ Монгол Улс 2000.11.02-нд нэгдэж орсон.

этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гуравдахь этгээдийн бие махбод, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг ойлгоно.

Эрүү шүүлт нь төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж байгаа этгээдүүдийн үйл ажиллагаа болон түүний өдөөн хатгалт буюу ил далд зөвшөөрлөөр үйлдэгддэг. Эрүү шүүлт тулгах гэмт үйлдлийг мэдүүлэг авах төдийгүй хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, мэдээ сэлт авах зорилгоор хийдэг.

Эрүү шүүлт тулгах магадлал бүхий субъект нь төрийн эрх бүхий албан тушаалтан байна. Өөрөөр хэлбэл эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа, эрх чөлөө хязгаарлах ажиллагааны явцад албадлага хэрэглэх, эрхшээлдээ байлгах эрх бүхий төрийн тусгай албан тушаалтан байдаг. Жишээ нь, гэмт хэрэгтнийг илрүүлэх, эрэн сурвалжлах, нууц далд аргаар мэдээлэл цуглуулах чиг үүрэг бүхий гүйцэтгэх ажилтан, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, шалгах, үнэлэх чиг үүрэг бүхий мөрдөн байцаагч, прокурор, саатуулах, баривчлах, цагдан хорих байрны ажилтан зэрэг байж болно. Түүнчлэн эдгээрийн ил, далд зөвшөөрөл, ятгалгаар хэн нэгэн энгийн иргэн эрүү шүүлт тулгасан байхыг үгүйсгэхгүй.

Эрүү шүүлт тулгах гэдэг нь мэдээ сэлт, мэдүүлэг авах зорилгоор уг эх сурвалжийг мэдэх буюу гаргуулан авах этгээдийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох үйлдлийг нэг удаа болон янз бүрийн давтамжтайгаар удаан хугацаанд санаатай хийгдэж байгаа үйлдлийг илэрхийлдэг. Ер нь эрүү шүүлт тулгах нь тодорхой зорилго, сэдэлтэйгээр тодорхой хугацаанд, бусдыг

ялгаварлан гадуурхах үндэслэл бүхий, төлөвлөсөн үйлдэл, эс үйлдэхүйн бодит илрэл болж өгдөг. Эрүү шүүлт тулгах гэдэгт гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий албан тушаалтан буюу албан үүрэг гүйцэтгэж байгаа бусад этгээд гэмт хэрэгт холбогдон шалгагдаж болон шүүгдэж байгаа хүнээс эсхүл, гэрч, хохирогч, шинжээч бусад хүнээс хэргийн талаар мэдээлэл авах, хэргийг хүлээлгэх, өөрийнх нь хүсээгүй мэдээлэл, мэдүүлгийг гаргуулах, ял шийтгэхийн тулд сэтгэхүйн болон биеийн хүч хэрэглэх, айлгаж сүрдүүлэх, албадах, санаатайгаар хүчтэй өвтгөх буюу бие махбод, сэтгэл санааг тарчлаан зовоосон аливаа үйлдлийг ойлгоно.

Эрүү шүүлтээс ангид байх эрх нь хүний жам ёсны эрх бөгөөд ямар ч үед үл хязгаарлагдах, онцгой эрх юм. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Дайны байдал, дайны аюул занал, дотоодын улс төрийн тогтворгүй байдал, нийтийг хамарсан онц байдал тогтоох зэрэг нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй” гэж, тус зүйлийн 3 дахь хэсэгт “Дээд шатны албан тушаалтны буюу төрийн эрх бүхий байгууллагаас авсан тушаал нь эрүүдэн шүүхийг зөвтгөх үндэслэл болохгүй” гэж тус тус хуульчилсан нь ямар ч үед хязгаарлагдахгүй байх баталгааг бий болгожээ.

Монгол Улс дахь эрүү шүүлтийн нөхцөл байдал

Монгол Улс Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нэгдэн ороод даруй 13 жил өнгөрчээ. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл Монгол Улс тус конвенцоор хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлсэнгүй. Тухайлбал, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг конвенцийн агуулгатай нийцүүлээгүйн улмаас эрүү шүүлт тулгах гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завшиж, эрүү шүүлттэй бодитойгоор тэмцэх боломж хязгаарлагдмал

хэвээр байгаа юм.

Эрүү шүүлт нь тухайн хүний бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох шинжтэй идэвхтэй үйлдэл байхаас гадна ийм нөхцөл байдлыг үүсгэсэн бусад хүчин зүйлс хамаардаг. Хорих байрны нөхцөл нь хоригдогчийн бие махбод, сэтгэл санааг шаналган зовоох гол хүчин зүйл болдог. Тиймээс Комиссын зүгээс өнгөрсөн хугацаанд хорих байрны нөхцөлийн талаар байнга шаардаж, шахаж ирсэн. Комиссын санал, зөвлөмжийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хүчин чармайлтаар 461 дүгээр анги, Дорноговь, Булган зэрэг аймгуудын цагдан хорих байруудыг олон улсын стандартад нийцүүлэн шинээр бариад байна. Ийнхүү алхам алхамаар нөхцөлийн эрүү шүүлтийн асуудал хумигдаж байгаа нь сайшаалтай хэдий ч эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас болж эрүү шүүлтийн нөхцөл байдал сайжрахгүй байна.

Эрүү шүүлт гэхээр зөвхөн гэмт хэргийн тухай боддог, гэтэл эрүү шүүлт тулгах гэмт хэргээс гадна хүнлэг бус хэрцгий харилцааг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцоор хориглосон байдаг.

Эрүүдэн шүүх болон хүнлэг бус, хэрцгий хандаж байгаа хэлбэрүүдийг товчхон ангилан авч үзье.

Гэмт хэрэг болохын тухайд.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 251 дүгээр зүйлд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн субъект нь зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч байхаар хуульчилсан байдаг. Гэтэл амьдрал дээр гэмт хэрэгтнийг илрүүлэх, эрэн сурвалжлах, нууц далд аргаар мэдээлэл цуглуулах чиг үүрэг бүхий гүйцэтгэх ажилтан /тагнуулын ажилтан, эрүүгийн төлөөлөгч, хэсгийн төлөөлөгч, хорихын төлөөлөгч/, шүүх хуралдаанд улсын яллагчийн чиг

үүргийг хэрэгжүүлэгч прокурор, баривчлах, цагдан хорих байр, хорих ангийн ажилтнууд эрүү шүүлт тулгах тохиолдол гарч байна.

Өнөөдөр дээрх субъектүүд бие махбодын эрүү шүүлт тулгаж бусдад гэмтэл учруулсан бол эрүү шүүлтээс өөр хөнгөн зүйлээр яллуулж, харин гэмтлийн зэрэг тогтоогдоогүй буюу бусдын сэтгэл санааг шаналган зовоосон эрүү шүүлтийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй хэмээн татгалзан хаадаг жишиг тогтсон байна.

Хүний эрхийн Үндэсний Комисст ирсэн нийт гомдлын 70 орчим хувь нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаатай холбоотой гомдол байх ба тэдгээрийн 13 хувь нь эрүү шүүлтэд өртөж зодуулсан, гэмтсэн талаарх гомдол байна. Түүнчлэн баривчлах, цагдан хорих үйл ажиллагаатай холбоотой болон хуулийн байгууллагын ажилтны ёс зүй, зан харилцаатай холбоотой гомдол 18 хувийг эзэлж байгаа юм.

Эрүү шүүлтийг бие махбодын болон сэтгэл санааны эрүү шүүлт хэмээн хоёр хэсэгт хуваан авч үздэг. Гэтэл өнөөдөр эрүү шүүлт тулгах гэмт хэргийг мөрдөн шалгах байгууллага зөвхөн бие махбодын эрүү шүүлттэй хөөцөлдөж, сэтгэл санааны эрүү шүүлтийг төдийлөн анхаарахгүй байгаа юм. Энэ нь эрүү шүүлт тулгах гэмт хэргийг харьяалан шалгах чиг үүрэг бүхий мөрдөн байцаах байгууллагын шалгасан хэргүүд болон татгалзсан материалуудаас харагддаг. Өөрөөр хэлбэл эрүү шүүлтийн улмаас гэмтэл учирсан эсэхэд онцгой ач холбогдол өгч сэтгэл санааны шаналал зовлонг тодорхойлох, нотлох талаар тодорхой ахиц гарахгүй байна. Үүнийг Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх мөрдөн байцаах албаны удирдлагууд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчилсан байдалтай холбож тайлбарладаг.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг урьтал болгосоор байна.

Мөрдөн байцаах чиг үүрэг хэрэгжүүлж буй байгууллагууд мөрдөн байцаах ажиллагаа явуулахдаа гэмт хэрэгт холбогдсон хүнийг цагдан хорихыг урьтал болгож байгаа хандлага түгээмэл байна. ЭБШХуулиас үзэхэд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг дотор нь сэжигтнээр цагдан хорих, яллагдагчаар цагдан хорих гэж хоёр ангилдаг. Хуулиас үзэхэд “онцгой” тохиолдолд гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдэд ял сонсгохын өмнө таслан сэргийлэх арга хэмжээ авч болохоор заалтыг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын практик ажиллагаанаас харахад албан тушаалтнууд *нэгдүгээрт*: хуулийн энэхүү “онцгой тохиолдол” гэсэн тодотголыг анхаарч үздэггүй, *хоёрдугаарт*: таслан сэргийлэх бусад төрлийн арга хэмжээг авч болох боломжтой байхад зөвхөн цагдан хорихыг урьтал болгодог. Улсын дээд шүүхийн судалгааны тайлангаас харвал 2012 оны байдлаар 4851 хүнийг цагдан хорих саналыг шүүх хүлээн авсанаас 4338 хүн буюу 89.5 хувийг цагдан хорих зөвшөөрөл олгож шийдвэрлэжээ. ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төвөөс гаргасан судалгаагаар 2012 онд 19732 хүн эрүүгийн хэрэгт холбогдсон бөгөөд хөнгөн хэрэгт холбогдсон 9637 хүнийг хасвал 10095 хүнээс 4338 хүн буюу 43 хувийг нь цагдан хорьж шалгажээ. Тиймээс ч Комисст ирж байгаа нийт гомдлын 35.6 хувийг цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож байгаа хүмүүсийн гомдол эзэлж байна.

Мөрдөн байцаах байгууллага хүнийг гэмт хэрэг үйлдсэн эсэх талаар хангалттай шалгаадаагүй, дөнгөж эрүүгийн хэрэг үүсгээд, уг хэрэг нь шүүхэд очих эсэх нь тодорхойгүй, ер нь хэрэг гарсан эсэх, хэрэв гарсан бол уг хэрэгт энэ хүн холбоотой

эсэх ямар зүйл ангиар буруутгагдах эсэх нь хангалттай тогтоогдоогүй байхад сэжигтнээр тооцож, улмаар цагдан хорих гэж махран хөөцөлдөж, хорьж байгаа явдал нь сэтгэл санаа, улмаар бие махбодын шаналал, дарамтын дор хэрэг хүлээлгэж мэдүүлэг авах сонирхол, оролдлоготой зайлшгүй холбоотой. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар гэмт хэрэгт сэжиглэж бусдыг баривчилж хорьж болох үндэслэлийг тодорхой заасан хирнээ буцаагаад суллах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх болзол журам, заалтыг орхигдуулснаас практик ажилтнуудын дунд хоригдогсдыг шүүхэд шилжихээс өмнө нь гаргасан ч эс гаргасан ч дурын хэрэг мэтээр хандах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нь саналаа прокурорт өгөхгүй байх, үндэслэлгүйгээр ёс юм шиг удаан хугацаагаар хорих нь ихээхэн түгээмэл байна.

Удаан хугацаагаар хэдэн жил, сараар ч хорих явдал байсаар байна. Шүүхэд шилжүүлээд хэдэн ч удаа буцаж, тэр хэмжээгээр урьдчилан хорих явдал хэвийн үзэгдэл болоод байна.

Мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хэн нь энэ таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлүүлэх тухай гомдол санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа нь олон хоног сараар хоригдож байгаа ар гэрийнхэнд нь маш төвөгтэй байдлыг үүсгэж байгаа нь нууц биш юм. Угтаа бол цагдан хорих тухай шүүхээс тогтоосон хугацаа дуусаагүй байхад уг шийдвэрийг прокурор хүчингүй болгох, өөрчлөх санал тавих эрхтэй. Гэмт хэргийн ангилал, сэжигтэн, яллагдагчийн хувийн байдлаас шалтгаалан цагдан хорих шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох үндэслэлтэй байвал зөвхөн тухайн хэрэгт хяналт тавьж байгаа прокурор энэ тухай саналаа шүүхэд танилцуулж шийдвэрлүүлнэ. Прокурор энэхүү саналыг

гаргахдаа мөрдөн байцаагчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзана. Энэ талаар прокурор санал гаргаагүй тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх, хүчингүй болгох талаар шүүхэд ирүүлсэн хүсэлтийг прокурорт шилжүүлнэ хэмээн УДШ-ийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан тушаалд⁴ заажээ. Энэ хамтарсан тушаалд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад прокурорын эрх хэмжээг тэр дундаа таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд хэрхэн тухайн хүний халдашгүй байх, эрүү шүүлтээс ангид байх эрхийг хангаж ажиллах талаар тодорхойлжээ.

Цагдан хорих байр ээлжүүлэн хорьдог хууль бус аргыг нэн даруй халах хэрэгтэй. Цагдан хорих байрыг шилжүүлэн хорих, ар гэрээс нь алслаж хорих нь хүнлэг бус харилцаанд суурилсан эрүү шүүлтийн нэг хэлбэр мөн. Эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй хэн ч бай гэр бүлийнхэнтэйгээ уулзах, эргэлт авах, өмгөөлөгчтэйгээ тухай бүр нь ганцаарчлан уулзах, хууль зүйн туслалцааг цаг алдалгүй авах зэрэг олон улсын болон үндэсний хууль тогтоомжоор баталгаажуулсан эрхтэй бөгөөд үүнийгээ байцаан шийтгэх ажиллагааны явцад баталгаатай эдлэх ёстой. Гэтэл сүүлийн үед хэрэгт холбогдсон хүний оршин суугаа газар болон мөрдөн шалгаж байгаа газраас өөр газарт алслаж хорих, хэд хэдэн цагдан хорих байр дамжуулан хорих хандлага ажиглагдаж, энэ төрлийн гомдол Комисст их ирэх боллоо.

Баривчлагдсан болон цагдан хоригдсон хүний эргэлт, уулзалтыг хязгаарлах замаар эрүүдэн шүүж, хүнлэг бус хэрцгий харьцаж

⁴ Баривчлах, цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам. УДШ-ийн Ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарсан 2008 оны 1 дүгээр сарын 30-ний өдрийн 07.26 тоот захирамж, тушаалын хавсралт

байна. Сэжигтнээр баривчлагдсан болон сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдсон хүнийг түүний эхнэр/нөхөр, хүүхэд, эцэг, эх, төрөл садантай нь уулзуулахгүйгээр өөрийг нь болон ар гэрийнхнийг нь шаналган зовоодог байдал түгээмэл байна.

2013 оны 9 сард Комисс Төв аймагт Хүний эрхийн өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд тус өдөрлөгийн үеэр цагдан хорих байранд хяналт шалгалт зохион байгуулсан. Шалгалтаар тус цагдан хорих байранд оршин суугаа газраасаа хол газар хоригдсон, шилжин ирсэн, шилжин явсан талаарх судалгааг гаргахад дараах дүр зураг харагдаж байна.

2012 онд Улаанбаатар хотоос 3 сэжигтнийг шинээр цагдан хорьсон, харин 7 сэжигтнийг цагдан хорих 461-р ангиас шилжүүлэн хорьсон байна. Энэ 10 сэжигтний 3 сэжигтнийг Авилгатай тэмцэх газраас, 6 сэжигтнийг Улсын мөрдөн байцаах газраас, 1 сэжигтнийг Тагнуулын ерөнхий газраас тус тус цагдан хорьсон байв. Тус цагдан хорих байрнаас 15 сэжигтнийг бусад аймгийн цагдан хорих байр руу шилжүүлэн хорьсон байна. Тэдгээрээс 12 сэжигтнийг цагдан хорих 0461 дүгээр анги руу, 2 сэжигтнийг Багануур дүүргийн цагдан хорих байр руу, 1 сэжигтнийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдан хорих байр руу тус тус шилжүүлжээ. 2013 онд Улаанбаатар хотоос 13 сэжигтнийг шинээр цагдан хорьсон, харин 3 сэжигтнийг цагдан хорих 461-р ангиас шилжүүлэн хорьсон байна. Энэ 16 сэжигтний 6 сэжигтнийг Авилгатай тэмцэх газраас, 3 сэжигтнийг Улсын мөрдөн байцаах газраас, 3 сэжигтнийг Налайх дүүргийн ЦХ-ээс, 3 сэжигтнийг СБД-ийн ЦХ-ээс, 1 сэжигтнийг СХД-ийн ЦХ-ээс тус тус цагдан хорьсон байв. Тус цагдан хорих байрнаас 8 сэжигтнийг бусад цагдан хорих байр руу шилжүүлэн хорьсон байна. Тэдгээрээс 6

сэжигтнийг цагдан хорих 0461 дүгээр анги руу, 1 сэжигтнийг Дархан-Уул аймгийн цагдан хорих байр руу, 1 сэжигтнийг Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдан хорих байр руу тус тус шилжүүлжээ. Энэ бол нэг л баримт...

Баривчлагдсан болон цагдан хоригдсон хүний эргэлт, уулзалтыг хязгаарлах замаар эрүүдэн шүүж, хүнлэг бус хэрцгий хандаж байна. Сэжигтнээр баривчлагдсан болон сэжигтэн, яллагдагчаар цагдан хоригдсон хүнийг түүний эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрөл садантай нь уулзуулахгүйгээр өөрийг нь болон ар гэрийнхнийг нь шаналган зовоодог байдал цөөнгүй байна.

2013 онд Комисст ирсэн гомдлыг шалгахад нийт 36 гомдол нь эрүү шүүлтийн шинжтэй байсан ба 23 гомдол нь бие махбод болон сэтгэл санааны эрүү шүүлтийн шинжтэй, 4 гомдол нь эргэлт уулзалт өгөхгүй байгаа тухай, 5 гомдол нь цагдан хорих байр шилжүүлэн хорьсон тухай, 4 гомдол нь хуульд заасан хугацаа хэтрүүлэн хорьсон тухай байна.

Гавлах, зодох, биед нь хөнгөн, хүндэвтэр гэмтэл учруулах замаар хэрэг хүлээлгэх оролдлого гарсаар л байна. Айлган сүрдүүлэх, хөтөлж байцаах, өөрөөр нь хэргийг нь хүлээлгэхийг оролдох, мэдүүлгийг нь хуурамчаар бичиж, хүчээр гарын үсэг зуруулах, бичиг үсэг мэдэхгүй байдлыг далимдуулах, өмгөөлөгчгүй байцаах зэрэг зөрчил ч гарсаар байна.

Энд би хэн нэгэн хүнийг, мөрдөн байцаах ажиллагаа явуулж байгаа төрийн ажилтныг буруутгах, эсхүл гомдол гаргасан хүмүүсийн бичсэн, хэлсэн болгон үнэн гэх зорилгыг тавьсангүй. Юм хоёр талтай. Гагцхүү эрүүдэн шүүхийн эсрэг конвенцын заалтыг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын төр, хууль сахиулах байгууллага, тэдгээрийн албан хаагчдаас гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагааг хуулийн дагуу явуулах, чин шударгаар ажиллаж, сайн үр дүнд хүрсэн амжилтыг чинь харлуулдаг, цөөхөн ч гэсэн гарсаар байгаа зөрчлөө арилгаач, арилгах боломж байна гэдгийг л сануулах гэсэн юм.

Мөрдөн байцаалтыг зөвхөн тодорхой шалгуурыг хангасан дүрс болон дуу бичлэгийн төхөөрөмжөөр тоногдсон өрөөнд явуулдаг болмоор байна. Мөрдөн байцаах ажиллагааг зөвхөн тоногдсон өрөөнд явуулж байх зөвлөмжийг Комисс 3 жилийн өмнө гаргаж, тухайн үедээ төсөвт боломжийн мөнгө сууж байсан боловч холбогдох газрууд хэрэгжүүлсэнгүй. Энэ ажлыг хийснээр хяналт сайжирч, эрүү шүүлттэй холбоотой хэл амнаас ангижирч чадна. Бидэнд ийм туршлага бий болсныг Монгол Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албаны үйл ажиллагаанаас харж болно. Энд шаардагдах төсөв хөрөнгө, эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэж өгөх талаар УИХ, Хууль зүйн байнгын хороо, Хүний эрхийн дэд хороо анхаарна гэдэгт итгэж байна.

ГЭР БҮЛ ДЭХ ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ



Улаанбаатар Их сургуулийн Гэр бүл судлалын тэнхимийн эрхлэгч, Философийн ухааны доктор, дэд профессор

Б.ОЮУН-ЭРДЭНЭ

Хүүхдийн эсрэг дарамт, хүчирхийлэл гэдэг нь ихэвчлэн эцэг, эх асран халамжлагчдын хүүхдээ асран хамгаалах ердийн хэм хэмжээний баталгаа алдагдсаны улмаас хүүхэд хор нөлөөг нь амсахыг өөрөөр хэлбэл хүүхдийн зүй ёсны хүсэл сонирхлыг хүчээр буюу бусад арга замаар хясан боогдуулах, хоорондын таарамжгүй харилцааны улмаас хүүхдийг сэтгэл санааны гүн дарамтанд оруулахыг хэлнэ. Үүнд эцэг, эх эсвэл асран халамжлагчдын зүгээс үйлдсэн болон хийх ёстой үүргээ биелүүлээгүй үйлдлүүдийг хамааруулдаг байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд⁵

- Бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл
- Бие махбодын хүчирхийлэл
- Сэтгэл санааны хүчирхийлэл
- Бэлгийн хүчирхийлэл

⁵ Нэгдсэн Үндэстний Байгууллагын ерөнхий нарийн бичгийн даргын Хүүхдийн эсрэг Хүчирхийллийн талаарх судалгаа, Улаанбаатар: 2006 он, хуу. 25-27.

1. Бага насны хүүхдийн эсрэг хүчирхийлэл

Бага насны хүүхдийн эсрэг гарсан хүчирхийлэл хүүхдэд хор хохирол учруулъя гэж бодоогүй ч хүүхдийн эрүүл мэндэд урт хугацааны дараа ч мэдрэгдэх, хохирол учруулах аюултай бүр цаашилбал үхэлд ч хүргэж болох талтай юм. Олон улс оронд хийсэн судалгаагаар “хүүхдийг сэгсрэх синдром” балчир хүүхдэд ноцтой аюул учруулах магадлалтай бөгөөд хүүхдэд тархи, толгойны гэмтэл учруулах эрсдэлтэйг тогтоожээ.

2. Бие махбодын хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг бие махбодын хүчирхийлэл нь хүмүүжүүлэх, сахилга бат сахиулах, томоотой байлгахын тулд хэрэглэдэг харгис, гутамшигтай бие махбодын шийтгэлээр илэрдэг. Энэ нь хүүхдийг санаатайгаар цохих, зодох, өшиглөх, сэгсчих, хатгах, түлэх, унагах, шидэх зэргээр бие махбодид нь ямар нэг хор уршиг учруулж байгаа явдал юм. Бие

махбодын хувьд хүчирхийлэх нь хүүхдийн нас биений онцлогт тохироогүй, хэт нарийн чанд, сахилга батын үр дагавар байж болно. Бие махбодын хүчирхийлэл нь нэг удаагийн эсвэл байнгын шинжтэй байхаас гадна үүссэн гэмтэл бэртэл нь хүнд хөнгөнөөрөө ялгагдана.

Хүүхдийн зан төлөвт илрэх сөрөг үзэгдлүүд:

- Хүүхэд өөрийн бэртсэн гэмтсэн тухайгаа ярих дургүй, айдаг, санадаггүй, томчуудтай нүүрэлдэхээс зайлсхийж хашир болгоомжтой болсон байдаг.
- Хүн хүрэхэд далдирч цочихоос гадна аймхай хулчгар, хэнэггүй, үл тоомсорлосон, хойрго, зусарч, хэт үгэнд оромтгой, уян зөөлөн, эсвэл хэт түрэмгий, нийтэч бус зантай байдаг.
- Гэмтэл сорвио нуухын тулд тохиромжгүй хувцасладаг.
- Гэр орноосоо зугтаасан, гэртээ эргэж харихаасаа эмээдэг, хүчирхийлэл доромжлолд өртсөн тухайгаа дүрслэн ярьдаг.
- Эцэг эх, асран хүмүүжүүлэгчийн хэрэгцээг анхаарч, том хүний үүрэг хүлээж авдаг.

3. Сэтгэл санааны хүчирхийлэл

Гэр бүлд хүүхдийг шийтгэхийн тулд бие махбодын хүчирхийллээс гадна сэтгэл санааны хүчирхийллийг ашиглах нь илүү давамгайлдаг ба бие махбодын хүчирхийлэл ихэнхдээ сэтгэл санааны хүчирхийллийг дагуулж байдаг. Сэтгэл санааны хүчирхийлэлд хүүхдийн сэтгэцийн болон оюуны үйл ажиллагаанд хор уршиг учруулах доромжлол, нэр хоч өгөх, шоовдорлох, хараан зүхэх, басамжлах, ад үзэх, хол хөндий байх, заналхийлэх, зэрэг үйлдлүүд ордог.⁶ Сэтгэл

санааны хувьд дарамт үзүүлэн, доромжлосны үр дагавар нь хүүхдийг насанд хүртэл нь нөлөөлж байдаг ба хүүхэд дарамтанд орсноор нийтэч бус зожиг, аймхай, хулчгар эсвэл түрэмгий зантай болдог. Хүүхдийг хэл амаар доромжлох, гүтгэх нь хүүхдийн сэтгэл зүйн хөгжил, сайн сайхан байдалд хор уршиг тарьж, нөхөж баршгүй зовлонд учруулна.

Хүүхдийн зан төлөвийн үзүүлэлтүүд:

- Бие махбодын өсөлт хөгжил нь хоцронгүй /үг яриа, булчин шөрмөс, мэдрэхүй/
- Хүнд дарамтанд байснаар их түгшүүртэй аймхай, эсвэл зожиг, бүр түрэмгий зантай болдог.
- Зан авирын гажуудлаас болж өөрийгөө хөнөөх оролдлого ч хийж магадгүй, хар тамхи, архи хэрэглэж гэр орноосоо дайжин зугтаадаг.
- Хэт боловсон хүмүүжилтэй, цэвэр цэмцгэр, гоё сайхан болох дүр үзүүлдэг, мөн хэт биеэ барьдаг.
- Байнгын анхаарлын төвд байхыг хичээдэг.
- Зан төлөвийн доголдол нь тоглох, ярихад нь гэртээ илэрдэг.

Эцэг эх, асран хамгаалагчдын шинж төрх нь:

- Үргэлж хүүхдийнхээ алдаа дутагдалтай талыг олны өмнө ил зарлан хочилж гутаадаг.
- Эгч, ах, дүү нараас нь өөр адласан маягаар үздэг.
- Хүүхдийн тусламж хүсэж, мэдьгэсэн зүйлд нь туслахаас татгалздаг.
- Хүүхдийг байнга айлган сүрдүүлж, сэтгэл санааны хувьд дарамтлах төдийгүй бие бялдрын хүч хэрэглэж хайртай хүнийг нь, жишээлбэл ээжийг

⁶ Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Хүүхдийн эсрэг

хүчирхийлэл" – ийн судалгааны тайлан. УБ: 2006 он. Хуу. 21.

нь зоддог.

- Хүүхдийг удаан хугацаагаар гэрт, байшинд, өрөөнд цоожилж орхиоос гадна гэр бүлээс гадуур томчууд үе тэнгийнхэн, найз нөхөдтэй нь холбоо харилцаа тогтоохыг зөвшөөрдөггүй.
- Хүүхэддээ гэмт хэргийн танхай балмад зан авирыг сурган зааж өгч, нийгмийн сөрөг үзэл явдлыг хэвийн гэж тайлбарлаж, танилцуулдаг.
- Хүүхдэд гэрт нь үйлчлэгчийн эсвэл эцэг, эх орлогчийн үүрэг хүлээлгэдэг.
- Хүүхдийн харилцах оролдлогыг үл хайхран, бие бялдрын болон үг хэлээр дайрч доромжилдог.

4. Хүүхдийг үл хайхрах

Үл хайхрах гэдэг нь эцэг, эх, асран хамгаалагчийн зүгээс бусадтай харьцуулахад ялгаварлаж байгаа үйлдэл юм. Өөрөөр хэлбэл энэ нь гэр бүл нь хүүхдээ аюулгүй байдалд эрүүл саруул өсөхөд шаардлагатай бүхнээр хангахад нь санаа тавьдаггүй, аюулаас хамгаалдаггүй гэсэн үг юм. Энэ байдал нь хүүхдэд бие бялдрын болон сэтгэл санааны хор хохирол учруулж байдаг. Үл хайхрагдсан хүүхдүүд гэр орон, хоол унд, байнгын хараа хяналт, эмнэлгийн тусламж, боловсрол зэрэг наад захын амьдралын хэрэгцээт зүйлсээр дутагдаж байдаг.

Хүүхдийн бие махбодын байдал:

- Улирал, цаг уурт тохирсон хувцас өмсөөгүй байдаг ба зуны халуунд, өвлийн хүйтэнд, цас, бороотойд ч нэг хувцастай байснаар хатгалгаа, ханиад томуу тусаж, наранд цохиулдаг.
- Эрүүл ахуйн дэглэм сахидаггүйгээс арьсны ямар нэг өвчтэй болж, хиртэй усанд ороогүй бохир явдаг.
- Байнгын удаан хугацаагаар болон эсвэл тодорхой хугацаанд хараа

хяналтгүй сэлгүүцдэг.

- Тэдний асран хамгаалагчид нь хэт залуу эсвэл хөгшин хүмүүс байдаг.
- Хоол тэжээлийн дутагдалтай учир жин бага, намхан, цонхигор шаравтар царайтай, биеийн тэнцвэрт байдал алдагдсан байдаг.
- Байнгын орон байргүй учир эрүүл ахуйн хувьд тохиромжгүй, халаалтгүй, аюултай, осолтой орчинд аж төрдөг.
- Нүүр царай нь цонхийж цайх, эцэж ядрах, нүд хонхойх, өгзөг хонго нь үрчийж арьсны өөхөн давхарга бараг үгүй болох, арьс нь нимгэн цаас мэт хэврэг, удаан хугацаагаар бөөлжих, суулгах.
- Хүүхдийн өсөлт хөгжилтийн байдал нь хэвийн үзүүлэлтүүдээс дорой байна.

Хүүхдийн зан төлөвийн байдал:

- Бие бялдрын өсөлт хөгжилт нь /үг яриа, булчин шөрмөс, мэдрэхүй/ хоцронгуй.
- Эцэг, эхдээ огт дасаагүй мөртлөө өөр насанд хүрэгчдэд сайн
- Сургуульд хамрагдах нь бага, муу сурдаг.
- Байнга гэрээсээ зугтаадаг.
- Өөртөө анхаарал, хайр шаардсан.
- Гэмт хэрэг, зөрчилд өртсөн, архи мансууруулах бодис хэрэглэдэг.

Эцэг, эх асран хамгаалагчдын шинж төрх нь:

- Өөрийн тулгамдсан асуудал, хэрэгцээ шаардлагадаа дарагдсан, түүнийгээ хүүхдийнхээ шаардлагын өмнө тавьдаг
- Хүүхэддээ суурь хэрэгцээ болох гэр орон, хоол хүнс, эмнэлгийн ба сэтгэл санааны дэмжлэг үзүүлдэггүй
- Хүүхэддээ өдөр тутмын хараа хяналт

тавихгүй, хаа байгаа, юу хийж байгааг мэддэггүй, хүүхдийг үл ойшоож, хараа хяналт тавьдаггүй.

- Хүүхдээ сургуульд бүртгүүлж явуулахгүй, сургууль завсардахыг үл тоож, хүүхдийн тусгай сургалтын хэрэгцээг хангадаггүй.
- Хүүхдийн амьдралыг бага сонирхдог, сургуулиас зохиосон арга хэмжээ, үйл явдалд оролцдоггүй.
- Хүүхдээ гаргахыг хүсээгүй байсан, одоо ч түүндээ хайргүй гэдгээ үргэлж хэлж, үзүүлдэг.

5. Бэлгийн хүчирхийлэл

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь насанд хүрсэн хүн бэлгийн хүсэл тачаалаа хангахын тулд хүүхдийг хүч хэрэглэн, айлган сүрдүүлж, биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулж бэлгийн харьцаанд татан оруулахыг хэлнэ. Хүүхдүүд, тэдэнтэй хамт гэрт нь амьдардаг эрэгтэйчүүд, хөвгүүдийн зүгээс бэлгийн харьцаанд орох албадлага, оролдлого эсвэл биед нь хүрэх зэргээр хүүхдэд эвгүй, дургуй үйлдэл хийх шахалтанд ордог. Энэ хэрэг нь гэр бүлийн дотор болон гэр бүлийн гаднах хүрээнд ижил буюу эсрэг хүйс хооронд тохиолдоно. Хүүхдийг урамшуулах, албадан шахах, хүч хэрэглэх замаар бэлгийн гаж буруу үзэгдэл садар самуунд татан оролцуулна.

Хүүхдийн зан төлөвд илрэх шинжүүд:

- Өөртэйгээ болон бусадтай тоглохдоо тоглоомоороо насандаа тохироогүй бэлгийн үйлдэл хийж тоглох, бэлгийн харьцааг дүрслэн үзүүлэх;
- Насандаа тохироогүй эротик зураг зурж, дүрслэн ярих;
- Гэртээ ганцаараа буюу гэр бүлийн зарим гишүүдтэй эсвэл тодорхой хүйсийн хүнтэй хамт үлдэхдээ айх;

- Бэлгийн харьцааны тухай ердийн бус мэдлэгтэй байх;
- Тодорхой шалтгаангүйгээр гэртээ харихаас, найз нөхөд, хамаатан садныдаа очихоос татгалзах;
- Бие нь өвчин, зовиуртай байгаа талаар үе үе гомдол мэдүүлэх;
- Сэтгэлийн дарамт, хямралд орох;
- Мансууруулах бодис, архи, тамхи хэрэглэж түрэмгий хэрцгий авирлах, амиа хорлох хандлага гаргах зэргээр өөртөө хортой зан авир гаргах;
- Бэлгийн харьцааны тухай өдрийн тэмдэглэлдээ бичиж, бусдад мэдэгдэх
- Хэт замбараагүй байх, садар самуунд өртөх, биеэ үнэлэх;
- Бэлгийн амьдрал, жирэмслэлт, бэлгийн халдварт өвчний талаар гэнэт хэт сонирхдог болох;
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэдгээ шууд эсвэл тойруу замаар ярьдаг

Ер нь хүүхэд өөрийнхөө талаар муу бодолтой болох нь хүчирхийллийн хамгийн нийтлэг үр дагавар юм. Таны хүүхэд, “би мангар”, “Хэн ч надад хайргүй” гэх мэтийн үгсийг хэлж болох юм. Эсвэл хэт зожиг, хэг ёг, сэтгэлийн зовиуртай байх зэрэг нь өөрийгөө доогуур үнэлж байгаагийн шинж.

Өөрийгөө гэмтээх үйлдэл. “Хэрчих” (хүрц иртэй татуургын хутга мэтийн зүйлээр арьсаа хэрчих) ба өөрийгөө гэмтээх нь хүүхэд чинь бусдын хэрцгийн үйл ажиллагаанаас болоод аюулд байна гэдгийн дохио юм.

Нийтлэг бус зан хандлага. Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд бие махбодын хэрцгийлэл, дүрсгүйтэл, харилцааны асуудлуудтай байдаг гэж дүгнэсэн. Хүүхэд бусад хүүхдүүдийг зодох, ангийн хүүхдүүдтэйгээ тогтмол маргалдах, амьтан яргалах, хэрцгий хандах

зэрэг үйлдлүүдийг гаргана.

Хожуу хөгжил. Хүүхдийн бие махбод, нийгэм, эрдэм ном, сэтгэл зүйн хөгжилд удаашрал ажиглагдана. Найз нөхөдтэй болохдоо хойргошиж, ухрах, орондоо шээх, хуруугаа хөхөх зэрэг үйлдлүүдийг хийж эхэлнэ.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд ихэвчлэн:

- Амьдралдаа дараа нь хүчирхийллийн хохирогч болох;
- Өөрсдөө хүчирхийлэгч болох;
- Сэтгэлээр унасан ба ирээдүйн амьдралаа сүйрүүлэгч болох;
- Сэтгэлийн зовиолтой болох нь түгээмэл байдаг.

Манай улсын хэмжээнд хүүхэд эрүүл мэнд, боловсрол, халамж, бүртгэл, эрх зүй зэрэг нийгмийн суурь үйлчилгээний гадна үлдэхийн зэрэгцээ, хараа хяналтгүй байх, тэдний үзэл бодлыг үл хүндэтгэх, хайхрамжгүй хандах, алагчилах, бие махбод, сэтгэл санааны хувьд хүчирхийлэх, биеийг нь үнэлүүлэх, алтны уурхай, зах дээр ажиллуулах /ачаа үүрэх, машин угаах, гуйлга гуйх, нүүрс ухах/ зэрэг олон төрлийн хүнд хөдөлмөр хийлгэх, худалдаалах, хуурч ашиглах, шийтгэх, дарамтлах зэрэг үйлдлүүд ихээхэн гарч байгаа. Энэ талаарх зарим судалгааны дүнг авч үзвэл

1. 5 хүртэлх насны хүүхдийн 6,3% тураалтай, 21% өсөлтийн хоцролттой, 2,2% туранхай байна. */Хүүхдийн хөгжил/ 2005. Түүвэр судалгаа. УСХ, НУБХС 2007*
2. Боловсролын үйлчилгээнд хамрагдвал зохих хүүхдийн 19,5% сургуулийн өмнөх боловсролын, 20,3% нь бага сургуульд элсэх, 4,7% нь бага сургуулийн, 14,6% нь дунд сургуулийн сургах үйлчилгээний гадна байна.

/Хүүхдийн хөгжил/ 2005. Түүвэр судалгаа. УСХ, НУБХС 2007


3. Хамрагдвал зохих хүүхдийн 7,9% нь өнчин, 3,8% нь эцэг, эхтэйгээ хамт амьдардаггүй, 16,6% нь хөгжлийн бэрхшээлтэй, 18,1% нь 5-14 насандаа, 22,5% нь 5-17 насандаа хөдөлмөр эрхэлж байна. */Хүүхдийн хөгжил/ 2005. Түүвэр судалгаа. УСХ, НУБХС 2007*
4. Хамрагдвал зохих хүүхдийн 79,4% нь сэтгэл санааны болон бие махбодын ямар нэг шийтгэл авсан, 7,7% нь 18 нас хүрэхээс өмнө гэрлэсэн, 3,3% нь гэр бүлтэй, хамтран амьдрагчтай 15-19 насны охид, бүсгүйчүүд байна.

/Хүүхдийн хөгжил/ 2005. Түүвэр судалгаа. УСХ, НУБХС 2007

5. 200 хүүхэд орон гэрээсээ дайжсан, 100 хүүхэд хараа хяналтгүй тэнүүлчлэн амьдарч байна. */Цагдаагийн ерөнхий газрын 2009 оны мэдээлэл/*
6. Насанд хүрээгүй хүний үйлдсэн 664 гэмт хэрэгт 943 хүүхэд холбогдсон байна. */Цагдаагийн ерөнхий газрын 2009 оны мэдээлэл/*
7. Нийт хүүхдийн 13% нь насанд хүрсэн хүний асрамж хамгаалалтгүй үлдсэн. */Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт-илтгэл/ МУЗГ 2007*
8. 2501 хүүхэд өөр айлд үрчилэгдсэн, 1219 хүүхэд асрамжийн газарт амьдарч байна. */Асрамж, халамж хамгааллын байгууллагын стандартын хэрэгжилтэнд хийсэн шинжилгээний мэдээ. НХХЯ, ХХҮГ, ХТГ 2009/*
9. Гэмт хэргийн улмаас 117 хүүхэд үүнээс 59 хүүхэд амиа хорлож, авто ослоор 36 хүүхэд, бусад гэмтэл өвчнөөр 1800 хүүхэд нас барсан байна. */Үндэсний статистикийн эмхтгэл. 2008/*

Энэ оны “Гэр бүлийн үнэ цэнэ” үндэсний хэлэлцүүлгийн үеэр миний бие 1000 хүнээс асуумжийн судалгаа авсан бөгөөд үүний анхаарал татсан зарим дүнг авч үзье.

Зураг 1. Гэр бүлээс хүүхэддээ хэн нь илүү анхаарал тавьдаг вэ?



Гэр бүлийн гишүүдээс хүүхэд тавих анхааралд ээж хамгийн их буюу 57,0 хувь байгаа нь судалгаанд эмэгтэйчүүд илүү оролцсонтой (60%, 40%) холбоотой байх магадлалтай хэдий ч энэ нь эмэгтэйчүүдийн гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, оролцоо илүү байгааг харуулж байгаа юм.

2010 оны судалгаагаар хүүхэддээ илүү анхаарал тавих нь мөн л ээж нь гэж 45,3% тай гарч байв. Харин энэхүү үзүүлэлт өссөн байна. Аавуудын оролцох хувь 2010 онд 24,8% байсан бол энэ удаагийн судалгаанд 7,0% байгаа нь маш их анхаарал татаж байна. Хүүхэд төрүүлэх, өсгөх ажил эмэгтэйчүүдийн нуруун дээр ачаалал болж ирэх тусам эсрэгээрээ төрөлт багасах аюултай юм. Аавуудын хүүхэддээ тавих анхаарал ах, эгчийн халамжтай бараг ойролцоо 1,0% л илүү байгаа нь туйлын харамсалтай хэрэг мөн.

Мөн 5,0% нь эмээ, өвөө гэж хариулсан нь залуу гэр бүлүүд хүүхдээ өсгөх, хүмүүжүүлэх ажлаа эцэг, эхдээ үүрүүлэх болсон нөгөө талаас ясли, цэцэрлэгийн тоо хүрэлцэхгүй байгаагаас үүдэлтэй юм.

Хүүхэддээ анхаарал хандуулж буй байдлыг хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт хот, хөдөөгөөр ангилж үзвэл

дараах онцлог ажиглагдаж байна. Ажилтай ээжүүдийн хувьд хүүхэддээ тавих анхаарал ажилгүй ээжүүдийнхээс бага хувьтай байгаа бол хөдөөгийн ээжүүд хүүхэддээ илүү их анхаардаг нь ажиглагдлаа. Мөн хүүхэддээ анхаарал тавьдаг аавуудын ихэнх хувь нь хөдөөгийн аавууд байна. Энэ нь хотжилт хийгээд ажлын ачаалал нь эцэг, эхчүүдийн хүүхдэд тавих анхаарлыг сулруулж байгааг харуулж байна. Өвөө, эмээ гэсэн хариултыг ихэвчлэн залуу эцэг, эхчүүд өгсөн байна.

Зураг 2. Хүүхэдтэй холбоотой дараах саналуудын алийг нь дэмжих вэ?

№	Асуулт	Хариултын хувь
1	Хүүхэд маань юмаар дутагдах гачигдах ёсгүй	8
2	Хүүхдийнхээ боловсрол мэргэжилд анхаарна	27,7
3	Хүүхдээ амьдралаа авч явах арга ухаанд сургана	17,3
4	Эрүүл саруул сайн хүн болгох нь чухал	37,5
5	Яаж амьдрахыг нь заяа тавилан нь мэдэг	8
6	Өнөө үед хүүхэд төрүүлж өсгөх нь хэцүү	1,5


Судалгаанд оролцогчдын 27,7% нь хүүхдийнхээ боловсрол, мэргэжилд анхаарна, 37,5% нь эрүүл саруул сайн хүн болгоно, 17,3% нь амьдралаа авч явах арга ухаанд сургана гэж хариулсан нь сайшаалтай байна. Эцэг, эхчүүд хүүхдээ эрдэм боловсролтой, эрүүл саруул амьдралаа авч явах ухаантай хүн болгох нь чухал гэж үзэж хичээж байгаа нь сайн байна.

Яаж амьдрах нь хувь тавилан нь мэдэг гэж хариулсан 8 хувийг судалж үзэхэд боловсролгүй, өрхийн орлого бага хэсгийнхэн байгаа бол өнөө үед хүүхэд төрүүлж өсгөх

нь хэцүү асуудал гэж хариулсан 1,5% нь боловсролтой хэсгийнхэн байна.

Улс орны хөгжил, нийгмийн тогтвортой байдал нь хүний хөгжлөөс шууд шалтгаална. Гэр бүлийн нийгмийн өмнө хүлээсэн нэг чухал үүрэг бол хүмүүжүүлэх үүрэг юм. Тухайн өрхөд хүүхэд төрсөн л бол эрдэм боловсролтой, иргэн бие хүн болгож нийгэмд нийлүүлэх үүрэгтэй билээ. Энэхүү үүргийг эцэг, эхчүүдийн дийлэнх нь мэдэж байгаа нь сайн хэрэг боловч бодит амьдрал дээр хэрхэн үр дүнд хүргэдэг нь анхаарах асуудал мөн.

Зураг 3. Хүүхдийнхээ дэргэд дараах үйлдлүүдийг гаргадаг уу.



Судалгаанд оролцогчдын 1,1% нь байнга, 43,7% зарим үед хүүхдийн дэргэд архидан согтуурдаг гэсэн нь маш өндөр хариулт бөгөөд судалгаанд оролцогчдын бараг 50% нь архи хэрэглэдэг гэсэн үзүүлэлт юм. Энэ нь эцэг, эхчүүдийн дунд архидалт маш их байгаа, хүүхдэд буруу үлгэр дуурайл үзүүлж байгааг илтгэж байна.

Архины хэрэглээг нас болон өрхийн орлогоор нарийвчилж үзвэл 25-45 хүртэл насныхан 78%-ийг эзэлж байгаа нь залуучуудад архины хэрэглээ их байгааг илтгэж буй үзүүлэлт юм. Өрхийн орлогоор хамааруулж үзвэл орлого санхүүдээ сэтгэл огт хангалуун биш хийгээд, тааруухан хэсгийнхэн архи хэрэглэдэг нь анхаарал

татлаа. Орлого санхүү бага хэдий ч архи хэрэглэх нь гэр бүлийн амьдралд маш их сөрөг нөлөөтэй.

Хүүхдийнхээ дэргэд 2,7% нь байнга, 65,7% нь зарим үед муудалцдаг гэж хариулсан нь 68,4%-д нь гэр бүлийн зөрчил, маргаан байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл 68,4% д хүүхдэд үзүүлэх гэр бүлийн харилцааны сөрөг нөлөөлөл байна.

Хүүхдийнхээ дэргэд 1,6% нь байнга, 17,9% нь зарим үед зодолддог гэж хариулсан нь гэр бүлийн зөрчил маргаан хүчирхийллийн хурц хэлбэрт шилжсэн болохыг харуулж байна.

Гэр бүлийн зөрчил маргааныг өрхийн орлоготой хамааруулан судалж үзэхэд орлого санхүү хангалттай болон, дундаж, хангалтгүй хэсгийнхэнд гэр бүлийн зөрчил маргааны эзлэх хувь төдийлөн ялгаатай биш байна. Харин насны байдлыг авч үзвэл маргаан зөрчил 18-40 хүртэлх насныханы дунд хамгийн их байна. Архины хэрэглээтэй бүх гэр бүлүүдэд зөрчил маргаан байгаа нь ажиглагдсан нь архидалт гэр бүлийн хэрүүл, маргаан зөрчил, хүчирхийллийн үндэс суурь болж байгааг харуулж буй юм. 69,1% нь хүүхдийн дэргэд тамхи татдаггүй гэж хариулсан нь сайшаалтай байна.

Судалгаанд оролцогчдын 6% нь хүүхдээ байнга зоддог, 37,8% зарим үед зоддог гэж хариулсан нь огт байж болохгүй асуудал бөгөөд хүүхдийг шууд хүчирхийлж буй хэлбэр юм. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогчдын 43,8% нь хүүхдээ бие махбод хийгээд сэтгэл санааны хувьд хүчирхийлдэг байна. Энэ бол ихээхэн анхаарал татах асуудал юм. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн ихэнх хувь нь гэр бүлийн орчинд үйлдэгддэг байна. 31,9% ямар ч үед хүүхэддээ цаг гаргадаг нь сайшаалтай бол 6,6% нь цаг гаргаж чаддаггүйгээс гадна, 47,6% шаардлагатай үед л цаг гаргадаг гэж

хариулсан нь хангалтгүй байна.

Эцэг, эхчүүд хүүхдийн нас сэтгэл зүйн онцлогыг мэдэхгүй байх, хүүхдийн хөгжил, танин мэдэхүйг хөгжүүлэхэд хэрхэн туслах, оролцох талаарх мэдлэг хомс байгааг харуулж буй юм.

Хүүхдийн сурлага, хүмүүжил, төлөвшил, нийгэмшил, соёл, ёс суртахуун, зан ааш, дадал зуршлын 80% нь төрөлх гэр бүлийн орчиндоо бүрэлдэж бий болдог. Гэр бүлийн амьдралын уур амьсгал, гэр бүлийн гишүүдийн харилцаа хандлага, бие биенээ хайрлах, хүндэтгэх байдал хүүхдэд шууд нөлөөтэй. Зөрчил маргаан, хүчирхийлэлтэй тайван бус гэр бүлд өсөж буй хүүхэд сурлага, хүмүүжлийн доголдолтой, зан чанарын хувьд ууртай, хэдэр, эсвэл аймхай, өөртөө итгэх итгэл сул, хэн нэгнийг үзэн ядаж өширхсөн, амиа хичээсэн хүн болж өсдөг.

Хүүхэд өсвөр үеийн хүмүүжил боловсролд анхаарахдаа эцэг, эхчүүдийн үүрэг хариуцлага, ёс суртахууныг дээшлүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг хамт анхаарах шаардлагатай болсныг энэхүү судалгаа харуулж байна.

Эцэг, эхчүүдийн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлэхэд шинэ шатны бодлого хэрэгтэй бөгөөд энэ асуудлыг чухалчлан шийдсэн гадны орны туршлагыг судлах нь чухал юм. Тухайлбал, БНСУ гэхэд хотын боловсролын газраас нь сургуулиудад эцэг, эхийн боловсролд зориулсан тусгайлсан төсөв хуваариладаг. Энэхүү ажлын хүрээнд эцэг, эхчүүдэд хүүхдийн нас сэтгэл зүйн онцлог, сурлага, хүмүүжлийг дэмжих арга зүй, гэр бүлийн орчны хүүхдэд үзүүлэх нөлөөлөл зэрэг бүрэн хэмжээний хичээлийг зааж сурах бичгийг өгдөг байна.

Манай улсын хувьд эцэг, эхчүүд хүүхдийн сурлага, хүмүүжлийг сургууль, багш нартай холбон ойлгож тэднийг буруутгах нь түгээмэл байдаг. Харин дээрх

судалгааны дүнгээс авч үзвэл гэр бүлүүдийн 68,4%-д нь гэр бүлийн харилцааны таагүй орчин байгаа бол, 43,8% нь хүүхдээ хүчирхийлдэг болох нь харагдаж байгаа нь хүүхдэд үзүүлэх гэр бүлийн орчны сөрөг нөлөөлөл их байгааг харуулж байна. Эцэг, эхийн гэр бүлийн боловсрол мэдлэг муу байгаа үзүүлэлт юм.

Бидний хийсэн 2010 оны Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал судалгааны чанарын судалгааны явцад хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдтэй ярилцаж байхад тэд өөрийнхөө болон хүүхдийнхээ аюулгүй байдалд санаа зовж байсан. Мөн хүүхдээ хүчирхийлэлд удаан хугацаанд байлгаж зан аашийг нь эвдэж, бие махбодын болон сэтгэл санааны дарамт, хүчирхийлэлд байлгаж байсандаа өөрийгөө буруушаан, зэмлэж байсан юм.

Чанарын судалгаа: Гэр бүлийн хүчирхийлэл

...Эцэг нь хүүгээ дэндүү харгислаж зоддог байсан. Нэг удаа хичээлээ тасалсныг нь мэдчихээд зодож, идэр есийн хүйтэнд гадаа гарнаас нь дүүлжээд орхичихсон. Тэгээд гарыг нь хөлдөөж л байсан хүн дээ. Манай хүү одоо дуу муутай, их зуунги, айхавтар муу санаатай болчихсон. Хүүгийнхээ занг тийм болтол нь яах гэж тэгж тэсэж тэвчиж байв аа гэж би одоо харамсдаг. Уг нь би тэнэмэл хүүхдүүдтэй их ажилладаг байсан болохоор хүүхдээ эцэггүй өсгөхгүй юмсан гэж бодож тэвчээр гаргадаг байсан. ..

нас 45, түүх нийгмийн ухааны багш, дээд боловсролтой, салсан гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэй Д-тэй хийсэн ганцаарчилсан ярилцлага. УБ., 2009

...Хүүхдүүдэд шууд нөлөөлдөг. Хүүхдүүд маань гэртээ тогтохгүй гадуур холуур байх сонирхолтой болсон нь ажиглагддаг. Бас их уцаартай болжгоосон. Охидууд маань ааваасаа л холдож байвал яаж ч байсан хамаагүй гээд хүнтэй сууцгаасан. Одоо нэг өсвөр насны бандигай л даа. Ааваасаа айгаад надад л хааяа юмаа ярьдаг. Хэрвээ архи уугаад ирвэл би юу хэлэх вэ гэж их айдаг. Намайг сал гэж зөндөө хэлж байсан. Би амьдралдаа дахиад алдаж хүүхдүүдээ өнчрүүлэхийг хүсдэггүй.

Эмэгтэй, 41 настай, БД боловсролтой, 2 дахь гэрлэлт Кейс судалгаа, УБ., 2009

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд хүүхэд, эмэгтэйчүүд ихэвчлэн байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл нь хүүхдэд айдаг түгшүүр, сэтгэл зүйн дарамт шаналал учруулахаас гадна зан ааш, хүмүүжилд сөргөөр нөлөөлж, эцэг, эхээс хөндийрөх, гэр орноос зугтах, үүний тулд амьдралдаа эрсдэлтэй янз бүрийн алхам хийхэд хүрч байна.

Хувь хүний эрсдэлийн хүчин зүйл болох хүүхэд насандаа хүчирхийллийн гэрч болсон, бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, эцэггүй өссөн байх нь хүчирхийлэлд өртөх илүү магадлалтай байдагчлан бидний хийсэн чанарын судалгаанд хүчирхийлэлд өртсөн гурван эмэгтэй нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан, 2 нь хойд эцэгтэй өссөн эмэгтэйчүүд байсан юм. Нөхрүүд нь мөн хүүхэд насандаа хүчирхийллийн гэрч болж байсан, гэр бүлийн тайван бус, зөрчилдөөнтэй харилцаанд өсөж торнисон байв.

Чанарын судалгаа: Гэр бүлийн хүчирхийлэл

...Ер нь нөхөр яхир, түргэн зантай. Архи уудаг. Хүүхдүүд хүртэл аав их хэцүү зантай. Аав нинжин сэтгэлтэй биш гэж хэлдэг. Би хараал хэлж үзээгүй байхад нөхөр намайг “п...” гээд элдвээр харааж загнадаг. Манай нөхөр л хамгийн гайгүй нь гэр дотроо, бусад нь бүгд боловсрол багатай хүмүүс. Эгч нар, ах дүү нар нь архи их уудаг. Олон жил хамт амьдраад ч ааш зан нь засраагүй. Хүмүүжил гэр бүлийн өссөн орчин бид хоёр тэс өөр хүмүүс л дээ. Ээж нь барга хүн, Өвөрмонголоос дээр үед нүүж орж ирсэн айл. Урд байхдаа аав нь Ү эхнэртэй байсан. Ээжийг нь бас их зодож зовоодог байсан гэж ээж нь ярьдаг...

*Салсан эмэгтэй, нас 50, багш,
дээд боловсролтой*

*Ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэл.
МГБХӨБ2009- судалгаа. Дорнод*

Бэлгийн зүй бус харилцаа гэдэгт бага насны хүүхдийг хүчиндсэн болон инцест буюу ураг төрлийн харилцаатай хүмүүсийн хоорондох бэлгийн харилцааг оруулж байна. Бэлгийн зүй бус харилцааны хохирогч бологсод судалгаанд оролцогчдын дунд байсан юм.

Чанарын судалгаа: Бэлгийн хүчирхийлэл

... Миний доод талын дүү 14-тэй байхдаа над шиг бас хүнд хүчиндүүлээд өөрийгөө буудчихсан байхгүй юу. Тэгэхээр иймэрхүү юмыг хүүхдэд маш эртнээс нь ойлгуулах хэрэгтэй юм байна. Дараа нь хараад байхад миний дүү л хохироод салж байгаа байхгүй юу. 14-тэй ч төрчихсөн хэв нэг явж байгаа хүүхэд ч байж л байна. Манай тэр дүү их ухаантай, 1-7-р анги хүртлээ онц сурсан хүүхэд байсан. Хүнд хүчиндүүлээд өөрийгөө буудчихсан. Тиймээс хүүхэдтэй эрт л энэ тухай ярилцаж байх хэрэгтэй юм байна гэж би боддог...

*Ганцаарчилсан ярилцлага, Дорнод, 2009
салсан, хүчирхийлэлд өртсөн эмэгтэй,
нас 33, боловсрол бага*

... Би хойд эцэгтэй байсан. Хойд эцэг их сайн хүн байлаа. Надад нэг ч муу үг хэлж үзээгүй. Харин хойд эцгийн аав нь намайг дунд сургуульд байхад оролдож, хүчирхийлсэн. Энэ тухай би хэнд ч хэлээгүй. Маш их хэцүү байдалд орсон, хэнд юу гэхээ, юу хийхээ ч мэдэхгүй байсан. Ээждээ ч хэлээгүй. Одоо хүртэл надад том балиар бэлэг эрхтэнээ ам руу маань хийж байсан нь санаанаас гардаггүй... Нөхөртэйгөө би маш хурдан суусан. Анхны ойртолтоор л хүүхэдтэй болж, жирэмсэн байх хугацаанд мэдээж бэлгийн харилцаанд орохгүй болчихож байгаа юм. Төрөөд удалгүй би хүнд өвдөөд дараагаар нь зүгээр болсон хойноо ч нөхөртэйгөө бэлгийн харилцаанд орохоос аль болох зайлсхийдэг байсан. Энэ нь ч бидний хоорондын харилцаа хөндийрөх, нөхөр өөр эмэгтэйчүүдтэй явалдахад хүргэсэн байх.

*Салсан, хүчирхийлэлд өртсөн эмэгтэй,
нас 45, боловсрол дээд*

Ганцаарчилсан ярилцлага, УБ, 2009

Бэлгийн зүй бус харилцаа нь хохирогчдыг бие махбодын хувьд төдийгүй сэтгэл зүйн хүнд дарамт, сэтгэл зүйн цочролд оруулж, үүний улмаас амиа хорлох болон өөр бусад янз бүрийн эрсдэлтэй алхмыг хийхэд хүргэж байна. Тухайлбал, биеэ үнэлэгч охидын дунд хийсэн судалгаагаар биеэ үнэлдэг гурван охин тутмын нэг нь гэр бүлийн гишүүд болон хамаатан садныхаа хүмүүсийн зүгээс бэлгийн хүчирхийлэлд өртсөнөөс хойш биеэ үнэлэх замд орсон нь тогтоогдсон.⁷

Мөн бидний явуулсан чанарын судалгааны нэгэн оролцогч 33 настай эмэгтэйн дүүг нь 14-тэй байхад нь хүчиндсэний улмаас охин амиа хорлосон. Тэрээр өөрөө 15-тайдаа хүчиндүүлсний улмаас эргтэй хүнд хэзээ ч хайртай болж байгаагүй, 2 удаа гэрлэхдээ хайр сэтгэлээр биш өрөвдөөд, түшиг болох хүн гэж бодож, мөн хүнд хүчиндүүлсэн учир хэн тоохов гэж бодсоноос ийм сонголтүүд хийсэн гэж ярьсан юм. Дээр нь хохирогч “бага боловсролтой байсандаа хамгийн их баглагдсан” гэж өөрөө дүгнэсэн юм. Энэ мэтчилэн хүчирхийллийн ул мөр насан туршид нь дагалдаж, хувь заяанд нь нөлөөлсөн байна. Түүнчлэн сэтгэл зүйн хувьд айдас түгшүүртэй, үзэн ядалт, хүнийг хайрлаж чаддаггүй, өөртөө итгэлгүй болгожээ. Ийм сэтгэл зүйн хямрал нь бэлгийн харилцаанаас ханамж авч чадахгүй байхад нь нөлөөлж, улмаар энэ нь гэр бүл салахад нь ч нөлөөлснийг үгүйсгэх аргагүй юм.

Бэлгийн зүй бус харилцаанд хохирогчид хохирсны дараа хэнд ч хандаж тусламж хүсээгүй, энэ талаар бусад хүн мэдэхээс айж, нуусан байгаа нь тэдний амьдралд насан туршид нь хар толбо болон үлдэхээс, бусдад чичлүүлэх, нэр хоч сэтэр зүүхээс айсантай нөгөө талаар үйлчилгээ тусламж үзүүлэх газар ховор, тухайлан мэргэшсэн мэргэжлийн хүмүүс байхгүй, ийм газруудын

талаарх мэдээлэл байхгүйгээс хаана, хэнд хандахаа мэддэггүйтэй нь бас холбоотой. Иймд бэлгийн зүй бус харилцаанаас сэрэмжлүүлэх сургалт, сурталчилгаа явуулах, ийм хүчирхийлэлд өртсөн тохиолдолд хаана хэнд хандах талаар мэдээллийг өргөн болгох, мэдээлэл авах боломж бололцоог иргэдэд сурталчлах, мэргэжлийн төвшинд ажиллах гэр бүлийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх төвүүдийг бий болгох, тэнд ажиллах нарийн мэргэшсэн мэргэжилтнийг бэлтгэх, дадлагажуулах хэрэгцээ шаардлага байсаар, шийдлээ хүлээсээр байна.

Дүгнэлт

Судалгаанаас үзвэл Монгол Улсад хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх асуудал байгааг илтгэхийн зэрэгцээ гэр бүлийн орчинд хүүхдэд үзүүлэх анхаарал халамжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Хүүхдэд тулгуурч буй эдгээр асуудлууд нь аавуудын үүрэг оролцоо муу байгаагаас шалтгаалж буйг үгүйсгэх аргагүй юм.

Аливаа улс орны хамгийн үнэт зүйл бол улс орны ирээдүй болсон хүүхэд өсвөр үе байдаг. Иймээс цөөн хүн амтай манай улсын хувьд хүүхэд өсвөр үеийнхний хөгжил, хамгаалал, эрүүл мэндэд онцгой бодлого баримтлах ёстой. Хүүхэд өөрийгөө бүрэн хамгаалж чадахгүй учраас насанд хүрэгчдийн харилцаа хандлага их чухал байр суурьтай байдаг. Хүүхдийн эсрэг гарч буй сөрөг үзэгдлүүд нь бүгд л насанд хүрэгчдээс шалтгаалан бий болдог. Иймд гэр бүл, эцэг, эх, албан тушаалтан олон нийтийн хүүхдийн талаарх харилцаа хандлагад ч нөлөөлөх цаг болсон байна.

Дэлхийн ихэнх улс орнуудад хүүхдийн мэргэжилтэнг нарийвчилан бэлтгэж сургууль, хүүхдийн байгууллагад дагнасан хүүхдийн төлөөлөл болгон тэдний төлөө ажиллуулж

⁷ ХЭҮТ-ийн судалгаа. 2005, 277 дах тал.

байна. Өнөө үед бэлтгэж буй нийгмийн ажилтан нь хүүхдийн эрх ашгийг хамгаалдаг хүүхэд асуудлаа ярьдаг тусламжаа хүсдэг ажилтан гэхээсээ илүү бодлогын чиглэлээр ажилласаар өнөөг хүрлээ. Хүүхдийн төлөө гэж овоглосон төрийн болон төрийн бус байгуулагууд хүүхэдтэй тулж ажилладаг асрамж, халамжийн төвүүдэд мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа нь нууц биш юм.

Иймд хүүхдийн хөгжил, нас бие сэтгэхүйн онцлог, өөрчлөлт бүх процессыг мэддэг тэдний эрх ашиг, хүсэл сонирхол, хөгжил төлөвшилд хувь нэмэр оруулахуйц бодит ажлыг хийж чаддаг орчин үеийн хүүхдийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн мэргэжилтэнг хүүхдийн чиглэлээр мэргэшүүлэх шаардлага бий болж байна.

Мөн хүүхэд ёс зүй, зан суртахууны буруу хэвшилд сурах, архидалт, мансуурах бодис, гэмт хэрэгт өртөх ихэссэн нь нөгөө талаасаа хүүхэд хамгаалал, хүүхдийг хүмүүжүүлэх, тэдэнтэй зөв харилцах, хайрлах хүндлэх, эрхийг нь хүндэтгэх зэрэг асуудлаар насанд хүрэгчидтэй ажиллах хэрэгцээ шаардлага бий болж байгааг харуулж байна.

Хүүхдэд гэм хор учруулсан эцэг, эх, хууль ёсны хамгаалагч болон албан тушаалтан, насанд хүрэгчдийн зан үйлийг өөрчлөх асуудал ч өнөөдөр чухал байна.

Ном зүй

9. Батчулуун Б. Хүчирхийлэл. Шинэ толь. УБ., 1995
10. Сарантуяа Г. Сэтгэц оношлогоо. УБ., 2001
11. Мягмар О. Хувийн дасан зохицохуй. УБ., 2000
12. Сосормаа Ч. Хүчирхийлэл дарамтанд өртсөн эмэгтэйчүүдийг хүч чадалтай болгох нь УБ., 1999
13. Жендерийн тэгш байдал ба хөгжил. /Зохистой хөгжил ба жендер төв/ УБ., 2002
14. Жендер судлалын удиртгал. /хүний эрх хөгжил төв, Жендер судлалын ажлын баг/ УБ., 2003
15. Баасанбат. С Жендер гэр бүлийн харилцаанд нөлөөлөх нь., УБ 2005
16. Монголын Гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. Суурь судалгаа. 2010

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХ БА КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



Күинслэндийн Их Сургуулийн судлаач,
Социологийн ухааны доктор

Д.БЯМБАЖАВ

Удиртгал

Монгол Улсын эдийн засаг сүүлийн 10 жилд эрчимтэй өсч, ялангуяа уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг дагасан эдийн засгийн өсөлттэй уялдан дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуйн нэгжүүдийн нийгэм-эдийн засгийн хөгжил дэх оролцоо, хувь нэмэр улам бүр нэмэгдэж байна. Олон улсын үндэстэн дамнасан корпорациуд болон тэдний салбар нэгжүүдийн тоо, үйл ажиллагаа ихсэхийн зэрэгцээ үндэсний томоохон аж ахуйн нэгж, корпорациуд бэхжиж байна. Уул уурхай, дэд бүтэц, барилга, мэдээлэл холбоо зэрэг эдийн засгийн голлох салбаруудын хөгжил нь ажлын байр, татвар, бүтээн байгуулалт гэх мэт хөгжлийн суурь нөхцөлд чухал хувь нэмэр оруулж буй ч зарим компаниудын үйл ажиллагаа байгаль орчны болон нийгмийн олон сөрөг үр дагаврыг бий болгож байна. Энэ нь аж үйлдвэр, эрүүл мэнд, худалдаа гэх мэт эдийн засгийн бусад салбарт ч хамааралтайг дурдах хэрэгтэй.

1990-ээд оноос хойш хэлбэршин тогтож буй олон улсын неолиберал эдийн засгийн

тогтолцоонд төрийн гүйцэтгэх үүрэг суларч, хувийн хэвшлийн цар хүрээ нэмэгдсэн. Монгол Улсад төр дангаар бүтээн байгуулалт, эдийн засаг, нийгмийн хөгжлийг хариуцдаг байсан үе ард хоцорч хувийн хэвшил хамтран бүтээлцэх боллоо. Монгол Улс дахь бизнесийн орчин, даяаршил, мэдээллийн нийгэм, сүлжээст дэлхий ертөнцийн аясаар өөрчлөгдөн, төр, иргэд, иргэний нийгмийн аж ахуйн нэгжүүдээс хүлээх хүлээлт мөн өөрчлөгдөж байна. Аж ахуйн нэгжүүдийг дан ганц ашгийн төлөөх байгууллага гэж үзэхээс илүүтэй тухайн нийгэм, орон нутгийн хариуцлагатай гишүүн, хөгжилд хувь нэмэр оруулагч байх ёстой гэдэг хандлага ихсэж байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд бизнесийн буюу компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн олон улсын бизнесийн хэм хэмжээ, сайн дурын санаачлагууд нэвтэрч, аж ахуйн нэгжүүд нийгмийн хариуцлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх боллоо. Цаашид компанийн нийгмийн хариуцлагын тухай ойлголт болон бодит хэрэгжилтийн асуудлыг сайтар тунгаан

хэлэлцэж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн зөвшилцлөөр дамжуулан нэгдмэл хандлагыг төлөвшүүлэх шаардлагатай юм.

Монгол Улсад компанийн нийгмийн хариуцлагыг авч үзэхдээ хүний эрхийн асуудлыг орхигдуулах тал ажиглагддаг. Ялангуяа компаниудын баримталж буй нийгмийн хариуцлагын тухай бодлого, үйл ажиллагаанд хүний эрхийн асуудал хөндөгдөх нь маш ховор. Гэтэл аливаа бизнесийн үйл ажиллагаа хүний эрхэд шууд ба дам байдлаар нөлөөлдгийг бид мэднэ. Зарим аж ахуйн нэгжүүд маш ноцтой хүний эрхийн зөрчил гаргаж буйг хэвлэл мэдээллээс мэдэж болно. Энэ нь нэг талаар компанийн нийгмийн хариуцлагын зөв ойлголт, хандлага төлөвшөөгүйн зэрэгцээ бизнесийн байгууллагын хүний эрхийг хангах талаарх үүрэг, хариуцлагын тогтолцоо тодорхой бус байгаатай холбоотой юм.

Цаашид Монгол Улсад компанийн нийгмийн хариуцлагын тухай нэгдмэл ойлголт, хандлага төлөвшихөд хүний эрхийн асуудлыг зайлшгүй авч үзэх хэрэгтэй. Энэ чиглэлд хүний эрхийн байгууллагууд ба эрдэмтэн судлаачид анхааран ажиллах буй заа. Хүний эрхийн хэрэгжилт нь зөвхөн хувь хүний, төрийн болон иргэний нийгмийн үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй. Төр ба нийгмийн харилцаанд бизнесийн байгууллагуудын эзлэх байр суурь өсөн нэмэгдэж тэр ч хэмжээгээр бизнесийн байгууллагууд хүний эрхийн хэрэгжилтэд чухал үүрэг хүлээж байна.

Уг асуудлыг хүний эрхийн хэрэгжилтийн асуудал компанийн нийгмийн хариуцлагатай хэрхэн уялдах тухай онолын болон бодлогын түвшний судалгаа шинжилгээ, маргаан мэтгэлцээний тоймд үндэслэн энэ өгүүлэлд товч авч үзнэ.

Бизнес ба хүний эрхийн хамгаалал

Олон улсын улс төр ба эрх зүйн хүрээнд хүний эрх ба бизнесийн харилцааны асуудал 1990-ээд оныг хүртэл маш хязгаарлагдмал хүрээнд буюу олон улсын хөдөлмөрийн эрх зүйн хүрээнд тусгагдсан хэм хэмжээгээр хязгаарлагдаж байжээ. Энэ асуудалонцгойлон хөндөгдөх болсон нь 1990-ээд онд олон улсын хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд илрүүлэн гаргасан Өмнөдийн буурай хөгжилтэй орнууд дахь уул уурхай, газрын тосны салбарт ажилладаг Өрнөдийн үндэстэн дамнасан корпорацуудын шууд болон шууд бус оролцоо бүхий хүний эрхийн зөрчлүүдтэй холбоотой юм. Эдгээрээс хамгийн ноцтой нь Нигери улс дахь газрын тосны Шелл корпораци ба нутгийн Огони иргэдийн хоорондын зөрчилдөөн юм. Нутгийн уугуул Огони иргэд 1990 онд Шелл корпорацийн олон арван жилийн туршид учруулсан байгаль орчны хохирол, орон нутгийн ядуурал, авлигын эсрэг тайван замаар тэмцэж эхэлсэн боловч Нигерийн засгийн газар энэ хөдөлгөөнийг харгислан дарж, удирдагч болон 8 гишүүдийг цаазлан хороосон юм. Шелл корпораци нь аллага, эрүүдэн шүүлт зэрэг хүний эрхийг ноцтой зөрчсөн үйл ажиллагаанд шууд бусаар буюу хамтран оролцсон хэмээн буруутгагдаж олон улсын эсэргүүцэл, хориг арга хэмжээтэй тулгарсан юм. Үүнтэй төстэй олон жишээг дурдаж болно.

Эдгээр хүний эрхийн зөрчлүүд нь хүний эрхийг хангахад бизнесийн байгууллагууд үүрэг хүлээх эсэхийг нухацтай авч үзэх асуудлыг хурцатгаж, 1998 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийг хамгаалах, хангах дэд комисс нь бизнес ба хүний эрхийн асуудлаар тусгай хуралдаан зохион байгуулж байв. Энэ хуралдаанаас 2003 онд “Хүний эрхийн талаарх үндэстэн дамнасан болон бусад бизнесийн

байгууллагуудын хүлээх үүргийн тухай хэм хэмжээ” хэмээх тайланг гаргаж, хүний эрхийг хамгаалах тогтолцоонд хувийн хэвшлийн үүргийг онцолсон юм.

2005 онд НҮБ бизнес ба хүний эрхийн асуудлыг онцгойлон анхаарч Ерөнхий нарийн бичгийн даргын Бизнес ба хүний эрхийн асуудлаарх Тусгай төлөөлөгчийн албыг байгуулсан. Тусгай төлөөлөгчөөр Харвардын Их Сургуулийн профессор Жон Раггиг томилсон юм. Тусгай төлөөлөгчийн гол зорилго нь компанийн хүний эрхийн талаарх үүрэг, хариуцлагыг тодорхойлох явдал байсан. Ийнхүү 2008 онд Рагги *Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ* хэмээх бодлогын баримт бичгийг танилцуулж, улмаар 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Зөвлөл “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ хэмээх бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг баталсан юм.⁸ Энэ нь НҮБ бизнесийн үйл ажиллагаанаас хүний эрхэд үзүүлэх сөрөг нөлөөллийг зохицуулах талаар батлан гаргасан анхны баримт бичиг болсон.⁹

Эдгээр баримт бичгүүд гарахаас өмнө олон улсын эрх зүйн хүрээнд хүний эрхийг хангах тухайд компанийн хүлээх үүрэг хариуцлага тодорхой бус байсан гэж үздэг. Ингэснээр компанийн хүлээх үүрэг олон улсын хүний эрхийн эрх зүйн зохицуулалтад тусгалаа олсон бөгөөд хяналт тавих тогтолцоо бүрэлдэн бий болж байна. Гэхдээ компанийн хүний эрхийн үүрэг хариуцлагыг цаашид тодруулан нарийвчлах хэрэгцээ бий.

“Бизнес ба хүний эрхийн удирдах

⁸ UN Human Rights Council, “Guiding Principles on Business and Human Rights: Implementing the United Nations ‘Protect, Respect and Remedy’ Framework” 2011

⁹ John Ruggie, “Progress in Corporate Accountability” IHRB Commentary: 2013, February 2013. <http://www.ihrb.org/commentary/board/progress-in-corporate-accountability.html>

зарчим” нь юуны өмнө аливаа бизнесийн байгууллагуудаас Хүний эрхийн олон улсын тунхаг болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын үндсэн зарчмуудыг хүндэтгэхийг шаарддаг. Энэ нь товчоор хэлбэл хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх тухай буюу Раггийн өөрийн тодорхойлсноор “үл хохироох” гэдэг зарчим юм.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь үндсэн 3 тулгуур зарчмаас бүрдэх ба зарчим тус бүрийг хэрэгжүүлэх ерөнхий арга замуудыг тодорхойлсон юм.

Нэгдүгээр зарчим-Хамгаал. Төр бол зохистой бодлого, зохицуулалтаар дамжуулан хүний эрхийг гуравдагч талууд зөрчихөөс хамгаалах үүрэгтэй гэдгийг онцолдог. Үүнд бизнесийн байгууллага хүний эрхийг зөрчихөөс хамгаалах үүрэг ч хамаарна.

Хоёрдугаар зарчим - Хүндэл. Бизнесийн байгууллага нь хүний эрхийг хүндэтгэх үүрэг хүлээнэ. Энэ нь “үл хохироох” гэдэг зарчим юм. Бизнесийн байгууллага нь эрсдлийн судалгаа, нөлөөллийн үнэлгээ, хуулийг чанд мөрдөх зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан хүний эрхийг зөрчихөөс сэргийлэх ёстой юм. Энэ нь бизнесийн байгууллага шууд бус байдлаар хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаанд оролцох тухай асуудалд ч хамааралтай бөгөөд урьдчилсан үнэлгээ судалгаа чухал гэдгийг онцолдог. Хүний эрхийг хүндэтгэх, эрх зөрчсөн үйл ажиллагааг дэмжих, хамтран оролцохоос татгалзах нь компаниудын хувьд нэр хүндээ алдахаас сэргийлэх болон “үйл ажиллагаа эрхлэх нийгмийн зөвшөөрөл” авах давуу талыг бий болгодог.¹⁰

Гуравдугаар зарчим - Эрхийг сэргээ.

Эрх нь зөрчигдсөн иргэд буюу хохирогчид

¹⁰ Энэ нь бизнесийн үйл ажиллагаа тогтвортой, үр ашигтай явагдахад төрөөс олгох үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн зөвшөөрлөөс гадна нийгмийн болон орон нутгийн иргэдийн зөвшөөрөл буюу дэмжлэг хэрэгтэй гэдэг ойлголт юм.

эрхээ хамгаалах шүүхийн ба шүүхийн бус тогтолцоог бий болгосон байх явдал юм. Төр нь хуулийн хүрээнд хохирсон иргэдийн эрхийг хамгаалах, хохирлыг барагдуулах, гэм буруутай этгээдэд шүүх болон захиргааны аргаар хариуцлага тооцох ажлыг хариуцах ёстой. Мөн төрийн зүгээс хохирсон иргэдэд мэдээллийн болон бусад шаардлагатай туслалцааг үзүүлэх тогтолцоог бий болгож, компаниудаас иргэдийн гомдлыг хэлэлцэх, хохирлыг барагдуулах үр дүнтэй механизмыг бий болгохыг шаардаж, хяналт тавих хэрэгтэй. Компаниуд иргэдийн гомдол, саналыг хүлээн авч, яриа хэлэлцээрийн зарчмаар шийдвэрлэх механизмтай байх шаардлагатай. Иргэний нийгмийн ба хүний эрхийн байгууллагууд компаниудад хяналт тавих, хохирогчдын эрхийг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

“Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” нь олон улсын байгууллагууд, засгийн газрууд, үндэстэн дамнасан корпорациудын зүгээс өргөн дэмжлэг хүлээсэн юм. Дэлхийн Банк, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны байгууллага зэрэг зээлдэгч байгууллагууд, АНУ, Европын Холбоо зэрэг өндөр хөгжсөн улсууд энэ баримт бичгийг хүлээн зөвшөөрч бодлогодоо тусгаж байна. Олон улсын томоохон корпорациуд, бизнесийн холбоод, үйлдвэрчний эвлэлүүд, хүний эрхийн байгууллагууд, хүний эрхийн үндэсний байгууллагууд үйл ажиллагаандаа баримталж эхлээд байна. Хөгжиж буй орнуудад зарим бүс нутгийн байгууллагууд, тухайлбал АСЕАН болон Африкийн Холбоо, “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим”-ыг холбогдох бодлогын баримт бичгүүддээ тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.¹¹

“Бизнес ба хүний эрхийн удирдах

зарчим” нь хүний эрхийн талаарх бизнесийн хариуцлагыг “хүндэтгэх” зарчмаар хязгаарлан, компаниудын хүний эрхийг хамгаалах, иргэдийн эрх эдлэх боломжийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зэрэг үүргийг хөндөөгүй гэдэг шүүмжлэлд өртдөг. Гэвч энэ баримт бичиг нь бизнесийн байгууллага хүний эрхийг хангахад хүлээх үүргийг хүлээн зөвшөөрүүлж, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх, эрхийг сэргээх нэгдмэл ойлголтыг бий болгож чадсан. Цаашид энэ баримт бичгийг суурь болгон тухайн улс орны болон бизнесийн салбарын онцлогт тохирсон нарийвчилсан хэм хэмжээ, зохицуулалтыг бий болгох санаачлагууд гарах нь дамжиггүй. Нөгөөтэйгүүр, хүний эрхийн талаарх бизнесийн байгууллагуудын өөрсдийн буюу ялангуяа удирдах төвшний ажиллагсадын ойлголт, итгэл үнэмшил чухал учраас энэ чиглэлийн түгээн дэлгэрүүлэх ажлууд ихээхэн хэрэгтэй юм.

Компанийн нийгмийн хариуцлага

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг ойлголт нь олон улсын түвшинд нэг мөр цэгцрээгүй олон талтай ойлголт юм. Монгол Улсын хувьд энэ ойлголт харьцангуй шинэ бөгөөд төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхэн болон судлаачдын дунд зөрөөтэй ойлголт хандлага ажиглагдаж байна. Цаашид энэ талаар өргөн хүрээтэй судалгаа, хэлэлцүүлэг, сургалтууд хийгдэх шаардлагатай юм.¹² Компанийн нийгмийн хариуцлага гэдэгт юуг ойлгох, энэ нь хуулиар даган мөрдөх ёстой үүрэг үү эсвэл сайн дурын үйл ажиллагаа байх ёстой юу, компанийн нийгмийн хариуцлагын хэрэгжилтийн

¹² Олон улсын байгууллагууд болон үндэсний Төрийн бус байгууллагуудын тодорхой санаачлагууд тухайлбал үндэсний форум болон энэ сэдвээр сэдэвчилсэн цахим хуудсууд гарч байна. Тухайлбал, Германы Хамтын Ажиллагааны байгууллага Монгол Улсын холбогдох яамд, төрийн бус байгууллагуудтай хамтран компанийн нийгмийн хариуцлагыг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлж байна.

¹¹ John Ruggie, “Progress in Corporate Accountability” IHRB Commentary: 2013, February 2013. <http://www.ihrb.org/commentary/board/progress-in-corporate-accountability.html>

хяналт байх ёстой эсэх, төр болон иргэний нийгмийн оролцоо ямар байвал зохистой зэрэг тулгамдсан асуудлууд бий.

Компанийн нийгмийн хариуцлага нь бизнесийн байгууллагууд нийгэм дэх үүргээ хариуцлагатайгаар биелүүлэх, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах чин эрмэлзэл гэдэг ойлголт харьцангуй түгээмэл байдаг, ялангуяа бизнесийн төлөөлийнхний дунд нийтлэг бий. Мөн компанийн үйл ажиллагаанд шууд ба дам оролцож буй болон нөлөөнд өртөж буй иргэд, орон нутаг мөн бусад талуудын эрх ашгийг хүндэтгэн харилцах явдал гэж ойлгох явдал ч нийтлэг байдаг.

Компанийн нийгмийн хариуцлага гэдэг ойлголтыг тодруулан үзэхийн тулд компанийн хариуцлага гэдэг ерөнхий ойлголтыг задлан авч үзэж болно.¹³ Юуны өмнө, компанийн бизнесийн хариуцлага гэдэг нь тухайн компанийн удирдлагын хувь нийлүүлэгчид болон хувьцаа эзэмшигч нарын өмнө хүлээсэн ёс зүйн болон хууль зүйн үүрэг бөгөөд энэ нь хууль болон компанийн дотоод дүрэм журмаар тогтоосон хэм хэмжээний хүрээнд зохицуулагдаж байдаг. Өөрөөр хэлбэл компанийн засаглалын асуудал юм.

Компанийн филантропи үйл ажиллагаа гэдэг нь компанийн хөрөнгийг компанитай эдийн засгийн болон бизнесийн шууд харилцаагүй иргэдийн сайн сайхан байдлын төлөө зарцуулах үйл ажиллагаа юм. Филантропи үйл ажиллагааг компанийн нийгмийн хариуцлагатай адилтган ойлгох явдал нэлээд бий. Том Кэмпбеллийн үзсэнээр компанийн нийгмийн хариуцлага нь компанийн бизнесийн хариуцлагаас ялгаатай нь хувь нийлүүлэгчид, хувьцаа

эзэмшигч нараас гадна бусад оролцогч, эрх ашиг нь хөндөгдөгч талуудад компанийн үйл ажиллагаанаас учирсан буюу учирч болох сөрөг нөлөөллөөс хамгаалах, тэдэнд үр өгөөж бүхий бизнесийн үйл ажиллагаа эрхлэх явдал юм. Харин филантропи үйл ажиллагаанаас ялгаатай нь компанийн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд буй талуудтай харилцдаг. Зарим судлаачид, эрх бүхий талууд буюу компанийн бизнесийн үйл ажиллагааны нөлөөлөлд орж эрсдэл хүлээсэн болон хүлээх магадлалтай иргэд ба орон нутгийг, компанийн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд ороогүй ч компанийн үйл ажиллагаанд хамаарал, сонирхол бүхий оролцогч талууд гэж ялган үздэг.

Компанийн нийгмийн хариуцлага нь сайн дурын үйл хэрэг гэдэг хандлага өнөөдөр давамгайлж байна. Компанийн нийгмийн хариуцлага нь тухайн компанийн хуулийн хүрээнд хүлээсэн үүргээс давсан зүйлийг илэрхийлэх учраас хуулиар шаардаж, үүрэгжүүлэх нь утгагүй гэж үздэг. Эсрэгээр, хуульчилж заавал даган мөрдөх хэм хэмжээ болгохгүйгээр компаниудын гаргаж буй зарим ноцтой зөрчлүүдийг, ялангуяа байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ба бусад хүний эрхийн зөрчлүүдийг арилгах боломжгүй гэж үзэх талууд байна. Тухайн нөхцөл болон бизнесийн салбарын онцлогоос хамааран эрх нь хөндөгдсөн иргэдийг хамгаалах зорилгоор компанийн зарим хариуцлагыг хуулиар үүрэгжүүлэх нь үр дүнтэй байж болно.

Монгол Улсын хувьд компанийн нийгмийн хариуцлагын талаарх гол баримт бичиг нь Олон улсын стандартын байгууллагаас 2010 баталж, улмаар Монгол Улсын Стандартчлал Хэмжил Зүйн Газраас 2012 онд баталсан Нийгмийн хариуцлагыг удирдамж ISO 26000 стандарт юм. Энэ нь “норматив, техникийн болон удирдлагын

¹³ Tom Campbell, "Corporate social responsibility: beyond the business case to human rights" in *Business and Human Rights*, edited by Wesley Cragg. 2012. Elgar online DOI:10.4337/9781781005774.00008

тогтолцооны уламжлалт стандарт биш бөгөөд мөн баталгаажуулалт хийх эсвэл аливаа гэрээ хэлэлцээрт мөрдөх буюу зохицуулах зорилгод ашиглах баримт бичиг биш болно.”¹⁴ Энэ удирдамж нь нийгмийн хариуцлагыг компаниудын хууль, эрх зүй, албан журмаар ногдсон заавал биелүүлэх үүргээсээ илүү өндөр түвшинд нийгмийн сайн сайхны төлөө сайн дураараа явуулах үйл ажиллагаа гэж тодохойлсон.

Компанийн нийгмийн хариуцлага ба хүний эрхийн асуудал

Саяхныг хүртэл хүний эрхийн асуудал компанийн нийгмийн хариуцлагын тухай ойлголт, үзэл баримтлалд төдийлэн хамааралгүй яригдаж иржээ. Энэ хоёр асуудал хоорондоо хэрхэн уялдаатай явж ирснийг 3 үеээр ангилан авч үзсэн байдаг.¹⁵

Нэгдүгээрт, 1980-аад оны дунд үеэс хөдөлмөрлөх эрх болон ажил эрхлэлтэй холбоотой асуудлууд олон улсад хурцаар тавигдаж байсан. Мөн энэ үед Өмнөд Африк дахь арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг хөдөлгөөнтэй холбоотой компаниуд хөрөнгө оруулалтаа зогсоох зэрэг компанийн хариуцлагын хэлбэрүүд бий болж байсан.

Хоёрдугаарт, 1990-ээд оноос хүүхдийн хөдөлмөр болон тэвчишгүй хөдөлмөрийн асуудал Өрнөдийн компаниудын ханган нийлүүлэгч болон гэрээт компаниудын хувьд тулгарч олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс компаниудаас өмнө шаардаж ирсэн ажилчдын эрхийн тухай уламжлалт асуудлыг бус харин хөдөлмөрийн орчин нөхцөл харилцагч нарынхаа тухай өргөн хүрээтэй

хариуцлага хүлээх шаардлага тавих болсон.

Гуравдугаарт, Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ бодлогын баримт бичиг болон “Бизнес ба хүний эрхийн удирдах зарчим” батлагдсан нь хүний эрх ба компанийн нийгмийн хариуцлагын асуудлыг шинэ төвшинд гаргаж судалгаа болон бодлогын баримт бичгүүд, хурал хэлэлцүүлгийн эхлэл болсон. Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ бодлогын баримт бичиг гарсантай уялдаж олон улсын Нийгмийн хариуцлагын ISO 26000 удирдамж 2010 онд шинэчлэгдсэн байдаг.¹⁶

Нийгмийн хариуцлагын ISO 26000 удирдамж нь хүний эрхийн асуудлыг олон талаар тусгасан. Удирдамж нь хөдөлмөрийн харилцаа болон хүний эрхийн асуудлыг тусгайлан авч үзсэн. Ялангуяа хүний эрхийн тухай хэсэг нь Раггийн удирдамжийн дагуу бичигдэж компанийн шууд бус оролцоо, компанийн хүний эрхийг хүндэтгэх механизм зэрэг асуудлыг дэлгэрүүлэн тусгажээ. Энд “хүний эрхийг хүлээн зөвшөөрөх гэдэг нь нийгмийн хариуцлагын удирдамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэг гол цөм” гэж онцолсон.

Хүний эрхийг хүндэтгэн дээдлэнэ гэдэг бол компанийн бизнесийн болон нийгмийн хариуцлагын суурь зарчим юм. Компани нь хүний эрхийг хүндэтгэн дээдлэхээс чанагш хүний эрхийг хамгаалах, иргэдийн эрхээ хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн боломжийг бий болгох зэрэг үйл ажиллагаа явуулах ч бололцоотой. Хүний эрхийг хүндэтгэх нь түүнийг эс зөрчих утгыг агуулдаг. Олон компаниуд хүний эрхийг хүндэтгэн дээдэлдэг гэж тайлагнаж хэлдэг ч хүний эрхийг зөрчихөөс сэргийлсэн компанийн бодлого, үйл ажиллагааны бүтэцтэй байх нь элбэг биш байдаг. Тийм

¹⁴ Стандартчлал Хэмжил Зүйн Газар. Нийгмийн хариуцлагыг удирдамж ISO 26000: 2012 <http://www.estandards.mn/file.php?sid=4505>

¹⁵ Florian Wettstein, “CSR and the Debate on Business and Human Rights: Bridging the Great Divide” *Business Ethics Quarterly* 22:4, 2012 ISSN 1052-150X pp. 739–770 DOI: 10.5840/beq20122446

¹⁶ Adrian Henriques, ISO 26000: a standard for human rights? *Sustainability Accounting, Management and Policy Journal* Vol. 1 No. 1, 2010 pp. 103-105

учраас Хамгаал, Хүндэл, Эрхийг Сэргээ бодлогын баримт бичигт компаниуд нь хүний эрхийн тухай бодлогоо тодохойлсон байх, компанийн үйл ажиллагааны хүний эрхийн нөлөөллийн үнэлгээг хийсэн байх, тэдгээр бодлогын чиглэл, судалгааны дүнгээ компанийн удирдах бүтэц, үйл ажиллагааны соёлд нэвтрүүлсэн байх, үр дүнг тооцох, тайлагнадаг байх гэдэг хүний эрхийг хүндэтгэх үүргээ хэрэгжүүлэх зохион байгуулалтын 4 үндсэн бүрэлдэхүүнийг бий болгохыг зөвлөсөн байдаг. Эдгээр нь тухайн улс оны онцлог, компанийн цар хүрээ, ажлын онцлогоос хамаарч хэлбэлзэж болно. Тухайлбал, Европын Холбооноос Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан хүний эрхийн удирдамж гаргасан байх бөгөөд түүнд 6 алхамыг тусгасан байна. Үүнд: хүний эрхийг хүндэтгэх эрмэлзэлтэй байх, хүний эрхийн эрсдэл бий эсэхийг тодорхойлох, тодорхойлсон эрсдлийг бууруулах арга хэмжээ авах, ахиц дэвшлийг хянах, үйл явц ба үр дүнгээ бусдад тайлагнах гэдэг 6 алхам орсон.¹⁷

Компанийн үйл ажиллагааны дээрх зохион байгуулалтаас гадна Нийгмийн хариуцлагын ISO 26000 удирдамж нь компани хүний эрхийн зөрчилд хамтран оролцогч болох буюу шууд бусаар оролцохгүй байх, эрх нь хөндөгдсөн талуудын гомдол, саналыг хүлээн авч, хэлэлцээрээр барагдуулах механизм, хөдөлмөрийн эрхийн хэрэгжилт зэрэг хүний эрхийн чухал асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн. Эдгээрийг амжилттай түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлж чадвал Монгол Улс дахь бизнесийн салбарт хүний эрхийн хүндэтгэн дээдлэх, “үл хохироох” хандлага, тогтолцоо бүрэлдэхэд чухал хувь нэмэр болно. Цаашид компаниудын нийгмийн хариуцлагын тайланд хөндлөнгийн мониторинг, аудит

хийх ажлууд өрнөхөд хүний эрхийн бүрдэл хэсгийн хэрэгжилтэд онцгой анхаарал тавих хэрэгтэй юм.

Дүгнэлт

Компанийн нийгмийн хариуцлага ба хүний эрхийн асуудал нь бизнесийн байгууллага хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, түүнд нийцсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Ялангуяа хүрээлэн буй орчин ба нийгэмд үзүүлэх нөлөөлөл ихтэй гэгдэх уул уурхай, газрын тос, аялал жуулчлал, барилга дэд бүтэц зэрэг салбарын компаниуд хүний эрхийг хүндэтгэн дээдлэх бодлогын болон үйл ажиллагааны бүтцийг бий болгож хэрэгжүүлэх нь эрх бүхий иргэдийн хувьд ч, компанийн хувьд ч эерэг үр дүн авчирна. Санхүү, хүний нөөцийн үзүүлэлтүүд нь яг ижилхэн нэг салбарын хоёр компанийн үйл ажиллагаа, ашиг орлого нь тухайн орон нутгийн иргэд, оролцогч талуудын эрхийг хүндэтгэж, хэрхэн зөвлөлдөж, хамтран ажилласнаас хамааран илт ялгардаг жишээ олон бий.

Компанийн нийгмийн хариуцлага ба хүний эрхийн хэрэгжилт нь компанийн удирдлага болон ажиллагчдын итгэл үнэмшил, эрмэлзлэлээс ихээхэн хамаарах учраас хүний эрхийн байгууллагуудын хувьд дан ганц “цоллох ба ичээх” арга барилаар бус “ойлгуулах ба үлгэрлэх” аргаар буюу мэдээлэл түгээх, сайн туршлагыг сурталчлах зэргээр хандлагыг өөрчлөх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай юм. Цаашид хүний эрхийн байгууллагууд Нийгмийн хариуцлагын ISO 26000 удирдамж дахь хүний эрхийн зөвлөмжүүдийг нухацтай судлаж, компанийн хүний эрхийн хариуцлагын тухай нэгдмэл ойлголт, практик удирдамжуудыг боловсруулах хэрэгтэй байна.

¹⁷ Draft Guide on Human Rights for Small and Medium-sized Enterprises. http://www.global-csr.com/fileadmin/Our_Approach/120823_Full_Guide_SMEs_Draft.pdf

ӨМЧЛӨХ ЭРХИЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ТҮҮХЭН АСУУДАЛ



Хүний эрхийн Үндэсний Комиссын
Бодлогын дүн шинжилгээ, хүний эрхийн
боловсролын хэлтсийн дарга, докторант

Г.АГАР-ЭРДЭНЭ

Өмчлөх эрх бол хувь хүний оршихуйн үндэс, эрх чөлөөний үнэт зүйлсийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг билээ. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн өнгөрсөн цаг хугацаанд сэтгэгчид хувийн өмч, өмчлөх эрхийн талаар оюун бодлоо уралдуулж, өмч гэж юу болох, зүй ёсны шинж байдлаа хэрхэн олдог тухай, нийгмийн харилцааны тодорхой түвшинд юу өмчийн объект болдог, аль нь энэ ойлголтоос ангид байх тухай асуудлыг тодорхойлж, түүний агуулгыг нээн илэрхийлэхийг зорьж, олон ургалч онол, үзэл санааг хөгжүүлсээр ирсэн юм. Сэтгэгчдийн дэвшүүлсэн үзэл санаа, онолын урсгал, чиглэлүүдэд хувийн өмч нь аливаа тохиолдолд хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож, хувь хүнд эрх чөлөөг хамааруулж үзэхийн тулд тухайн хүн зохион байгуулалтад орсон нийгэмд амьдардаг байх ёстойг онцлон тэмдэглэсэн нь бий. Нийгмийн зохион байгуулалтын нэг хэлбэр бол хувийн өмч юм. Өөрөөр хэлбэл хувийн өмч нь эд баялаг, хөрөнгө мөнгөтэй холбогддог ч хүний эрхэм чанарыг түүнээс дээгүүрт тавьж, хувь

хүний эрх чөлөөний тулгуур нь юм гэдгийг сэтгэгчид байнга онцолсоор иржээ.

Энэхүү нийтлэлээр өмчлөх эрх, хувийн өмчийн талаар судлаачдын дэвшүүлсэн үзэл сэтгэлгээний түүхэн асуудлыг хөндөхийг зорилоо.

Нэг. Эртний Грек, Ромын өмчлөх эрхийн сэтгэлгээ

Барууны эрх зүйн сэтгэлгээ анх МЭӨ VI зуунд үндэс сууриа тавьж байсан үеийн Грекийн философийн түүхэн цаг хугацааг Сократаас өмнөх үе болон Сократаас хойших үеийн гэж хоёр ангилах нь элбэг байдаг. Сократаас өмнөх үеийн сэтгэгчдийн шинжлэх ухааны судалгаа нь одон орон, байгалийн болон биологийн ухаанд голчлон хандсан байх агаад түүхэн сурвалжаас үзвэл эртний Грекийн Йонын болон Милетийн сургуулийн сэтгэгчдийн үзэл сэтгэлгээ энэ үед давамгайлж байв. Грекийн философи сэтгэлгээний эцэг гэж алдаршсан Фалес, философийн сэдвээр мэргэшсэн анхны зохиолч гэгддэг Анаксимандр, түүнчлэн

Анаксимен, Гераклит нарыг энэ үеийн сэтгэгчдээр нэрлэж болно.

Дурдсан сэтгэгчдийн бүтээл туурвилд хувийн өмч, өмчлөх эрхийн талаарх дорвитой баримтууд ховор ба сэтгэлгээний чухал нөлөө үзүүлсэн цаг хугацааг Сократын үеэс эхлэн тоолбол илүү үр дүнд хүрэх юм. Энэ үеийн сэтгэгчид гол төлөв өмчийн гарал үүсэл, түүний мөн чанарын асуудалд голлон анхаарч ирсэн байх агаад хувийн өмч, нийтийн өмч гэсэн ойлголт ямар учир шалтгааны улмаас бий болсон тухайд оюун ухаанаа уралдуулж байв.

Платон (МЭӨ 427-347) нийтийн өмч нь нийтийн ашиг сонирхлын тусын тулд нийтээрээ хийх үйл ажиллагааг хөгжүүлэхэд, мөн нийгэмд бий болж болох “нэг нь хэмжээлшгүй их уй гашууд автсан байхад нөгөө нь аз жаргалдаа сэтгэл ханан баярлаж суух¹⁸” тэрхүү сөрөг байдлаас зайлсхийхэд зайлшгүй чухал ач холбогдолтой гэж үзэж байлаа.

Афинд Платоны академи (энэ үгийг Платон Аттикийн баатар Академусын нэрийг зээлдэж хэрэглэсэн гэж үздэг)-д суралцаж боловсорсон түүний шавь Аристотель (МЭӨ 384-322) хувийн өмчийн талаар авч үзэхдээ өмч хөрөнгийг гэр бүлийн, нийтийн хэмээн Платоны ангилсныг буруушааж, өмч хувь хүнд л байх нь чухал гэдгийг сануулсан байна. Энэхүү хувийн өмчийг төрөөс хамгаалах ёстой. Учир нь хувь хүн ямагт хувьдаа өмчтэй байхыг хичээдэг байгалиас заяагдсан хүсэл сонирхолтой байдаг юм гэж хэлээд өмч хөрөнгийг нийтийн болгохыг эсэргүүцсэн юм.

Хувийн өмч нь хүний өөртөө хайртай байх мөн чанараас урган гарна. Хүн бүр өөртөө хайртай байх нь хувиа бодсон үзэл бөгөөд энэ нь шударга бус хувиа бодсон

үзлээс ялгаатай хэмээн тайлбарлажээ. Аристотель цааш нь хууль тогтоогчид хувийн өмчийг ухаалаг, сайн санааны илрэл гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Өмч нь хувийнх байх ёстой агаад түүний үр ашгийг нийтээр хүртэх ёстой гэжээ. Тэр “Хүн бүр өөрөө өөрийнхөө найз нөхөр ба өөрийгөө юунаас ч илүү хайрлах хэрэгтэй. Тийм учраас хууль бүтээгчид хувийн өмчийг сайн үйлийн эхлэл гэж хүлээн зөвшөөрөх ёстой¹⁹” гэсэн байдаг.

Аристотелийн өмчлөх эрхийн сэтгэлгээний үндэс нь түүний дэвшүүлсэн дараах тайлбаруудаас бүрддэг. Тэрээр хувийн өмч нь хүний амьдралд гурван учир шалтгааны улмаас нэн шаардлагатай байдаг гэдгийг онцлоод, үүнд, *нэгдүгээрт*, хүн бүр хамтын ашиг сонирхлыг бусдад найдан үлдээж, хөдөлмөрлөхөөс зайлсхийх болсон тэр цагаас хойш өөрт хамааралтай бүхэндээ нийтэд хамаатай бусад ашиг сонирхлоос илүү анхаарал халамж тавих шаардлагатай болсон нь хувийн өмч үүсэх шалтгаан болсон, *хоёрдугаарт*, хэрэв хүн бүр аливааг удирдан зохицуулах өөрийн чадавхидаа найдаж амьдарвал тэнд ямар нэгэн будлиан гарахгүй бөгөөд хүний ажил төрөл, амьдрал нь илүү дэг журамтай болох юм. *Эцэст нь*, энэ утгаараа нийгэмд энх тайван байдал сайн хамгаалагдана. Нийгмийн гишүүн бүр өөрийн эзэмшил, өмчтэй байх үедээ сэтгэл хангалуун байж чаддаг. Ийм нөхцөлд өмчлөлийн талаар маргаан гарах нь ч багасна гэж тайлбарлажээ.

Ийнхүү Аристотель хувийн өмч бол хүний хариуцлагатай байдал, эрүүл саруулаар сэтгэх явдлыг хөгжүүлж байдаг гэж өмгөөлөхдөө “Хүн бүр тус тусын ашиг сонирхолтой байгаа цагт хэн ч өөр бусдынхаа талаар гомдоллохгүй бөгөөд өөр өөрийн гэсэн ажил төрөлтэй байдаг учир хариуцлагын

¹⁸ Plato (1993), Republic [c. 370 BCE], Robin Waterfield (trans.), Oxford: Oxford University Press.

¹⁹ Aristotle (1999), Nicomachean Ethics [c. 370 BCE], Terry Irwin (trans.), Indianapolis: Hackett Publishing. Chapter IX Para 8.

тал дээр илүү дэвшилт гаргаж чадна²⁰” гэж үзсэн юм. Түүний өмчлөх эрхийн сэтгэлгээ хувийн өмчийн оршин тогтнох, түүнийг хөгжүүлэх тал дээр илүүтэй хандсан хэдий ч өмчлөх эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаад нь ёс зүйн анхаарал тавьснаар бусдыг энэрэх үзэл (altruism)-ийг бодитой хөгжүүлж болно гэж тайлбарласнаас үзвэл хувийн өмчөөр дамжуулж нийтийн сайн сайханд илүү хурдан хүрнэ гэдэгт Аристотель итгэж байжээ. Нөгөөтэйгүүр хүний биеэ бодсон аминч үзлийг бусдыг халамжлах үзэлтэй ухаалгаар нийцүүлэх оролдлогыг тэр хийсэн юм. Бусдыг энэрэх үзлийг хожмоо А.Комте нарын сэтгэгчид бодит утгаар нь хөгжүүлсэн билээ.

Түүнчлэн Аристотель өмч болон эрх чөлөөний хоорондын харилцааг авч үзсэн ба хүнийг эрх чөлөөтэй байхад нь, түүнчлэн улсын иргэний хувьд өмчлөлийн оруулах хувь нэмрийг судалсан байдаг. Грекчүүд эрх чөлөө гэсэн ойлголтыг боолчлолоос ялгарах статус гэж үзэж байсан бөгөөд Аристотелийн хувьд “эрх чөлөөтэй байна гэдэг нь өөрөө өөртөө хамаарагдаж, өөрийн гэсэн хувь хүн байх гэсэн үг ба боол гэдэг бол өөр хэн нэгэн хүний өмчөөс өөрцгүй юм” гэж тайлбарлажээ. Жинхэнэ боол хүн буюу төрөлхөөс боол болж төрсөн хүн өөрийн биеийн дур хүслийг тодорхойлж чаддаггүй учраас эрх чөлөөгүй юм гэж тэр үзэж байв. Аристотель боолчлолын нөгөө талд “ажиллах хүчний илүү тааруу хэлбэр” байдаг гэсэн үзэл бодлоо эргэлзээгүйгээр хамгаалж байлаа. Амьдралын хэрэгцээ шаардлагадаа баригдаж шаналснаасаа болоод ядуус эрх чөлөөт хүмүүс шиг улс төрд оролцох ямар ч чадваргүй, “хэтэрхий чанар муутай болсон” гэж тэр үзжээ. Мөн тэрээр “Та боолчуудаас бүрдүүлж

байгуулснаас арай дээр хотыг үгээгүй ядуу гуйлгачдаас бүрдүүлэн байгуулж чадахгүй юм” гэж бичиж байлаа. “Тэдгээр ядуусыг боолчуудтай адил түвшинд авч үзэж, боолтой адилтган журамлаж байх ёстой. Эс тэгвээс тэдний аминд тулсан хэрэгцээ шаардлагаас нь болж атаархал, хүчирхийлэл бий болно” гэжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр өөрийн гэсэн өмчгүй, эд хөрөнгөгүй хүн боолоос ялгаагүй гэсэн санааг илэрхийлсэн юм.

Ромын эрдэмтэн Сенека (МЭӨ 54 - МЭ 39) стойкчуудаас ялгаатай нь чөлөөт иргэд болон боолуудын тэгш эрх, оюун санааны эрх чөлөөг хамгаалагч хэмээн алдаршсан билээ. Эртний Грек, Ромын өмчлөх эрхийн сэтгэлгээний нэг онцлог бол боолыг өмчийн объект болгон ойлгож байсанд оршино. Тухайн үед боолыг *instrumentum semivocale* буюу дуугардаг багаж-гэрийн тэжээмэл амьтан, *instrumentum mutum* буюу хэлгүй багаж гэсэн хоёр хэрэгслээс ялгаатай нь *instrumentum vocale* буюу үг хэлдэг, ярьдаг болохоос бус эд хөрөнгийн л нэг хэлбэр²¹ гэж үзэж байлаа. Боолыг өмчийн объект гэж үздэг байсан энэ үед тэднийг зарж, худалдаж авах нь хууль ёсны эрх байв. Боолууд өөрийн сонгосон амьдралаар амьдрах эрх чөлөөгүй, эзний тушаал заавраар үйлдэл хийдэг байсан бөгөөд тухайн үед ихэнх нь боолыг хөдлөх эд хөрөнгө гэж үзэж байсан юм.

Сенека нь хүмүүс нийгмээс үл шалтгаалан оюун санааны хувьд бүгд тэгш, адилхан байх ёстойг онцолсон ба “Хүнийг боолчлоход түүний бие цогцсыг л боолчилж болохоос оюун санааг боолчлох аргагүй. Эрх чөлөөт иргэд хийгээд боолчууд ч бүгд ялгаагүй хувь заяаны боол юм” гэсэн байдаг.

Тэрээр мөн хувийн өмчийн гарал үүслийн талаар өөрийн үзэл санааг дэвшүүлэхдээ “Тухайн бүдүүлэг үед хүмүүс хоорондоо тун эе эвтэй, жаргалтай, хувийн өмч гээчийг

²⁰ Aristotle (1988), *The Politics* [c. 330 BCE], Stephen Everson (ed.), Cambridge: Cambridge University Press.

²¹ J.E.Cairnes *The Slave Power* [1862], London. Page 46.

мэдэхгүй, бүх нийтээр эзэмшиж, боолчлол, төр гэх юм байхгүй, хэв журмыг бүгдээр мөрдөж, хамгийн ухаантай нь жолоодож, тэднийг аль ашигтай зүйл рүү хөтөлж байсан учир түүнд дуртайяа захирагддаг байв. Хүй нэгдлийн гэм зэмгүй байдал цаг хугацааны явцад арилж үгүй болжээ. Баялгийг нийтээр хэрэглэхэд дургүйцэх байдал нэмэгдсээр байв. Иймд баялгийг хувьдаа эзэмших хүсэл хүмүүст бий боллоо. Ухаантай нь тэргүүлэх байдал түрэмгийчүүдийн гарт шилжив. Иймд тэднийг хянаж байх зорилгоор хуулийг бүтээхэд хүрсэн юм.²² гэжээ.

Сенека хүний өмчгүй байх үеийн номхон, хүлцэнгүй байдал бол хүний өөрийнх нь сайн сайхных ч биш, харин өөрийн төрөлх мөн чанарыг танин мэдэж чадаагүй байсантай холбоотой гэж хувийн өмчийн талаарх байр сууриа илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл тэрээр хүний хувьдаа өмчтэй байх хүсэл нь төрөлхөөс заяагдсан шинжтэйг тайлбарлажээ.

Эртний Ромын өмчлөх эрхийн сэтгэлгээний хөгжлийн эхэн үед (МЭӨ 3-р зууны дунд үе хүртэл) өмчийг эд юмс болон гэр бүлийн баялаг-*res familiaris* хэмээн нэрийдэх явдал хэвээр байсан ба түүнийг хэн нэгэн ганцаараа эзэмшиж болох ч аливаа их хэмжээний эд хөрөнгийг бүхэлд нь өрхийн тэргүүн мэдэлдээ байлгадаг байв. Практик утгаар нь тайлбарлавал тэр үед өрхийн тэргүүн өөрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээсээ илүүтэй гэр бүлийнхээ сайн сайхны төлөө өмч хөрөнгийг өөрийн мэдэлд хянаж байдаг заншилтай байжээ.

Онолчид өөрийн мэдэлдээ гэр бүлийн бүх өмч хөрөнгийг байлгаж байсан энэ түүхэн баримтад хандахдаа томоохон хэмжээний хөрөнгө эзэмшигч этгээд өөрийгөө бие даасан этгээд гэж ойлгодог нөхцөл байдлаас

шалтгаалан *paterfamilias* дахь өөрийн үүрэг ролио “нэг хүний удирдлага²³”-аас өөрөөр ойлгох болсон гэж тайлбарладаг. Үүний улмаас хувийн өмч үүссэн гэж тэд үздэг. Харин өрхийн тэргүүн гэр бүлийн бүх эд хөрөнгийг өөрийн мэдэлд байлгадаг дээрх практик цаашид үргэлжлэх учиртай байсан гэж үзвэл түүний оршин тогтнох боломжтой нөхцөл байдал нь коммунизм, эсвэл хэмжээгүй эрхт хаант засаглалын үед боломжтой ба энэ тохиолдолд хүн бүрийн өмчтэй байх үүрэг хариуцлага алдагдах бөгөөд газар сайгүй хөдөлмөрлөхгүйгээр хэрэгцээгээ хангах сөрөг үр дагавар бий болно гэж хожмын сэтгэгчид шүүмжилжээ.

Өнөөгийн өмчлөх эрхийн сэтгэлгээ, түүний онолын үндэс болсон эртний Ромын эрх зүйн сэтгэлгээний хэлбэр ёсоор өмчийн объектыг *res publicae* буюу иргэний гүйлгээнд хамааралгүй эд баялаг, *res privatae* буюу иргэний гүйлгээн дэх эд баялаг хэмээн ангилж байсан бөгөөд *res publicae* нь нийтийн өмч гэсэн ойлголтыг илэрхийлдэг. Ой мод, гол мөрөн, агаар, зам, гүүр гэх зэрэг объектууд нь энэ ангилалд хамаардаг байна²⁴. Харин *res privatae*-г эрх чөлөөтэй нийгмийн гишүүн бүр өмчлөх эрхтэй бөгөөд үүнд тухайн хүний газар, үр тариа, мал аж ахуй зэрэг орж байлаа.

Ромд материаллаг болон материаллаг бус эд баялаг, түүнчлэн тодорхой этгээдийн үйлдэл, үйл ажиллагаа нь өмчийн харилцааны объектод тооцогддог байв. Материаллаг эд баялгийн тоонд газар, мал, үйлдвэрлэлийн хэрэгсэл болон боолыг багтаан ойлгосон *res mancipi* төрлийн баялаг ордог байсан²⁵ нь тухайн үеийн боолын нийгмийн харилцааны онцлог билээ. Боол нь эрх зүйн харилцааны объект болохын хувьд

²³ Joseph Rickaby, S.J. *Moral Philosophy: Ethics, Deontology and Natural Law*. [1905]. Page 231

²⁴ Х.Сэлэнгэ Ромын эрх зүй [1999] УБ.

²⁵ Мөн тэнд.

²² А.К.Романов (2002) Английн эрхийн тогтолцоо. УБ. 28-р тал.

эд юмсаас төдийлэн ялгарахгүй статустай байв. Харин ромын эрх зүйн хөгжлийн сүүлийн шатанд нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогоос шалтгаалан боолыг чөлөөлж, тэдэнд жижиг хэмжээний ногдол газар олгож, хөдөлмөрийг нь ашиглах болсон нь хамжлагын тариачин үүсэх нөхцөлийг бүрдүүлжээ. Төдийлэн ялгарахгүй гэдгийн гол шалтгаан бол зарим тохиолдолд боолын эзэн нь *rescilium* хэлбэрээр боолоо ашиглаж эд юмсыг ашиглах, эзэмших эрхийг түүнд олгож²⁶, эрх зүйн харилцаанд оролцуулах тохиолдол байжээ.

Ромд Сенека, Эпиктет нар боолыг өмчийн объект болгохыг эсэргүүцэж байлаа. Эпиктет удам судрын хувьд боол байсан бөгөөд түүний тайлбарласнаар хүн бүр ертөнцийн хууль ба хувь заяандаа захирагдаж, өөрт олгогдсон үүргийг биелүүлэх нь зөв гэсэн ба “өөрөө хүсээгүй зүйлийг бусдаас бүү хүс” гэсэн жам ёсны эрхийн сэтгэлгээний зарчмыг боловсруулжээ. Уг зарчмыг боолчлолтой холбон үзэхдээ боолчлолыг ёс зүйгүй, жам ёсны эрх зүйд харшилсан, түүнийг үл тоомсорлосон үзэгдэл болно. Иймээс хэрэв чи өөрөө боол болохыг хүсээгүй бол өрөөл бусдыг бүү боолчил гэсэн агуулгыг гарган илэрхийлжээ.

Харин Цицерон (МЭӨ 106-43) өмчлөх эрхийг шударга ёсны шаардлагын нэг хэлбэр гэж үзээд нийтийн өмчийг өөрийн өмч хэмээн ойлгож хандах хэрэгтэйг зөвлөж байв. Ийм учраас төрийн ба хувийн өмчийн халдашгүй байдлыг зөрчих нь шударга ёс ба эрх зүйг зөрчсөнөөс ялгаагүй байх болно гэжээ. *Ager redditus* буюу хувийн өмчийн эрх нь эзэмших, ашиглах, ашиг орлого олж авах, захиран зарцуулах, шаардах эрхүүдийн хамтаар өмчлөх эрхийг бүрдүүлнэ гэсэн зарчим энэ үеэс хэрэгжиж эхэлсэн юм.

Цицерон төр барьж буй хүмүүс

²⁶ Мөн тэнд.

иргэдийн хувийн өмчийг хамгаалах ёстой гэдэг байр суурь дээр хатуу зогсож байлаа. Өөрөөр хэлбэл төр засаг хувийн өмчийг л хамгаалан бэхжүүлэхийн тулд бий болсон гэж тайлбарласан билээ. Иймд Ромд хувийн өмчийн халдашгүй эрхийг хамгаалж, өмчлөгч хуулиар хориглоогүй бүхнийг хийх эрхтэй байсан бөгөөд өмчлөгчийн эрх гагцхүү бусдын эрхийг зөрчсөн тохиолдолд буюу бусдын эрхийг хамгаалах үүднээс хязгаарлагддаг негатив болон позитив хязгаарлалт хэрэглэгдэж байжээ.

Хожмоо Ж.Локк болоод түүнийг залгамжлагчдын үзэл сэтгэлгээний үндэс болж, хамгийн их түгэн дэлгэрсэн онолын урсгал болсон өмчийн тухай хөдөлмөрийн онолын эх сурвалж энэ үеийн Ромын өмчлөх эрхийн сэтгэлгээнээс улбаатай юм. *Res nullius* буюу эзэнгүй эд юмс хэний ч өмч бус гэсэн ойлголт ямар нэгэн улс орон, хувь этгээдийн өмчлөлд хараахан ороогүй газар зэрэг нь хэний ч өмч биш юм гэсэн үндэслэгээг дэвшүүлдэг. Газар зүйн хожмын нээлтүүд болон колончлолын үед уугуул иргэдийн амьдарч байсан нутгийг европчууд ийн нэрийдэж байлаа.

Түүнчлэн *occupatio* буюу эзэнгүй эд юмсыг өөрийн өмчлөлд авах тухай эртний ромын эрх зүйн уламжлал ч хожмын өмчлөх эрхийн хөдөлмөрийн онолын үндэс мөн билээ.

Хоёр. Дундад зууны өмчлөх эрхийн сэтгэлгээ

Дундад зууны болон Сэргэн мандалтын үеийн Европын өмчлөх эрхийн харилцаа үл хөдлөх эд хөрөнгө болоод газар зэрэг бодит объект дээр төвлөрөн хөгжиж байв. Энэ үед худалдааны өсөлтийг нэмэгдүүлэх, мөнгө хүүлэх гэх мэт хуулиар хориглогдсон ашиг сонирхол бүхий гэмт хэргүүдийг таслан зогсоох, мөн төвлөрсөн эзэн хаант улсуудын

хөгжил цэцэглэлтийг өндөр түвшинд хүргэх үндсэн гурван зорилгод нийт Европ анхаарлаа хандуулсан байсан нь өмчлөх эрхийн сэтгэлгээг харьцангуй бодитой нөхцөл байдалд хандуулах шалтгаан болжээ. Цөөн тооны нөлөө бүхий сэтгэгчид өөрсдийн байр сууриа илэрхийлж байсан ч тэдгээрийн үзэл сэтгэлгээ нь дээр дурдсан гурван салбарын хүрээнд төвлөрч байв.

Дундад зууны үед Фома Аквиний (1225-1274) хэн нэг хүн нөгөөгийнхөө өмчийг хүндэтгэж ашигласнаар өмч бодит илрэлээ олно гэсэн Аристотелийн үзлийг цааш нь үргэлжлүүлсэн байна. Гэхдээ Ф.Аквиний үүнийг илүү хурц хэлбэрээр авч үзжээ. “Зөвхөн баячууд л өгөөмөр нинжин байх ёс суртахууны үүрэг хүлээгээд зогсохгүй ядуучууд ч гэсэн баячуудтай адил эрх эдэлнэ. Тэнгэрлэг бурхнаас тогтоож өгсөн төрөлхийн тушаал ёсоор угтвар нөхцөлийг авч үзвэл хүмүүсийн хэрэгцээнд зайлшгүй тусламж үзүүлэх зорилгоор л тааруухан муу зүйлсийг бий болгосон юм²⁷” гэж үзэж байлаа.

Тэрээр “Хүн төрөлхтөний хуульд үндэслэн бий болсон ямар ч өмчийн хуваарилалт нь ядуу зүдүү байдлаас үүссэн хэрэгцээ шаардлагыг давж гарч чадахгүй” гэжээ. Энэ үзэл санаа өмчийн талаарх цаашдын уламжлалыг тэр чигт нь тодорхойлсон бөгөөд Ж.Локкын “Засаглалын тухай хоёр шаштир” бүтээлд илүү өргөн хүрээгээр тусгагдсан билээ.

Дундад зууны үеийн Английн нийгмийн амьдралд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөл томоохон байр суурийг эзэлж байлаа. Баячууд, томоохон газрын эзэд болон жижиг хэмжээний газартай, хүн амын ядуу хэсгийнхний хооронд газрын төлөөх тэмцэл байнга явагдаж байсан бөгөөд түүхэнд ядуу иргэдийн газрыг булаан авах явдлыг эдлэнг

²⁷ Thomas Aquinas (1988), *Summa Theologiae* [1272], in Paul E. Sigmund (ed.) *St. Thomas Aquinas on Politics and Ethics*, New York: W.W. Norton. Page 72.

цэвэрлэх (clearing of estates) хэмээн нэрийдэж байжээ. Шотландын уулархаг нутгаар амьдардаг кельтууд клан (Америкт иргэд рүү гэнэт халдан довтолгож, эд хөрөнгийг нь дээрэмддэг байсан клан хэмээх бүлэг хүмүүс нь Англи дахь газрын дээрмийн гол төлөөлөгчдийн үргэлжлэл юм.) хэмээх нэртэй цөөнгүй овог аймгуудаас бүрдэж байсан ба тэд суурьшсан газрынхаа эзэн нь болдог бичигдээгүй уламжлалтай байв.

Тэндхийн овог аймгуудын тэргүүнийг тухайн овгийн газрын эзэн хэмээн нэрлэж заншсан байх ба Английн засгийн газар тэдний хооронд үүссэн газрын тэмцлийг шийдвэрлэх арга хэмжээ олонтаа авч цол хэргэм олгож байсан авч энэхүү цол хэргэм нь газрын дээрмийг үндсэн хэлбэрээ өөрчлөн өмчлөх эрх хэмээн нэрлэгдэхэд хүргэжээ. Ийнхүү томоохон газрын эзэд тэндхийн иргэдийг уугуул нутгаас нь зайлуулах, газрыг нь цэвэрлэх үйл ажиллагаа явуулснаар ядуу иргэдэд амьдралын эх үүсвэр болсон газар нь байхгүй болж Америкийг зорихоос өөр аргагүй болж байв. Үүнийг 1851 онд Лондонд хэвлэгдсэн Ф.В.Ньюмэны “Улс төрийн эдийн засгийн лекцүүд” номд “Английн аль нэгэн хаан мөн тийм үндэс дээр өөрийн харьяат албат нарыг тэнгис рүү хөөхийг санаархаж болох билээ²⁸” гэж бичжээ. Ийнхүү дундад зууны үед ядуусын газрыг хүчээр хураан авч, баян чинээлэг ноёдод шилжүүлэн өмчлүүлэх үйл ажиллагааг хууль батлах үйл ажиллагааны тусламжтайгаар хэрэгжүүлж байсан нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Энэ үеийн Английн эрх зүйн түүхэнд үл хөдлөх эд хөрөнгө²⁹ нь хөдлөх эд хөрөнгөөс

²⁸ F.W.Newman Lectures on Political Economy. London. [1851]. Page 132.

²⁹ Common law системт орнуудад хөдлөх эд хөрөнгийг personal property, үл хөдлөх эд хөрөнгийг real property хэмээн нэрлэдэг. Мөн хөдлөх эд хөрөнгийг chattels гэж нэрлэх нь бий. Хэл зүйн үүднээс судалбал өмчийг хэлбэрээр нь ангилсан эдгээр ойлголтууд хоорондоо ялгаатай болохыг мэдэж болох бөгөөд civil law системийн immovable

илүү чухалд тооцогдож байсан юм. Дундад зууны үед зөвхөн хөдөө аж ахуй дээр суурилсан эдийн засагтай байсан тэр үед газар бол баялаг бүтээх цөм нь байлаа. Тийм учраас үл хөдлөх эд хөрөнгийг тойрсон хууль тогтоомжууд нь хөдлөх эд хөрөнгийг зохицуулсан эрх зүйн зохицуулалтаас илүү нэгдмэл, зохион байгуулалттай хөгжсөн юм. Гэхдээ энэ тохиолдолд зарим шаардлагатай эд хөрөнгийн өмчлөл урт удаан хугацааны туршид тодорхой бус битгий байг гэсэн нийгмийн гишүүдийн эрх ашгийн тусын тулд хийгддэг “эзэмшлээр өмчлөх эрх”-ийн тухай эртний Ромын эрх зүйн зарчим алдагдсан ажээ. Өөрөөр хэлбэл түүхийн энэ цаг үед үл хөдлөх хөрөнгийн төлөөх тэмцэл хурцадсан нь эртний Ромын хуульч Гайн баталгаажуулсан “*Bono publico usucapio introducta est, ne silicet quarundum rerum dui et fere semper incerta dominia essent*” буюу удаан хугацаанд эзэмшсэн газар нутаг дээр өмчлөх эрх нэмэх гэсэн зарчмыг зөрчсөн үйл явдал болсныг ажиглаж болно.

XV зууны үеийн Английн нийгэмд жижиг хэмжээний газрын өмчтөн орчин үеийг бодвол хүн амын нэлээд хэсгийг эзэлж байлаа. Гэр бүлийнхэнтэйгээ нийлээд нийт хүн амын 1/7-ээс илүү хувийг эзэлж байсан 160 мянгаас доошгүй өмчтөний газрын бүрэн чөлөөт өмч³⁰ (Freehold гэсэн нэр томъёоор

property, real estate гэсэн ойлголтууд нь common law-ийн real property буюу зарим тохиолдолд realty, монголоор бүгд үл хөдлөх эд хөрөнгө гэсэн томъёололтой нэг утга агуулдаг. Зарим эрдэмтэд real property болон personal property хоёрыг нэршлийн шинж байдлаар харьцуулах оролдлого хийдэг боловч үнэн хэрэгтээ эдгээр нь ямар нэгэн учир холбогдолгүй ажээ. Өөрөөр хэлбэл real property-г personal property-гээс илүү “real” буюу жинхэнэ гэж үздэггүй гэсэн үг. Феодалын нийгмийн үед үл хөдлөх эд хөрөнгө буюу газар нь зөвхөн эзэн хааны өмч байсан ба real estate буюу үл хөдлөх эд хөрөнгө гэсэн ойлголт royal estate буюу хааны өмч гэсэн үгний шууд утга юм. Энэ нь франц хэлтэн Нормандчууд энэ хэллэгийг англид оруулж ирснээс үүдэлтэй бөгөөд real гэсэн англи хэлний энэ үг испанийн real буюу эзэн хаан гэсэн үгтэй ижил ажээ. Харин Civil law системд хөдлөх эд хөрөнгийг movable property, үл хөдлөх эд хөрөнгийг immovable property хэмээн нэрлэдэг.

³⁰ Thomas Babington Macalay The History of England [1685], Philadelphia. Volume 1.

Томас Бэбингтон Макалай “Английн түүх” бүтээлдээ хэрэглэжээ.) нь тухайн үеийн англичуудын өмчлөлийн гол хэлбэр байсан билээ. Эдгээр жижиг газрын өмчтөнүүдийн газраа боловсруулж олдог байсан дундаж орлогыг 60-70 фунт стерлинг байсан гэжээ. Ийнхүү өөрийн газрыг боловсруулдаг иргэдийн тоо бусдын газрыг түрээсэлдэг иргэдийнхээс хавьгүй олон байсан тухай мэдээ байдаг.

Гурав. Орчин үеийн өмчлөх эрхийн сэтгэлгээ

Энэ үед сэтгэгчид, онолчид жам ёсны эрхийн болон нийгмийн гэрээний онол, эрх чөлөө, шударга ёсны тухай үзэл санаанд тулгуурласан номлол, эрхийн сэтгэлгээг хөгжүүлж, хувийн өмчийн хууль ёсны байдлыг түүний мөн чанартай хэрхэн уялдуулах, яагаад өмчлөх эрх нь эрх чөлөөний илрэн гарах жам ёсны бөгөөд зайлшгүй хэлбэр болох талаар олон өнцгөөс нь судлан үзэж, үзэл санаагаа дэвшүүлжээ.

Өмч нь нийгмийн байгууллын ерөнхий үндэс суурийг бүрдүүлдэг гэх үзлийг Т.Хоббс (1588-1679) анхлан гаргаж тавьсан юм. Тодруулбал, тэр өмчийг улс төрийн философийн түлхүүр гэж үзэж байв. Т.Хоббс “Юуны өмнө хүн хэзээнээс эхлэн ямар нэг эд хөрөнгийг өөр хэн нэгнийх биш, миний өөрийн юм гэж нэрлэх болсон юм бол?”³¹ гэсэн асуултад хариулах хэрэгтэй гэжээ. Хувийн өмч төдийгүй эрх зүйт ёсны тухай асуудлыг нийгмийн зүй зохистой зохион байгуулалттай уялдаа холбоонд тайлбарлаж, уг чанарыг нь төртэй холбож үзэх тухайд Т.Хоббс бичихдээ: “Төрөлхөөс минийх, чинийх гэсэн ойлголт байх ёсгүй, харин өмч гэдгийг тусгаар тогтносон төрийн бий

³¹ Thomas Hobbes (1983), *De Cive: The English Version* [1647], Howard Warrender (ed.), Oxford: Clarendon Press. Pp 26-7.

болгосон бүтээл гэж ойлговол зохино³² гэжээ.

Т.Хоббс иргэн төр хоёрын харилцааг авч үзэхдээ төрийн хэрэгжүүлэх үндсэн бүрэн эрхийн хүрээнд өмчийн харилцааг зохицуулсан хуультай болох асуудлыг чухалд тавьж байсан бөгөөд энэ эрхийг хамгаалах субъект нь төр болохыг тодотгож байлаа. Өөрөөр хэлбэл төр нь иргэдийнхээ төлөө ажиллах, иргэд нь төрийн хамгаалалтан дор өмчлөх эрхээ жинхэнэ утгаар хэрэгжүүлэх тухайд өөрийн үзлээ тайлбарлаж байв. Тэр өмчийг ямарваа улс төрийн шийдвэр, эсвэл гэрээ хэлэлцээргүйгээр төрөөс баталгаажуулж болно гэсэн үзэлдээ үнэнч байлаа.

Т.Хоббс “хүн бүрт өөрийнх нь өмчийг эзэмшүүлье” гэж уриалсан ба хамгийн гол нь хаант засаглалтай улсад тэрхүү эрхийг эдлүүлэгч хүчирхэг эрх мэдэл оршин байх ёстой, энэ нь жинхэнэ утгаар иргэдийн өмчийг хамгаалан бэхжүүлж чадна гэж үзэж байв. Төрийн эрх мэдэл их байх тусам өмч тэр хэмжээгээр иргэдэд хамаарна гэж тэр бичжээ.

Т.Хоббстой нэгэн үед үзэл номлолоо түгээн дэлгэрүүлж байсан сэтгэгч Жэймс Харрингтон (1611-1677) өмч нь жам ёсны зүйл, гэхдээ зайлшгүй шинжтэй биш гэж үзэж байв.

Ж.Харрингтон бол анхны улс төрийн онолчдын нэг юм. Тэр улс төрийн эрх мэдэл өмчийн хуваарилалтын үр дүнд үүсдэг болохоос бус, түүний учир шалтгаан, уг үндэс нь биш юм гэж Т.Хоббсын үзлийг шүүмжилжээ. Тодруулбал, өмч болон төрийн хоорондын харилцааны шийдвэрлэгч нөхцөл шалтгааныг Т.Хоббсынхоос эрс ялгаатай, сөргүүлэн авч үзсэн байна. Тэрээр өөрийн санааг тайлбарлахдаа, “Хэрэв төрөөс өмчийн хуваарилалтыг хийдэг тогтолцоо орших

боломж байдаг гэж үзвэл хамгийн багаар бодоход жирийн иргэд тухайн улсын эд баялгийн тэн хагасыг, харин үлдсэн хэсгийг хаан, язгууртан, баячууд өмчилж болох юм. Харин хамгийн зохистой хувилбар буюу тогтвортой улс гүрэнд бол бүх эд баялгийг зөвхөн жирийн иргэд өмчлөх ёстой³³ гэжээ. Хожим түүний үзэл номлолыг Америкийн хувьсгалч Жон Адамс (1797-1801 онуудад АНУ-ын хоёр дахь ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.) цааш нь хөгжүүлж, сурталчилсан билээ.

Харин хаант засаглалыг хөхиүлэн дэмжигч, “хааны эрх мэдэл бол тэнгэрийн эрх мэдэл юм” гэж тайлбарлаж, энэ эрх мэдлийн эх үндсийг хүний өвөг эцэг Адамаас эхтэй хэмээн сурталчилж байсан Английн улс төрийн онолч Роберт Филмер (1588-1653) Т.Хоббсын үзэл баримтлалыг дэмжиж, түүнтэй адил дүгнэлт хийсэн байдаг. Хаант засаглал бол нэг ёсондоо эцгийн эрхэт ёстой адилхан бөгөөд тэнд хүүхдүүд байх нь дамжиггүй. Эдгээр хүүхдүүд нь дуулгавартай, бас зарим нь сахилгагүй байж болно. Өмчлөх эрх бол өрх гэрийн эд хөрөнгө гэсэн үг бөгөөд аав нь тэрхүү баялгаар өөрийн үр хүүхдүүдийг тэтгэж болно³⁴ гэж тайлбарлажээ.

Эдгээр сэтгэгчдээс ялгаатай нь хүний эрх, эрх чөлөөний салшгүй нэг хэсэг гэдэг утгаар нь өмчид хандаж, түүнийг жам ёсны эрхийн онолын үүднээс тайлбарласан эрх зүйн онолч бол Ж.Локк (1632-1704) юм. Нөгөөтэйгүүр эрх чөлөөний номлолд

³³ James Harrington (1977) *The Commonwealth of Oceana* [1656], John Hopkins University, Baltimore.. Para 73. James Cotton (1991) *James Harrington's Political Thought and its Context*. New York: Garland Pub.

³⁴ Robert Filmer *Observations concerning the Original of Government upon Mr Hobbes's Leviathan, Mr Milton against Salmasius, and H. Grotius' De jure belli ac pacis*, [1652]. Английн улс төрийн онолч Р.Филмерын (1588-1653) *Freeholders Grand Inquest touching our Sovereign Lord the King and his Parliament* (1648), *Anarchy of a Limited and Mixed Monarchy* (1648), *King of England* (1648), *Patriarcha, or the Natural Power of Kings* (1680) зэрэг бүтээлүүд нь хэвлэгджээ.

³² Мөн тэнд.

тулгуурласан үзэл санааны онцлог нь Ж.Локк өөрийн үзэл баримталыг хэрхэн боловсруулсан, хаанаас эх үндэс аван судалсны үр дүн юм. Учир нь тэрээр өөрийн үзэл баримтлалын эхлэлийг бурхан дэлхий ертөнцийг хүмүүст нийтэд нь өгсөн гэсэн тайлбараас эхэлсэн ба хүн төрөлхтөн нийтийн тэгш байдлаас хувь тэнцүү биш тэрхүү нийгэмд яагаад шилжсэн, мөн өмчийн хуваарилалтын ялгаатай ертөнцөд хувийн өмч хэрхэн оршин тогтнох тухайд гол анхаарлаа хандуулжээ.

Тэрээр хязгаарлаж болдог зарим эрхүүдээс өмчлөх эрхийг тусгаарлаж, хязгаарлаж болдоггүй эрхүүдтэй нэгтгэх зоригтой алхам хийжээ. Өөрөөр хэлбэл, өмчлөх эрх нь амьд явах эрхтэй нэгэн адил үндсэн эрх болж бичигдэх ёстой гэж үзсэн юм. Яагаад энэхүү эрхийг ийнхүү үндсэн эрх байх ёстой гэж тэрээр хамгаалж байсан тухайд олон талаас нь тайлбарлаж болно. Ж.Локк хувийн өмчийн талаар төрийн эдэлж буй эрхийг эрс багасгахыг хүссэн³⁵ байх магадлалтай. Т.Хоббс өмчлөх эрхийг төрөөс олгоно, төр юуг чинийх гэж хэлнэ тэр нь л чинийх байна. Төр өгсөн юмаа буцаагаад авч ч болно гэж тайлбарласан бол Ж.Локк өмчлөх эрхийг төрөөс хүндэтгэх ёстой хүний үндсэн эрх гэж үзсэн юм.

Энэ үеийн ихэнх сэтгэгчид өмчийн харилцаанд үүссэн төрөл бүрийн хүндрэлийг хэрхэн давж туулах тухайд өөр өөрсдийн онолыг дэвшүүлж байсан бол Ж.Локк дээрх хүндрэлийг шийдвэрлэх арга замыг тайлбарлахдаа ямар нэг онол, догма дээр тулгуурлалгүйгээр өөрийн туурвисан өмчийн тухай бүтээлдээ аль нэг талын хөрөнгө оруулалтын (өмчийн хуваарилалтын) хууль ёсны байдлыг ёс суртахууны үүднээс хамгаалахыг урьтал болгосноороо шинэлэг бөгөөд онцлог ажээ.

Түүний “Засаглалын тухай хоёр шаштир” бүтээлд “Бурхан дэлхий ертөнцийг нийт хүн төрөлхтөнд өгсөн төдийгүй тэдэнд дэлхийг өөрсдийн хамгийн сайн сайхнаар амьдрахад зориулан ашиглах шалтгаан нөхцлүүдийг нь ч бүрдүүлж өгсөн юм. Дэлхий ертөнц болон түүн дээр оршин буй бүх зүйлс хүнийг тохь тухтай амьдрахад зориулагдсан билээ. Хүний идэж хооллодог жимс, ургамал, мал амьтан бүгд л байгалиас өөрөө аяндаа бий болсон зүйлс тул эдгээр нь бүхэлдээ хүн төрөлхтөнд шууд хамаардаг бөгөөд үндсэндээ хэн ч тусгайлж, давамгайлсан эрхийг эдэлдэггүй юм. Эдгээр баялаг бүх хүний ашиг тусын тулд оршиж байдаг. Иймээс эхэн үед эдгээр баялаг бүх хүмүүст харьяалагдаж байгаа тул загас, шувуу, жимс зэрэг нь тэдгээрийг олж авч, ашиглаж чадсан хэн бүхний өмч болно.³⁶” гэсэн байдаг. Ж.Локкийн үзлээр бол хэн ч анхнаасаа ямар нэг зүйлийг өмчилж төрөөгүй. Бурхан ч дэлхий ертөнцийн аль нэг хэсгийг хүн төрөлхтний аль нэг бүлэгт оноож өгөөгүй ажээ. Гэвч байгалийн баялаг нь бүх хүний тусын тулд оршдог учраас түүнийг шууд хувийн өмчөө болгох боломжгүй юм. Нэг алим байлаа гэж төсөөлвөл түүнийг ашиглахын тулд тодорхой нэг хүн түүнийг хазах хэрэгтэй. Ингэж хазаж байж л тэр алим тухайн хүний хувийн өмч болно гэж Ж.Локк тайлбарлаж байв.

Ж.Локк “...Бүх хүнд нийтлэгээр заяасан дэлхий ертөнц дээр хүн бүр өөрийн гэсэн өмчтэй байдаг. Хэн ч өөрөөсөө гадна хэн нэгэн рүү чиглэсэн эрх эдлэхгүй. Хүний бие махбодироо бүтээсэн хөдөлмөр, гараараа хийж буй ажил зэргийг түүний өмч гэж ойлгож болно. Ямар нэг объектод хөдөлмөрөө шингээж, түүндээ өөрийн ажил хөдөлмөрийн үр дүнг нэгтгэсэн тохиолдолд

³⁵ John Constable (1996), *Theory of Property*. Para 1. Seymour 244, MWF 11-12; TTh 3:30-5

³⁶ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 26.

тэр зүйл тухайн хүний өмч болно.³⁷” гэжээ.

Ж.Локкийн дээрх үзэл нь анхлан эзэмших онол (first occupancy theory)-ын бүтцийг хөдөлмөрийн ёс суртахууны ач холбогдлын тухай үзэлтэй холбон тайлбарлахад оршиж байлаа. “...Ийнхүү тухайн зүйлд хүн хөдөлмөрөө шингээж өөрийн болгосноор байгалиас нийт хүн төрөлхтөнд өгсөн баялгаас уг зүйлийг өөрийн болгон салган авч, дээрх зүйлд хөдөлмөр нь шингэсэнээр уг зүйлийн хувьд бүх хүн бус гагцхүү хөдөлмөрөө зарцуулсан этгээд өмчлөх эрхтэй болдог. ...Бусад хүмүүст хангалттай эд баялаг үлдсэн бол тэр этгээд өөрийн өмч болсон зүйлийн хувьд бүрэн эрх эдэлнэ.³⁸” гэжээ.

Ж.Локкийн тодорхойлсноор хүний хөрөнгөжих үе гэдэг бол уг хүн өөрийн хөдөлмөрийг байгалийн бүтээгдэхүүнд шингээж байгаа цаг мөч, тухайлбал, ухаж малтаж, барьж авч, түүж цуглуулж байгаа үйлдлүүд ажээ. Энэ мөчид уг байгалийн бүтээгдэхүүнд тухайн этгээдийн хөдөлмөр бүрмөсөн шингэх бөгөөд ингэсэнээр бусад хүмүүс уг зүйлийн хувьд ямарваа эрх эдлэх боломжгүй болдог гэж тэр үзсэн юм.

Байгалийн бүтээгдэхүүн буюу жимс, ургамал, амьтан зэрэг нь нийт хүн төрөлхтөнд харьяалагддаг хэдий ч хэн нэг хүн тэр баялгаас авч, өмчөө болгохын тулд бусдаас зөвшөөрөл авах хэрэг гарах ба бодит нөхцөлд ийм боломж хомс байдаг. Ж.Локк үүнийг тайлбарлахдаа “...Тэгвэл тэр хүн хэдэн алим юм уу, боргоцойг өөрийн болгохдоо бүхий л хүн төрөлхтөнөөс зөвшөөрөл аваагүй учраас тэдгээр жимс, ургамлыг эзэмших ямар ч эрхгүй хэрэг үү? Бүх нийтэд харьяалагдах баялгаас өөртөө

авсныг нь дээрэм гэж үзэх үү? Хэрэв ийм зөвшөөрөл авах зайлшгүй шаардлагатай юм бол Бурхан түүнд хангалттай их баялаг заяаж өгсөн ч ялгаагүй тэр өлбөрч үхэх болно.³⁹” гэжээ. Өөрийн үндэслэгээ, нотолгоогоо бодит нөхцөл байдалд хэрхэн биелэх боломжийг нь судалж үзсэний дараа тэр “Тиймээс хэдийгээр бүх хүнд заяасан боловч өөрийн хөдөлмөрөө зарцуулан олж авсан гэдэг утгаараа буга алсан индиан ч гэсэн дээрх бугыг өөрийн болгохыг бусад нь зөвшөөрдөг.⁴⁰” гэсэн байна.

Харин бусад сэтгэгчид, тухайлбал Сэмуэл Пуфендорф “байгалийн баялгийг, жишээ нь, хэсэг газрыг бусдаас өмнө амжиж ашигласан хүн уг объектыг эзэмшихийн тулд хэн нэгнийг уг газраас хөөн зайлуулах хэрэг гарахгүй⁴¹” бөгөөд үүний үндсэн дээр анхлан эзэмших онол хэрэгжинэ гэж тайлбарлажээ. С.Пуфендорфын энэ үзэл бодол нь хүн аливаа объектыг хэрхэн, яаж эзэмших эрхтэй болсон, түүнийгээ ямар хэлбэрээр ашиглаж байгаа зэрэг нь онцын ач холбогдолгүй бөгөөд харин тухайн объектыг эзэмшиж, өмчлөхийн тулд өөр хэн нэгний эзэмших, өмчлөх эрхэд халдаагүй байх явдал чухал юм гэсэн тайлбарт үндэслэж байна.

Хэдийгээр Ж.Локкийн дэвшүүлсэн ёс суртахуун, хөдөлмөрийн хоорондын харилцан хамаарлын зарчим нь С.Пуфендорфын тайлбарласан үзэл санааны логик учир шалтгаантай төсөөтэй боловч түүний хувьд хүн объектыг (газрыг) эзэмшиж, өмчлөхдөө түүнийг боловсруулах, нөхөн сэргээх, эсвэл бусад үр ашигтай байдлаар ашиглаж болдог тул тухайн

³⁷ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 27.

³⁸ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 27.

³⁹ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 28.

⁴⁰ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 30.

⁴¹ Samuel Pufendorf (1991), *On the Duty of Man and Citizen According to Natural Law* [1673], Jame Tully (ed.), Cambridge: Cambridge University Press. Page 84.

объектыг анх өмчлөхдөө түүнийг ямар арга замаар, хэрхэн олж авсан байдал нь басхүү ач холбогдолтой гэж үзэж байсан юм. Энэ учир шалтгааны улмаас тухайн газар нутгийн уугуул иргэд, эсвэл нүүдэлчин ардууд хэрэн хэсүүчилсэн, малаа бэлчээрлүүлсэн, орон байраа төвхнүүлсэн тэр газар нутгийнхаа өмчлөгч, эсвэл эзэмшигч болно хэмээн Ж.Локк тайлбарласан байна.

Түүнчлэн хамгийн чухал нь Ж.Локк хөдөлмөрийн үндсэн дээр өмчлөх эрх бий болно гэдгийг хүн бие махбодь, оюун санаагаа төрсөн цагаасаа эхлэн өөрөө өмчлөх явдалтай салшгүй холбоотой зүйл гэсэн юм. Өөрөөр хэлбэл, хүн өөрийгөө анхнаас өмчилсөн байх нь өөрийн хөдөлмөрийг эзэмших, улмаар өмчтэй болох явдалтай учир зүйн холбоотой гэж үзжээ. Үүний үр дүнд анхлан эзэмших онолтой холбогдон үүсч болох зарим нэг бэрхшээл, үл ойлгогдох асуудлыг шийдвэрлэх, түүнд хариулт өгөхөд хөдөлмөрийн үр шимийн тухай ойлголт тусална гэж үзсэн нь энэ үеийн өмчлөх эрхийн сэтгэлгээг хөгжүүлэгчид дотор тэргүүлэх байр суурь эзлэх онолч нь Ж.Локк мөн гэдгийг нотолдог юм.

Ж.Локкийн өмчлөх эрхийн сэтгэлгээний агуулгад ёс суртахууны төдийгүй эдийн засгийн шинжлэх ухааны эргэцүүлэл бодитой байр суурь эзэлж байжээ. Хэдийгээр эд баялгийг бусдаас түрүүлж эзэмшихдээ өөр хэн нэгний өмчлөх эрхэд халдаагүй боловч тухайн этгээдийн ийнхүү эд баялаг өмчилж буй явдал нь цаашдаа бусад иргэдийн нийтлэг ашиг сонирхолд хохирол учруулах магадлалтай байж болно. Энэ нь нөөц баялгийн хязгаарлагдмал байдал, түүний нөхөн сэргээгдэх цаг хугацаа зэрэг асуудал юм хэмээн бичжээ.

Хэрвээ ийнхүү ашиг сонирхолд нь хохирол учирсан хүмүүс байхгүй бол “нийтэд зориулсан хангалттай бөгөөд хүрэлцэхүйц

эд баялаг үлдсэн⁴²” гэдэгт итгэлтэй байж болох ба үүндээ сэтгэл ханамжтай байж болно хэмээн Ж.Локк үзжээ. Дээрх асуултад өгсөн Ж.Локкийн тайлбар энгийн бөгөөд үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийн үр дүнд нийгэмд оршин буй бусад иргэнд зориулагдсан бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэнэ гэдгийг тэмдэглэхэд оршиж байлаа.

Бүх нийтэд зориулагдсан баялгаас хүн бүр өөрийн амьдралыг залгуулахаар авах эрхтэй байдаг ч гэсэн юуг авч болох, юуг авч болохгүй байх талаар тодорхой хязгаарлалт түүний бүтээлүүдэд тусгагдсан байдаг. Хүн өөрийн хэрэгцээнийхээ хэрээр баялгаас авах эрхтэй байдаг ч эд баялгаас муудаж гэмтэхээр ихийг авч болохгүй. Хэрэв өөрийнхөө хэрэглэж чадахаас илүүг автал тэр зүйл нь муудчих юм бол хулгай хийсэнтэй адил юм. Тэрээр хэний ч ашиг тусыг бодохгүй, хүн төрөлхтнийг ядууруулах зүйл хийсэн гэсэн үг гэж цохон тэмдэглэжээ. “Хүн хэдий чинээ ихийг амьдралдаа ашиглаж чадна, төдий чинээ хөдөлмөрөө шингээж өөрийн болгодог. Түүний ашиглаж, хэрэглэж чадахаас цааш байгаа эд баялаг бусдад харьяалагддаг. Бурхан юуг ч эвдэлж, сүйтгэж, муутгаж гэмтээлгэхийн тулд бүтээгээгүй юм. Дэлхий дээр байгалийн нөөц баялаг урт удаан хугацааны турш хангалттай ихээр оршин байтал хэдхэн үрэлгэн хүн, тэр дундаа ганц нэг хүн зөвхөн өөрийнхөө хэрэгцээг бодож, нөөц баялгийг өөрт хадгалж, бусдад хор хохирол учруулж байгаа цагт өмчийн тухай хэрүүл тэмцэл үүсэх нь гарцаагүй.⁴³” гэсэн байна.

Ж.Локкийн үзсэнээр түүхийн эхэн үед буюу байгалийн баялаг хангалттай их

⁴² John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 27.

⁴³ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 31.

бөгөөд дэлхий дээр цөөн хүмүүс амьдарч байсан тэр цаг хугацаанд хэрүүл тэмцэл бага гарч байсан. Хэрүүл маргаан хэзээд үүссэн бэ гэвэл дэлхий өөрөө өмч хөрөнгийн зүйл болсон тэр цагаас өмчийн талаар маргалдаж эхэлсэн ажээ. Үнэндээ дэлхийн аль ч газрыг тэмдэглэж аваад түүнийг хөрс шороог боловсруулна гэдэг хэн бүхний эрх юм. Ингэсэн тохиолдолд тэр газрыг боловсруулж өөрийн хөдөлмөрөө уг газарт шингээсэн тул өмч хөрөнгө болгож авч болно гэсэн үг билээ.

Түүний хувьд газар өмчлөлийг зөвтгөх нь тусдаа асуудал байжээ. Газар бол тогтвортой байнгын зүйл бөгөөд илүү томоохон хэмжээний өмчлөлийн асуудал яригдаж байдаг.

Цаашлаад Ж.Локкийн амьдарч байсан тэр цаг хугацаанд мөнгө хэмээх арилжааны хэрэгсэл эдийн засгийн харилцааг өөрчилжээ. Мөнгө бий болохоос өмнө хэн ч өөрийгөө болон гэр бүлээ тэжээхэд хангалттай хүрэлцэхүйц хэмжээнээс илүү газартай болохыг хичээдэггүй байв. Хэрэгцээнээсээ илүү гарах зүйлийг олж авахын тулд хөдөлмөрлөнө гэдэг нь учир утгагүй зүйлийн нэг гэгдэж байлаа. Мөн тухайн үед Европ төдийгүй дэлхийн хүн ам харьцангуй бага байв. Харин мөнгө бий болсноор энэ байдал өөрчлөгдөж, өөрийн хэрэгцээнээс илүү гарсан эд баялгийг цуглуулж байсан ба ямар нэгэн хязгаарлалт байсангүй. Ногоо, тарваснаас ялгаатай нь мөнгийг цаашид хадгалахад муудна гэсэн ойлголт байхгүй байв.

Түүнчлэн Ж.Локк “Хэрэв чи амьдралдаа эзэн нь юм бол өмч хөрөнгө ч гэсэн чинийх байх ёстой бөгөөд энэхүү өмч хөрөнгө чинь бусадтай харилцан солилцоонд орж, арилжаалагдаж чаддаг байх ёстой” гэж түүний эдийн засгийн холбогдлыг тайлбарласныг дурдах хэрэгтэй.

Ж.Локкийн үеийн Англи орны нийгэм, эдийн засгийн байдал түүний өмчлөх эрхийн сэтгэлгээний үзэл санаатай салшгүй холбоотой бөгөөд ёс суртахуун, эдийн засаг, хөдөлмөрийн харилцааны шалтгаант холбоонд авч үзсэн үзэл баримтлал нь тухайн үеийн Английн эрх зүйн болон төрийн байгуулалтын практикт гарсан өөрчлөлт зэрэгтэй уялдан илүү төгөлдөржиж, утга агуулгын хувьд хүний эрх, эрх чөлөө, жам ёсны эрхийн онолтой уялдан улам бүр боловсорсоор иржээ. Энэ бүхний үр дүнд эрх чөлөөний үзэл санааг өмчлөх эрхтэй холбон тайлбарласан түүний сонгодог онол бүрэлдсэн байна.

Тэрээр юуны өмнө төрийн зохион байгуулалтын учир шалтгаан, улс гүрэн бүрэлдэн бий болох зүй тогтлын талаар тайлбарлахыг зорьжээ. Ж.Локк хүмүүс нийгэмд нэгддэгийн гол шалтгаан нь хувийн өмчийг зөвхөн тэнд хамгаалдаг л оршино гэж үзэж байв.

Ж.Локк хүн бүрт оногдох өмч хөрөнгийг өмчлөх тухай жам ёсны эрхийн шаардлагыг хамгаалж, хувийн өмчийн эрх чөлөө бол хүний нийгмийн эрх чөлөөний үндэс мөн хэмээгээд аливаа хүн эрх чөлөөтэй байхыг хүсч байвал хувийн өмчтэй байх хэрэгтэйг зөвлөжээ.

Өмч бол хүнд байгаа бүх зүйл, тухайлбал эд хөрөнгө төдийгүй амь нас, эрүүл мэнд, алдар хүнд, гэх мэт хуульчилсан эрхүүд юм гэж тэр үзсэн байна. Тодруулбал, Ж.Локк хувийн өмч бол хүний мөн чанарын илэрхийлэл бөгөөд хүн жам ёсны, байгалийн хуулийн дагуу өөрийн өмчөө хамгаалах эрхтэй. Гэхдээ хувийн өмч бол хүний эрхэм дээд, мөнхийн зорилго бус харин хүний амьдралын зорилгыг хангах үүрэгтэй хэрэгсэл, түүнд үйлчлэх хамгийн чухал хөшүүрэг мөн гэж нотлохыг хичээсэн юм.

“Хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээ, зарчмууд нь аяндаа, аажмаар бүрэлдэж тогтсон гэдгийг өмчийн харилцааны түүхэн хөгжлийн замналыг хараад хэн ч ойлгох билээ. Төрийн үүсэл, хөгжил, хувьслын үйл явц түүнээс өмнө бүрэлдсэн тэрхүү харилцааны хэм хэмжээг өөрчлөөгүй, харин тэднийг хожим төр хуульчилж, баталгаажуулж өгсөн нь түүхэн үнэн юм. Иймээс төр нь хүний эрх, эрх чөлөө, өмчийг хамгаалагч юм.” гэж Ж.Локк үзэж байлаа. Түүнийхээр, хувийн өмч нь иргэний эрх чөлөөний үндэс, иргэний нийгмийн тулгын чулуу мөн. Бие хүний амьдрах, орших энэхүү үндсийг хамгаалах нь төрийн оршихуйн эхлэл⁴⁴ ажээ.

Ж.Локк төр, нийгмийн зохион байгуулалт нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, түүнийг хангах зорилгод үндэслэдэг хэмээн номлосныг доорх тайлбараас нь харж болох юм. Тэрээр “Хүн бүр өөрийн шинж чанараар эрх чөлөөтэй бөгөөд тухайн хүн өөрөө л зөвшөөрөөгүй тохиолдолд түүнийг өөр хэн ч, юу ч энэ газар дээрх аливаа эрх мэдлийн захиргаанд оруулж чадахгүй юм. Хүнийг аль нэг төрийн харьяалалд оруулж чадах өөрийнх нь зөвшөөрлийн хангалттай илэрхийлэл гэж юуг тооцож болохыг зайлшгүй авч үзэх ёстой. Ерөнхийдөө энэ нь хурц илэрхийлсэн мэдэгдэл ба дуугүйхэн толгой дохисон зөвшөөрөл гэсэн хоёр янз байна гэж үздэг. Аль нэг нийгэмд элсэн орж байгаа ямар нэг хүний бодитой гаргаж илэрхийлсэн зөвшөөрөл л түүнийг энэ нийгмийн жинхэнэ гишүүн, төрийн харьяат болгож чадна гэдэгт хэн ч эргэлзэхгүй биз... Үүнийг сайн ойлгохын тулд хүн бүхэн аль нэгэн нийгэмлэгт орох, эсвэл түүнд нэгдэхдээ өөр төр улсад өөр хүнд хамаагүй, зөвхөн өөрөө л олж авсан тэр зүйлүүдээ бас өөртэйгээ хамт

нийлүүлэн өгдөг. Хэн нэгэн өмчийг хамгаалж зохицуулахын тулд бусад хүмүүстэй хамт нийгэмд элсчихээд тэр нийгмийн хуулиар зохицуулагдах ёстой өөрийн хувийн өмч, өөрийн газар нь харьяат нь болж байгаа төрийнх нь хуулийн гадна байна гэж бодох аваас шууд эсрэг зүйл болно биз. Тэгэхээр аливаа хүн өмнө нь эрх чөлөөтэй байсан бие махбодоо төр улсад нэгтгэж байгаа тэр баримтаар л мөн энэ хүртэл чөлөөтэй байсан эзэмшлээ тэр төрд нэгтгэн тушаадаг байна. Тухайн хүн ба түүний эзэмшил хөрөнгө хоёр тэрхүү төрийн эрх мэдэл, засгийн газарт харьяалагдах болно. Өвлөж болон худалдаж авсан ямар боловч тэр газартайгаа хамт тэр төрийн хууль тогтоомжийг бас хүлээн авч байгаа хэрэг юм. Гэтэл төр нь зөвхөн газар дээр нь шууд хуулийн эрхтэй бөгөөд энэ нь түүгээр дамжин эзэнд нь хамаардаг тул уг хүн төрд захирагдах нь тэр газар дээр амьдарч, түүнийг ашиглаж байгаа үед л хүчинтэй байна. Тэгэхээр төрд дуугүй зөвшөөрлөөс өөр юу ч өгөөгүй өмчлөгч нь уг өмчөөсөө худалдах, бэлэглэх зэрэг ямар нэгэн аргаар салсан хүн өөр тийшээ явж, өөр ямар ч төр улсад нэгдэх болон дэлхий ертөнцийн аль ч өнцөг булангаас хэний ч биш чөлөөтэй газар олж аваад бусадтай хамт шинэ нийгэм байгуулах гэрээ байгуулах зэрэг нь чөлөөтэй болох юм.⁴⁵ гэжээ.

Ж.Локкийн энэ санааг тайлбарлавал, хүн зөвхөн байгалийн хуульд захирагдаж, түүнийг хамгаалах, энэхүү хуулийн шаардлагыг жам ёсны байдалд хэрэгжүүлэх нь хувийн өмчийн халдашгүй дархан байдлыг бэхжүүлэхэд хангалтгүй юм. Иймээс энэ бүхнийг даван туулах арга зам нь төрийг бүрдүүлэх тухай нийгмийн гэрээнд хүргэж байдаг. Гэрээний үндсэн дээр бүрэлдсэн төрийн эрхэм зорилго нь хүн бүрийн шударга

⁴⁴ Н.Лундэндорж Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага.

⁴⁵ John Locke (1988), *Two Treatises of Government* [1689] Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press. Para 35.

хөдөлмөрөөрөө олж авсан өмчлөх эрх, эрх чөлөөг хамгаалах явдал гэж ойлгож болно.

Жан Жак Руссо (1712-1778) нийгмийн гэрээний онолыг үндэслэгчдийн нэг болохын хувьд Ж.Локкийн дэвшүүлсэн санааг “холбооны гишүүн хүн бүрийн болон тэдний өмч хөрөнгийг бүх нийтийн чармайлтаар хаацайлан хамгаалдаг тийм холбооны хэлбэрийг байгуулах явдал” хэмээн тодорхойлжээ. Тэр хувийн өмчийг үгүйсгээгүй ч иргэдийн эд хөрөнгийн байдал харьцангуй тэгш байх ёстой гэж үзэж байсан бөгөөд энэ байр сууринаас тансаг, элбэг хангалуун байдал, баян ядуугийн хэт ялгарлыг шүүмжилж байсан юм. Нэг иргэн нөгөөгөө худалдаж авах бололцоо бүхий өмч хөрөнгөтэй байж болохгүй ба нэг ч иргэн өөрийгөө худалдахад хүрэх ядуу байж болохгүй гэж Ж.Ж.Руссо үзэж байлаа. Ердийн тэгш байдалд харшилсан хувийн өмч, нийгмийн тэгш бус байдал бий болсноос ядуучууд болон баячуудын хооронд тэмцэл эхэлдэг. Үүн дээр улс төрийн тэгш бус байдал нэмэгдэх юм бол дарангуйллын үеийн туйлын тэгш бус байдалд хүргэдэг гэжээ.

1760-аад онд Английн эрх зүйн тогтолцоог журамлах оролдлого хийсэн Уильям Блэкстоуны (1723-1780) өмчлөх эрхийн сэтгэлгээ өөрийн онцлогтой. “Английн эрх зүйн тухай тайлбарууд”⁴⁶ номдоо тэрээр “субъектын хүсэл зоригийг ямар нэгэн учир шалтгаангүйгээр хязгаарлах явдлыг хаад, язгууртан, эсвэл парламентын зүгээс хийсэн тохиолдолд энэ бүхэн нь дарангуйллын нэг хэмжүүр болно” хэмээн тайлбарлаад “энэ дарангуйллыг сөрөн зогсох, түүнээс сэргийлэх арга нь өмчлөх эрх байх болно” гэжээ. Үүнийг жишээн дээр тайлбарлахдаа “Газар өмчлөгч нь үдшийн

бүрийгээс үүрийн гэгээ хүртэл өөрийнх өмчийн газар руу нэвтэрсэн үл таних ямар ч этгээдийг хөнөөх эрхтэй. Хэрэв хааны туслах ийнхүү харанхуйд явж байгаад алуулбал хэн ч газар өмчлөгчийг буруутгах ёсгүй. Учир нь тийм харанхуй шөнө түүнийг хааны туслах мөн эсэхийг хэн таньж чадах билээ” гэсэн байдаг. Түүний энэхүү үзэл нь өмчлөгч этгээд гадны ямар нэгэн халдлагаас өөрийн өмчийг хамгаалах эрх чөлөөтэй байх ёстой гэсэн амин чухал үзэл санааг үндэслэхэд чухал үр нөлөө үзүүлсэн юм.

Энэ үеийн сэтгэгчид дотор өмчлөх эрх, хувийн өмчийн тухайд илүү философи сэтгэлгээний үүднээс хандаж, үзэл бодлоо дэвшүүлж байсан онолч бол Дэвид Юм (1711-1776) билээ. Тэрээр өмч бол бараа бүтээгдэхүүнийг эзэмших, олж авах нөхцөл байдлыг хангахын тулд эд баялгийг өөрсдөө бүтээх, өөрийнхөө аз завшаанаар түүнийг олж авах тэрхүү боломжит таатай орчинг бүрдүүлэх зорилготой, нийгмийн бүх гишүүдийн элсэн орсон гэрээ хэлэлцээрийн үр дүнд бий болсон зохиомол бүтээгдэхүүн юм⁴⁷ гэж үзжээ.

Д.Юм юуны өмнө материаллаг баялагтай харилцах хүний энэ харилцаанд төрөлхөөс философийн сонирхол гэж байдаг уу? гэдэгт хариулт өгөхийг зорьсон юм. Хэн нэг этгээд Х бол миний өмч гэж зарлалаа гэж үзвэл Х нь ямар нэгэн үйлдэл байсан тохиолдолд сэтгэгчдийн хэлэлцэж судлахыг хүсдэг санаа зорилго, чөлөөт хүсэл зориг, хариуцлагын тухай сонирхолтой асуудлыг эндээс олж харах боломжтой юм. Эсвэл хэн нэг хүн Х нь II гэдэг хүнд хамаарна гэж хэлсэн ба Х нь ямар нэг үйл явдал, арга хэмжээ, дурсамж, туршлага зэрэг зүйлсийн аль нэг нь байвал хувь хүнд хамаарах сонирхолтой асуудлууд бий болно. Харин Х нь алим, хэсэг газар,

⁴⁶ William Blackstone (2001), Blackstone's commentaries on the Laws of England [1763], Wayne Morrison (ed.), London: Cavendish Publishing.

⁴⁷ David Hume (1978), A Treatise of Human Nature [1739] L.A. Selby-Bigge and P.H. Nidditch (eds.), Oxford: Clarendon Press.

аль эсвэл сүйх тэрэг байгаа бол Х, П хоёрын хоорондын харилцааны талаар судлаачдын сонирхлыг татах ямар ч асуулт бий болохгүй гэж Д.Юм үзсэн байдаг.

Д.Юм цааш нь, бидний хүсэл зориг, дур зоргын зөрчилдөөн болон материаллаг зүйлсийн сул чөлөөтэй хөрвөх явдал, түүнийг нэгээс нөгөөд амархан шилжүүлэх боломж зэрэг нь аливаа этгээдийн эд баялгийг эзэмшилдээ байлгаж ашиглах эрхэд сөргөөр нөлөөлөх аюултай гэжээ⁴⁸.

Ийнхүү хувийн өмч олж авах явдлыг нийгмийн дүрэм, журмаар зохицуулж тодорхойлох хүртэл хүн ба эд зүйлсийн хоорондын харилцаа баталгаатай, найдвартай байж чаддаггүй. Жишээ дурдахад, хүн өөрийн хийсэн ямар нэг зүйлсийн талаар ёс суртахууны эрх эдлэх бөгөөд харин нийгмийн зүгээс уг ёс суртахууны эрхэд нь хууль зүйн үүднээс хариулт өгөх үүрэгтэй хэмээн ойлгож болно⁴⁹ гэж хожим зарим сэтгэгчид тайлбарласан байна. Харин Д.Юмын үзэж байгаагаар тодорхой нэг хүн ба эд баялгийн хоорондын харилцааны норматив ач холбогдлын тухай ямар нэг дүгнэлтэд хүрэхээсээ өмнө нийгэмд юу ийм төрлийн дүрэм журмыг бий болгож мөрдүүлэхэд хүргэж байгааг тодруулах хэрэгтэй ажээ.

Д.Юм үүнийг тайлбарлахдаа, өмч гэдэг бол нийгмийн буюу шударга ёсны хуулиар тогтмол эзэмшлийг нь тогтоосон тэрхүү бараа материалаас өөр юу ч биш юм. Шударга ёсны гарал үүслийг тайлбарлахаас өмнө өмч, эрх, үүрэг гэх зэргийн тухай ярьж буй этгээдүүд бүдүүлэг алдаа гаргаж байгаага ухамсарлах хэрэгтэй. Учир нь хувийн өмч гэдэг бол хүнд өөрт нь хамааралтай ямар нэг зүйлийг хэлэх бөгөөд энэ харилцан хамаарал нь төрөлхийн биш ч гэсэн ёс

суртахууны шинжтэй байдаг ба шударга ёсонд үндэслэсэн байдаг. Шударга ёсны мөн чанарыг бүрэн дүүрэн ойлголгүйгээр өмчийн тухай төсөөлөх ч боломжгүй, энэ нь маш утга учиргүй зүйл юм. Шударга ёсны гарал үүслээс үүдэн өмчийн гарал үүслийг тайлбарлаж болно⁵⁰ гэжээ.

Т.Хоббс эрх мэдлийн тусламжтай бий болгосон бүтээгдэхүүн бол өмчийн зохицуулалт гэж үзээд, энэхүү эрх мэдэл нь тусгаар тогтносон улсын хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрх бөгөөд үүний тусламжтай хүмүүсийн энх тайван байдлыг хангаж, иргэд өөрийн хүчээр өөрийгөө хамгаалах чадварын хэр хэмжээнээс хэтэрсэн нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаандаа оролцох боломжийг төр хангадаг гэж үзсэн тухай өмнө нь тайлбарласан билээ. Түүний энэ үзлээс ялгаатай нь Д.Юм өмчийн зохицуулалтууд нь бүрэн эрх бүхий аль нэг субъектын шийдвэр бус, харин хүмүүсийн ердийн харилцан ажиллагааны үр дүнд уг харилцааг зохицуулсан гэрээ хэлэлцээрийн журмаар бий болох боломж юм⁵¹ гэдэгт анхаарлаа хандуулж байв. Ийнхүү шударга арга замаар олж авсан эд хөрөнгө тухайн этгээдийн өмч болон хэлбэршинэ гэсэн Д.Юмын үзэл санааг цухас авч үзлээ.

Английн либерализмын томоохон төлөөлөгч, утилитаризмыг үндэслэгчдийн нэг Жереми Бентам (1748-1832) өмчлөх эрх бол аюулгүй байдлын эх сурвалж бөгөөд хувийн өмч бий болсон үед хууль ёс хамт үүсч, бүрэлдэн тогтсон хэмээгээд хувийн өмчийг үгүйсгэх, хязгаарлах алхам хийх нь тухайн төрийн оршин тогтнох баталгааг сулруулна гэж үзэж байв. Түүний үзэл санаа 19-р зууны сэтгэлгээнд томоохон нөлөө үзүүлсэн билээ.

⁴⁸ David Hume (1978), *A Treatise of Human Nature* [1739] L.A. Selby-Bigge and P.H. Nidditch (eds.), Oxford: Clarendon Press. Page 488.

⁴⁹ Jeremy Waldron (1988), *The Right to Private Property*, Oxford: Clarendon Press.

⁵⁰ David Hume (1978), *A Treatise of Human Nature* [1739] L.A. Selby-Bigge and P.H. Nidditch (eds.), Oxford: Clarendon Press. Page 491.

⁵¹ David Hume (1978), *A Treatise of Human Nature* [1739] L.A. Selby-Bigge and P.H. Nidditch (eds.), Oxford: Clarendon Press. Page 490.

Түүний тодорхойлсноор нийгэмд харилцан адилгүй бүлэг давхаргууд оршин байгаа нь хувийн өмчтэй холбоотой. Өмчгүй хүмүүс ядуу давхаргад багтана, харин тэд өмчтэй хүмүүсийн нөлөөнд, тэдний ач буянаар аажимдаа өмчтэй болох үйл явц үргэлжилнэ гэжээ. Тиймээс ардчилал бол хувь хүний эрх, эрх чөлөө хувийн өмчийн байдлаар хэмжигдэнэ хэмээн үзэж байв.

Либерализмын герман дахь урсгалыг хөгжүүлэгчдийн нэг Л.Штейн хүний эрх, хувийн өмчийн талаар ангич байр сууринаас хандахыг эсэргүүцэж байсан бөгөөд “Өмчлөх эрх нь харьцангуй хүрээнд бус эзэмших, захиран зарцуулах, худалдах зэрэг өргөн хүрээнд байх ёстой. Өмчлөх эрх бол аливаа эрх чөлөөний эх сурвалж төдий зүйл биш, харин өмчийг хэрхэн эзэмшиж, захирч байгаа нь эрх чөлөөний үндэс мөн. Хүний өмч хэдий чинээ ихсэх тусам түүнд эрх чөлөө төдий чинээ нэмэгдэнэ” гэжээ.

Энэ үеийн сэтгэлгээнд Германы идеалист философийн голлох төлөөлөгчдийн үзэл сэтгэлгээ томоохон байр суурийг эзэлдэг. Тэдний нэг И.Кант жам ёсны эрх зүйд дүн шинжилгээ хийх явцдаа иргэний эрх зүйн үндсэн институтыг гаргаж тавьсан билээ. Тэрээр өмчийн, гэрээний, гэр бүлийн эрх зүйн институтыг системчилсэн бөгөөд өмчийн харилцаа нь хүмүүсийн хоорондын чөлөөт харилцааны үндэс мөн гэж тодорхойлжээ. Тодруулбал, иргэд юуны түрүүнд өмчийн харилцаанд идэвхитэй оролцдог болохыг дурдсан байна.

И.Кантынхаар өмчийн эрх зүйн харилцаа нь хүний өмчтэй харьцаж буй харилцаа бус харин өмчөөр дамжуулан хүмүүс хоорондоо харьцаж буй харилцаа⁵² юм.

Тэрээр өөрийн судалгааг өмч болон агентлагийн хоорондын ерөнхий холбоог онцолж үзэхээс эхэлжээ. Тэр үзэхдээ

⁵² И.Кант Собрание сочинений в восьми томах. Т-6 стр 286.

ашигтай объектуудыг хэрхэн ашиглахыг зөвшөөрөх агентлаг болон хүний хувийн зан чанарыг олны өмнө гаргаж тавих ёстой гэсэн байна. Үүнээс үүдэн тэрээр, бусдыг чиглэн үйлчилнэ гэдэг нь эрхийн үүрэг байдаг, тийм ч учраас ямар нэг ашиглаж болохоор зүйл хэн нэгнийх болдог⁵³ гэжээ. Гэсэн хэдий ч түүний энэхүү үндэслэл сайтай боловч нэг талыг баримталсан үзэл нь удаан оршин тогтнож чадаагүй юм. Нэгэнт эд баялаг, тухайлбал хувийн өмч нь хүн бүрийн байр суурьт нөлөөлдөг тул (тэдгээр хүмүүст хувийн өмчгүй байсан бол оногдохгүй байсан үүргийг тэдэнд тохоох гэх мэт) нэг талын үйл ажиллагаагаар бүхэл бүтэн хууль ёсны шинжийг олж авч чадахгүй бөгөөд энэ тохиолдолд хамаарах бүх хүний ашиг сонирхлыг хүндэтгэсэн зохицуулалтыг хэрэглэх ёстой ажээ. Тиймээс хүмүүсийг үйл ажиллагаа явуулахыг шаарддаг, хэрэглэж болохуйц зүйлсийг өмчийн хэлбэрээр ашиглаж болно хэмээн үздэг зарчим нь иргэдийг Үндсэн хуульд нэгдэхийг шаарддаг ба Үндсэн хуулиар бүгдэд шударга, эрх тэгш хандах үндсэн дээр хэн, юуны өмчлөгч болохыг бодитой тогтоох ёстой гэж үзэж байжээ.

Германы сонгодог идеалист философийн төлөөлөгч Ф.Гегелин (1770-1831) эрх зүйн онол, номлол нь эрх чөлөөний үзэл санаатай гүнзгий учир шалтгаанаар холбогддог. Тодруулбал, өмчийн талаарх түүний үзэл нь хүний хөгжилд өмчийн оруулж буй хувь нэмэрт төвлөрч байжээ. Ингэхдээ тэрбээр хувийн эрх чөлөөний жинхэнэ санаа нь юу болох талаар зарим нэг бодит хариултыг өгч, мөн хувийн зан чанарын субъектив үе шатыг орлуулан хэрэглэж байв.⁵⁴

⁵³ Immanuel Kant (1991) *The Metaphysics of Morals* [1797], Mary Gregor (trans.) Cambridge: Cambridge University Press. Page 74.

⁵⁴ G.W. F. Hegel (1967), *The Philosophy of Right* [1821], T.M. Knox (trans.), Cambridge: Cambridge University Press. Para 41a.

Энэхүү томъёоллыг хожим Английн идеалист философич Томас Хилл Грин (1836-1882) бусдаас илүүтэй гарган илэрхийлжээ. Тэрээр ёс зүйн хөгжилд, түүнчлэн хариуцлагаа ухамсарлах хүсэлд өмчийн оруулж болох хувь нэмрийг онцлон тэмдэглэж байв⁵⁵. Гэвч дээрх хоёр сэтгэгчийн аль нь ч хувь хүний хөгжилд өмч “бүхнийг эхлүүлэгч”, эсвэл “бүхнийг төгсгөгч” гэдэг талаас нь хандаагүй юм. Дурдсан хоёр тохиолдолд аль алинд нь үүнийг нийгмийн хариуцлагын өсөлт дэх үе шат гэж үзсэн байна. Аль аль нь өмчид агуулагдах эрх чөлөөг төгс бөгөөд эерэг эрх чөлөө гэж үзсэн ба энэ нь нийгмийн илүү сайн сайхны тулд хариуцлагатай, ухаалаг, оновчтой сонголт хийх эрх чөлөө юм гэж онолджээ.

Ф.Гегелийн үзлээр хүний эрхийн үндэс нь эрх чөлөө бөгөөд энэ нь юуны өмнө хувьдаа өмчтэй байх эрхээр илэрдэг. Аливаа хүн чөлөөт хүсэл зоригтой субъект болохын хувьдаа өмчтэй байх эрхтэй. Хувийн өмчийг өмчлөх эрх тэгш боловч өмчийн хэмжээ нь янз бүр байдаг. Учир нь өмчийн хэмжээ нь тухайн хүний хөдөлмөрөөс шалтгаална. Хувийн өмчид л бие хүний эрх чөлөө илэрнэ гэжээ. Тодруулбал, хувийн өмч гэдэг бол бие хүний тодорхойлолт юм. Хүн хувийн өмчийг эзэмшсэнээр ухаалаг болдог гэсэн байна. Өөрөөр хэлбэл өмчийн зохистой байдал нь хүний хэрэгцээг хангахаас гадна түүний субъектив байдлыг авч хаяхад оршино гэж үзэж Ж.Локкийн үзэл сэтгэлгээг хөгжүүлсэн юм.

Өдгөө эрх зүйчдийн анхаарлаа хандуулж буй өмчийн удирдлага ба хяналтын тухай ойлголтыг Ф.Гегель анхлан үндэслэсэн бөгөөд тэрээр өмч эзэмших туйлын эрх гэдэг нь тухайн өмчид хүн өөрийнхөө хүсэл зоригийг шингээх явдал юм. Ийнхүү хүсэл

зоригийн гадаад ахуйг илэрхийлдэгийн хувьд зайлшгүй шинжтэй гэсэн юм. Өөрөөр хэлбэл бие хүн чөлөөт хүсэл зориг бүхий субъект болохын хувьд өөрийнхөө эрх чөлөөг илэрхийлэх үүднээс зайлшгүй хувийн өмч эзэмших ёстой ажээ. Мөн тэрээр хүн аливаа өмчийг шууд буюу гэрээний үндсэн дээр эзэмшиж болно. Иймээс гэрээ гэдэг бол өмчийн бодит ахуй юм гэж номлосон билээ.

1800-аад оны үеийн Европын аж үйлдвэржилтийн хувьсгал Англи орныг бүрэн хамарч, үр нөлөөгөө Францад нэвтрүүлснээр энэ үеийн улс төр, эрх зүйн үзэл сэтгэлгээнд францын онолчдын үзэл сэтгэлгээ хүчтэй орж ирсэн юм. Цаашилбал хөдөлмөрийн хөлс, түрээс, үр ашиг, орлого гэх зэрэг эдийн засгийн бусад хэрэглэгдэхүүнүүдийн өмчтэй харилцах харьцааг шүүмжлэх шинэ үзэл суртлын хэлбэрийг Адам Смит болон Давид Рикардо нар дэлгэрүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийн онолыг хөгжүүлсэн нь өмчлөх эрхийн сэтгэлгээнд томоохон өөрчлөлт авчирсан байна. Үүний үр нөлөөгөөр өмч нь философийн асуудал гэхээсээ илүүтэй улс төртэй холбогдох явдал ихэссэн нь энэ үеийн бас нэг онцлог юм.

Өмчийн хууль ёсны эх үндэс юунд оршиж буй тухайд хичээл зүтгэл гарган ажилласан онолч бол Чарльз Комте юм. Тэрээр “*Traite de la Propriete*” (1834) гэх бүтээлдээ хувийн өмчийн хууль ёсны байдлыг хэрхэн бэхжүүлэх тухайд авч үзсэн байдаг. Түүний нотолгоо гурван үндсэн тайлбар дээр төвлөрч байв:

Нэгдүгээрт, Өмнөх зуунуудад хувийн өмчийг эзэмших явцад төрийн зүгээс хөндлөнгийн оролцоо их байсан явдал шударга ёс төдийгүй эдийн засгийн бүтээмжид аймшигтай үр дагавар үлдээсэн,

Хоёрдугаарт, Өмчийн хууль ёсны шинж нь хэн нэгэнд ямар нэгэн байдлаар хор хөнөөл учруулаагүй байх үед илүү тодорч гардаг,

⁵⁵ T.H. Green (1941), *Lectures on the Principles of Political Obligation* [1895], London: Longmans Green & Co.

Гуравдугаарт, Түүхийн үүднээс авч үзвэл бүхэлдээ биш ч гэсэн хууль ёсны болон хууль ёсны бус гэсэн холимог хэлбэрээр өмчийн хуваарилалтыг хийж ирсэн бөгөөд энэ нь бага хэмжээгээр ч атугай өмчийн зүй ёсны байдлыг олж хувьсан хөгжихөд сайнаар нөлөөлсөн гэсэн дүгнэлтийг хийжээ.⁵⁶

Ч.Комте ч мөн адил эртний Ромын эрх зүйн уламжлал болсон боолын тогтолцоог шүүмжилж байснаас гадна нийтийн өмч нь нийтлэг бараа таваараас бүтдэг гээд үүний жишээ болгон түүн олзворлож хэрэгцээгээ хангаж байсан эртний нийгэм дэх газрыг авч үзжээ. Авлах, олзворлохоос илүү хувийн өмчийг хэн нэгэн эзэмших нь үр ашигтай болсон тэр үеэс хойш газар тариалан эрхлэхээр үлдсэн цөөн олзворлогч нарт газар угаас хангалттай оногдох юм. Иймээс тэдэнд ямар ч хор хохирол учрахгүй гэжээ. Газрыг ийнхүү ашиглах тухай Ч.Комтегийн ойлголт нь Ж.Локкийн “баялаг хангалттай байгаа, сайн сайхан зүйлс үлдсэн” гэсэн томъёоллоос зөрүүтэй биш ажээ. Түүний энэхүү үзэл санаанд хожмын онолчид өмчийн тухай социалист шүүмжлэлээр хариу тайлбар хийсэн юм.

Францад Ф.Бастия (1801-1850) нь Ч.Комтетэй нэгэн үед амьдарч, үзэл сэтгэлгээгээ түгээж байлаа. Түүний өмчийн талаарх үндсэн номлолуудыг “Эдийн засгийн зохицолдоо” бүтээлийнх нь 8-р бүлгээс үзэх боломжтой. Уламжлалт өмчийн онолоос ялгаатай нь тэрээр өмч бол бодит биежсэн объект биш, харин хүмүүс болон тэрхүү объектын хоорондын харилцаа бол өмч юм гэж үзэж байлаа. “Аягатай усыг гартаа барьсан хэн нэгэн тэрхүү усаа өөр нэг хүнд бэлэглэх буюу худалдаж болно. Мөн чанартаа бол тэр хүн биет зүйлсийг өмчилж буй хэрэг бус харин объектын үнэлэмж

буюу өртгийг өмчилж байгаа юм.⁵⁷” гэж Ф.Бастия тайлбарласан байна. Тэрээр өртөг бол зах зээлийн өртөг гэсэн үг бөгөөд ашиг тус гэсэн ойлголтоос тэс ондоо юм гэдгийг цохон тэмдэглэж байв. Тэр “Бие биетэйгээ үйлчлэлцдэг бидний харилцаанд хэзээ ч эд юмсын ашиг тусыг өмчилж байдаггүй, харин түүний өртгийг л өмчилдөг. Энэ өртөг бол хоёр талын харилцан ажил хэргийн дүнд бий болсон үнэлгээ юм⁵⁸” гэсэн байна.

Хүнийг “амьдрал, авьяас чадвар, үйлдвэрлэл буюу хувь хүн, эрх чөлөө, өмч хөрөнгийн цогцолбор⁵⁹” гэж тодорхойлсон тэрээр хувийн өмч бол хууль тогтоосны үндсэн дээр үүсдэг бус, харин хувийн өмчийг хамгаалж, түүнийг бэхжүүлэхийн тулд хүмүүс хуулийг бүтээсэн гэсэн үзэл санаагаа гарган илэрхийлжээ. Эд хөрөнгө бол хүнд төрөлхөөс заяасан жам ёсны эрх гэдгийг тэр хүлээн зөвшөөрч “Хүн бүр өөрийн бие, өөрийн эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалах зүй ёсны заяагдсан эрхийг Бурхнаас хүртсэн...⁶⁰” хэмээн номлож байв.

Өмчийн тухай хөдөлмөрийн онолыг Францад хөгжүүлэгчийн хувьд Ф.Бастия хүн өөрийн уйгагүй хөдөлмөрөөр өмчийг бүтээдэг гэсэн үзэл бодолдоо үнэнч байжээ. Тэр үзэхдээ “...өөрт заяасан авьяас чадвараар байгалийн эд баялагтай уйгагүй харьцсанаар хэрэгцээгээ хангана. Энэ явц бол өмч хөрөнгийн эх үүсвэр мөн⁶¹” гэжээ. Өмчийн талаарх түүний үзэл сэтгэлгээ ямагт хууль ёсны дагуу өмчийг бий болгож, түүнийгээ хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн хүчээр хамгаалуулж байх нь аливаа улсын иргэдийн зайлшгүй хүсэмжлэх ёстой үндсэн шаардлагуудын нэг гэдгийг тайлбарлахад оршиж байлаа.

⁵⁷ Frederick Bastiat *Economic Harmonies* [1850] Chapter 8.

⁵⁸ Мөн тэнд.

⁵⁹ Фредерик Бастия (2001), Хууль [1849], Орч Н.Баярбаатар. 2-р тал.

⁶⁰ Мөн тэнд.

⁶¹ Фредерик Бастия (2001), Хууль [1849], Орч Н.Баярбаатар. 7-р тал.

⁵⁶ David Hart *The Radical Liberalism of Charles Comte and Charles Dunoyer*.

“Хуулийн бүхий л арга хэмжээ өмчийг сахин хамгаалж, дээрэм тонуулыг залхаан шийтгэж байх ёстой”⁶² гэж тэр тайлбарласан бөгөөд өөрийн үнэнч хөдөлмөрөөр өмчийг бүтээдэг ард иргэдийн нэг хэсэг байхад, бусдын хүч хөдөлмөрийг сорон мөлжиж дээрэм тонуул хийдэг нэг хэсэг байна гэдгийг анхааруулж, түүний эсрэг тэмцэхийг уриалсан билээ. Түүнчлэн тэрээр хувийн өмч хэзээ ч устаж алга болохгүй гэж үзэж байв. Учир нь хүмүүс цаашид илүү их хэрэгцээ шаардлага болон хүсэл сонирхлыг өдөөн бий болгох чадвартай ажгуу⁶³ гэсэн юм.

Товч дүгнэлт:

Дурдсан бүхнийг товч дүгнэвэл, *нэгдүгээрт*, эртний Грек, Ромын үеийн эрх зүйн сэтгэлгээний тодорхойлогдох онцлог бол сэтгэгчид, онолчид хувийн өмчийн оршин тогтнохуй нь чухам хэнд, юунд хэрэгтэй болохыг танин мэдэх, уг өмчийн тусламжтайгаар хүн өмчлөх эрх гэдэг ойлголтод багтаан ямар эрх эдлэх ёстойг, нийгэм дэх түүний үнэлэмж чухам ямар байх ёстойг ойлгон ухаарахад анхаарч, эргэцүүлэн бодож, марган мэтгэлцэж байсан явдал юм.

Хоёрдугаарт, дундад зууны үеийн Европын өмчлөх эрхийн харилцаа нь Ромын эрх зүйгээр зохицуулагдаж байсныг энд тэмдэглэн хэлэх нь зүйтэй. Европын орнуудаас ялгаатай нь Англид нийтийн эрх зүйн хөгжлийн явцад ромын эрх зүйг улам төгөлдөржүүлж, өмчлөх эрхийг олж авах анхдагч болон үүсмэл аргыг бий болгосон нь энэ үеийн онцлог юм.

Энэ үед өмчлөх эрх, хувийн өмчийн харилцаа газар зэрэг үл хөдлөх эд хөрөнгө дээр голлон төвлөрч байсан хэдий ч хүний амьдралын шийдвэрлэх асуудлуудыг шашны номлолоор тайлбарлах, түүгээр шийдвэрлэхийг зорьж байсан тул энэ үе нь дийлэнхдээ номлолт сэтгэлгээний үе байсан юм. Учир энэ үед МЭ 30-аад оноос эхтэй бурхны үзэл санаа улам бүр хүчээ аван хөгжиж байсан билээ. Хүн гэж юу вэ, хүн яаж аз жаргалд хүрэх вэ? гэдэг асуултад Аристотель болон стойкчүүд бүрэн дүүрэн хариулт өгч чадаагүй гэдэг үзэл дундад зууны үед ихээхэн газар авсан нь түүнд хариу өгөх боломжит номлол нь бурхныг шүтэх үзэл сэтгэлгээ гэж үзэхэд хүргэж байв.

Эцэст нь тэмдэглэхэд, дундад зууны үеийн Европын эдийн засгийн амьдралын гол цөм нь газар, түүнтэй холбогдсон харилцаан дээр төвлөрч, өмчийн төрөл, хэлбэрүүд дотор үл хөдлөх хөрөнгө, газрын өмчийн нөлөө давамгайл байсан бол шинэ үеийн Европын сэтгэгчид газартай холбогдсон өмчийн харилцаа, түүний хууль ёсны байдлын тухайд эрх чөлөөний үзэл санаа, жам ёсны эрхийн онолтой холбон авч үзэх, практик амьдралтай ойртуулан тайлбарлах, хувийн өмчөөр нийт иргэдийн эрх ашгийг хамгаалах тухайд үндэслэлгээ, нотолгоогоо гарган тавьж байсан бөгөөд хамгийн чухал нь хувь хүний өмчлөх эрхийн мөн чанар чухам юунд оршин буйг тайлбарлахыг зорьж байснаараа тэдний дэвшүүлсэн үзэл баримтлал өнөөдөр улам бүр үнэ цэнэтэй болж байна.

⁶² Фредерик Бастия (2001), Хууль [1849], Орч Н.Баярбаатар. 8-р тал.

⁶³ Frederick Bastiat Economic Harmonies [1850] Chapter 8.

ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГУЙ ИРГЭНИЙ ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ЭРХИЙГ ХАНГАХ НЬ ТӨРИЙН ҮҮРЭГ МӨН



Монгол Улсын Их Сургуулийн Худалдааны
сургуулийн багш, өмгөөлөгч, докторант

Л.БАНЗРАГЧ

Нэг. Хууль зүйн туслалцаа авах эрхийн тухай

Монгол Улсын иргэний үндсэн эрх, Эрх чөлөөг Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлээр тодорхойлон тэдгээр үндсэн эрхүүдийг иргэдийн улс төрийн эрх, нийгэм соёлын эрх, хувийн халдашгүй эрх, эрх чөлөө, иргэдийн тэгш эрх, эдийн засгийн эрх гэж ангилахаас гадна сүүлийн үед байцаан шийтгэх ажиллагааны талаарх эрх буюу процессын эрх⁶⁴ гэж ангилах болсон бөгөөд энэ эрх нь Монгол Улсын Үндсэн хуульд ч бас тусгалаа олжээ.

Хүний хувийн эрх, эрх чөлөөний нэг хэсэг нь Үндсэн хуулийн болон эрүү, иргэн, захиргааны зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо эдлэх эрх болох процессын эрхийг Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн арван дөрөв дэх хэсэгт “Монгол Улсын иргэн ...өөрийн гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд өөрийн биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал

⁶⁴ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008, 107 дахь тал

хүсэх эрхтэй.” гэж бэхжүүлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү заалтад найман зүйл үндсэн эрх тодорхойлогдсоны нэг нь хууль зүйн туслалцаа авах эрх юм. Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөөг үндсэн эрх гэдэг.⁶⁵ Иймээс хууль зүйн туслалцаа авах эрх нь хүний үндсэн эрх болно. Гэхдээ хууль зүйн туслалцаа авах эрх нь Үндсэн эрх мөн эсэхийг нотлох гэхээсээ илүүтэй Үндсэн хуулиар бэхжүүлсэн энэхүү эрхийн агуулга, хүрээ хязгаарыг тодорхойлох нь зүйтэй байх.

Хууль зүйн туслалцаа авах эрх нь процессын эрхийн нэг хэсэг бөгөөд өөртөө өмгөөлүүлэх эрх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг агуулдаг. Өмгөөлүүлэх эрхийг хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө өмгөөлөгчөө сонгох эрхээ эдлэх учиртай.

Өмгөөлүүлэх болон өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг эдлээгүй үед хууль зүйн туслалцаа авах эрх хангагдахгүй. Иргэд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгохдоо тухайн өмгөөлөгчийн мэргэшсэн байдал, туршлага, хувь хүний төлөвшил, нэр хүнд, үйлчилгээний хөлсний хэмжээг харгалзан

⁶⁵ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008, 118 дахь тал

өөрийн итгэл үнэмшилд үндэслэн сонгодог.

Энэхүү өмгөөлөгчөө сонгох эрхийг хангаж байж хууль зүйн туслалцаа авах эрх хангагдах учиртай.

Хоёр. Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах нь төрийн үүрэг болох нь

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтад нийцүүлэн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн бие даасан бүлгийг Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг болгон бататгасан байна. Ийнхүү төрийн байгуулал гэсэн бүлгийн өмнө нь уг асуудлыг оруулсан нь хүн, хүний эрх нь анхдагч, төр нь хүний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахын тулд оршин байдаг гэсэн эрх зүйт төр, иргэний нийгмийн тухай ерөнхий онолд нийцэж байгаа юм⁶⁶. Төрийн эрх мэдлийн байгууллагаас тасралтгүй хэрэгжүүлдэг эрх зүйн үйл ажиллагааг (хууль тогтоох, биелүүлэх, хамгаалах) төрийн үндсэн чиг үүрэг гэдэг.⁶⁷ Хууль хамгаалах чиг үүргийн нэг тал бол хүний эрх, эрх чөлөөг хамгаалах явдал мөн. Нөгөө талаар төр нь хүний эрхийг хамгаалах нь гадаад болон дотоод гэсэн хоёр үндсэн шалтгаанаар ард түмнийхээ өмнө Үндсэн хуулийн ёсоор хүлээсэн зайлшгүй үүрэг юм. Өөрсдийн тусын тулд байгуулсан төр нь ард түмнийхээ эрх, эрх чөлөөг хамгаалах нь төрийн эрхэм зорилго мөн бөгөөд энэ нь дотоод гол шалтгаан юм.

Монгол Улс дэлхийн хамтын нийгэмлэгийн бүрэн эрхт гишүүний хувьд хүний эрхийн олон улсын гэрээг шударгаар сахин биелүүлэх үүргийг дэлхийн улсуудын өмнө хүлээсэн байдаг. Энэ бол гадаад гол шалтгаан.⁶⁸ Ийнхүү төр хүний эрхийг хангаж хамгаалах дээрх хоёр гол шалтгаан байдаг учраас хүний эрхийг хангаж, хамгаалдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19

⁶⁶ Амарсанаа .Ж “Ардчилсан эрх зүйт ёс” УБ., 2009 71 дахь тал

⁶⁷ Лүндэндорж Н. Төрийн онол УБ., 2005, 196 дахь тал

⁶⁸ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг” УБ., 2008 он 148 дахь тал

дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт **”Төрөөс хүний эрхийг хангахуйц нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”** гэж төрийн иргэний өмнө хүлээх үүргийг тодорхойлон хуульчилсан байна.

Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр тунхаглан хуульчилсан хүний эрхийг төрийн зүгээс санаатай буюу болгоомжгүй аль нэг хэлбэрээр зөрчих нь зөвхөн ганц хүний эрхэнд халдаад зогсохгүй нийтийг хамарсан зөрчилд хүргэж ноцтой хохиролд учруулдаг тул түүнээс урьдчилан сэргийлэх нь ардчилсан төрийн үйл ажиллагааны нэг үндсэн чиг үүрэг түүний хүмүүнлэгийн гол агуулгыг илэрхийлдэг.⁶⁹ Ийм учраас хүний эрх, эрх чөлөөний бүх талын /нийгэм, эдийн засаг, хууль зүйн г.м/ баталгаа болгож Үндсэн хуульд дээрх заалтыг шигтгэж өгсөн. Ийнхүү хүний эрхийг хангаж, хамгаалах нь төрийн үүрэг учраас Монгол Улсын иргэний үндсэн эрх болсон хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж хамгаалах нь төрийн үүрэг мөн.

Гурав. Төлбөрийн чадваргүй иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж буй байдал

Монгол Улсад хууль ёсоор оршин сууж байгаа хүн бүр өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хэрэгжүүлэх, хамгаалахын тулд хууль зүйн туслалцааг шаардлагатай үедээ өмгөөлөгчөөс хуулиар хориглоогүй аль ч хэлбэрээр авах боломжтой хэдий ч төлбөрийн чадваргүй иргэн энэ эрхээ хангалттай эдэлж чаддаггүй.

Энэ ч утгаар нь төрөөс хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд Өмгөөллийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.8 дахь хэсэгт “Өмгөөлөгч нь жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх

⁶⁹ Совд Г. “Үндсэн хуулийн тайлбар” УБ., 2000 он 134 дахь тал

үүрэгтэй” гэж өмгөөлөгчийн үүрэг болгон хуульчилсан. / Энэ хууль 2002 онд батлагдаж 2012 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар хүчингүй болсон/ Хуулийн энэхүү заалтын дагуу Монголын өмгөөлөгчдийн холбоо, Нийслэлийн болон бусад аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгч томилж ирсэн.

Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг 2006 онд батлан хэрэгжүүлж ирсэн төдийгүй мөн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.11 дэх хэсэгт “...мэргэжлийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ эрхлэх ажлыг зохион байгуулах” гэж зааж, улмаар УИХ-аас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай” хуулийг баталж, улмаар төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага буюу хууль зүйн туслалцааны төвийн эрх зүйн байдлыг хуульчилсан нь төр процессын үндсэн эрх болох хууль зүйн туслалцаа авах эрхийг хангаж, хамгаалах үүргээ биелүүлж байгаагийн нэг илэрхийлэл болно.

Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эрх зүйн төвүүд байгуулагдаж, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ Өмгөөллийн тухай хуулийн дагуу Монголын өмгөөлөгчдийн холбоо ч төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгч томилсоор байна. Эдгээр төрийн болон төрийн бус байгууллагын ажлын үр дүнд төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгч олдохгүй байх байдал арилсан гэж үзэж болно. Гэвч тэдний хууль зүйн туслалцаа авах эрх баталгаатай хангагдаж байна уу гэвэл үгүй. Учир нь хууль зүйн туслалцаа авах эрх нь өмгөөлөгчөө сонгох эрхийг өөртөө агуулдаг. Гэтэл төр эрх зүйн төвүүд болон Монголын өмгөөлөгчдийн холбоогоор

дамжуулан энэ үүргээ хэрэгжүүлэхдээ төлбөрийн чадваргүй иргэний сонгосон бус аль нэг дурын өмгөөлөгч томилж байгаа нь тэдний өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг хязгаарлан улмаар хууль зүйн туслалцаа авах эрхийг хэлбэрийн төдий хангаж байгаа явдал юм. Зүй нь тэдний сонгосон өмгөөлөгчийг томилж өгснөөр өмгөөлөгчөө сонгох эрх хангагдаж улмаар хууль зүйн туслалцаа авах эрх сонгодог утгаараа хэрэгжих учиртай.

Өмгөөлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “...өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж, тулгаж болохгүй” гэж зааж өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулсан боловч практикт тухайн хэрэгт мэргэшсэн чиглэлийг харгалзахгүй, тодорхой өмгөөлөгчийг нэр зааж томилж иргэдийн хуулиар олгосон эрхийг хангах нэрийдлээр хязгаарлаж байна. Өөрөөр хэлбэл, хууль зүйн туслалцаа хүссэн төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөгчийг өөрөөр нь сонгуулахгүй шууд томилж иргэний өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласаар байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар Монголын өмгөөлөгчдийн холбооны Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс хууль зүйн туслалцаа хүсч өмгөөлөгч томилуулсан төлбөргүй чадваргүй нийт 967 иргэн байна.

Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс хууль зүйн туслалцаа авсан төлбөрийн чадваргүй иргэдийн тоог сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл⁷⁰.

№	Он	Өмгөөлөгч томилуулсан төлбөрийн чадваргүй иргэний тоо
1	2011	306 иргэн
2	2012	285 иргэн
3	2013 оны 10 сарын 29-ны байдлаар	376 иргэн

⁷⁰ Нийслэлийн өмгөөлөгчдийн зөвлөлөөс авсан мэдээлэл

Эндээс харахад сүүлийн 3 жилийн байдлаар нийт 976 иргэний өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох эрхийг эдлүүлэлгүй өмгөөлөгч томилсон байна.

Ийнхүү хууль зүйн туслалцаа авах эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар иргэний үндсэн эрхийн хүрээнд бэхжүүлж бусад хуулиудаар хамгаалсан боловч практикт төлбөрийн чадваргүй иргэд энэхүү эрхээ бодитойгоор эдэлж чадахгүй байгаа нөхцөл үргэлжилсээр байна. Энэ эрхийг бодитойгоор хангаж хамгаалах үүрэг нь төрийн бус байгууллага болох Хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо зэрэг байгууллагын үүрэг бус Монгол Улсын төрийн үүрэг мөн.

Төрөөс төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргасан гэдгээр нь аль нэг өмгөөлөгчийн шууд томилох бус түүний сонгосон өмгөөлөгчийг нь томилж өгснөөр Үндсэн хуульд заасан иргэний хууль зүйн туслалцаа авах эрхийг нь хангаж байна гэж үзэх учиртай.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.11-т “... мэргэжлийн чиглэлээр бодлогын нөлөөлөл, хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа болон төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах” гэж төр төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах үүргээ Хуульчдын холбоонд олгосон. Гэхдээ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсэгт заасны дагуу төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг нь төр хариуцахаар заасан байдаг.

Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах, тэдэнд энэ эрхийг эдлүүлэхэд зардал чухал боловч уг зардлыг төр хариуцна гэж зааснаар төлбөрийн чадваргүй

иргэний хууль зүйн туслалцаа авах эрх хангагдахгүй. Учир нь Өмгөөллийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.” гэж заасан боловч төрөөс холбоонд шилжүүлсэн мөнгө нь өмгөөлөгчийн төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн зардалд ч хүрэлцэхээргүй хэмжээтэй байсан. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх өмгөөллийн үйлчилгээний зардлыг төр хариуцна.” гэж заасныг өмнөх жишгээр хэрэгжүүлвэл өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох иргэний эрхийг хангалттай эдлүүлж чадахгүй болох нь тодорхой билээ.

Иймээс цаашид төлбөрийн чадваргүй иргэний өөрийнх нь сонгосон бус аль нэг дурын өмгөөлөгч томилдог байдлыг арилгаж, тэдний сонгосон өмгөөлөгчийг томилж өмгөөлөгчөө сонгох эрхийг нь хангаж, хууль зүйн туслалцаа авах Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх бодит боломжийг бүрдүүлэх нь төрийн үүрэг мөн.

Төр энэхүү боломжийг бүрдүүлэх нэг нөхцөл нь юуны өмнө өмгөөлөгчийн хөлсний асуудал юм. Энэхүү өмгөөллийн үйлчилгээний зардал, өмгөөлөгчийн хөлсний асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаас энэ эрхийн хэрэгжилт шууд хамаарах тул төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчийн өмгөөллийн үйлчилгээний зардал, хөлсийг бодитойгоор тогтоох шаардлагатай.

ХҮНИЙ ЭРХИЙН АЛБАН БА АЛБАН БУС СУРГАЛТЫН ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ НЬ



“Монголын Эмнести Интернэшнл” Төрийн
бус байгууллагын Гүйцэтгэх захирал

Б.АЛТАНТУЯА



“Монголын Эмнести Интернэшнл” Төрийн
бус байгууллагын Хүний эрхийн боловсрол
хариуцсан Удирдах Зөвлөлийн гишүүн

С.ГАНЧИМЭГ

Оршил

Хүний эрхийг хүндэтгэн биелүүлэх Хөдөлгөөн газар сайгүй өрнөсөн өнөө үед хүний эрхийн тухай боловсролын үүрэг ач холбогдол маш чухал байр суурь эзэлнэ. Хүний эрхийг хамгаалах явдал нь хүмүүсийн зүгээс хүний эрхийг хамгаалах талаар мэдээлэлтэй, мөн хүний эрхийг хамгаалах шаардлага байж хэрэгжих билээ. Мөн түүнчлэн ямар эрхтэйгээ мэдэх, эрхээ хэрхэн хамгаалах талаар сайн мэдэж байж бид хүний эрхийг хамгаалан хэрэгжүүлж чадна. Ийм учраас хүний эрхийн тухай боловсрол нь хүний эрхийг зөрчих явдлыг цаашид таслан зогсоох үйл хэрэгт оруулж буй ихээхэн хувь нэмэр болоод зогсохгүй, шинэ Үндсэн хуулиндаа хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлсэн, хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгож тунхагласан манай орны хувьд иргэний нийгмийг цогцлон

байгуулахад чухал хөрөнгө оруулалт болох юм. Энэ утгаараа Хүний Эрхийн Боловсрол (Хүний эрхийн боловсрол) нь Хүний эрх юм.

Нөгөөтэйгүүр хүний эрх, эрх чөлөөг эн тэргүүнд тавьж, хөгжлийн шинэ бодлого ч хүн рүүгээ илүү анхаарлаа хандуулж байгаа өнөө үед хүн бүр хувийн эрх, эрх чөлөө ба аюулгүй байдлаа хангах, бие бялдар, оюун ухааны хувьд бололцоотой хамгийн дээд түвшинд хүрч хөгжих эрхтэй. Тэгвэл хүнийг хөгжилд хүргэж, амьдралын чанарыг сайжруулахад гарцаагүй шаардлагатай хэрэглэгдэхүүн нь боловсрол юм. Энэ утгаараа хүний эрхийн боловсрол нь чанартай боловсролын нэг салшгүй хэсэг бөгөөд боловсролын гол зорилго нь хувь хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүн бүр нэр төрөө ухамсарлахад чиглэгдэж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх ёстойг хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд заасан байдаг ба энэ

нь Дакарын Тунхаглал⁷¹ болон Мянганы Тунхаглал⁷²: “...Бүх нийтийн чанартай боловсролд хүрэх, ингэснээр бие хүнийг хөгжилд хүргэх боловсролыг эзэмшүүлэх ба улмаар ядуурлыг бууруулан, хүмүүсийн амьдрах чадварыг дээшлүүлж чадсанаар тогтвортой хөгжилд хүрнэ” гэж тусгалаа олсон байдаг.

Мөн Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 29-р зүйлд боловсрол нь “...Хүний эрх, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг хүндэтгэн нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх, байгаль орчноо хайрлан хүндэтгэдэг болгоход хүүхдийн хүндэтгэлийг хөгжүүлэх ёстойг заасан байдаг.

Хүний эрхийн боловсролыг сурч боловсрох эрхийн салшгүй хэсэг мөн гэж үздэг учраас боловсролын чанарын тухай асуудлыг хөндөхдөө хүний эрхийн зарчмуудын үүднээс хандах ёстой. Сургалтын агуулга, арга зүй, сургуулийн дотоод дүрэм, журам, сургуулийн орчин нь өөрөө хүний эрхийг хүндэтгэсэн, хамгаалсан байхыг шаарддаг.

Тийм ч учраас өнөөдөр дэлхий нийтийн чиг хандлага нь боловсролын бүхий л агуулга, арга зүйгээр дамжуулан хүний эрхийн боловсролыг олж авах, нөгөө үгээр хэлбэл эрхэд суурилсан боловсролын хандлагыг дэмжих болсон ба **Хүний эрхэд суурилсан боловсрол** гэдэгт

- Сурч боловсрох нь хүний эрх
- Боловсролоор хүний эрхийн ойлголтыг өгөх нь
- Боловсрол дахь хүний эрх зэрэг асуудлуудыг хамааруулан авч үзэж байна.

⁷¹ Dakar declaration on Education For All :Дараах линкээр орж үзнэ үү unesdoc.unesco.org/images/0012/001211/121147e.pdf

⁷² The Millennium Development Goals (MDGs) Дараах линкээр орж үзнэ үү <http://www.un.org/millenniumgoals/>

Тиймээс хүний эрхийн боловсролын талаар ярихдаа зөвхөн хүний эрх хэмээн тодотгосон тэр хичээлийг бус, эсвэл нийгмийн шинжлэх ухааны хэдэн хичээлийг бус, бүхий л хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүй энд хамаарах болоод байгаа билээ.

Нэг. Хүний эрхийн боловсролын хэрэгцээ, шаардлага

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 26.2-т “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биенээ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд тусдөхөм үзүүлэх ёстой” хэмээн боловсролын зорилгыг нэн оновчтой тодорхойлжээ. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын энэхүү үзэл санааг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан хүний эрхийн бусад суурь гэрээ, конвенцоор баталгаажуулсан байдаг. Тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 13 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн конвенцийн 29 дүгээр зүйл, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 10 дугаар зүйл, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн 7 дугаар зүйлд хүний сурч боловсрох эрхийг баталгаажуулж, иргэд энэ эрхээ эдлэх нөхцөл бололцоог бий болгох төрийн үүргийг тодорхойлсон байна.

1990-ээд оноос хойш хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор НҮБ болон бусад олон улсын байгууллагуудаас олон чухал арга хэмжээ зохион байгуулж, нэлээд олон тооны хөтөлбөр, зарчим, тунхаглалыг батлан

гаргасан. Тухайлбал, 1993 оны Хүний эрхийн боловсролын Олон улсын Анхдугаар бага хурал – Венийн баримт бичиг бөгөөд үүнд Хүний эрхийн боловсролыг сургалтын бүх түвшинд болон сургуулиас гадуурх тасралтгүй боловсролын хөтөлбөрөөр дамжуулан олгох нь хүмүүс өөрийн эрх, эрх чөлөөгөө бүрэн эдэлж чадахуйц эдийн засаг, нийгэм, соёлын орчинг бүрдүүлэх гол үндэс болно гэсэн байдаг.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблей 1995-2004 оныг “Хүний эрхийн боловсролын Нэгдсэн Үндэстний Байгууллагын 10 жил” болгон зарласан нь энэ асуудлыг шинэ шатанд гаргасан ба уг арван жилийн хугацаанд улс орон бүр хүний эрхийн боловсролын үндэсний хэмжээний үр дүнтэй, тогтвортой стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. 2004 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас Хүний эрхийн боловсролын 10 жилийн үр дүнд үнэлгээ хийсэн юм. Хэдийгээр 1995-2004 онд дэлхий нийт, бүс нутаг, улс орон бүр хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэхэд хүчин чармайлт гаргаж, ололт амжилтанд хүрсэн боловч энэ ажлыг цаашид ч үргэлжлүүлэх шаардлагатай байгаа нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хийсэн үнэлгээнээс⁷³ харагдсан байна. Иймд 2004 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн 59 дүгээр чуулганы хуралдаанаас “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (2005-2015)”⁷⁴-ийг баталжээ. “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр”-г дэвшүүлэн тавьсан нэн тэргүүний зорилт бол 2005-2007 онд багтаан улс орон бүр ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоонд хүний эрхийн

боловсрол олгож буй үйл ажиллагаандаа үнэлгээ хийх, үнэлгээндээ тулгуурлан хүний эрхийн боловсролын талаар хөтөлбөр боловсруулах, хүний эрхийн сургагч багш нарыг бэлтгэх явдал гэж заасан байна. Энэ ажил дэлхий нийтээр удаашралтай байснаас үүдэн 2008-2009 онуудыг уг зорилтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхэд чиглүүлэн ажиллах үүднээс сунгасан юм. Ийнхүү хөтөлбөрийн 1-р үе шат (2005-2009) нь бага болон дунд боловсролын тогтолцоонд чиглүүлэн ажиллахыг Засгийн газруудад үүрэг болгосон. Энэ дагуу сургуулиуд нь хүний эрхийг заан сургах болон хэрэгжүүлэхүйн үлгэр загвар болох ёстой ба хүний эрхийг ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоонд нэвтрүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэгч болохын хувьд багш нар энэхүү зорилгыг хангахад голлох үүрэгтэй байна.

Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр (2003)-ийн 1.1.2.6-д “Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр ... хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ” хэмээн заасан. Мөн Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007-2008 оны төлөвлөгөө”-г баталж, хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, хүний эрхийн мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж ажиллахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яаманд даалгасан байна. Дараах хэсэгт Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлагдсанаас хойш хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагуудаас

⁷³ <http://www.ohchr.org/EN/Issues/Education/Training/Pages/Decade.aspx> хаягаар орж үзнэ үү

⁷⁴ http://www.unesco.org/new/en/brasilgia/about-this-office/single-view/news/plan_of_action_world_programme_for_human_rights_education_first_and_second_phases_The_World_Programme_for_Human_Rights_Education

авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар товч дурьдахыг хүсэж байна.

Хоёр. Албан боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

А. Бага дунд боловсрол дахь хүний эрхийн боловсрол

Манай улсын нийт хүн амын 30 гаруй хувийг албан боловсролд хамрагдагсад эзэлж байгаагийн хувьд хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллежийн өнөөгийн тогтолцоонд түшиглэн олгох өргөн боломжтой. Гэвч энэ ажил хангалттай түвшинд хийгдээгүй.

1. 1998-2003 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс хамтран хэрэгжүүлсэн “Хууль бидний амьдралд” хөтөлбөр нь орчин үеийн шаардлагад нийцсэн хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын сургалтанд нэвтрүүлэхэд эхний нааштай алхам болсон юм. Хөтөлбөрийн үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн эрх зүйн хичээлийн агуулга, хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, арга зүйг цогц байдлаар боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн 6-р ангид “Хүний эрх” сэдвээр бие даасан хичээл орох болсон байна. 2005 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” судалгааны ажлыг хийж, тэр үед мөрдөж байсан боловсролын стандарт болон Гэгээрлийн сайдын 1998 оны 100 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ерөнхий боловсролын сургуулийн 6-р ангид судалж буй “Хүний эрх” хичээлийн чанар, үр нөлөө, сургалтын агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, багшлах боловсон хүчний болон сургуулийн хүний эрхийн орчин нөхцөлийн талаар үнэлгээ хийсэн байна. Судалгаагаар сургалтын

төлөвлөгөөнд тусгагдсан “Хүний эрх” хичээлийг зарим сургуулиуд огт ордоггүй, зарим нь хэт цөөн цагаар орж байсан байна. Мөн хүний эрхийн сургалтын чанар, үр дүнд багш нарын заах арга зүй хоцрогдсон, сургуулийн удирдлагаас мэргэжил, арга зүйн туслалцаа хангалттай үзүүлж чаддаггүй, нэг ангид суралцаж буй сурагчдын тоо хэт олон, ном, сурах бичгийн хүртээмж муу байгаа болон сурах бичгээс өөр хүний эрх, эрх зүйн чиглэлийн ном, гарын авлагаар хангагдаагүй байдал зэрэг нь сөргөөр нөлөөлж байгааг гаргаж ирсэн ба одоо ч энэ байдал төдийлэн дээрдээгүй зогсонги байдалтай хэвээр байна.

2. 2004 онд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас “Бага, дунд боловсролын стандарт”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг стандартын бүрэлдэхүүн хэсэг болох “Түүх, нийгмийн ухааны боловсролын стандарт”-д суралцагчдад хүний эрхийн тухай мэдлэг, эрхээ эдэлж, зөрчигдсөн эрхээ хамгаалах чадвар олгох болон хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх хандлага төлөвшүүлэх зорилтыг дэвшүүлэн тавьжээ. Түүнчлэн, 11, 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжих бэлтгэл ажлын хүрээнд Сургалтын төлөвлөгөө, хичээлийн агуулгын үлгэрчилсэн хүрээг турших тухай Боловсролын сайдын 2004 оны 132 дугаар тушаалд ерөнхий боловсролын сургуулийн “Хүн ба нийгэм”, “Иргэншил”, “Иргэн ба нийгэм” зэрэг хичээлийн хүрээнд хүний эрх, эрх зүйн тухай мэдлэг, ойлголтыг 1-11 дүгээр ангиудад тус бүр судлахаар заасан байна. Үүний зэрэгцээ дээрх тушаалд сурагчид хичээлээс гадуурх ажлын хүрээнд “Иргэний боловсрол” хичээлийг судлахаар тусгасан нь хүний эрхийн боловсролыг түгээхэд ач холбогдолтой болсон. Хэдийгээр хүний эрхийн боловсролыг ерөнхий боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх талаар төрөөс дээр дурдсан болон бусад арга хэмжээ авч хэрэгжүүлсэн боловч бага,

дунд боловсролын стандарт, хөтөлбөр нь шилжилтийн, туршилтын гэх байдлаар олон удаа өөрчлөгдөж, тогтворжихгүй байсан, иргэний боловсрол хичээлийн агуулга хөтөлбөр тодорхойгүй байснаас уг ажлуудын хэрэгжилт хангалттай түвшинд хүрч чадаагүй байна. Ерөнхий боловсролын түвшинд тухайн хичээлийг заах багшийг бэлтгэх, давтан сургах ажил удаашралтай байгаа ба судалгаагаар⁷⁵ хүний эрх хичээлийг зааж буй багш нарын нийтлэг бэрхшээлийг багшийн ном байдаггүй, сургалтын хэрэглэгдэхүүн хомс, хүний эрхийн талаар нарийн мэдлэггүй, нэмэлт мэдээлэл авах бололцоо муу, бусад багш нар төдийгүй сургуулийн удирдлагууд хүний эрхийн хичээлийн ач холбогдлыг ойлгодоггүй гэж тодорхойлсон байна. Боловсролын стандартыг хангах, сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг сургууль дээрээ зохион байгуулна гэдэг нь нэг багшид тухайн хичээлийн цагийг тавьж өгснөөр хэрэгжчихгүй бөгөөд үүний тулд багшид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажилд нь хяналт-шинжилгээ хийх зэрэг байдлаар бүрэн хэрэгжих ёстой байтал энэ ажил огт хийгдээгүйгээс сурагчдад хүний эрхийн цогц мэдлэг, чадвар, хандлага төлөвшүүлэх ажил удаашралтай байсан ба энэ байдал одоо хүртэл хэвээр үргэлжилж байна.

3. Хүний эрхийн Үндэсний Комиссоос “Хүний эрх” хичээлийг заах багш нарт тавигдах шаардлага, Улсын Их Хурал, Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Улсын Мэргэжлийн Хяналтын Газар, Боловсролын Хүрээлэн, Аймаг, Нийслэлийн Боловсрол, Соёлын Газар, багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд болон ерөнхий боловсролын сургуулиудад хандсан зөвлөмжийг боловсруулж, холбогдох

байгууллагуудад хүргүүлсэн байна.

4. Хүн өөрийн хүрээлэн буй орчноос ихийг сурч мэддэг ба тухайн хүний зан төлөв ч орчноосоо хамааран төлөвшдөг тул сургуулийн хүний эрхийн орчин нь боловсролын тогтолцооны үнэт зүйл байх ёстой. Сургуульд хүний эрхийн орчин бүрдээгүй нөхцөлд хүний эрхийн хичээл заагаад ч бодитой үр дүн гарч чадахгүй билээ. Гэтэл Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2005 онд хийсэн судалгаа болон Их Британий Хүүхдийг ивээх сан, Зохистой хөгжлийн жендэр төвөөс хийсэн судалгааны үр дүн сургуулийн орчинд хүүхдийн бие махбодод халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр хүүхдийн эрхийг зөрчих явдал гарсаар байгаа нь сургуулиудад хүний эрхийн орчин бүрдэж чадаагүй байгааг бэлхнээ харуулж байна. Ялангуяа, сургуулийн удирдлага, багш нарын зүгээс сурагчдад нэр хоч өгөх, үг хэлээр доромжлох, хүч хэрэглэх, ялгаварлан гадуурхах, сурагчдын үзэл бодлыг үл хүндэтгэх зэрэг зөрчил түгээмэл гарч байна. 2006 оны 12-р сард Боловсролын тухай хуулинд “хүүхдийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хуульд заагаагүй төлбөр хураамж авах, ялгаварлан гадуурхах” явдлыг албан ёсоор хориглосон нэмэлт өөрчлөлт орсон билээ. Гэсэн хэдий ч өнөөг хүртэл эдгээр заалтууд Ерөнхий боловсролын сургуулиудад биеллээ олохгүй байсаар байгааг 2009 оноос эхлэн Английн Хүүхдийг ивээх сангаас хэрэгжүүлж байгаа “Ерөнхий боловсролын сургуулиудад боловсролын хуулийн хэрэгжилтийг дэмжих, удирдлага хяналтын тогтолцоог сайжруулах нь” төслийн хүрээнд хийсэн судалгаа харуулж байна. Уг төслийн үйл ажиллагаа нь багш нарт сахилга батыг тогтоох хүмүүжлийн эерэг аргуудын талаар мэдлэг олгох, хуулийг сахин биелүүлдэг, оролцоог хангасан

⁷⁵ 2005 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Хүний эрхийн боловсрол-Ерөнхий боловсролын сургуульд” судалгааны ажил

сургуулийн сайн засаглалыг дэмжихэд чиглэгдэж байгаа бөгөөд төсөлд хамрагдсан сургуулиудын хүүхдүүд аюулгүй, ээлтэй орчинд сурч боловсрох эрхээ эдэлж багш сурагчдын хоорондын зүй зохистой харилцаа бий болоход улмаар хүүхдийн сурч боловсрох орчныг сайжруулах үйлст хувь нэмэр болох нь дамжиггүй хэдий ч сургуулийн удирдлагуудын зүгээс уг ажлыг ойлгож дэмжих тал дээр учир дутагдалтай хэвээр байсаар байна.

5. Английн хүүхдийг ивээх сан, Монгол Улсын Боловсролын Их Сургуультай хамтран “Оюутан сурагчдыг хүчирхийлэлгүй орчинд эерэг арга барилаар сурган хүмүүжүүлэх үйл явцыг дэмжих төслийг хэрэгжүүлж, Багш мэргэжлийн багц хөтөлбөрт хүмүүжлийн эерэг аргын үзэл санааг тусгах зөвлөмж гарын авлагыг гаргасан байна.

Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас хийсэн ажил

2004 оны 12 сарын 10-нд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан Хүний эрхийн боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн (2005-2015 он) дагуу эхний шатанд 2005-2009 онуудад бага, дунд боловсролын хүрээнд **Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг** боловсруулан хэрэгжүүлэхийг Засгийн газруудад үүрэг болгосон бөгөөд Эмнести Интернэшнл байгууллага ч энэ зорилтыг дэмжин үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгож дараах ажлуудыг хийж ирлээ.

1. 2006-2007 онд **“Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан Хүний эрхийн боловсрол”** төслийг Австралийн Хөгжлийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хүний

эрхийн талаарх мэдлэг боловсрол болон эрхэд суурилсан боловсролын талаарх мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн эрхэд суурилсан чанартай боловсролыг дэмжих, хүний эрхийг бүхий л боловсролын тогтолцоогоор, Ерөнхий боловсролын сургуулийн хичээлүүдээр нэгтгэх замаар суралцагчдад суралцах таатай орчинг бүрдүүлэн чанартай боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахад оршиж байлаа. Төслийн хүрээнд Эмнести Интернэшнлийн Английн секцээс хэвлүүлж гаргасан “Хүний эрх сургалтын хөтөлбөрт” цуврал номын “Математик” ба “Түүх” “Хүний эрхийг иргэний боловсролоор” багш нарт зориулсан гарын авлагыг орчуулж, бага болон дунд сургуулийн сурагчдад зориулан Хүний эрхийн боловсролын зурагт хуудсуудыг сургалтын гарын авлага болгон хэвлүүлж тараасан юм. “Хүний эрх-сургалтын хөтөлбөрт” сэдэвт хоёр өдрийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтанд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Говьсүмбэр, Завхан, Дорнод аймаг, Багануур дүүргийн нийт 869 багш, сургуулийн удирдлага, Боловсрол соёлын газрын арга зүйчид, хүүхэд хамгаалал төвийн ажилтнууд хамрагдлаа. Сургалтанд оролцогсдын бүтцийг авч үзвэл: Сургалтанд оролцогчдоос орон нутгийн Боловсрол соёлын газрын арга зүйч 18, сургуулийн захирал 11, сургалтын менежер 120, нийгмийн ажилтан 89, цэцэрлэгийн арга зүйч 8, цэцэрлэгийн эрхлэгч 3, Хүүхэд хамгаалал төвийн ажилтан 5, бусад нь Ерөнхий боловсролын сургуулийн багш нар байлаа. Энэ төслийн нэг үндсэн санаа нь хүний эрхийг Ерөнхий боловсролын сургуулийн хичээл бүрээр хэрхэн нэгтгэж зааж болох тухай ойлголтыг өгөх явдал байсан ба байгаль, нийгмийн болон хүмүүнлэгийн хичээлүүдийн нэгдмэл байдлыг хангах, хүн ирээдүйдээ байгаль, нийгмийн аюулгүй

орчинд амьдрах арга ухаан, иргэншлийн өндөр соёлыг эзэмшсэн байхын чухлыг шавь нартаа мэдрүүлэхэд нь багш нарт туслах явдал байсан бөгөөд энэ нь өнөөгийн боловсролын шинэчлэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд зохих хувь нэмрээ өгсөн юм. Төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь цаашлаад ерөнхий боловсролын сургуулийн бүх хичээлүүдийн хэрэглээний агуулга, цогц чадамжид суурилсан мэдээллийг хүний эрхийн суурь зарчмуудтай холбон авч үзсэнээр суралцагчдад бусдыг хүндэтгэж, хариуцлага мэдэрч, өөрийн эрхээ хэрэгжүүлэх чадвартай болгоход оршиж байлаа. Энэ ч утгаараа манай төслийн хүрээнд хийгдсэн сургалтууд нь багшийг хөгжүүлэх, тэдний сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, хүүхдийн эрхийн мэдрэмжийг хөгжүүлэх, хүний эрхэд тулгуурласан сургалтын таатай орчин бүрдүүлэхэд зохих хувь нэмэр болсон. Мөн төслийн үр дүнд Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан хүний эрхийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсрогдон, гарын авлага, материалууд бэлтгэгдсэн юм. Сургалтанд оролцсон багш нар сургалт болон сургалтын гарын авлага материалыг өндрөөр үнэлж, энэхүү сургалтын үзэл санааг нийт багш нарт хүргэж ажиллахыг сургалт зохион байгуулсан орон нутгийн боловсролын байгууллага, сургалтанд оролцогчид чухалчлан санал болгож байсныг энд дамжуулан хэлж байгаадаа таатай байна.

2. Монголын Эмнести Интернэшнлээс Ерөнхий боловсролын сургуульд хүний эрхийг нэгтгэх зорилтын хүрээнд хийж байгаа бас нэг ажил бол **“Хүний Эрхэд Ээлтэй Сургууль”** олон улсын төслийг Монгол-Энэтхэгийн хамтарсан сургуулийг түшиглэн хэрэгжүүлж байгаа явдал юм. Монголын Эмнести Интернэшнлээс хэрэгжүүлсэн “Ерөнхий боловсролын сургуулийн багш

нарт зориулсан Хүний эрхийн боловсрол” төслийг Олон Улсын Эмнести Интернэшнл Байгууллагаас зүй ёсоор үнэлж, уг төслийн үзэл санааг цааш бэхжүүлэх зорилгоор олон улсын төвөөс дэлхийн 14 орны 17 сургууль дээр хэрэгжүүлж байгаа “Хүний Эрхэд Ээлтэй Сургууль” хөтөлбөрт Монголын Эмнести Интернэшнлийг хамруулсан юм. Энэ төслийг Монголын Эмнести Интернэшнл байгууллага Монгол-Энэтхэгийн хамтарсан сургууль дээр өнгөрч байгаа 2009-2010 оны хичээлийн жил туршилтын 1 жилийн хугацаанд хэрэгжүүлж ирсэн ба уг төсөл ирэх хичээлийн жил 4 дэх жилдээ үргэлжлэн хэрэгжинэ. Зорилго нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоонд хүний эрхийг нэвтрүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх, сургуулийн бүхий л үйл ажиллагаа түвшинд хүний эрхийг дээдэлсэн загвар сургуулийг бий болгохыг зорилгоо болгосон юм. Хөтөлбөр нь Сургуулийн удирдлага оролцоо, Сургуулийн амьдралд оролцогч бүхий л талуудын харилцаа, Сургалтын хөтөлбөр, Хичээлээс гадуурхи сургалтын үйл ажиллагаа буюу сургуулийн орчин гэсэн 4 хүрээг хамарч байна. Үүнд: 1. *Сургалтын хөтөлбөр*: Сургалтын хөтөлбөрийн бүхий л хэсгүүд болон сурах/сургах үйл ажиллагаанд хүний эрхийг нэгтгэх, багшийн хөтөлбөр боловсруулах чадварыг хөгжүүлэх, хичээлийг шинэ агуулга, арга зүйгээр баяжуулах, сургалтын практикт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд чухал хувь нэмэр болж байна. 2. *Хичээлээс гадуурхи үйл ажиллагаа буюу сургуулийн орчин*: Суралцагчид боловсролоор дамжуулан бүрэн дүүрэн хөгжихөд нь чадавхижуулахад анхаарч байна. 3. *Сургуулийн удирдлага/ оролцоо*: сургуулийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд сургуульд хамаатай хүн бүр

оролцсоноор сургуулийн амьдралд өөрсдийн үүргийг илүү ухамсарлуулан нийгмийн идэвхитэй иргэн болж төлөвшихөд чиглэгдэж байна. 4. *Багш-сурагч, сурагч-сурагчийн хоорондын харилцаа*: Итгэлцлэл, хүндэтгэл, хариуцлагатай байх соёлыг бий болгосноор ил тод байдал, хариуцлага өндөржиж, багш сурагч, эцэг эхийн харилцаа сайжирснаар эрхэд суурилсан боловсролын үзэл санааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй алхам болж байна.

Боловсролын салбараас “нэгж хичээлийн бэлтгэл үр өгөөжийг нэмэгдүүлэх” стратегийг сонгож, сургалт, хүмүүжлийн ажлын агуулга, арга зүйн уялдаа холбоог сайжруулах ажлыг эрчимжүүлэх зорилтыг дэвшүүлээд байгаа өнөөгийн нөхцөлд сургуулийн менежмент, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын сэтгэлгээ, хандлагыг өөрчлөхөд нааштай үр дүнд хүргэх нь дамжиггүй. Иймээс одоогийн Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын практикт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, сурагчдыг нийгмийн амьдралд оролцох, ирээдүйн иргэн болж төлөвшүүлэхэд чиглүүлсэн хичээлээс гадуурхи сурагчдын дунд зохиох ажлын агуулга, арга хэлбэрийг шинэчлэн, олон улсын туршлагаас суралцаж, сургуулийг “Хүний Эрхэд Ээлтэй Сургууль” болгон хөгжүүлэхэд чухал хувь нэмэртэй болох нь харагдаж байна.

3. Мөн Монголын Эмнести Интернэшнлээс “Хүний эрхийг сургалтын хөтөлбөрт нэгтгэх нь” хөтөлбөрт ажлын хүрээнд шилдэг нэгж хичээлийн хөтөлбөрийн уралдааныг 2009 оноос хойш жил бүр зарлан явуулж байна.

Бусад Төрийн бус байгууллагаас ч энэ төрлийн ажлуудыг зохион байгуулж ирсэн байна. Тухайлбал: *Иргэний Боловсрол Төвөөс* хэрэгжүүлж буй “Мозайк-2” Иргэний

боловсролын төслийн хүрээнд иргэний боловсролын шилдэг хичээлийн хөтөлбөр боловсруулах уралдааныг 2009 оны 11 сард явуулсан байна. Уг уралдааны зорилго нь одоогийн Ерөнхий боловсролын сургуулиудад тулгамдаж буй иргэний боловсролын хичээлийн агуулга, арга зүйтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийнханд иргэний боловсролын сэдвээр орж болох хичээлийн жагсаалтыг өргөжүүлэх, арга зүйг боловсронгуй болгох, хүүхдүүдэд илүү ойлгомжтой, үр дүнтэй, шинэлэг арга барил, шинэ агуулгаар баяжуулахад туслах зорилготой байв. Эдгээр уралдааныг зарлан явуулсан нь тухайн оролцогчийн нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах чадварыг хөгжүүлэх, шинэ агуулга, арга зүйг эзэмших, сургалтын практикт тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх, сайн багш нарын туршлагаас суралцах, хуваалцах боломжтой болоход чиглэгдсэн үйл ажиллагаа байлаа.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн Хөтөлбөрт дэлхий нийт өргөн ач холбогдол өгч цаашид эрчимжүүлэх, ЗГ-уудад энэ чиглэлээр цаашид хойш тавилгүйгээр эхлүүлэн ажиллахыг үүрэг болгож байгаа энэ үед энэ хөтөлбөрийн хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран энэ чиглэлээр ажиллах саналыг хүргүүлэн хэд хэдэн удаагийн уулзалтыг зохион байгуулсан ба “Боловсролын Шинэчлэл-Иргэний Нийгмийн Байгууллагуудын Оролцоо” сэдэвт уулзалт ярилцлагад оролцогчид болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулсан “12 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын тогтолцоонд шилжих төлөвлөгөө” сэдэвт семинарт оролцогч мэргэжлийн судлаачид, бодлого боловсруулагчдад “Ерөнхий боловсролын сургуулийн багш

нарт зориулсан Хүний эрхийн боловсрол” төслийн үзэл санаа, үр дүнг танилцуулан нийт 58 хүнд төслийн хүрээнд хэвлэгдсэн ном гарын авлагыг хүргэж ажилласан билээ. Харамсалтай нь энэхүү ажлууд нь төсөл хөтөлбөрийн хүрээнээс хэтэрч чадахгүй, санхүү хөрөнгийн эх үүсвэргүйгээс цааш тогтвортой үргэлжилж чадахгүй байна.

5. Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007-2008 оны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд 2008 оны 1-р улиралд хийгдсэн байхаар төлөвлөгдсөн боловч ажлын эхлэл төдий уулзалтаас хэтрээгүй бөгөөд тодорхой эрх бүхий байгууллагын шийдвэр зайлшгүй хэрэгтэй нь харагдаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам дээр 2008 онд ажлын хэсэг байгуулагдан 2 удаа уулзалт зохион байгуулж, менежментийн багийнханд 1 удаагийн сургалт явуулсан боловч менежментийн багийнхныг бүрэн хамруулж чадаагүй.

6. Мөн төслийн үзэл санааг 12 жилийн сургалтын хөтөлбөрийн менежментийн багийнханд хүргэх мөн үндэсний сургагч багш бэлтгэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамтай хамтран зохион байгуулсан сургалтанд менежментийн багаас цөөхөн хэдэн хүн хамрагдсан нь энэ талаарх ойлголт дутмаг, ач холбогдлыг дутуу үнэлсэн хэвээр байгааг харуулж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас томилогдсон ажлын хэсгийнхний ажлын зохион байгуулалтаас хамаарч төлөвлөгдсөн ажил хийгдэлгүй жил гарангийн хугацаа өнгөрөөд байна. Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт нь зөвхөн ганц хоёр удаагийн сургалтаар хязгаарлагдахгүй нь ойлгомжтой бөгөөд энэ тал дээр цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо шаардлагатай нь харагдаж байна.

Энэ бүхнээс дүгнэвэл: Хэдийгээр

Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр 2003 онд батлагдсанаас хойш энэ 10 жилийн хугацаанд хийгдсэн нилээд ажлууд байгаа боловч Хүний эрхийн боловсролын дэд хөтөлбөр боловсруулагдаагүй, Хүний эрхийн боловсролын нэгдсэн бодлогогүй хэвээр байна. Ийм нөхцөл байдал нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлээгүй, механизмыг цаг тухайд нь тодорхойлж чадаагүйтэй холбоотой байна. Мөн Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007-2008 оны төлөвлөгөө”-г баталж, хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, хүний эрхийн мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж ажиллахыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яаманд даалгасан боловч уг ажлыг зохион байгуулах хөрөнгийг улсын төсөв, олон улсын байгууллагын санхүүжилтээс гаргахаар заасан нь тодорхой биш байгаа бөгөөд төлөвлөгдсөн ажил цалгардах, орхигдох нөхцөл байдлыг үүсгэхэд нөлөөлж байна. Иймд эдгээр санал санаачлагад үндэсний хэмжээний чиглүүлэлт, санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа нь улам бүр тодорхой болж байна.

Б. Мэргэжлийн боловсрол дахь хүний эрхийн боловсрол

Их, дээд сургуулийн ялангуяа, эрх зүйч, төрийн захиргааны албан хаагчдыг бэлтгэж буй сургуулиудын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг заавал судлах хичээл болгон оруулах, хүний эрхийн мэдрэмжтэй төрийн албан хаагчдыг бэлтгэн гаргах шаардлагатай байна.

Хууль зүйн Яам, Гэгээрлийн Яамны хамтарсан тушаалаар 1997 оноос хойш эрх зүйч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд

сургуулиудад хүний эрхийн хичээлийг 36 цаг үзэхээр заасан байдаг. Гэвч эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудаас цөөн тооны сургуулиуд хүний эрхийн хичээлийг заавал үзэхээр, ихэнх сургуулиуд нь сонгон суралцах байдлаар үзэхээр сургалтын төлөвлөгөөндөө оруулсан байна. 2003 онд Хүний эрхийн Үндэсний Комисс нь эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулиудын хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулсан. Энэ ажлын хүрээнд 2 кредит цагаар судлах “Хүний эрх” хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулах, агуулга, арга зүйг нь тодорхойлох, хууль зүйн их, дээд сургуулиудад түгээх, сургалтанд нэвтрүүлэх, их, дээд сургуулийн багш нарыг сургах зэрэг ажлуудыг зохион байгуулсан ч цааш нь үр дүнтэй авч явах тал дээр сургуулиудын удирдлагууд төдийлөн анхаарал тавихгүй байна. 2009 онд Эрх зүйн боловсрол олгож буй их дээд сургуулиудын “Хүний эрх” хичээл зааж буй байдалд хийсэн дүн шинжилгээгээр энэ байдалд дорвитой өөрчлөлт ороогүй хэвээр байна.

Их, дээд сургуулиудын удирдлагуудын дунд хүний эрхийг тусад нь хичээл байдлаар орох шаардлага байхгүй харин эрх зүйн боловсролын нэг хэсэгт нэгтгэгдэхэд хангалттай гэж үзэх бодол байсаар байна. Энэ нь тэдгээр хүмүүсийн хүний эрхийн талаарх ойлголт хандлага дутмаг байгааг илтгэж байна. Гэтэл өнөөдөр хүний эрх нь хүний өдөр тутмын амьдралтай нягт уялдаатай байдгаараа үүнд хуульчид төдийгүй бусад төрийн салбарт ажиллагсад болон хувийн салбарт ажил үйлчилгээ эрхлэгчид, ирээдүйн нийгмийн хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх эрхэм зорилго бүхий бүх шатны сургууль боловсролын байгууллага анхаарах цаг аль хэдийнээ болоод байгаа билээ. Жишээлбэл, Сонгино хайрхан дүүргийн нэгэн нийгмийн ажилтан хогны

мөнгөө тушаагаагүй өрхийн 70000 төгрөгийг нь өгөхгүй гэх мэтээр шаардлагагүй хязгаарлалт тавьсан гэх саяхны жишээ л гэхэд төрийн үйлчилгээг ард түмэнд хүргэх эрхэм зорилго бүхий төрийн алба хашиж байгаа хүмүүсийн наад захын мэдлэг, ажлын ур чадвар, арга барил дутмаг байдал байсаар байгааг илтгэн харуулж байна. Иймэрхүү жишээ олон арваараа байгааг бид мэднэ. Иймд төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сэтгэлгээ хандлагыг өөрчлөх шаардлага хэрэгцээ нэн чухлаар тавигдаж байна. Одоогоор төрийн алба хашиж буй хүмүүсийн дийлэнх нь хүний эрхийн хичээлийг дунд сургууль болоод их, дээд сургуульд үзээгүй, энэ чиглэлээр шаардлагагаар мэргэжлийн сургалтанд хамрагдахгүй байгаа байдал нь хүнд үйлчлэх биш хүнд суртлыг л бий болгоход нөлөөлж байгаа нь дамжиггүй.

Бусад их дээд сургуулиудын хувьд хүний эрхийг Үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд судлаж байгаагаас хэтрэхгүй байсан хэвээр байгаа ба мэргэжлийн боловсролтой нь хүний эрхийг нэгтгэн ойлгуулах талаар ажиллаж чадахгүй хэвээр байсаар байна. Гэтэл энэ талын ажил маш хангалтгүйгээс төгсөөд төрийн аль нэг салбарт (боловсрол, эрүүл мэнд, халамж үйлчилгээ, татвар, гааль гэх мэт), эсвэл хувийн салбарт ажил үйлчилгээ эрхлэгчид өөрсдийн ажил үйлчилгээгээ эрхлэхдээ хэрхэн хүний эрхийн үндсэн зарчмуудыг мөрдөж ажиллах талаар ойлголтгүй байгаа нь харагдаж байна.

Багш бэлтгэх, давтан сургах их, дээд сургуульд хүний эрхийн хичээл үздэг байх нь хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх олон чухал асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой юм. 2004-2005 оны хичээлийн жилээс эхлэн Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн эрх зүй,

нийгмийн ухаан, түүхийн багшийн ангиудад “Хүний эрхийн боловсрол” хичээлийг сонгон суралцах хэлбэрээр судалж эхэлжээ. Түүнчлэн, 2006 оноос тус сургууль нь дэргэдээ “Хүний эрхийн боловсролын төв”-ийг нээн ажиллуулж, хүний эрхийн сургагч багш бэлтгэх, сургалтын материал боловсруулах, хүний эрхийн мэдээлэл, сургалтын интернэт хуудас ажиллуулах зэрэг олон ажил хийж байна. Манай улсын багш бэлтгэх тогтолцооны цөм болсон Монгол Улсын Боловсролын Их Сургууль ийнхүү хүний эрхийн боловсролын асуудалд анхаарч, уг санаачлагыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яамнаас дэмжиж ирсэн нь сайшаалтай хэдий ч энэ нь зөвхөн нийгмийн ухааны мэргэжлийн багш нарын хүрээнээс халихгүй, бусад мэргэжлийн багш нарт хамааралгүй хэвээр байсаар байна.

Эндээс дүгнэвэл: Хэдийгээр дээр дурдсан зарим нэг нааштай алхмууд байгаа боловч хүний эрхийн боловсролыг албан боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх ажил нийтийг хамарч чадахгүй, хязгаарлагдмал хүрээнд явагдсан хэвээр байна. Ялангуяа албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна. Иймд хүний эрхийн боловсролыг бүх шатны боловсролын стандартад тусган эрх зүйч, багш, эмч, төрийн захиргаа, удирдлагын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуульд заавал үзэх, бусад дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагуудад сонгон суралцах хэлбэрээр олгож, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Гурав. Албан бус боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол

Иргэдийн хүний эрх, эрх зүйн боловсролын түвшин, хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор төрийн ба төрийн бус байгууллагуудаас нэлээд олон тооны судалгаа хийсэн байна. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа, тусалцааны хүртээмжтэй байдал” (2005), Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн нийгмийн ухааны тэнхимийн “Монгол дахь хүний эрхийн боловсрол ба соёлын харьцангуй чанар” (2005), Хууль Зүйн Үндэсний Төвийн “Иргэдийн эрх зүйн албан бус боловсролын эрэлт хэрэгцээний судалгаа” (2005), АНУ-ын Азийн сангийн “Эрх зүйн гэгээрэл-Монгол Улсад” (2004) зэрэг судалгааг дурдаж болно. Эдгээр судалгааны үр дүнгээс иргэдийн дийлэнх нь хүний эрх, эрх зүйн боловсролын ач холбогдлыг мэдэж байгаа боловч хүний эрхийн талаар цогц мэдлэг ойлголтгүй, эрх, эрх чөлөөгөө хамгаалах чадвар дутмаг байгааг тогтоожээ. Дээрх судалгаануудад иргэдийн ихэнх нь эрх, эрх чөлөө нь зөрчигдсөний дараа л хүний эрхийн боловсрол чухал болохыг ойлгодог талаар дурдсан нь анхаарал татаж байна.

Нийт иргэдэд хүний эрхийн албан бус боловсрол олгох ажлыг төрийн болон төрийн бус байгууллагаас олон улсын байгууллагуудтай хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулж ирсэн байна.

2005 оноос эхлэн Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх байгууллагад хүний эрхийг хангах салбар хороод байгуулагдсан ба төрийн албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдийн эрх, эрх чөлөөг

хүндэтгэн харьцах хандлага төлөвшүүлэх үүргээ гүйцэтгэхэд нь эдгээр салбар хороодыг мэргэшил, арга зүйгээр дэмжин, тогтвортой ажиллах нөхцөл бололцоогоор хангах улмаар төрийн албан хаагчдад хүний эрхийн албан бус боловсрол олгох түшиц нэгж болгон хөгжүүлэх, энэ тал дээр хүний эрхийн сургалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийн боловсрол олгох хүний эрхийн сургалт, сургалчилгааны ажлыг бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг хамруулан зохион байгуулах ажлыг бодлогоор дэмжин чиглүүлэх, үүнд бусад Төрийн бус байгууллагуудыг татан оролцуулах тал дээр илүү түлхүү анхаарч ажиллах нь зүйтэй.

Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд иргэний нийгмийн байгууллагууд ихээхэн хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн, энэ ажилд хэвлэл, мэдээллийн байгууллагууд идэвхтэй оролцож иржээ. Үүний жишээ болгон илтгэлийн энэ хэсэгт би Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас байгууллагын чиг үүрэг, кампанит ажлын хүрээнд албан бусаар Хүний эрхийн боловсрол олгох чиглэлээр хийсэн ажлуудаас дэлгэрүүлэн дурдахыг хүсч байна. Үүнд:

Сургагч багш бэлтгэх чиглэлээр

Монголын Эмнести Интернэшнл нь дангаар болон бусад байгууллагуудтай хамтран Ерөнхий боловсролын сургууль-ын менежер, нийгмийн ажилтан, багш, Төрийн бус байгууллагуудын ажилтан, албан хаагч, хүний эрхийн хамгаалагч⁷⁶, Хууль сахиулах

байгууллагын ажилтнууд, сэтгүүлч, Монголын Эмнести Интернэшнлийн гишүүд зэрэг давтагдсан тоогоор нийт 1500 гаруй хүнийг хүний эрхийн сургагч багшаар бэлтгэсэн бөгөөд үүнд зарим сургагч багш нарыг хүний эрхийн заах арга зүй, хүүхэд, эмэгтэйчүүдийн эрх, шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх, хууль сахиулах байгууллага ба хүний эрх, хүний эрхийг сургалтын хөтөлбөрт, эрүүдэн шүүхийн эсрэг чиглэлээр төрөлжүүлэн бэлтгэсэн байна. Мөн сургагч багш нарт зориулсан “Эрх чөлөөний төлөө тэмцэх нь” боловсролын багц, Иргэдийн хүний эрхийн боловсрол, Хүний эрхийн боловсролыг иргэний боловсрол хичээлээр заах нь, “Хүний эрх сургалтын хөтөлбөрт: Түүх, Математик”, “Эрхээ эдлэцгээе: Жендэрийн тухай мэдлэгийг дээшлүүлэх нь”, “Хүний эрхийг заах багш нарт зориулсан гарын авлага”, “Цагдаа нарт хүний эрхийг заах нь”, “Кино хэлэлцүүлгээр амьдрах чадвар олгох нь”, “Бидний эрх- Бидний ертөнц: Дунд сургуульд эрх, хариуцлагын тухай заах нь”, “Хүний эрхийг заах цагаан толгой” зэрэг 20 гаруй гарын авлага, ном товхимолыг тус бүр 500-2000 хувь хэвлэж тараасан байна. Эдгээр бүх ном нь хүний эрхийг заах багш нарт зориулсан гарын авлагууд юм.

Хүүхэд, Эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр

Бидний эрх- Бидний Ертөнц, Гэр бүл ба хүүхэд, Хүний эрх чанартай боловсрол, ХЭТТ, Эр хүн эр хүндээ, Эдлэх ёстой эрх, Эрхийнхээ төлөө шуугицгаая, Феминизм ба хүний эрх, Эмэгтэйчүүдийн эрх- хүний эрх, Эрхээ эдлэцгээе, Орчин үеийн боолчлол ба хүний наймаа, Охидод аюулгүй сургууль, Хүйсийн тэгш эрх, Эрхүүлэйг төрүүлэх аян,

⁷⁶ “Хүний эрхийг хамгаалагч” гэдэг нь бие дааж буюу бусадтай хамтран хүний эрхийг хамгаалах буюу хөхүүлэн дэмжих талаар ажиллаж байгаа хүнийг хэлнэ.

дараах линкээр орж үзнэ үү. <http://www.amnesty.mn/files/aim/docs/files/2010/03/file-48.pdf>

Эрхүүлэйтэй найзалцгаая зэрэг олон арван сэдвээрх сургалт, иргэдийг гэгээрүүлэх ажлыг Ерөнхий боловсролын сургууль-ын 30 гаруй дунд сургууль, Найрамдал, Нарс, Зулзага, Ундраа зэрэг 10-аад зуны зуслан, Их, дээд сургуулийн оюутан залуучууд, Зүүн хараа, Амгалан, Эмэгтэйчүүдийн хорих ангийн хоригдогчидод явуулсан бөгөөд эдгээрт 23000 гаруй хүн хамрагдаж, сургалт сурталчилгааны ажилд оролцсон байна. Эмэгтэйчүүдийн эрх ном, ХЭТТ-ын хялбаршуулсан зурагт хуудас, Бид эрхээ заалгах эрхтэй зурагт хуудас, ХЭТТ бүхий Дэлхийн иргэний паспорт зэргийг нийт 30000 хувь хэвлэн тараасан байна. Мөн Гэр бүлийн Радио 104,5, Монголын Үндэсний радио, Монгол телевизээр сар бүрийн цуврал нэвтрүүлгүүдийг хийж олны хүртээл болгосон байна. Мөн онлайнаар хүний эрхийг заах сургалт зохион байгуулж, нийт 20 гаруй сурагчийг хамруулсан ба цаашид энэ чиглэлээр сургалт явуулах сургагч багш нарыг бэлтгэх, сургалт явуулах чиглэлээр анхааран ажиллаж байна.

Хууль сахиулах байгууллагын ажилтнуудад зориулсан болон Эрүүдэн шүүхийн эсрэг сургалт

Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх, Хүний эрх ба хууль сахиулах байгууллага, Хорих байгууллага дахь хүний эрхийн боловсрол, Хүний эрх ба эрүүдэн шүүхийн эсрэг конвенц, Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх нь, Цаазаар авах ял ба хүний эрх, Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь зэрэг олон арван сургалт, олон нийтийг гэгээрүүлэх ажлыг шүүгч, прокурор, хорих байгууллагын ажилтнууд, хоригдол, цагдаагийн байгууллагын алба хаагч, удирдах албан тушаалтнуудад давтагдсан тоогоор нийт 21 аймгийн 2560 гаруй алба хаагч, 3000 гаруй хоригдолд явуулсан байна.

Мөн Иргэн тантай цагдаа яаж харьцах ёстой вэ танилцуулга хуудсыг 10000 хувь хэвлэж тарааснаас гадна Хүч ба галт зэвсэг хэрэглэх нь Цагдаагийн гарын авлагыг 6000 хувь хэвлэн бүх орон нутгийн Хэв журмын хэлтэсийн цагдаагийн алба хаагчдад тараасан байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн чиглэлээр

Америкийн Эмнести интернэшнл, Ажил олгогч Эздийн Холбоо, Нийслэлийн дэргэдэх хүний эрхийн хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс зэрэг байгууллагуудтай хамтран гадаадын хөрөнгө оруулалттай зарим аж ахуйн нэгж, уул уурхайн компаниудад “Бизнес ба хүний эрх” Бизнесийн үйл ажиллагаанд баримтлах хүний эрхийн зарчмууд, Даяаршлын тунхаг зэргээр нийт 460 гаруй хүнд сургалт явуулсан бөгөөд “Хүнийг хүндэл” кампанит ажлын хүрээнд Архангай аймгийн малчид, нийслэлийн дүүрэг хороодын нийгмийн ажилтнууд, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургууль, ЭМ-А-ЮУ дээд сургууль гэх мэт улсын болон хувийн их дээд сургуулийн оюутнууд нийт 2500 гаруй хүнд энэ чиглэлээр сургалт сурталчилгааны ажлыг хийсэн байна.

Цагаач ажилтны эрх, Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх зэрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргадаг Мэргэжлийн цуврал сургалтын гарын авлага, Бизнесийн үйл ажиллагаанд баримтлах Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн хэм хэмжээ зэрэг ном товхимолуудыг орчуулан тус бүр 1000 хувь хэвлэн гаргаж номын сан, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын алба хаагчдын хүртээл болгоод байна.

Эндээс дүгнэвэл: Хүний эрхийн байгууллагууд болон хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд нь иргэдийн хүний эрхийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, хүний эрхийг түгээн дэлгэрүүлэх асар их нөөц, бололцоо мөн гэдэг нь харагдаж байна. Иймд эдгээр мэргэшсэн байгууллагуудаас хүний эрхийн боловсролын чиглэлээр зохион байгуулж байгаа ажлыг уялдуулан зохицуулах, мэдээллээр хангах, хүний эрхийн болоод бусад Төрийн бус байгууллагуудын хүний эрхийн чиглэлээр гаргасан ном товхимол, гарын авлага, тараах материал зэргийг шаардлагатай гэж үзвэл төрийн хөрөнгөөр олшруулан олон нийтийн хүртээл болгох, төрийн албан хаагч болон гол гол мэргэжлийн хүмүүст ширээний ном болгон тараах, хүний эрхийн боловсрол олгож буй Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад саад тавихгүй байх, зарим сургалтыг гэрээгээр гүйцэтгүүлэх зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай байна.

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний талаар санал зөвлөмж

Ингээд албан ба албан бус боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгох ажлын чанар, үр дүнг сайжруулах үүднээс дараах саналуудыг оруулж байна.

Мэргэжлийн сургалтын хүрээнд

1. Хүний эрхийн боловсролыг дээд боловсролын стандартад тусган эрх зүйч, багш, эмч, төрийн захиргааны болон цэргийн албан хаагчид бэлтгэдэг их, дээд сургуульд заавал судалдаг хичээл болгон оруулах;

2. Улс төрийн томилгоогоор төрийн алба хашигч аливаа этгээдэд хүний эрхийн чиглэлээр 2-оос доошгүй кредит цагийн

сургалтанд суусан байх шалгуур тавьж, үүнийг хуульчлан баталгаажуулах, Хууль зүйн их дээд сургууль, хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн байгууллагуудад хандан тэдэнд зориулсан сургалтын хөтөлбөр бий болгох, сургалт явуулах тогтолцоо бий болгох, мөн энэ төрлийн сургалт явуулдаг Их дээд сургууль, Төрийн бус байгууллагыг бодлогоор дэмжих, сургалтыг төр гэрээгээр гүйцэтгүүлэх;

3. Хуульчдын давтан сургалт, кредит цагийн сургалтын хөтөлбөрт хүний эрхийн чиглэлээр сургалтуудыг нэмж оруулах, энэ чиглэлээр мэргэшсэн хүний эрхийн болон бусад Төрийн бус байгууллагын хөтөлбөрийг аттестатчилан батламжилж, кредит тооцдог болох, тэдэнтэй гэрээ хийн ажиллуулах.

Албан бус боловсролын хүрээнд:

1. Урлаг, хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд хувь нэмрээ оруулах, энэ чиглэлээр гэгээрүүлэх үйл ажиллагаанд уриалах, ийм нэвтрүүлэг, нийтлэлийг дэмжих, худалдан авах, захиалах, үүнд тодорхой хөрөнгө мөнгө төсөвлөх;

2. Хүний эрхийн болоод бусад Төрийн бус байгууллагуудын хүний эрхийн чиглэлээр гаргасан ном товхимол, гарын авлага, тараах материал зэргийг шаардлагатай гэж үзвэл төрийн хөрөнгөөр олшруулан олон нийтийн хүртээл болгох, төрийн албан хаагч болон гол гол мэргэжлийн хүмүүст ширээний ном болгон тараах;

3. Хүний эрхийн боловсрол олгож буй Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, зарим сургалтыг гэрээгээр гүйцэтгүүлэх;

4. Хүний эрхийг хангах салбар хороодыг тогтвортой ажиллах нөхцөл бололцоогоор ханган, төрийн албан хаагчдад хүний эрхийн албан бус боловсрол олгох

түшиц нэгж болгон хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд анхаарах;

5. Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох талаарх иргэний нийгмийн байгууллагуудын санаачлагыг дэмжих, урамшуулах, хамтран ажиллах.

Үндэсний сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд:

1. Тодорхой салбар чиглэл бүрээр хүний эрхийн үндэсний сургагч багш нарыг ойрын хугацаан эрчимтэйгээр бэлтгэх тусгай хөтөлбөр гаргаж түүнийг ЗГ-аас санхүүжүүлэх;

2. Одоогоор төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд бэлтгэгдсэн хүний эрхийн чиглэлээр сургалт явуулж байгаа сургагч багш нарын жагсаалтыг гаргаж хүний нөөцийг бүрдүүлэх, дайчлах, хүний эрхийг заах багшид тавих шаардлага хангасан байдлыг баталгаажуулах, тэдний мэдлэг, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх ажлыг нэгдсэн бодлогоор зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3. Хүний эрхийн чиглэлээр сургалт явуулж байгаа мэргэшсэн байгууллагуудын сургалтын хөтөлбөрийг аттестатчилан батламжилж, кредит тооцдог болох.

Хүний эрхийн боловсролын чиглэлээр боловсрогдсон гарын авлага материалыг олон нийтийн хүртээл болгох үүднээс:

1. Хүний эрхийн боловсролын тусгайлсан ном, сургалтын гарын авлага, материал бусад хэрэглэгдэхүүнийг боловсруулах, хэвлүүлэх, түгээх ажлыг эрчимжүүлэх, одоо бэлэн байгаа, хүний эрхийн болон Төрийн бус байгууллагуудын боловсруулж гаргасан гарын авлага материалыг шаардлагатай гэж үзвэл хангалттай тоогоор хэвлүүлж, олон нийтийн хүртээл болгох, тэдгээрийг ашиглах талаар

дагалдах сургалтуудыг зохион байгуулахад хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

2. Хүний эрхийн боловсролын сургалтын материалыг цуглуулах, орчуулах, өөрийн орны агуулгаар баяжуулах, багшид зориулсан гарын авлага, ном, сургалтын материалыг боловсруулах ажлыг дэмжих;

3. Төрийн бус байгууллагуудын боловсруулж гаргасан гарын авлага материалыг хангалттай тоогоор хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох, тэдгээрийг ашиглах талаар дагалдах сургалтуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, түүнд шаардагдах хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн Бага дунд боловсролын тогтолцоонд хүний эрхийг нэгтгэх зорилтыг хангах ажлыг эрчимжүүлэх үүднээс:

1. Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоонд хүний эрхийг нэгтгэх Дэлхийн Хөтөлбөрийн 1-р шатны зорилтын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх үүднээс Үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх стратегийг энэ чиглэлээр гарсан олон улсын баримт бичиг, хөтөлбөрүүдэд нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх, энэ стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохицуулах ажлын нэгж хэсгийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны дэргэд шинэчлэн зохион байгуулах, ажлыг эрчимжүүлэх, үйл ажиллагаанд нь шаардагдах төсөв санхүүг хуваарилах;

2. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн Төрийн бус байгууллагуудад түшиглэх, гэрээгээр гүйцэтгүүлэх, санхүүжүүлэх;

3. Төрийн бус байгууллагуудын амжилттай хэрэгжүүлж ирсэн, зохих үр дүн нь тодорхой төсөл хөтөлбөрийн үзэл санааг

дэмжин үргэлжлүүлэх;

4. Энэ талаар Олон улсын туршлага, сургалтын материал, санал санаачлагаас судлах, мэдээлэл цуглуулах судалгааны төвийг дэмжих ажлыг зохион байгуулах;

5. Сургуулиуд дээр эрхэд суурилсан боловсролын хандлагыг хөгжүүлэх чиглэлээр НҮБ болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас хамтран хэрэгжүүлж ирсэн “Хүүхдэд ээлтэй сургууль” төсөл, мөн ОУ-ын Эмнести Интернэшнл байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Хүний эрхэд ээлтэй сургууль” төслийн үзэл санааг цаашид түгээн дэлгэрүүлэх, хүртээмжтэй болгох, тогтвортой үргэлжлүүлэхэд төрөөс хөхиүлэн дэмжиж дэмжлэг үзүүлэх.

Хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд багш нар гол үүрэг гүйцэтгэдгийн хувьд Сургуулийн удирдлага, багш нарын хүний эрхийн боловсрол, хандлагыг төлөвшүүлэх үүднээс:

1. Хүний эрхийн боловсролд сургах/сурах арга барилд багшийг сургах, чадавхижуулах ажлыг багш мэргэжлээр суралцаж байгаа оюутнууд болон одоо байгаа багшийг давтан бэлтгэх дэд хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хүний эрхийн болон бусад Төрийн бус байгууллагуудыг дэмжих, гэрээгээр гүйцэтгүүлэх

2. “Хүний эрх” хичээлийг багш мэргэжлээр сурч төгсөж байгаа оюутан бүр заавал судлах хичээлийн тоонд оруулах;

3. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын заах арга зүйн сургалтын цугларалтын үеэр 1-2 кредит цагийн хүний эрхийн үндсэн сургалтыг явуулж байх;

4. Багш нарт Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулж байгаагаас гадна Хүний эрхийн чиглэлээрх Төрийн бус

байгууллага, олон нийтийн байгууллагаас явуулж буй сургалтанд суусан бол түүнд сертификатыг нь үндэслэн кредит тооцдог болох;

5. Хүний эрхийн боловсролыг заах арга зүй, хүний эрхэд ээлтэй сургалтын арга зүй болон хүний эрхийн үзэл санааг хичээлдээ тусгах арга зүйд багшийг сургах, чадавхижуулах, уг ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллуулах талаар холбогдох шийдвэр гаргаж баталгаажуулах, багшийн мэргэжлийн ур чадварыг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болгон баталгаажуулах;

6. Хүний эрхийн боловсролыг сургуульдаа хөхиүлэн дэмжих чиглэлээрх сургуулийн төлөвлөгөөг сургууль бүр гарган мөрдөж ажиллахад мэргэжлийн байгууллагууд хяналт тавьж ажиллах, үүнийг “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх үзүүлэлтүүдэд”, ерөнхий боловсролын сургуулийн хүний эрхийн орчныг хэрхэн бүрдүүлж буйг хэмжих шалгуурт оруулан тооцдог болгох;

7. Сургуулийн захирал нь хүний эрхийн талаар зөв хандлагатай байж энэ ажил амжилттай хэрэгжинэ. Иймд сургуулийн захирлын томилгоонд анхаарлаа хандуулах цаг болсон. Мөн үүний зэрэгцээ одоо байгаа захирлууд болон нийгмийн ажилтанг мэргэшүүлж, мэргэжлийн ур чадварыг нь ахиулах,

Хүний эрхийн боловсролын тусгайлан хариуцлагын бодлого тогтоох үүднээс:

1. Багшлах эрхийг олгох, багшийн мэргэжлийн зэргийг ахиулах шалгуур үзүүлэлтэнд Хүний эрхийн боловсролын сургалтанд хамрагдсан байх шаардлагыг нэг үзүүлэлт болгох;

2. Сурагчдын хүний эрхэд суурилсан

мэдлэг, чадвар, хандлагын төлөвшилд хийх үнэлгээг боловсруулан баталж мөрдөх, түүнийгээ багшийн хичээл заалт, заах арга зүй, ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтэнд оруулах, Энэ чиглэлээр орон нутгийн боловсролын удирдлагуудад удирдамж гаргаж өгөх;

3. Хүний эрхийн боловсролын сургалтыг заавал суух кредиттэй сургалтын тоонд оруулах;

4. Сурагчдын ХЭ-д суурилсан мэдлэг, чадвар, хандлагын төлөвшилд хийх үнэлгээг боловсруулан баталж мөрдөх;

5. Сургуулийн удирдлага, менежмент, дотоод дэг журмыг хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэх, сургуулийн захирлын томилгооны шалгуур үзүүлэлт болгон мөрдөж эхлэх;

6. Нийслэл, орон нутгийн боловсрол соёлын газрууд өөрийн нутаг дэвсгэрт сургуулийн хүний эрхийн орчинг

бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулж, шаардлагатай мэргэжил, арга зүйн туслалцаа дэмжлэгийг үзүүлэх;

7. Хүний эрхийн суурь зарчмууд, мэдлэг, чадвар, хандлагыг бичиг үсэг тайлагдалт, тоо бодох чадварт сургах зэрэгтэй адил зайлшгүй эзэмшвэл зохих үндсэн суурь чадвар, цогц чадамж гэж авч үзэх талаар боловсролын стандартад суулгаж өгөх;

8. Хүний эрхэд сурах/ сургах үйл ажиллагааг иргэний боловсрол, нийгмийн ухаан, түүхийн хичээлүүдээс гадна Ерөнхий боловсролын сургуулийн бүхий л хичээлийн салшгүй нэг гол хэсэг байлгах чиглэлээр холбогдох тушаал шийдвэрийг зохих байгууллагаас гарган баталгаажуулах, хүний эрхийн үзэл санааг Ерөнхий боловсролын сургуулийн бүхий л хичээлийн хөтөлбөрт тусгаж, агуулга, арга зүй, сурах бичгийг үүнд нийцүүлэх ажлыг нэн даруй эхлүүлэх.

ЛЕСБИЯН, ГЕЙ, БИСЕКСУАЛ, ТРАНСЖЕНДЭР ХҮМҮҮСИЙН ТУХАЙ ХЭВЛЭЛЭЭР ТУСГАЖ БУЙ БАЙДАЛ

Чөлөөт сэтгүүлч

Б.ЭГШИГЛЭН

Монгол Улс ардчиллын хаалгаар алхан орсноос хойш 20 гаруй жилийн хугацаа өнгөрчээ. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж, хэнийг ч яс үндэс, гарал угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болохыг Үндсэн хуульдаа заасан 123 улсын нэг. Түүнчлэн манай улс 1961 онд НҮБ-ын босгыг алхан орсноор тус байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээг дэмжиж, оролцох болсон билээ. НҮБ-ын Ерөнхий ассамблей, Хүний эрхийн хорооноос 2011 онд санаачилсан Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендэр (цаашид “ЛГБТ” гэх) хүмүүсийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийллээр гадуурхах, ЛГБТ хүмүүсийг хүчирхийлэхийн эсрэг тогтоолд нэгдэж, гарын үсэг зуран баталгаажуулсан 94 улс байгаагийн нэг нь Монгол Улс юм⁷⁷. Дашрамд дурдахад, Ази тивээс долоон орон уг тогтоолд нэгдсэн билээ. Гэвч өнөөгийн нийгэмд бэлгийн цөөнх буюу ЛГБТ хүмүүсийн тухай ерөнхий ойлголт дутмаг байна. Үүнээс болж цөөнхийн тоонд багтдаг цөөн бус хүний эрх зөрчигдөх, дарамт шахалтан дор, айдастай амьдрах, өөрийн бэлгийн чиг баримжааг нуух, цашилбал бусдын гарт амиа алдах, өөрийн амийг егүүтгэх хүртэл хурцадмал асуудал үүсдэгийг

Монголын ЛГБТ төвийн тайлан, илтгэл харуулдаг⁷⁸. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь зохион байгуулах үүргийнхээ дагуу нийгмийн санаа бодлыг төлөвшүүлж байдаг. Энэ тохиолдолд үзэгч, уншигч, сонсогчид олон нийтийн мэдээллийн хэрэгслээс ухамсартай болон ухамсаргүйгээр бэлгийн цөөнхийн тухай ойлголт, харах өнцгөө бүрдүүлдэг байх хандлагатай. Гэвч манайд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ тухай хэрхэн мэдээлж, ямар өнцгөөс тусгаж буйг судалсан ажил байхгүй байна. Тиймээс бид олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн нэвтрүүлсэн бэлгийн цөөнхийн тухай мэдээлэл, нийтлэлийг судлах замаар хүмүүст ямар нөлөө үзүүлж буйг нь тусгахаар зориглолоо.

Сэдвийг сонгох болсон өөр нэг учир нь сайн сэтгүүл зүйн тухай ойлголт юм. Сайн сэтгүүл зүй буюу үнэн, тэнцвэртэй, бодитой мэдээллийг түгээдэг сэтгүүл зүйн үндэс суурь нь хүний эрх байдаг. Хүний эрхийг хүндэтгэж, зөв өнцгөөс тусгасан мэдээлэл нийгэмд эерэгээр нөлөөлдөг. Сэтгүүл зүйн хочоч нохойн үүрэг ч хүний эрхийн зөрчлийг илрүүлэх, мэдээлэх, шийдвэрлэх арга зам хайхаас эхтэй. Хээл хахууль авсан албан тушаалтны тухай мэдээ, уул уурхай, барилгын ажлын зөрчил, эрх баригчдын алдаатай шийдвэрийг шүүмжилсэн нийтлэл гээд бүгд л үндсээрээ

⁷⁷ http://www.huffingtonpost.com/2011/06/17/un-gay-rights-protection-resolution-passes-_n_879032.html

⁷⁸ <http://lgbtcentre.mn/mn/reports-publications/reports.html>
<https://www.amnesty.org/en/region/mongolia/report-2010>

хүний эрхийг зөрчсөн асуудлыг тусгаж буй хэрэг. Тэгвэл бэлгийн цөөнх (ЛГБТ) хэмээн нэрлэгддэг ижил хүйстэн эрэгтэй, эмэгтэй, аль, аль хүйсийнхэнд татагддаг бисексуал, трансгендер буюу төрөлхийн хүйс нь оюуны хүйстэйгээ зөрчилддөг хүмүүстэй холбоотой мэдээллийг хэвлэл мэдээлэлд хэрхэн тусгаж байгаа нь хүний эрхэд суурилсан сэтгүүл зүйн нэг шалгуур үзүүлэлт юм. Ийм учраас ЛГБТ хүмүүсийг хүлээн авах нийгмийн хандлагад олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар нөлөө үзүүлдэг эсэх, үүгээр дамжуулан хүний эрхэд суурилсан сэтгүүл зүй Монголд ямар түвшинд байгааг судлахаар энэ сэдвийг сонгон авлаа.

Энэ хүрээнд 2012 оны бүх дугаарыг түүвэрлэн нэлэнхүй байдлаар сэтгүүл зүйн онол ба нийгмийн харилцаа, агуулгын судалгаанд тулгуурлан судалгаа хийлээ. Хэвлэлийн хүрээлэнгийн хэвлэл мэдээллийн мониторинг судалгаагаар сүүлийн дөрвөн жил борлуулалтын тоогоороо тэргүүлж, хамгийн түгээмэл сониноор шалгарсан “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ” сонинг судалгаанд сонгосон юм⁷⁹. Түүнчлэн “Alexa” компанийн явуулсан судалгаагаар Монголын хамгийн их хандалттай 10 сайтын нэгээр шалгарсан News.mn-ыг судалгаанд хамруулсан⁸⁰. Үүнээс гадна сэтгүүлчдийн ойлголт, өнцгийг илрүүлэхийн тулд анкетийн аргаар түүвэрлэн судалгаа хийсэн. Тус гурван хэвлэлд 2012 онд нийт 53 мэдээлэл гарчээ. Үүнээс “Зууны мэдээ” 20, “Өнөөдөр”, “Өдрийн сонин” тус, тус 5, News.mn сайтад 23 мэдээ, мэдээлэл нийтэлжээ.

“Зууны мэдээ” сонин 2012 оны дугаартаа ижил хүйстэн, трансгендерийн тухай нийт 20 материал нийтэлжээ. Үүнээс дийлэнх нь буюу 16 нь мэдээ бол гурав нь нийтлэлийн дэд гарчиг бүхий жижиг хэсэг, үлдсэн нь

ярилцлага байна. Нэг дутагдалтай тал нь нийт гарсан мэдээллийн 80 хувь нь гадаад мэдээ аж. Үүн дотор олны танил хүмүүстэй холбоотой мэдээлэл дийлэнх хувийг эзэлнэ. Тухайлбал, “Рики Мартин анх удаа нөхөр хүүхдээ харуулав” гарчигтай мэдээнд ижил хүйстэн дуучин “Vanity Fair” сэтгүүлд гэр бүлийнхнийхээ зургийг нийтлүүлсэн тухай бичжээ. “Мадоннаг гомосексуализмийг сурталчилсан гэж буруутгав”-д нэрт дуучин Оросын Холбооны Улсын Санкт-Петербургт хийсэн тоглолтынхоо үеэр тус улсын эрх баригчдын ижил хүйстнийг хяхан хавчихаа больж, эрхийг нь хүндэтгэхийг уриалсанд буруутгасан тухай нийтэлжээ. Оросын хуулиар ижил хүйстний харилцааг дэмжсэн, сурталчилсан тохиолдолд 15700 долларын торгууль ногдуулдаг тухай тайлбарлан хүргэсэн байна.

Харин Монгол мэдээлэлд трансгендер, манин хүмүүстэй холбоотой асуудлыг мэдээ, нийтлэлдээ оруулжээ. Тухайлбал 2013 оны нэгдүгээр сарын 9-нд нийтэлсэн “Манин төрсөн хийгээд тарсны учир”-ын эхний хэсэгт интерсекс буюу саармаг хүйстний биеийн бүтэц, онцлогын тухай тайлбарласнаа Ардчилсан нам, Монгол ардын намын зөвшилцөлийн Засгийн газартай холбон бичсэн байна. Тэгвэл өөр нэгэн мэдээ нь “Гей мисс Энхриймаа мэс засалд удахгүй орно” гарчигтай. Ц.Батболд зохиогчтой уг мэдээнд “...Бэлгийн чиг хандлагаасаа болж олон нийтэд ад үзэгдэж байсан гей мисс Энхриймаа хүйс солиулах хагалгаанд удахгүй орох гэж байна...” хэмээн бичсэн нь уншигчид буруу ойлголт төрүүлэхээр байна гэж үзлээ. Мэдээнд өгүүлж буй хүн нь трансгендер буюу байгалиас заяасан хүйс, сэтгэл санааны хүйс хоёр нь хоорондоо тааран зохицохгүй зөрчилддөг нэгэн. Харин дээрх мэдээ нь гей буюу ижил хүйстэн хүмүүс эсрэг хүйсийнхээ хүмүүсийн дүрд

⁷⁹ Хэвлэлийн хүрээлэнгийн мониторинг судалгаа, 2012 он
⁸⁰ <http://www.alexa.com/topsites/countries/MN>

хувирах, эрэгтэй нь эмэгтэй, эмэгтэй нь эрэгтэй болохыг хүсдэг мэт буруу ойлголт төрүүлж байна. Тэгвэл “Өнөөдөр” болон “Өдрийн сонин”-ы хувьд зөвхөн гадаад мэдээнүүд орчуулан нийтэлжээ Агуулгын хувьд, Берлин хотод зохион байгуулагдсан ижил хүйстнүүдийн жагсаал, гадаад орнуудын ижил хүйстнүүдийн гэрлэлтийг зөвшөөрсөн хууль, эсэргүүцсэн хүмүүсийн тухай эсвэл Лэди Гага, Элтон Жон нарын оддын тухай мэдээлэл байна. Эндээс дүгнэлт хийвэл томоохонд тооцогддог тус хоёр сонин ЛГБТ асуудлын тухай, ялангуяа Монголтой холбоотой мэдээлэл, нийтлэл бэлтгэхгүй байгаа нь үгүйсгэсэн, асуудлыг хөндөхөөс зайлсхийсэн мэт ч нөгөө талаар гадаадын ЛГБТ-тэй холбоотой мэдээ орчуулан хэвлэсэн нь мөн эргэлзээтэй юм. Судалгаанд хамруулсан хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс News.mn-д дурдан буй сэдэвтэй холбоотой мэдээ, мэдээлэл харьцангуй их гарчээ. Хэдийгээр үүний дийлэнхийг мөн л гадаад мэдээ эзэлж байгаа ч хэмжээний хувьд том, өргөн цар хүрээтэй байв. Тухайлбал, “Ногоонтнуудын дундах анхны цэнхэр” орчуулгын нийтлэлд өнгөрсөн онд болсон Финляндын ерөнхийлөгчийн сонгуулийн хүчтэй өрсөлдөгчдийн нэг, анхны нээлттэй гей буюу бэлгийн чиг баримжаагаа нуудаггүй нэр дэвшигч болсон юм. Ногоонтны намын зүтгэлтэн түүний тухай уг нийтлэлд өгүүлсэн байлаа. Түүнчлэн нийтлэлд “...Одоо бол уламжлалт бус сексийн хандлагатай хүнээс дээд тушаалд сууж байгаа ганц хүн нь Исландын ерөнхий сайд лесби Йоханна Сигурдардоттир юм. Тэрээр 2009 онд ерөнхий сайд болонгуут ижил хүйсийн гэрлэлтийг зөвшөөрсөн хууль батлуулсныхаа дараа зохиолч эмэгтэй Йонина Леосдоттиртай гэр бүл болжээ...” хэмээн нэмэлт мэдээлэл оруулжээ.

Судалгаа хийсэн хэвлэлүүдээс Монгол

дахь ЛГБТ асуудлыг хөндсөн ганц нийтлэл олдсон нь мөн л News.mn (Ардын эрх)-д гарсан байв. Сэтгүүлч А.Шархүүгийн бичсэн “Ядаж ганц цаг өгчих” нэртэй эл нийтлэлд нийгмийн зүгээс ижил хүйстнүүдэд учирдаг дарамт шахалт, ялангуяа боловсролын орчин, хүмүүсийн ойлголт дутмаг байгаа явдлыг хөнджээ. Нийтлэлээс иш татвал, “... Тэдний тухай мэдээллийг хайх явцад нэг зүйлийг улам баттай мэдэв. Бас ч үгүй боловсролтой хэсгийн хэрэглэгчидтэй мэдээллийн сайтад “Улс орнуудын хүн амын арав орчим хувь нь бэлгийн цөөнх байдаг” тухай мэдээлжээ. Гэтэл энэ тухай мэдээллийн доор бичигдсэн comment буюу сэтгэгдлийн 98 хувь нь эсэргүүцсэн зүйл бичжээ. Зүгээр эсэргүүцэхээр барахгүй доромжилж, заналхийлж. Хэдийгээр өнөөгийн нийгэм хүн бүрийг эрх чөлөөтэй, тэгш эрхтэй хэмээн тунхагладаг боловч бэлгийн цөөнхийг хүлээн зөвшөөрөх хэмжээнд хүрээгүй л байгаа нь улам тодорхой болов. “Нийгмийн сайн сайхны төлөө шаардлагагүй цөөнхийг зохиослож байж хөгжинө” “Та нар хоорондоо л явалд, битгий жоохон хүүхдүүдийг уруу тат”, “Ямар сэжгийн юм бэ, ийм хүний бус зүйлийг сурталчлахаа болиосой” гээд бичих нь бүү хэл уншихад ч эвгүйцмээр зүйлс цааш уртаас урт үргэлжилнэ. Тэд “хүн өөрийн бэлгийн чиг баримжааг сонгодоггүй. Эхийн хэвлийд үр хөврөл бүрэлдэж эхлээд өнчин тархи бүрэлдэж эхлэхэд хүний бэлгийн чиг баримжаа тогтдог ба төрөлхийн учир түүнийгээ өөрчилж чаддаггүйг олон орны эрдэмтэд нотолсон” гэдгийг сонсоогүй, хэн ч тэдэнд сургаагүй тул ийнхүү үзэн ядаж буй нь аргагүй. Бэлгийн цөөнхийг хамгаалсан, өмгөөлсөн үгс цөөн харагдах хэдий ч өмгөөлж үг хэлснийх нь төлөө доромжлуулж, үгийн муугаар дуудуулна. “Цөөхөн байна гэдэг нь гаж гэсэн үг биш. Үр хүүхэд чинь ижил хүйстэн болж төрвөл яах вэ? Ингээд

та нар хараагаад үр хүүхдээсээ амьдын холбоогоо таслах уу?” “Уруу татагдаад бэлгийн чиг баримжаагаа өөрчилчихдөг ч юм биш” “Би та нараас талх гуйгаагүй. Тайван амьдармаар байна л гэж гуйж байна” гэх үгсийг ойлгохыг хүссэн “зочин” даанч алга...” зэргээр бичжээ.

Ерөнхийдөө 2012 оны хэвлэлүүдийн ЛГБТ мэдээ, мэдээлэл төвийг сахиж, дундыг баримталсан байр суурьтай байна. Ижил хүйстэн, трансжендерүүдийг буруутгасан, гутаан доромжилсон, эсвэл дэмжсэн агуулга, байр суурь бараг байхгүй. Магадгүй ихэнх мэдээлэлд олон улсын мэдээ, гадаад улсуудад ижил хүйстний гэрлэлтийг хуульчилсан эсвэл ЛГБТ жагсаал, парад болсон тухай мэдээлж байгаа учраас байр суурь нь ялгарч харагдахгүй байж болох юм. Харин сөрөг агуулгатай мэдээлэл ганцхан байгаа нь “Өнөөдөр”-т гарчээ.

М.Сугар-Эрдэнэ зохиогчтой “Хятад гомочууд ууртай байна” мэдээнд Хятадын эрх баригчид Бээжинд зохион байгуулах байсан “Mr.Gay China” тэмцээнийг хориглосон тухай өгүүлжээ. Ингэхдээ тэмцээний нэрийг “Томо мисс шалгаруулах тэмцээн” хэмээн орчуулсан нь мөн л буруу, сөрөг ойлголт төрүүлэхээр байна. “Мисс” гэдэг нь эмэгтэй хүйсэнд хамаарах үг, түүнчлэн Ассошэйтэд пресс агентлаг, Glaad зэрэг байгууллагаас сэтгүүлчдэд зориулан гаргасан зөвлөмжинд “гомо” буюу “homo” хэмээх үг нь хүнийг алагчлах, гутаан доромжлох утга агуулгатай хэмээн хэрэглэхгүй байхыг зөвлөжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлж буй өнцөг төвийг сахисан тухай дээр дурдсан. Жишээлбэл, “Өдрийн сонин”-ы 2013 оны наймдугаар сарын 23-ны дугаарт “Тайваньд ижил хүйстнүүд гэр бүлээ баглуулав” мэдээнд Азид хэдийгээр ижил хүйстний гэрлэлтийг албан ёсоор хуульчилсан улс байхгүй ч Тайванийн буддын сүм хоёр эмэгтэйн

гэрлэлтийг адисласан тухай нийтэлжээ. Тэгвэл 2013 оны гуравдугаар сарын нэгэн дугаарт ерөнхийлөгч Барак Обамагийн ижил хүйстний гэрлэлтийг Америк даяар хуульчлах саналтай холбогдуулан цэргүүд ижил хүйстэн, трансжендер хүмүүсийн тухай гарын авлагатай болох тухай бичсэн аж.

Харин News.mn-ы хувьд ЛГБТ-тэй холбоотой мэдээ, мэдээлэл хамгийн их гаргажээ. Үүн дотор Америкийн ерөнхийлөгч Барак Обаматай холбоотой мэдээлэл цөөнгүй хувь эзэлнэ. “Барак Обама ижил хүйстнүүдийг гэрлэх эрхтэй гэв”-д АНУ-ын ерөнхийлөгчийн ABC телевизэд өгсөн ярилцлагтаа гэрлэлтийн тухай байр сууриа албан ёсоор илэрхийлсэн тухай, “Newsweek анхны гей ерөнхийлөгчөөр Обамаг нэрлэжээ”-д долоо хоногийн их гурвалын нэг ерөнхийлөгчийнхөө саналыг дэмжиж буй талаар нийтэлжээ. Түүнчлэн ижил хүйстнүүдийг эсэргүүцэгчдийн тухай цөөнгүй мэдээлсэн нь хоёр талын байр суурийг тусгаж буйгаараа тэнцвэртэй мэдээлж байгааг нь харуулна. Тухайлбал, “Английн сүм ижил хүйстнүүдийг эсэргүүцэв”-д ЛГБТ эрхийг хамгаалдгаараа алдартай Их Британийн сүм хийдүүдийн тэргүүнүүд нэгдэн, ижил хүйстнүүд шашны үнэт зүйлс, уламжлалд харшилж байгааг анхааруулсныг тусгажээ. Тэгвэл өөр нэгэн мэдээнд “Оросын Холбооны Улсад ижил хүйстнүүдийг баривчлав”-д үндсэн эрх нь зөрчигдөж байна хэмээн жагсаал хийсэн ЛГБТ хүмүүсийг цагдаа нар хүч түрэмгийлэн зодож, баривчилсан тухай мэдээлжээ. Ижил хүйстнүүдийн эрхийн төлөө тэмцдэг Анжелина Жолигийн хадам ээж, Брэд Питтийн ээж нь ижил хүйстнүүдийг эсэргүүцсэн захидал “Нью-Йорк Таймс”-д нийтлүүлсэн тухай бичсэн байна. ЛГБТ сэдэвтэй мэдээ, нийтлэл маш ховор хэвлэгдэж байгаа нь өдөр

тутмын сонинуудын судалгаанаас харагсан. Тиймээс 2010 оноос хойш нийтлэгдсэн ЛГБТ асуудлыг хөндсөн нийтлэл, нэвтрүүлгийн тусгайлан сонгон авч, судалгаа хийв. Үүнд, “Өнөөдөр” сонины 2011 оны тавдугаар сарын 31-ны дугаарт сэтгүүлч Ж.Солонгийн бичсэн “Сонголтгүй амьдрал”, “Ардын эрх” сонины 2012 оны наймдугаар сарын 8-ны дугаарт сэтгүүлч А.Шархүүгийн бичсэн “Ядаж ганц цаг өгчих”, “Үндэстний тойм” сэтгүүлийн 2013 оны хоёрдугаар сарын 18-ны дугаарт сэтгүүлч Л.Эрдэнэжаргалын бичсэн “Сэтгэлийн хүйс” нийтлэлийг сонгон авав. Тэгвэл телевизийн нэвтрүүлгийн хувьд Шонхор телевизийн сэтгүүлч Б.Гэрэлжаргалын бэлтгэсэн “Сэтгүүлчийн цаг” цуврал нэвтрүүлгийн дугаар, ТМ телевизийн сэтгүүлч Б.Байгалийн “Ил биш далд ч биш” нэвтрүүлэг, “Стар” телевизийн “Час өдөр” нэвтрүүлгийн дугааруудыг сонгон авсан болно. “Өнөөдөр” сонинд гарсан нийтлэлд ЛБГТ хүмүүсийн эрхийг хамгаалсан байр суурьтай байгаа нь гарчгаас нь л харагдаж байна. Нийтлэл дотроо “Ижил хүйстнээ сонирхох нь гаж хүсэл биш. Тэд ч бас дурладаг”, “Эмэгтэй байх хүсэлтэй ч эр бие заяав”, “Тэд таны хайртай хүн хэвээрээ” гэсэн гурван дэд гарчигт хуваажээ. “... Өөрийгөө ил тод зарласан ижил хүйстэн болон транс охид, хөвгүүдээс гадна ийм байдалтайгаа эвлэрдэггүй олон мянган залуус бидний дунд амьдарч байна. Тэд бусдын хэл амны бай болж, эцэг эхийнхээ нэрийг хугалахаас эмээн бусдын адил гэр бүл зохиодог ч сэтгэл хангалуун байж чаддаггүй. Анх ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчин хэмээн үзэж байсан ч 1990 оны тавдугаар сарын 17-нд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санаачилгаар ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг сэтгэцийн өвчнийг жагсаалтаас хасчээ. Тиймээс эл өдрийг International Day Against

Homophobia and Transphobia (IDАНО) буюу Гомофоби, трансфобийн эсрэг олон улсын өдөр болгон тэмдэглэх болжээ. Ижил хүйстэн хүмүүс, ижил хүйсийн бэлгийн чиг баримжааг ялгаварлан гадуурхах, үзэн ядах, тэднээс айх явдлыг гомофоби, төрсөн хүйсээсээ өөрөөр өөрийгөө илэрхийлж буй хүмүүсийг ялгаварлан гадуурхах үзлийг трансфоби хэмээн тодорхойлдог аж...” хэмээн уг нийтлэл эхлэх бөгөөд ангийн нь хүү трансгендер бүсгүй байсан тухай цааш үргэлжилнэ. Монголын ихэнх ЛГБТ хүн бэлгийн чиг баримжаанаас болж ялгаварлан гадуурхалтад өртөхгүйн тулд эсрэг хүйсийн хүнтэйгээ гэрлэж, хоёр амьдралаар амьдардаг тухай нийтлэлд цааш өгүүлсэн бөгөөд “... Таны ойр дотны хэн нэгэн гей, лесби, бисекс, трансгендэрийн аль нэг нь гэдгийг олж мэдсэн үедээ сайн тунгаан бодоод “Тэр аав, ээж, ах, дүү нараа таньж байна уу?, Таны тухай бүх дурсамжаа санаж байна уу?, Дотнын хүмүүсээ хайрладаг хэвээрээ юу?, Хийж чаддаг байсан ажлаа огт хийж чадахаа больсон уу? Жишээ нь, тэр багш хүн байсан бол хичээл зааж чадахаа больж, эмч байсан бол хүн эмчлэх арга ухаанаа мартсан уу?, Тэр инээдэг үү?, Тэр уйлдаг уу?, Тэр хоол иддэг үү, унтдаг уу?, Тэр ямар нэгэн зүйлээс айдаг уу, ичдэг үү?” гэж өөрөөсөө асуугаарай. ЛГБТ нар бэлгийн чиг баримжааны хувьд танаас ялгаатай байж болох ч тантай л адилхан уйлдаг, инээдэг, боддог, ярьдаг, ажилладаг, хайрладаг, айдаг, ичдэг хэвээрээ байгаа...” хэмээжээ. Гэсэн ч сэтгүүлч Ж.Солонго нийтлэлийн төгсгөлд ЛГБТ нар хэт олширвол хүн амын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх аюултай гэсэн санаа илэрхийлсэн нь өмнө бичсэн зүйлсээ бүхэлд нь үгүйсгэсэн мэт болжээ. Дашрамд дурдахад энэ талын мэдээ, нийтлэл, сурвалжлагат гей хүмүүс олширох нь хүн амын өсөлтөд сөрөг нөлөөтэй хэмээн байнга дурддаг.

Гэтэл хүн амын 10 хүрэхгүй цөөн хувь л ижил хүйстний бэлгийн чиг баримжаатай байгаа нь үнэхээр харанга дэлдэх тоо мөн үү? Дэлхий даяар техник технологи, шинжлэх ухааны хөгжил өсөн нэмэгдэхийн хэрээр хязгааргүй боломжууд бий болсоор байна. Үүний үрээр гей, лесби хосууд ч үр хүүхэдтэй болж чадаж байна⁸¹. Монголын хувьд авч үзвэл ЛГБТ олон нийтийн цөөнгүй хэсэг нь хоёр амьдралаар амьдардаг эсвэл өмнө нь бэлгийн чиг баримжаанаасаа татгалзахыг оролдон, гэр бүл зохиож, үр хүүхэдтэй болсон тохиолдол олон байдаг тухай холбогдох байгууллагийнхан өгүүлсэн. Үүнээс гадна эмэгтэйчүүдийн боловсролын түвшин нэмэгдэх нь хүн амын өсөлттэй урвуу хамааралтай байдаг аж. Харин манай орны хувьд эмэгтэйчүүдийн боловсрол эзэмших, эрчүүдтэй тэгш эрхтэй байхыг дэмждэг. Тэгвэл яагаад ЛГБТ хүмүүстэй холбоотой мэдээ, нийтлэлд төрөлт, хүн амын өсөлтийн бага хувийг байнга тусгаж, бурууг зөвхөн энэ тал руу хазайлдаг вэ? Эндээс харвал сэтгүүлч мөн л асуудалд хайнга хандсан нь анзаарагдана.

“Үндэстний Тойм”-ийн сэтгүүлч Л.Эрдэнэжаргал “Сэтгэлийн хүйс” нийтлэлдээ ижил хүйстэн эрчүүд, трансгендер хүмүүс, тэдний үр удмаа үлдээхтэй холбоотой асуудлыг тусгахыг зорьсон бололтой.

Нийтлэл “...Орчин үед бол Адам туслагч эмэгтэйнхээ адил байхыг хүсдэг болжээ. Өнгөрсөн зууны наяд оноос эхтэй гэх, одоо эрчтэй явагдаж буй эрчүүдийн эмэгтэйших үзэгдэл манай оронд 90-ээд оноос эхтэй гэж үздэг аж...” хэмээн эхэлж байна. “Эрчүүдийн эмэгтэйших үзэгдэл Монголд ихэссэн хэмээн үздэг” гэхдээ хэн ийн үзэж, судалсан тухай

дурдсангүй. Цаашаа сэтгэл зүйн шинжлэх ухаанд хүн төрөлхөөсөө ижил хүйстэн байдаггүй тухай өгүүлсэн ч холбогдох судалгаа, эрдэмтдийн дүгнэлтийн тухай огт дурссангүй нь учир дутагдалтай болжээ. Хэрвээ хүн ижил хүйстэн болж төлөвшдөг бол юунаас болдог тухай ч оруулсангүй.

Нийтлэлийн дунд хэсэгт өөрийн хүйсээ хүлээн зөвшөөрдөггүй трансгендерүүдийн талаар, дэлхийд хүйсээ солиулж эмэгтэй болсон хэдэн зуун сая эрэгтэй бий талаар өгүүлсэн байх юм. “...*Мичиган Стейт Университэт судалгааны байгууллагын судалгаагаар трансгендер байх магадлал эрэгтэй болж төрсөн хүнд 80.000-д 1 байдаг бол эмэгтэй хүнд 125000-д 1 тохиолддог гэж гарчээ. Манай улсын хэмжээнд бол хүн амынхаа тоотой харьцуулаад үзэхээр хамаагүй бага тоо гарах биз. Гэхдээ төрөлхийн дээр нь олдмолыг нь нэмээд үзвэл үндэстний хэмжээнд багадаагүй тоо...*” гэж ээ. Өөрөөр хэлбэл нийтлэл эрчүүдэд эмэгтэй шинж давамгайлах болсон үзэгдлийн тухай эхэлж, ижил хүйстнүүдийн төрөлхийн эсэх талаар үргэлжилсэн нь трансгендер хүмүүсийн тухай судалгаанд хүргэжээ. Сэтгүүлч өөрөө ЛГБТ-тэй холбогдох ойлголт, нэр томъёоны тухай мэдээлэл эрж хайгаагүй, бүхэлд нь хольж хутгаж байгаа нь эндээс харагдаж байна. Хэрвээ хүн бэлгийн чиг баримжаагаа сонгодог бол энэ нь юунаас үүдэлтэй вэ, үүнийг засаж болох уу, нийтлэлд байнга дурдагдаж буй “Монголд олдмол хүмүүс олон” гэх судалгаа, мэдээллийг хаанаас авсан бэ тэргүүтэй баримт, судалгаа, эрдэмтэд, сэтгэл зүйчдийн дүгнэлт огт байхгүй байгаа нь уг нийтлэлийг сэтгүүл зүйн бүтээлээс илүүтэй тухайн сэтгүүлийн сэтгэгдлийн шинжтэй болгож байна.

Нийтлэлийн гарчиг болох “Сэтгэлийн хүйс”-ийг харвал трансгендер хүмүүсийн тухай өгүүлэх гэсэн мэт харагдсан ч агуулга

⁸¹ <http://www.nhs.uk/Livewell/LGBhealth/Pages/Havingchildren.aspx>
<http://abcnews.go.com/Health/wireStory/fertility-clinics-gay-couples-kids-20580759>

нь зөрчилдөж байна. Нийтлэлийн төгсгөлд “...Хүйс солиулах мэс засал хийлгэснээр эмэгтэй хүн шиг өндгөн эс боловсруулж, үр хүүхэд төрүүлэх боломжгүй юм. Гэсэн ч үр удамаа үлдээх хүслээ гүйцэлдүүлэхээр үр шилжүүлэн суулгах зэргээр үрийн зулай үнэрлэдэг. Энэ үед л жинхэнэ аюул үүсч эхэлж магадгүй болоод байгаа юм. Мартаж болохгүй нэг зүйл бол бүхий л амьд зүйлээр дамжуулж удамидаг генийн олон янз байдал нь хэдэн сая жилийн туршид байгалийн шалгарал, генийн шилжилтийн үр дүн байдаг. Байгалийн шалгарал нь дасан зохицож чадсан нь амьд үлддэг тухай бүгд мэддэг ч тэрхүү дасан зохицох хүртлэх зам ямар байхыг хэн ч тааж тайлбарлашгүй юм. Байгалийн хүч тухайн зүйл амьтны ДНХ-г солидоггүй хэдий ч тохирохгүй бодьгалуудыг устгах, нэгэн зүйлийг нийт генийн сангийн мэдээллийг устгаж бол чадна. Энэ нь товчхондоо генийн мэдээллийг алдаж байгаа явдал юм. Генийн өөрчлөлт, амьд бие, эцэг, эхээсээ удамиин авснаас өөр ДНХ-г олж авах нь тэдний ДНХ өөрчлөгдөн мутаци үүсэх эхлэл болдог. Дэлхий дээр шинжлэх ухаанаар тогтоогдсон удамиллийн 5000 төрлийн өвчин мэдэгдээд байна. Хувьслын онол ёсоор үүссэн бүхий л генүүд мутацилагдсан. Бидэнд мэдэгдээд, илэрч байгаа нь ихэнхдээ эерэг байгаа. Харин энэ нь хувьслын маш сулхан жишээ бөгөөд үнэндээ хувьслыг эсэргүүцэж буй жишээ төдий. Энэ бүгд тодорхойгоор ашигтай бус, тодорхой бусаар ашигтай байгаа нь хамгийн аюултай юм...” хэмээн бичжээ. Трансжендер хүн үр шилжүүлэн суулгах аргаар хүүхэдтэй болвол хүүхдийн ДНХ өөрчлөгдөж, мутацид орох нөхцөл бүрдэнэ гэсэн санаа илэрхийлсэн болов уу. Гэхдээ үр шилжүүлэн суулгах нь зөвхөн ЛГБТ хүмүүстэй холбоотой бус, хүүхэд төрүүлэх боломжгүй, үргүй гетеросексуал хүмүүст ч хамаатай асуудал. Тэгэхээр үүнийг

шинжлэх ухааны үндэслэгээ, судалгаа, баримттайгаар тусад нь авч үзэх хэрэгтэй. Харин нийтлэлд Библийн домог, сул дорой эрчүүд, ижил хүйстнүүд, трансжендер, хүйс солих, үр шилжүүлэн суулгах гээд бүх асуудлыг хольж хутган, баримт, судалгаагүй бичсэн нь нийтлэлийг ойлгомжгүй болгожээ. Сэтгүүлч өөрөө сэдвээ огт ойлгоогүй, зорилгоо тодорхойлоогүй бичсэн нь эндээс харагдана. Дашрамд дурдахад, “Үндэстний Тойм” сэтгүүлийнхнээс судалгаа авах явцдаа тус нийтлэлийн зохиогчтой уулзаж, нийтлэлийн нь талаар ярилцсан юм. Нийтлэлийг нь уншвал сэтгүүлч ЛГБТ олон нийтийн эсрэг нэлээд сөрөг хандлагатай гэж тодорхойлохуйц байна. Гэтэл үнэн хэрэгтээ мөнхүү сэтгүүлч ЛГБТ хүмүүсийг тун ч дэмждэгээ илэрхийлсэн нь гайхмаар хэрэг байв. Эндээс үзвэл сэтгүүлч тэдний зүг эерэг хандлагатай байж, тэдний тухай нийтлэл бичихийг хүссэн ч залхуурсан гэж хэлж болохоор юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх хүчтэй зэвсэг билээ. Тийм ч учраас хүний эрх, эрх чөлөөг дээдлэхийн ялдамд цэгцтэй, бодит, тэнцвэртэй мэдээлэл хүргэх үүрэг хүлээдэг. Ардчилсан нийгэм, цагийн аясаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн бэлтгэж буй нийтлэл, нэвтрүүлгийн сэдэв, хүрээ тэлсээр буйн нэг нь ЛГБТ олон нийттэй холбоотой мэдээ, нийтлэл юм. Хэдийгээр Монголын үзэгч, уншигч, сонсогчдод хүрч буй ЛГБТ асуудлыг хөндсөн нийтлэл, нэвтрүүлгийг Өрнийн сэтгүүл зүйн өнөөгийн чиг хандлага, үзэл баримтлалтай харьцуулах аргагүй ч 1990-ээд он, 2000 оны үетэй жишвэл агуулга, өнцгийн хувьд улам нааштай болсоор байна.

ЛГБТ асуудлыг хамарсан мэдээ, нийтлэл, нэвтрүүлэгт гадаадын улс орнуудын хууль тогтоомж, оддын амьдралын тухай сэдэв зонхилох хандлагатай байгаа. Гэхдээ үүнийг өдөр тутмын сонинуудын

хувьд Олон улсын мэдээллийн буланд хачин жигтэй, сонирхолтой зүйл хүргэж буй мэтээр нийтэлдэг нь учир дутагдалтай юм. Нийтлэл, нэвтрүүлгүүдийг авч үзвэл ижил хүйстэн, трансжендер хүмүүсийг ойлгохыг хүссэн, эрхийг нь хамгаалах тал давамгайлсан нь харагдлаа. Гэвч сэтгүүлчид өөрсдөө асуудлын гүнд орж, ойлгож ухамсарлаж чадаагүй, сэдвээ судлаагүйгээс дутуу дулимаг ажил хийх, сөрөг ойлголт өгөх, ойлгомжгүй зүйл бичих, нэвтрүүлэх тохиолдол их байна. Хэдийгээр нийгэм цаг үе нээлттэй болсоор буй ч ЛГБТ хүмүүсийн дийлэнх нь нуугдмал хэвээрээ байдаг, гей, гетеро эсэхээс үл харгалзан массын хувьд энэ нь хаалттай сэдэв, монгол хэлээр ном, судалгааны ажил бараг байдаггүй нь сэтгүүлчдэд уг асуудлыг хөндөхөд саад учруулдаг байж болох юм. ЛГБТ хүмүүстэй холбоотой нийтлэл, нэвтрүүлгийн алинд ч ЛГБТ төлөөлөл болон оролцож байгаа хүн нь мөн л тоотой хэд байна. Монголын ЛГБТ төвийн ажилтнууд ихэвчлэн төлөөлөл болон дуу хоолойгоо хүргэдэг. Олонд танигдсан, амжилттай явж буй ЛГБТ хүмүүс өөрсдийн бэлгийн чиг баримжааг нууцалдаг учраас нийгэмд зөв дүр төрх болох хүн энэ тал дээр үгүйлэгдэж байна.

Тусгах өнцгийн хувьд нийтлэл, нэвтрүүлгийн аль нь ч эхэндээ зорилгоо ЛГБТ хүмүүсийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг зогсоох, хүний эрхийг нь хүндэтгэх, тэднийг ойлгох хэмээн тодорхойлсон ч бичих явцдаа зорилтынхоо эсрэг агуулгатай зүйлс бичсэн явдал ч түгээмэл байв. Нэг хэсэг ЛГБТ хүмүүстэй холбоотой асуудлыг зөвхөн ДОХ, ХДХВ-тэй холбоотой мэдээлэлд тусгадаг байсан нь үеэ өнгөрөөжээ. Сүүлийн үед энэ талын нийтлэл, мэдээлэлд тухайн өвчтөний хувийн мэдээлэл, бэлгийн чиг баримжааг нууцалдаг болсон нь “Оюуны дархлаа” сэтгүүлчдийн ТББ-ын идэвхтэй үйл

ажиллагааны үр дүн гэж дүгнэж байна⁸². 100 сэтгүүлчийг хамруулан хийсэн судалгааны үр дүнд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд ЛГБТ хүмүүсийг эерэгээр хүлээн авдаг нь харагдсан ч ойлголт маш багатай, ижил хүйстэн, трансжендерүүдийг хольж хутгах, бэлгийн чиг баримжаа төрөлхийн эсвэл сонголт эсэхт эргэлзэж байгааг ажиглалаа. Сэтгүүлчдийн хувьд эерэг хандлагатай байгаа нь сайшаалтай ч тогтсон ойлголт байхгүй байгаа нь ойлгомжгүй, сөрөг нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх үндэс болдог байж болох юм. Үүний хамгийн тод илэрсэн жишээ нь “Үндэстний Тойм” сэтгүүлийн Л.Эрдэнэжаргалын “Сэтгэлийн хүйс” нийтлэл, “Стар” телевизийн С.Хабулын “Час өдөр” нэвтрүүлэг байв. Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн тал орчим хувь нь энэ тухай нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхийг хүсдэгээ илэрхийлсэн бөгөөд асуудлыг хүний эрхийн талаас болон ЛГБТ олон нийтээс төлөөлөл сонгон авч, хувь хүний дотоод ертөнцийг нь нээхийг хүсдэгээ илэрхийлжээ.

Эцэст нь дүгнэхэд, ЛГБТ хүмүүсийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусгаж буй байдал нааштайгаар өөрчлөгдөж байна. Хэдийгээр тэдний тухай тусгаж, мэдээлж байгаа нь нийт сонин, сэтгүүлийн зай талбай, цацалтын 10 хувьд ч хүрдэггүй ч жил ирэх тусам ЛГБТ асуудал хөндсөн мэдээ, нийтлэлийн тоо бага, багаар нэмэгдэж, шуугиан тарисан материалуудаас илүүтэй эрх тэгш байдлыг эрхэмлэсэн шинжтэй нийтлэл, мэдээллийн тоо ихсэх хандлагатай байна. Үүнд сэтгүүлчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь илүү байгаа болон залуу сэтгүүлчид олон байгаагай холбоотой биз ээ.

⁸² <http://oyuniidarhlaa.blog.gogo.mn/index.ht>

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА**НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРҮҮ ШҮҮЛТЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ХОРОО БОЛОН ҮНДСЭНИЙ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ МЕХАНИЗМЫН ХООРОНДЫН
ХАРИЛЦААНЫ ӨӨРЧЛӨГДӨХ ШИНЖ: ТЭНЦВЭРИЙГ ОЛОХ НЬ****ЭЛИНА СТЭЙНЕРТЭ**

Элина Стейнертэ нь 2001 онд Латвийн Их сургуулийг эрх зүйн бакалаврын дипломтой төгссөн. 2001-2002 онд Британий Чевенингийн тэтгэлгээр олон улсын эрх зүй, хүний эрхийн чиглэлээр магистрын зэрэг дүүргэсэн. Роберт Гордоны Их сургуульд 2002-2006 онд Европын Холбооны улс төр судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалсан.

Докторын сургалтад хамрагдаж байхдаа Роберт Гордоны Их сургуульд Европын улс төрийн хичээл, Страктглайдын Их сургууль, Глазгоугийн их сургуульд Европын Холбооны эрх зүй хичээлийг тус тус, мөн Напиэрийн Их сургуульд Олон улсын нийтийн эрх зүй хичээлийг зааж байсан.

2006 оны 6-р сард Профессор Рейчел Муррей, Профессор Малькольм Эванс нарын удирдсан нэр хүндтэй судалгааны төслийн шугамаар Бристолын их сургуулийн Хууль зүйн сургуульд ажиллах болсон. Уг төсөл нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын хүрээнд томилогдсон үндэсний байгууллагуудын үр дүнтэй байдлыг үнэлэх зорилготой байв.

Хураангуй

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатын онцлог чанар нь түүний болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх конвенцийн нэмэлт протоколоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон гишүүн улсын үндэснийхээ хэмжээнд үүсгэн байгуулсан Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хооронд үүсдэг харилцаанд оршдог. Гэхдээ анхандаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбогдон ажиллах хөлөө олоход

бэрхшээлтэй байсан юм. Төсөв, санхүүгийн асуудалтай, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллах зохистой аргаа олохгүйгээс болж эхний таван жилийг үндэсний механизмуудтай идэвхгүй зэрэгцэн орших байдалтай өнгөрөөжээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо 5 дугаар ээлжит илтгэлдээ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай хамтран ажиллаж байгаа байдлаа өөрчлөх төлөвлөгөөтэй байгаагаа илтгэв. Шалгалтын шинэ арга хэлбэрийг нэвтрүүлж, шалгалт хийх мандатаасаа гадуур Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллах хандлагаа өөрчлөн, дотоод бүтцээ

шинэчлэн зохион байгуулсан зэрэг нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хоорондох харилцаанд өөрчлөлт орсныг бүх талаар илтгэх дохио болж байна. Таван жилийн дараа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь хамтран ажиллагчидтайгаа үндэсний хэмжээнд харилцаагаа өргөжүүлэхэд бэлэн болохоо илэрхийлж байгаа бөгөөд энэ харилцаанаас эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйлст хүчин зүтгэж буй хүн бүр ихээхэн үр дүн хүлээж, найдвар өвөрлөх эрхтэй юм.

Энэ нийтлэлд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хоорондох харилцааны өнөөгийн байдал болон өмнөх жилүүдэд хөгжиж ирсэн байдлыг авч үзэх болно. Мөн үүнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцсаны үндсэн дээр хийж байгаа өөрчлөлт нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай харилцах харилцаандаа барих тэнцвэрийг олохын дохио болж байгаа болохыг өгүүлэх юм. Энд ийм тэнцвэргүйгээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд туссан эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх урьдач нөцлийг хангаж чадахгүй болохыг дурджээ.

Гол нэр томъёо: Урьдчилан сэргийлэх үндэсний механизм, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо, айлчлал шалгалтын

механизм

1. Удиртгал

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол⁸³ нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүний эрхийн цорын ганц гэрээ юм. Энэ гэрээнд хэрэв эрх зөрчидсөн тохиолдол гарвал эрхийг сэргээх утгатай ганц ч заалт байхгүй. Харин үүнд бие даасан олон улсын болон үндэсний байгууллага хүний эрхийг хязгаарладаг газруудад очиж шалгах замаар *эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар* буюу хүний *нэр* төрийг гутаан доромжилж харьцах болон шийтгэх тохиолдол гарахаас урьдчилан сэргийлэх, тийм тохиолдлыг таслан зогсоох механизмын тогтоож өгдөг.⁸⁴ Бие даасан олон улсын байгууллага гэдэг нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын байгууллага болох Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо⁸⁵ бөгөөд үндэсний байгууллагын үүргийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нэгдэн орсон гишүүн улс бүр байгуулах ёстой Үндэсний урьдчилан сэргийлэх механизм гүйцэтгэнэ.⁸⁶ Энэ бүтэц нь Эрүү шүүлтээс

⁸³ GA Res. 57/199 on the Optional Protocol to the Convention Against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. A/RES/57/199, adopted 18 December 2003.

⁸⁴ Art. 1 OPCAT.

⁸⁵ Art. 2 OPCAT; the SPT was elected in October 2006 and held its first session from 19 to 23 February 2007. See: UN, 'Press Release: New Panel on Prevention of Torture to hold inaugural session', 16 February 2007, available at: www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=1727&LangID=E.

⁸⁶ Art. 3 OPCAT.

урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад гэрээний байгууллагуудынхаас эрс ялгаж өгч байгаа юм. Гишүүн улсын илтгэл, хувь хүний гомдлыг⁸⁷ авч хэлэлцэх зэрэг уламжлалт бүрэлдэхүүн хэсгүүд нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны үүргийн шинжид хамаарахгүй. Харин эсрэгээрээ энэ мандатад гурван үндсэн элемент орно. Үүнд: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын гишүүн улсын эрх зүйн харьяалалд байх хүний эрхийг хязгаарласан газруудад очиж шалгалт хийх, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай хамтран ажиллах, эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг Нэгдсэн Үндэстний Байгууллагын болон бүс нутгийн бусад механизмуудтай хамтран ажиллах зэрэг болно.⁸⁸

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол нь гишүүн улсууддаа оногдуулсан үүргийн хэлбэрийн хувьд онцлог шинжтэй Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээ юм.⁸⁹ Үүгээр гишүүн улсууд Урьдчилан

сэргийлэх үндэсний механизм хэмээх шинэ байгууллагыг үндэсний хэмжээнд бий болгох үүрэг хүлээдэг.⁹⁰ Эдгээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатад Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандат ихээхэн хэмжээгээр тусгалаа олсон байдаг. Урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь эрх чөлөөг хязгаарласан газруудад тогтмол очиж шалгах тогтолцоог хэрэгжүүлж, эрх баригчдад хандсан зөвлөмж өгч, үндэсний хууль тогтоох тогтолцоотой хамтран ажиллан бусад урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцдог.⁹¹ Олон улсын хүний эрхийн гэрээ үндэсний механизмд олон улсын хүний эрхийн үүрэг хариуцлага тэр дундаа эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажиллагаа явуулах мандат олгож байгаа нь энэ юм.

Магадгүй олон улсын хүний эрхийн гэрээнээс үүдэн гарсан тийм мандат үндэсний байгууллагад үзүүлж болох ээдрээтэй нөхцөл байдлыг урьдаас анхаарч Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын эхийг боловсруулагчид Урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хоорондын онцгой холбоог гаргаж ирсэн байна. Энэ харилцаа холбоо нь гэрээний байгууллагыг өөрийгөө Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний байгууллагын онцгой мандаттай⁹² шинэ үе болгон тодорхойлох ёстой санааг дэвшүүлж өгүүлсэн нь:

[...] бол Нэгдсэн Үндэстний

relating to the status and functioning of national institutions for protection and promotion of human rights.'

⁸⁷ Art. 3 OPCAT.

⁸⁸ Art. 19 OPCAT.

⁸⁹ Subcommittee on Prevention of Torture, First Annual Report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/C/40/2 (2008), at para. 5.

⁸⁷ For example, the Human Rights Committee is mandated to examine reports submitted by State Parties to the International Covenant on Civil and Political Rights as per Art. 40 of the Covenant and consider individual communications as per Optional Protocol to the same treaty. The Committee against Torture receives and considers reports of State Parties to the Convention Against Torture as per Art. 19 of the same treaty and may receive individual communications if the State Party in question has made a declaration as per Art. 22 of the same treaty.

⁸⁸ Art. 11 OPCAT.

⁸⁹ The only exception here is the UN Convention on the Rights of Persons with Disabilities which obliges states parties to establish independent monitoring mechanisms. See Art. 33 (2): 'States Parties shall, in accordance with their legal and administrative systems, maintain, strengthen, designate or establish within the State Party, a framework, including one or more independent mechanisms, as appropriate, to promote, protect and monitor implementation of the present Convention. When designating or establishing such a mechanism, States Parties shall take into account the principles

Байгууллагын гэрээний байгууллагаас ялгаатай бөгөөд голлон үйл ажиллагааны шинжтэй ажилд анхаарч Нэмэлт протоколд нэгдэн орсон улс орнуудад жич ажиллахаас гадна тэдгээр улсуудад сургалт зэрэг зөвлөгөө тусламж үзүүлж, үндэсний урьдчилан сэргийлэх механизмуудад эрх чөлөөгөө хасуулсан хүмүүст эрүү шүүлт, бусад зүй бус харьцаанд өртөхөөс хамгаалах хамгаалалтын хүрээнд дэмжлэг үзүүлдэг.⁹³

Мэдээж Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хооронд үүсэх онцгой харилцаанаас үүдээд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо бол гишүүн улсуудад үндэсний түвшинд шууд бодит нөлөө үзүүлж чадах Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний байгууллага юм. Тэрхүү нөлөө нь олон улсын хүний эрхийн механизмуудад дутагдалтай байдаг учир нь тэдгээрт ихэнхдээ үндэсний нөхцөл байдалд шууд оролцох оролцоогоо сайндаа л жишээ нь тусгай илтгэгч гэхэд л улс оронд чиглэсэн айлчлал шалгалт хийх эсвэл гэрээний байгууллагын хувьд тухайн улсын илтгэлийг хүлээн авах зэрэг үйл ажиллагааг тодорхой цаг хугацааны дараалалтай хийхээр тодорхойлсон байдаг.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ажлаа эхэлснээс хойш таван жил өнгөрч, уг гэрээний байгууллага мандатынхаа айлчлал шалгалтын чиглэлд санаа зовохооргүй гүйцэтгэж ирсэн бол Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай харилцах харилцааны хувьд их зүйл хийх шаардлагатай байна. Их төлөв энэ доголдол нь дэд хороог ажлынхаа анхны

⁹³ *Ibidem*, at para. 67.

жил мандатаа хэрэгжүүлэх боломжгүйгээ мэдэгдэхэд хүргэсэн санхүүгийн бэрхшээлээс шалтгаалж ирсэн юм.⁹⁴ Тухайн үед Дэд хороо гишүүн улс бүрт ядаж дөрөв буюу таван жил тутам айлчлал шалгалт хийж,⁹⁵ тэдгээрийн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай идэвхтэй хамтран ажиллахаар⁹⁶ зорьж байсан хэдий ч ажлаа эхэлсэн анхны жилдээ ердөө гурван айлчлал хийж,⁹⁷ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай тулж ажиллах санхүүжилт огт байхгүй байлаа.⁹⁸ Нөхцөл байдал дараагийн хэдэн жилд олигтой дээрдээгүй⁹⁹ бөгөөд зохих санхүүжилт байхгүйгээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллах бүтээлч арга зам хайж олох гэж хичээж байв. Энэ нөхцөл байдал харин Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороог мандатынхаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын элементийг барьж ажиллахад түлхэц өгсөн юм.¹⁰⁰

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 2011 онд гарсан дөрөв дэх ээлжит илтгэл нь өөрчлөлт гарч байж болохыг, мөн гэрээний байгууллага арга барилаа ялангуяа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд

⁹⁴ *Ibidem*, at para. 56.

⁹⁵ *Ibidem*, at para. 15.

⁹⁶ *Ibidem*, at para. 29.

⁹⁷ A visit to Mauritius took place from 8–18 October 2007, followed by a visit to the Maldives from 10–17 December and a visit to Sweden from 10–15 March 2008. Subcommittee on Prevention of Torture, *op.cit.* note 10, at para. 18.

⁹⁸ Subcommittee on Prevention of Torture, *op.cit.* note 10, at para. 53.

⁹⁹ See: Subcommittee on Prevention of Torture, Second Annual Report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/C/42/2 (2009), at paras. 75–76; Subcommittee on Prevention of Torture, Third Annual Report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/C/44/2 (2010), at paras. 73–74; Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/C/46/2 (2011), at paras. 108–109.

¹⁰⁰ Murray, R., 'National Preventive Mechanisms under the Optional Protocol to the Torture Convention: One Size Does not Fit All', *Netherlands Quarterly of Human Rights*, Vol. 26, No. 4, pp. 485–516, at p. 516.

хандах хандлагадаа дахин үнэлэлт хийж байгааг няхуур байдлаар илтгэж байв. Энэ өөрчлөлт одоо Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 2012 оны айлчлал шалгалтын хөтөлбөрт тусгалаа олсон нь:

[...] Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос илүү өгөөжтэй, үр дүнтэй арга ажиллагаа руу шилжих эрмэлзлийг илэрхийлж байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо шаардлагатай гэж үзсэн үедээ мандатынхаа тодорхой элементүүдэд анхаарлаа хандуулахад айлчлал шалгалтуудаа явуулах байдлаар айлчлал шалгалтын мандатаа ашиглахаар зорьж байна. Ингэснээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд илүү үр бүтээлтэй ажиллах, мөн маш олон гишүүн улстай хамтран ажиллах боломж өгөх юм.¹⁰¹

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны сүүлчийн буюу тав дахь ээлжит илтгэлд¹⁰² мөн дурдсан энэ мэдэгдэл нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлалын мандат болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн чиг шугам барих болсныг илтгэсэн хүчтэй дохио бөгөөд энэ өөрчлөлт эртнээс шаардлагатай байсан юм.¹⁰³

Энэ нийтлэлд хэдийгээр нэмэлт санхүүжилт аваад ч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь үндэсний байгууллагын хувьд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хангаж чадах айлчлал шалгалтын давтамжид хүрч ажиллаж чадахгүй тул Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан

сэргийлэх үндэсний механизмын мандатын хооронд барих тэнцэл дээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын урьчилан сэргийлэх тогтолцоо амжилтад хүрэх гол учиг нь оршиж байгаа талаар өгүүлэх болно. Тиймээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь гишүүн улс бүрт газар дээр нь ажиллах найдвартай хамтрагчтай байх шаардлагатай бөгөөд энэ тал дээр хүчтэй, чадварлаг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд нь энэ гэрээний байгууллагын хувьд тухайлан заяасан түнш мөн юм. Мэдээж тийм түнш болохын тулд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд нь зүй зохистойгоор зохион байгуулагдсан, зохих эрх мэдэл бүхий, хангалттай санхүүжилттэй байх хэрэгтэй юм. Гэхдээ энэ нөхцөлийг хангахын тулд тэдэнд мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дэмжлэг, чиглэл хэрэг болох магадлал бий. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь энэ тал дээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах харилцаандаа барих тэнцвэрийг олох шаардлагатай бөгөөд тэрхүү тэнцвэр нь аль нэг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хөгжил, үр дүнтэй ажиллагаанаас хамаарч цаг хугацааны хувьд өөрчлөгдөн хувьсаж чаддаг байвал зохимжтой юм.

2. Дэд хороо ба Үндэсний урьдчилан сэргийлэх механизм: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын утга санаа

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн

¹⁰¹ UN, 'Press Release: Subcommittee on Prevention of Torture announces its Programme of Field visits for 2012', 18 November 2011, available at: www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=11621&LangID=E.

¹⁰² Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/C/48/3 (2012), at para. 41.

¹⁰³ Murray, R., Steinerte, E., Evans, M. and Hallo de Wolf, A. *The Optional Protocol to the UN Convention Against Torture*, Oxford University Press, Oxford, 2011, Chapter 5.

эсрэг конвенцын нэмэлт протоколын агуулгад байгаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах тухай заалт нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээний байгууллага анх удаа тухайлан үндэсний шинжтэй нэгжийг олон улсын хүний эрхийн механизмд татан оруулж, эдгээр механизмд олон улсын гэрээг хэрэгжүүлэхэд чиглэсэн үүрэг оногдуулсанаараа онцлог юм.¹⁰⁴ Энэ нь мөн анх удаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн гэрээ гишүүн улсад тухайн гэрээнд туссан эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг хүсэх буюу ямар арга хэмжээ авах сонголтыг тухайн улсад үлдээлгүй харин ч эсрэгээрээ гишүүн улсад бодитой хэрэгжүүлэх механизмыг зааж өгсөн хэрэг юм.¹⁰⁵ Эцэст нь мөн анх удаа олон улсын хүний эрхийн байгууллага Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд айлчлал шалгалтаар зогсохгүй эдгээр үндэсний механизмтай хамтран ажиллах замаар гишүүн улсын үндэсний түвшинд бодит өөрчлөлт авчрах мандат олгосон явдал байлаа.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг албан ёсоор оноож томилох үүргийг оруулж өгсөн нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын төслийг боловсруулах үеэр Мексикийн төслөөс¹⁰⁶ оруулсан

¹⁰⁴ This has since been duplicated in the UN Convention on the Rights of Persons with Disabilities, see Art. 33.

¹⁰⁵ For example, as in case of the ICCPR (Art. 40); UNCAT (Art.19) and Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of Their Families (CRMW) (Art. 73).

¹⁰⁶ The 2001 Mexican proposal introduced National Preventive Mechanisms (NPMs) which would carry out systematic visits to places of detention within their respective States. The mandate of the Subcommittee on Prevention of Torture was to be that of merely supervising and supporting the work of NPMs, providing them with assistance and advice as well as making recommendations to NPMs about their operation and to State Parties in relation to the establishment and functioning of NPMs. The SPT itself would be able to carry

томоохон хувь нэмэр мөн. Тухайн үед үүнд сэжиглэх байдлаар хандаж Европын Холбооноос¹⁰⁷ санал гаргахад хүргэж байсан бол энэ нь одоо гишүүн улс эрүү шүүлт, зүй бус харилцаа яваандаа гарахаас урдчилан сэргийлж болох хамгийн чухал зүйл болж иржээ.¹⁰⁸ Ийнхүү сайшаах нь бүхэлдээ зүй ёсны хэрэг юм. Учир нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн олон механизм бөглөж чадаагүй орон зайг гүйцээн бөглөх боломжтой юм. Энэ бол тогтвортой, тухайн өдөр тутам хэрэгжих шинжтэй бөгөөд үүгээрээ улс орны нөхцөл байдлын талаар анхан шатны мэдлэг, ойлголт, мөн холбогдох албан тушаалтнуудтай байнгын хамтран ажиллах боломж олгох механизм болно.

Эдгээр үндэсний байгууллагуудыг байгуулж, зааж өгөх нь харин бэрхшээлгүйгээр бүтэж ирсэнгүй.¹⁰⁹ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг хэрхэн зохион байгуулах талаар тун хомс заавар тусгасан агаад үүнд үйл ажиллагааны болон боловсон хүчний¹¹⁰ аль алиных нь

out visits to places of detention of State Parties only when NPMs fail to do so: See Arts. 1, 2(1), 15 (1), (3), (5) and (6), 22 of the Mexican Draft, see E/CN.4/2001/WG.11/CRP.1.

¹⁰⁷ The EU proposal was prompted by a fear that the obligation to establish NPMs would not be taken seriously and lead to weak national mechanisms lacking independency and so it shifted emphasis back to the SPT. The SPT was once again the key body to carry out visits to places of deprivation of liberty within the jurisdiction of State Parties without prior consent. See: Evans, M. and Haenni-Dale, C., 'Preventing Torture? The Development of the Optional Protocol to the UN Convention Against Torture', *Human Rights Law Review*, Vol. 4, No. 1, 2004, 19–55, at p. 42.

¹⁰⁸ Statement by Mr Malcolm Evans, Chairperson of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment during the 66th session of the General Assembly, Third Committee, Item 69(a); 18 October 2011, New York. Available at: www2.ohchr.org/english/bodies/cat/opcat/docs/statements/StatementSPT_Chair_to_UNGA67.docx.

¹⁰⁹ For detailed analysis on NPMs see: Murray *et al.*, *op.cit.* note 21, Chapter 6; Murray, *loc.cit.* note 18.

¹¹⁰ Art. 18(1) OPCAT.

бие даасан, хараат бус байдлын талаар өргөн агуулгатай шаардлага, мэргэжлийн ур чадвар, чадавхи, ажиллах багийн олон талыг хамарсан бүрэлдэхүүний талаарх шаардлага, мөн гишүүн улсыг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа байгуулах үедээ заавал харгалзан үзэхийг заасан Парисын Зарчмын¹¹¹ тухайн заалт¹¹² зэргээс хэтрэхгүй зүйл туссан байна. Үйл явцад жинхэнэ асуудал нь эдгээр шаардлагыг бодит практикт тайлбарлах үед гарч ирэх бөгөөд үүн дээр л гишүүн улсуудын хувьд амаргүй байна. Магадгүй ийм бэрхшээлийн хамгийн бодит жишээ нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын гишүүн улсуудын дөнгөж тал орчим хувь нь л Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа оноож өгсөн¹¹³ байгаа нь гишүүн улсуудын мөн тал орчим хувь нь хэрэг дээрээ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор хүлээсэн гол үүрэг хариуцлагаа биелүүлэхгүй байгааг харуулж байгаа юм.¹¹⁴

Эдгээр бэрхшээлийг урьдаас таамаглаж Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын төслийг

боловсруулагчид Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд гишүүн улсад Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахад зөвлөж, туслах, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад өөрсөд нь сургалтын болон техникийн туслалцаа үзүүлэх гэсэн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбоотой хоёр гол үүрэг хариуцлага оногдуулжээ.¹¹⁵ Гэхдээ эдгээрийг хэрхэн бодит хэрэг болгох талаар тодорхой заалт байхгүй бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын агуулгад тодорхойлсон ямар нэг арга хэрэгсэл байхгүй байгаагаас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ашиглах хамгийн зөв аргаа өөр чөлөөтэй сонгоход хүрч байна. Харамсалтай нь ядахдаа л эхэн үедээ дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах үүргээ биелүүлэхэд бэрхшээлтэй байв. Мэдээж Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллахад гарч байсан бэрхшээл дутагдлууд бүгдээрээ гэрээний байгууллагын өөрийнх нь амжилтгүй ажиллагаанаас болоогүй бөгөөд тун хязгаарлагдмал төсөв үүнд үүрэг гүйцэтгэсэн нь дамжиггүй юм. Үнэндээ эдгээр хязгаарлагдмал төсөв түүний мандатынх нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбоотой бүрэлдэхүүн хэсэгт онцгой бэрхшээл учруулж ирсэн байна. Гурав дахь ээлжит тайландаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо тухайн тайлангийн жилд, мөн мэдээж Дэд хороо ажлаа эхэлснээс хойш Дэд хороонд гишүүн улстай буюу үндэсний урьдчилан сэргийлэх механизмтай шууд харьцан ажиллахад зориулсан төсөв огт хуваарилагдаагүй¹¹⁶ гэж тэмдэглэжээ.

¹¹¹ Principles Relating to the Status and Functioning of National Institutions for the Protection and Promotion of Human Rights (The Paris Principles), Resolution 1992/54, endorsed by the UN General Assembly Resolution 48/134, 20 December 1993.

¹¹² Arts. 18(2) and (3) OPCAT.

¹¹³ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at paras. 20–23; SPT, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para 17.

¹¹⁴ According to Art. 17, the obligation to designate an NPM must be fulfilled within a year of becoming a Party to OPCAT unless a State Party makes a declaration postponing the implementation of this obligation as per Art. 24 OPCAT. According to the United Nations Treaty Collection website, six states have made such declarations: Germany, Kazakhstan, Hungary, Montenegro, Philippines and Romania, available at: treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-9-b&chapter=4&lang=en.

¹¹⁵ Art. 11(b) OPCAT.

¹¹⁶ Subcommittee on Prevention of Torture, Third Annual Report, *op.cit.* note 17, at para. 4.

Гэсэн ч зарим боломжийг бас алдсаныг хэлэх хэрэгтэй.

3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн улсад хийх айлчлал шалгалт: Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллах боломжийг алдсан нь

Гишүүн улсад хийдэг айлчлал шалгалт нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатын нэгэн цөм бүрэлдэхүүн хэсэг бөгөөд төсвийн хүндрэлтэй байдлаас хамааралгүйгээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо одоогийн байдлаар 18 удаагийн айлчлал шалгалт хийгээд байгаагаас гадна цаашид айлчлал хийх улсуудаа төлөвлөөд байна.¹¹⁷ Эдгээр айлчлалууд мөн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай харилцан ажиллах боломж олгодог. Үнэндээ энэ бол Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг боловсруулагчид урьдаас харж тооцсон¹¹⁸ зүйл юм. Коста Рикагаас дэвшүүлсэн анхны төслөөс¹¹⁹ эхлээд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батласнаар тухайн улсын эрх зүйн хүрээнд байгаа

хүний эрх чөлөөг хязгаарладаг газруудад очих Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны эрхийг хүлээн зөвшөөрдөг тул Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатад гишүүн улсад урьдчилан мэдэгдэлгүйгээр айлчлал шалгалт хийх¹²⁰ эрх хэмжээг оруулахыг санал болгожээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны энэ мандатын сонирхолтой онцлог тал нь “томилолт”, “айлчлал” хоёрын хоорондох ялгаа юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь гишүүн улсуудад тийм томилолтын баг явуулж, тэд нь эрх чөлөөг хязгаарладаг тодорхой газруудад очдог байв. Тухайн үедээ энэ ялгааг тойрсон зөрөлдөөний гол нь урьдчилан мэдэгдэл өгөх тухай асуудал¹²¹ байгаа бол энэ өнгө аяс нь нэмэлт протоколын төслийг боловсруулах явцад төсөөлсөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлалын утга агуулгын талаар ойлголт өгөхөд чухал ач холбогдолтой юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос тухайн улсад явуулах ажиллагааг эрх чөлөөг хязгаарлах жинхэнэ газруудад очих төдийгөөр хардаггүй байлаа. “Гишүүн улсад явуулах томилолт”, “эрх чөлөөг хязгаарласан газруудад хийх айлчлал”¹²²-ын хоорондын ялгаа нь гэвэл томилолт нь хорих байгууллагуудад очихоос гадна хорих газруудад шалгалт хийх төдийгөөр хязгаарлагдахааргүй өргөн хүрээг хамардаг гэдэгт оршино.¹²³ Сонирхолтой нь Европын Холбооноос гаргасан төсөлд

¹¹⁷ Subcommittee on Prevention of Torture. ‘SPT Visits’, available at: www2.ohchr.org/english/bodies/cat/opcat/spt_visits.htm.

¹¹⁸ For a detailed historical account of the drafting of OPCAT see: Murray *et al.*, *op.cit.* note 21, Chapters 1–3; Evans and Haenni-Dale, *loc.cit.* note 25, at pp. 19–54.

¹¹⁹ Draft Optional Protocol to the Draft International Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, submitted by Costa Rica, UN Doc. E/CN.4/1409, 10 April 1980 (reproduced in Burgers, J. and Danelius, H. *The United Nations Convention Against Torture: A Handbook on the Convention Against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment*, Martinus Nijhoff, Dordrecht, 1988). It should be noted here that this draft Optional Protocol was considered during the adoption of UNCAT but given the controversy surrounding adoption of UNCAT and the difficulties around Art. 20, it was agreed that the proposal would not be tabled until the adoption of UNCAT.

¹²⁰ Art. 8(2) Costa Rica Draft Protocol (1980).

¹²¹ The State would be notified of a ‘mission’, but this would not impact the ability of SPT members to visit any place of detention within the jurisdiction of a State Party without any previous notice. Art. 10 Costa Rica Draft Protocol (1980).

¹²² Arts. 1(b) and (c) EU Draft. According to the EU Draft, the Subcommittee on Prevention of Torture would carry out missions to State Parties to which no objections could be raised. Visits to places of deprivation of liberty would constitute a part of such missions and states would be able to object to visits to particular places of deprivation of liberty on some tightly circumscribed grounds: Art. 3(3) EU Draft. See E/CN.4/2001/WG.11/CRP.2.

¹²³ Nowak, M. and McArthur, E. *The United Nations Convention Against Torture: A Commentary*, Oxford University Press, Oxford, 2008, at p. 933.

Коста Рикагийн төсөлд анх тогтоосон томилолт болон айлчлал шалгалтын ялгаа нэмж тодотгосон байна. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын сүүлийн эхэд энэ ялгааг оруулаагүй байхад түүний цаана агуулагдах санааг гэрээний сүүлийн эхээс олж харж болно.

Энэ түүхэн сануулгыг харгалзан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлал болон түүний Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллах ажиллагааны харилцаанд анхаарч үзвэл зохих гурван зүйл байна. Эдгээр нь айлчлах улс орныг сонгох асуудал, айлчлалын төрөл, агуулга юм.

3.1. Шалгалт хийх улсыг сонгох нь: Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулагдсан нь нөлөөлөх үү?

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын эхэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлан ажиллах гишүүн улсыг сонгон авах аргачлалын талаар зааж өгсөн зүйл тун хомсхон бий. 13 дугаар зүйлийн (1)-д Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь ээлжит айлчлалын хөтөлбөр гаргахаар зааж, эхний үед үүнийг их хэмжээгээр зохион байгуулна хэмээн тэмдэглэжээ. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 2 дугаар зүйлийн (3)-т заасан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны үйл ажиллагааны удирдлага зарчмаар бол сонгон авах үйл явц тал хараагүй, бодитой, зориуд сонгох бодлогогүй

байх ёстой гэжээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос өөрөөс нь гаргасан Айлчлалын талаар баримтлах заавар¹²⁴ нь асуудалд илт товч цомхон бөгөөд гагцхүү Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь ажлын хөтөлбөрөө боловсруулахдаа Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын 1 дүгээр зүйл, 11 дүгээр зүйлийн (с), 31 дүгээр зүйлийг харгалзан үзнэ гэж заасан байна.¹²⁵

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд анхны шалгалтуудыг хийхэд хэдэн оронд хийх талаар дурдаагүй байхад Дэд хороо эдгээр нь гурав байна гэж шийдсэн нь Мауритиус¹²⁶, Мальдив¹²⁷, Швед¹²⁸ улсууд байсан юм. Дараа нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлан очих дараагийн улсыг сонгоход зөв зүйтэй гэж үзсэн журмаараа¹²⁹ ажиллав. Эхнээсээ л Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо соёрхон батласан огноо, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулан бэхжүүлсэн байдал, газар зүйн байршил, тухайн улсын хэмжээ болон бүтэц, мөн бүс нутгийн урьдчилан сэргийлэх хяналт байгаа болон ажиллаж байгаа эсэх,

¹²⁴ Subcommittee on Prevention of Torture, Guidelines of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment in relation to visits to States parties, UN Doc. CAT/OP/12/4 (2011).

¹²⁵ *Ibidem*, at para. 4.

¹²⁶ The visit to Mauritius took place from 8–18 October 2007; See First Annual Report, *op.cit.* note 10, at para. 18.

¹²⁷ The Maldives were visited from 10–13 December 2007; See Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to the Maldives, UN Doc. CAT/OP/MDV/1 (2009).

¹²⁸ Sweden was visited from 10–14 March 2008; See Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to Sweden, UN Doc. CAT/OP/SWE/1 (2008).

¹²⁹ Subcommittee on Prevention of Torture, First Annual Report, *op.cit.* note 10, at para. 14.

цаашилбал мэдэгдэж илтгэсэн яаралтай асуудал зэрэг хүчин зүйлсийг гишүүн улсыг сонгон авахдаа харгалзан үзэх ёстой хэмээн нилээн учир дараатай тэмдэглэж байжээ.¹³⁰ Гуравдугаар ээлжит тайланд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах гэдгийн оронд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг хөгжүүлэх хэмээн сольсоныг эс тооцвол Хоёрдугаар¹³¹ болон Гуравдугаар¹³² ээлжит илтгэлд бараг үг бүрчлэн ижил үг хэллэг давтан хэрэглэсэн байдаг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлах орныг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцэх Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахад хэр их хүчин чармайлт гаргаж байгааг нь харгалзан сонгож байснаар бодсон ч энэ бяцхан өөрчлөлт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах асуудалд ихээхэн сэтгэл тавин, анхаарч байсныг харуулж байх шиг.

Дөрөвдүгээр ээлжит илтгэлээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо аливаа улс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батламагц Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах талаар зөвлөгөө, тусламж үзүүлэх үүднээс аль болох даруйхан айлчлал хийж болох загвар руу чиглэн ажиллаж байна гэснээс¹³³ үзвэл саях мэдэгдлүүдээс бага зэрэг өөрчлөгдсөн

бололтой санагдана. Тухайлбал, Дэд хороо тийм айлчлалыг өөрийнхөө одоогийн тогтмол хөтөлбөрөөс гадна авч хэрэгжүүлэх бөгөөд заавал хорих байгууллагад хийх айлчлал шалгалтыг хамрааруулахгүй, тиймээс харьцангуй богино хугацаатай байж болно гэж үзсэн юм.¹³⁴

Ийнхүү байр сууриа өөрчилсөн нь гишүүн улсыг сонгон айлчлах шалгууртай холбоотой дүр зурагтай зөрчилдөж байгаа бөгөөд хэрэв Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хийсэн жинхэнэ сонголтыг энэ шалгуурыг харгалзан шалгаж үзвэл бүрч зөрчилтэй харагдана. 2012 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо 18 айлчлал шалгалт, нэг ул мөрөөр давтан шалгалт хийсэн байна. Эдгээрээс Европын орнуудад гурван шалгалт,¹³⁵ Америк тивд найм,¹³⁶ Азид хоёр,¹³⁷ Ойрхи Дорнодод нэг,¹³⁸ Африкт тавыг¹³⁹ хийжээ. Эндээс харвал тэдгээр шалгалтын тал хувь нь Европт¹⁴⁰ байгаагаас үзэхэд л Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын гишүүн улсуудын газар зүйн байршил тархацыг тусгасан тал байхгүй байна. Гэтэлийм харилцан адилгүй хандлагыг тухайн бүс нутаг дахь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх Европын Хорооны идэвхтэй ажил болон иймэрхүү механизмтай

¹³⁴ *Idem*.

¹³⁵ Sweden (2008), Ukraine (2011) and NPM-focused visit to Moldova in 2012.

¹³⁶ Mexico (2008), Paraguay and Honduras (2009), Bolivia (2010), Brazil (2011), Argentina (2012), follow-up visit to Paraguay in 2010 and NPM-focused visit to Honduras in 2012.

¹³⁷ The Maldives (2007) and Cambodia (2009).

¹³⁸ Lebanon (2010).

¹³⁹ Mauritius (2007), Benin (2008), Liberia (2010), Mali (2011) and NPM-focused visit to Senegal in 2012.

¹⁴⁰ Of the 63 State Parties to OPCAT, 31 are from the European region: United Nations Treaty Collections, available at: treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtidsg_no=IV-9-b&chapter=4&lang=en.

¹³⁰ *Idem*.

¹³¹ Subcommittee on Prevention of Torture, Second Annual Report, *op.cit.* note 17, at para. 14.

¹³² Subcommittee on Prevention of Torture, Third Annual Report, *op.cit.* note 17, at para. 20.

¹³³ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 45.

ажлаа давхардуулахаас зайлсхийх бодлогоор уялдуулан тэнцвэржүүлж болох байв.¹⁴¹

Нөгөөтэйгүүр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны тэмдэглэсэн шалгуураар бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны сонгон авсан улсууд нь холбооны болон нэгдмэл улсууд, янз бүрийн хэмжээтэй болон эрх зүйн тогтолцооны цогцолмол шинжийн хувьд өөр өөр цар хүрээтэй орнуудын холимог байна. Тиймээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны тавьсан шалгуур нь уг гэрээний байгууллагын хийсэн жинхэнэ сонголттой тохирох байдалтай байна.

Харин эдгээр орнуудыг сонгосныг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дэвшүүлсэн өөр нэг шалгуур болох Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулахтай холбоотой өнцгөөс харвал бэрхшээл үүснэ. Дээр дурдсан гурван улсыг нэг тийш орхиод Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлахаар сонгосон орнуудаас ердөө хоёр нь л тухайн айлчлалын үеэр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа байгуулсан байсан нь Мексик, Гондурас улсууд юм. Энэ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо хэрэг дээрээ Дөрөв дэх ээлжит илтгэлд өгүүлснээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа оноож томилох үйл явцад хувь нэмрээ оруулахын тулд гишүүн улсуудад Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахаас нь өмнө айлчлах хувилбарыг илүү дээрд үзэж байгаа гэсэн үг үү?

Үнэндээ тийм биш юм. Тухайлбал 2011 онд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн

эсрэг конвенцын нэмэлт протоколыг шинээр дөрвөн улс соёрхон батласнаас¹⁴² нэг нь ч Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулаагүй байна. Гэтэл мөн 2012 онд эдгээрийн алинд ч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо шалгалт хийгээгүй юм. Үнэндээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны өдийг хүртэл хийсэн шалгалтуудаас эхний гурвыг сугалаагаар сонгодоогоор нь орхиод бусдыг нь сөхөн авч үзвэл Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батласны дараахан хамгийн эрт шалгалт хийсэн улс нь Бенин байна. Энэ улс 2006 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр соёрхон батлаж 2008 оны 5 дугаар сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо тус улсад шалгалт хийсэн бол Габон улс 2010 оны 9 дүгээр сард соёрхон батласан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо 2012 онд шалгалт хийх төлөвлөгөөтэй юм. Гэхдээ энэ хоёр тохиолдлын аль алинд соёрхон батласнаас хойш шалгалт хийх хүртэл 2 жил өнгөрчээ. Энэ нь мөн Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд заасан Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах нэг жилийн хугацаа хэтэрсэн¹⁴³ байна гэсэн үг. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо гишүүн улсад соёрхон батласнаас нь хойш харьцангуй богино хугацаанд шалгалт хийж амжихгүй байгаа нь харамсалтай. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг

¹⁴¹ For an analysis of the relationship between the SPT and the CPT see: de Beco, G., 'The Optional Protocol to the Convention Against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (the OPCAT) in Europe: Duplication or Reinforcement?', *Maastricht Journal of European and Comparative Law*, Vol. 3, 2011, pp. 257–274.

¹⁴² These were: Bulgaria (1 June 2011), Panama (2 June 2011), Tunisia (29 June 2011) and Turkey (27 September 2011).

¹⁴³ Art. 17 OPCAT. There is a possibility to defer this by up to three years by making a declaration under Art. 24. It should be noted, however, that at the time of the SPT's visit, Benin had not established an NPM and as of 1 June 2012 there is no NPM in Gabon either.

соёрхон батлаад нэг жилийн дотор байгуулах ёстой байдаг учир Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах үйл явцад бодит нөлөө үзүүлэхэд чухал ач холбогдолтой үе юм. Мэдээж Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбогдон ажиллах үүднээс шалгалт хийх мандатаа ашигласан байх боломжтой. Тийм шалтгаанаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны шалгалтыг шинжилж үзэх юм.

3.2. Шалгалтын агуулга: Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллах нь

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын II(a)-р зүйлд хүний эрх чөлөөг хязгаарладаг газруудад шалгалт хийх нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүн улсад айлчлал хийх мандатын маш чухал бүрэлдэхүүн хэсэг мөн гэж тэмдэглэсэн байдаг. Мэдээж энэ бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатын нэг гол шинж тал юм. Учир нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын оршин байхын бүрэн утга учир нь хүний эрх чөлөөг хязгаарладаг газруудад тогтмол байдлаар шалгалт хийдэг байх батлагааг хангахад орших бөгөөд энэ бол гэрээний байгууллага энэхүү шинж талыг анх ажлаа эхлэхээсээ л шүүрч авсан гэдгийг хэлэх шударга юм.

Хүний эрх чөлөөг хязгаарладаг газруудад айлчилж ажиллахаас гадна тухайн айлчлалын үеэр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо эрх баригчидтай

холбогдон ажиллаж, холбогдох хууль тогтоох хүрээтэй танилцаж ирсэн билээ. Эхнээсээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо үндэсний хууль тогтоомжид туссан¹⁴⁴ зүй бус харьцааны эсрэг албан ёсны хамгаалалтын тухайд өөрсдийн сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд үндэсний хууль тогтоомжид туссан эрүү шүүлтийн талаарх тодорхойлолт¹⁴⁵ болон бие махбодын шийтгэл¹⁴⁶ зэрэг асуудлуудыг хөндөн ажиллаж ирэв. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо хууль тогтоомжийн хэрэгжилтийг соргоогоор шалгаж ирсэн бөгөөд, түүгээрээ холбооны улсуудын гол хууль тогтоомж болон хоёрдогч түвшний хууль тогтоомжуудын хоорондын хийдэл, цоорхой,¹⁴⁷ хууль тайлбарлах асуудал,¹⁴⁸ олон улсын үүрэг хариуцлагыг үндэсний хууль тогтоомжид зохистой тусгаж байгаа¹⁴⁹ зэрэг асуудлыг нягт нямбай шинжиж ирсэн юм. Түүний нэг адилаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Хүний эрхийн үндэсний байгууллага¹⁵⁰, хорих

¹⁴⁴ For example, see: Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit Report, *op.cit.* note 45, at paras. 17–33; Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to Paraguay, UN Doc. CAT/OP/PRY/1 (2010), at paras. 22–29; Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to Benin, UN Doc. CAT/OP/BEN/1 (2011), at paras. 27–30.

¹⁴⁵ Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to Honduras, UN Doc. CAT/OP/HND/1 (2010), at paras. 75–78; Subcommittee on Prevention of Torture, Benin Visit Report, *op.cit.* note 62, at paras. 29–30; Subcommittee on Prevention of Torture, Paraguay Visit

Report, *op.cit.* note 62, at paras. 26–29; Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit report, *op.cit.* note 45, at paras. 23–25.

¹⁴⁶ Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit report, *op.cit.* note 45, at paras. 26–29.

¹⁴⁷ Subcommittee on Prevention of Torture, Report on the Visit of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment to Mexico Visit Report, UN Doc. CAT/OP/MEX/1 (2010), at paras. 47–57.

¹⁴⁸ *Ibidem*, at paras. 58–63.

¹⁴⁹ Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit report, *op.cit.* note 45, at paras. 18–22.

¹⁵⁰ For example, the Human Rights Commission of Maldives

байгууллагуудаар орж шалгалт хийдэг үндэсний механизмууд¹⁵¹, үндэсний өргөдөл гомдол шийдвэрлэх механизм¹⁵² болон янз бүрийн шатны шүүх¹⁵³, прокурорын байгууллагуудын¹⁵⁴ мандат, туршлагыг шалгах зэргээр институцийн хүрээний шүүмжийн арга хэмжээ авч хэрэгжүүлж ирэв. Энэ цухас дүн шинжилгээнээс зохих эрх зүйн бүтэц байгаа эсэх төдий бус тэрхүү бүтцийг дотоодын тогтолцоондоо хэрхэн ойлгож, хэрэгжүүлдэг вэ гэдэг, мөн тэр нь дотоодын эрх зүйн, шүүхийн, захиргааны тогтолцоо мөн эсэхэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо анхаарал хандуулдаг нь харагдана. Энэ чиг шугам мэдээж Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын удиртгал хэсэгт дурдсан урьдчилан сэргийлэх өргөн мандаттай зохицож байгаа юм.

Харин Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухайд одоогоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлал бүр Урьдчилан сэргийлэх үндэсний механизм-той холбоотой элементийг агуулж байна. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаар тодорхойлогдсон байгууллагатай уулзалт хийж¹⁵⁵, Урьдчилан

сэргийлэх үндэсний механизмаар тодорхойлогдсон байдлынх нь талаар ярилцан¹⁵⁶, ийнхүү толорхойлогдсонх нь зохимжийн тухайд тайлбар өгөх буюу Урьдчилан сэргийлэх үндэсний механизм-байгуулагдаагүй тохиолдолд тодорхойлох үйл явцын¹⁵⁷ талаар хэлэлцүүлэгт оролцон уг үйл явцад нь санаа бодлоо илэрхийлдэг¹⁵⁸. Гаднаас нь харвал Дэд хороо үндэсний хэмжээний хамтрагчынхаа байгуулагдах тухайд болон үйл ажиллагаанд нь хяналт тавьж ирсэн мэт харагдана. Харамсалтай нь олон нийтийн домейнд тавигдсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлалын илтгэл тайлан бүрт орж байдаг нэг томоохон нийтлэг шинж бий. Энэ нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах харилцаагаа товч хүйтэн өнгө аясаар тодорхойлж, бие даасан Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах, хэрхэн ажиллагаанд оруулах талаар тун хомсхон зөвлөмж өгдөг байдал юм. Аль нэг улсад хийсэн айлчлалын тайланд зуугаас доошгүй зүйл заалт ордог хорих байгууллагууд дээр хийдэг шалгалтын талаар

Mexican NPM 'and exchanged information on working and visiting methods and on the national preventive mechanism's visits to date to places of detention, together with reports of its activities and recommendations'. Subcommittee on Prevention of Torture, Mexico Visit report, *op.cit.* note 65, at para. 27.

(*ibidem*, at paras. 35–43), the Ombudsman's Office in Paraguay (Subcommittee on Prevention of Torture, Paraguay Visit Report, *op.cit.* note 62, at para. 33), and the National Human Rights Commission in Mexico (Subcommittee on Prevention of Torture, Mexico Visit Report, *op.cit.* note 65, at paras. 64–66).

¹⁵¹ For example, the Inter-institutional Commissions in Paraguay: see Subcommittee on Prevention of Torture, Paraguay Visit Report, *op.cit.* note 62, at paras. 31–32.

¹⁵² Subcommittee on Prevention of Torture, Benin Visit Report, *op.cit.* note 62, at paras. 31–44.

¹⁵³ For example, the Constitutional Court in Benin (*ibidem*, at paras. 47–50) and the Juvenile Court in Maldives (Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit report, *op.cit.* note 45, at paras. 30–33).

¹⁵⁴ Subcommittee on Prevention of Torture, Mexico Visit Report, *op.cit.* note 65, at paras. 83–92; Subcommittee on Prevention of Torture, Benin Visit Report, *op.cit.* note 62, at paras. 45–46; Subcommittee on Prevention of Torture, Honduras Visit Report, *op.cit.* note 62, at paras. 87–95.

¹⁵⁵ For example, when visiting Mexico, the SPT met with the

¹⁵⁶ In the case of Sweden, for example, after having met the Swedish NPM and authorities, the SPT noted that while '[I]t is not for the SPT to give an opinion as to the constitutionality of the designation process' it will however 'need to assess Sweden's compliance with the provision of OPCAT'. Subcommittee on Prevention of Torture, Sweden Visit report, *op.cit.* note 46, at para. 35.

¹⁵⁷ For example, the visit report to Benin notes the SPT's regret regarding its inability to meet with the members of the Ad-Hoc Working Group in charge of NPM process despite repeated requests. Subcommittee on Prevention of Torture, Benin Visit report, *op.cit.* note 62, at para. 17.

¹⁵⁸ For example, when in Paraguay, the SPT expressed 'its satisfaction at the process that led to the adoption of the draft legislation setting up the National Preventive Mechanism' describing this as 'a model for the open, transparent and inclusive participation of a wide range of stakeholders'. At the same time, the SPT noted with concern the delay in approval of said legislation by the Legislative Commission of the Senate. Subcommittee on Prevention of Torture, Paraguay Visit report, *op.cit.* note 62, at paras. 56–57.

дүрсэлдэгтэй нь харьцуулахад Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд зориулсан хангалттай зүйл заалт байдаггүй билээ.¹⁵⁹ Энэ ажиглалт бол тоон шинжилгээний үр дүн бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухайд холыг харсан зөвлөмжийг товч хураангуй байдлаар дэвшүүлсэн байж болох тул буруу ойлголтод хөтөлж болох юм. Гэхдээ асуудлыг бодитойгоор үнэлж үзвэл өөрөөр ойлгож болох байх. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын талаарх зөвлөмжүүдэд нь хүлээж болох зүйлийн талаар тодорхой мэдээлэл дутмаг, заримдаа Дэд хороо аль хэдийн бүх Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад зориулж гаргасан ерөнхий баримт бичиг болох Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын гарын авлагын¹⁶⁰ зүйл заалтыг давтсанаас хэтэрдэггүй.¹⁶¹ Ийн нарийвчилж заадаггүй нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд тулгараад байгаа сорилт, бэрхшээлийг анхаарал тавьдаг байгууллага гэж харагдуулахгүй байгаагийн дээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний

механизмыг газар дээр шалгах механизм¹⁶² байгаасай гэсэнтэй нь таарахгүй байна.

Хамгийн чухал нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь “гишүүн улсад хийх айлчлал”, “эрх чөлөөг хязгаарладаг газруудад хийх шалгалт” хоёрын хоорондын ялгааг гаргаж чадахгүй байгаа мэт байх тул Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын түүхийг бичилцэхэд оролцохоос зайлсхийж байгаа мэт дүр зураг харагдаж байна. Улсад хийх айлчлал нь гишүүн улсын эрх баригчидтай эсвэл Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай нь өөртэй яриа хийх зарим элементийг агуулдаг бол эрх чөлөөг хязгаарладаг газруудад шалгалт хийхэд зориулах анхаарал болон мандатынх нь энэхүү талыг тойрсон асуудлуудад нийцэхээр буюу жаахан ойр дөхөх зүйл байгаагүй юм. Эрх чөлөөг хязгаарладаг газруудад очиж шалгалт хийхтэй харьцуулбал Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай ажиллах хамтын ажиллагаан дахь энэ ялгаа нь гэрээний энэ байгууллагыг улс орнуудад хийх айлчлал шалгалтыг олон олон давтамжтайгаар хийхэд саад болсон санхүүжилтийн хүндрэлтэй давхцсан бөгөөд үүгээрээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо төсөвөө хэр стратегийн байдалтай зарцуулж ирсэн бэ гэдэг асуулт тавихад хүргэж байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо санхүүгийн хүндрэлтэй байсан ч 18 гишүүн улсад айлчлал хийсэн гэрээний байгууллагын хувьд сайшаавал зохих амжилт мөн. Эдгээр айлчлалыг бүгдийг нь тодорхой Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай тулж холбогдон

¹⁵⁹ *Idem*. For example, in the case of Paraguay, there are three paragraphs devoted to the NPM (paras. 56–58) in comparison to 167 paragraphs describing visits to actual places of detention (paras. 59–224). In the case of Sweden, the SPT used 100 paragraphs (paras. 43–141) to report its visits to police facilities and remand prisons, whilst only 23 paragraphs (paras. 19–42) were devoted to the NPM issue (Subcommittee on Prevention of Torture, Sweden Visit Report, *op.cit.* note 46). In the case of Mexico the SPT used three paragraphs to describe the legal framework applicable to the Mexican NPM and three paragraphs to evaluate it, and devoted three paragraphs to recommendations regarding NPMs (paras. 24–32). This can be contrasted with overall 183 paragraphs that deal with visits to places of detention (Subcommittee on Prevention of Torture, Mexico Visit report, *op.cit.* note 65).

¹⁶⁰ Preliminary Guidelines on NPMs were published with the First Annual Report of the SPT, *op.cit.* note 10, at para. 28. These have been recently updated: Subcommittee on Prevention of Torture, Guidelines on National Preventive Mechanisms, UN Doc. CAT/OP/12/5 (2010).

¹⁶¹ See: Subcommittee on Prevention of Torture, Sweden Visit Report, *op.cit.* note 46, at para. 41; Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit report, *op.cit.* note 45, at para. 71.

¹⁶² Subcommittee on Prevention of Torture, First Annual Report, *op.cit.* note 10, at para. 29.

ажиллах, тэдэнд зохих байдлаар туслалцаа үзүүлэх онцгой, төгс боломж болгож ашиглаж чадаагүй нь даанч харамсалтай.

Магадгүй энэ харамсмаар бодит байдлыг сайтар ухаарсан бололтой Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Тав дахь ээлжит илтгэлдээ ийнхүү өгүүлжээ:

Айлчлах улсуудыг сонгоходоо Дэд хороо олон янзын хүчин зүйлийг харгалзан үзэж, Дэд хорооны өргөтгөсөн хэлбэрийг оновчтой ашиглан, боломжит санхүүгийн нөөцийг хамгийн үр өгөөжтэйгөөр ашиглаж, гишүүн улсуудыг зохистойгоор хамруулах баталгааг ханган илүү учир зүйтэй үйл явцаар ажиллах болно. Үүний дээр урьдын адилаар соёрхон батласан огноо, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын төлөвшил, газар зүйн байршил, тухайн улсын хэмжээ болон бүрэлдмэл байдал, бүс нутгийн түвшин дэх урьдчилан сэргийлэх мониторинг, өмнө нь мэдээлсэн тодорхой/яаралтай асуудлууд зэргийг анхааралтай хянаж үзэх болно.¹⁶³

Дээрх мэдэгдэл бол хоёр шалтгааны улмаас сонирхол татаж байна. Эхнийх нь санхүүжилт хүрэлцээгүй нөхцөлд урьдын адил байгааг тэмдэглэхийн хажуугаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ирээдүйд айлчлалд төсөв зарцуулж байгаа байдалдаа дүгнэлт хийх болно гэдгээ илэрхийлж байна. Хоёр дахь нь айлчлал хийх улсыг сонгоход Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулсан байхыг шалгуур хэвээр байна. Хамгийн чухал нь энэ хоёр шалтгааныг нэгтгэсэнээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо 2012 оноос шинэ төрлийн айлчлал зарлахад хүргэжээ.

3.3. Шалгалтын төрлүүд: Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон

харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын агуулгаас гадагш гарсан нь

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд хоёр айлчлалын төрлийг зааж оруулжээ. Ээлжит, гишүүн улсад хийх айлчлал¹⁶⁴, мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо шаардлагатай гэсэн үедээ санал болгодог богино хугацаатай шалгалтын мөрөөр хийх айлчлал¹⁶⁵. Гэхдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо өөр хоёр төрлийн айлчлал байж болохоор дурдсан байдаг. Дөрөв дэх ээлжит илтгэлдээ чухам юу гэдгийг нь тодорхойлон хэлэлгүйгээр Дэд хороо Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батламагц нь аль болох удалгүйгээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахад нь зөвлөгөө, туслалцаа үзүүлэх үүднээс арай богино, нэмэлт айлчлал хийхийг илүүд үзнэ гэж хэлжээ.¹⁶⁶ Түүгээр ч барахгүй 2012 ондхийх айлчлалынхаа хөтөлбөртөө Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Аргентин, Габон, Гондурас, Киргиз, Молдав, Сенегал улсуудад айлчлал хийнэ гэж зарласан бөгөөд Гондурас, Солдав, Сенегал улсуудад хийх айлчлал Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд илүүтэй анхаарах болно гэж мэдэгдсэн юм.¹⁶⁷

Энэ мэдэгдлээрээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо 4 дэх төрлийн айлчлал болох Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн айлчлал гаргаж ирсэн бөгөөд ийм айлчлалын төрөл

¹⁶⁴ Art. 13(1) OPCAT.

¹⁶⁵ Art. 13(4) OPCAT.

¹⁶⁶ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 45.

¹⁶⁷ UN, *op.cit.* note 19.

¹⁶³ Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para. 89.

бий болгосныхоо учрыг тайлбарласан нь:

Боломжит нөөц хөрөнгийн байдлаас төсөөлж байснаараа ээлжит айлчлалынхаа тоог нэмэгдүүлэх боломжгүй байдалтай байгаа тул Дэд хороо айлчлал хийх шинийг эрэлхийлсэн арга замыг хайж байна. Тиймээс Дэд хороо айлчлал хийхдээ гишүүн улстай эхний холбоо тогтоож, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллан, ээлжит айлчлал, айлчлал шалгалтын мөрөөр хийх айлчлалыг аль алийг нь ханган ажиллахын тулд боломжтой бол хооронд нь нэгтгэсэн байдлаар, урьдчилан сэргийлэх мандатынхаа олон янзын шинж талыг анхааран айлчлал зохион байгуулж байхаар шийдээд байна.¹⁶⁸

Энэ мэдэгдэл нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо эцэст нь мандатынхаа бүхий л шинжийг биелүүлэхийн тулд үг хэлээ үйл хэрэг болгохоор ажиллаж эхэлсэн хийгээд Коста Рикагийн болон Европын Холбооны боловсруулсан Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын төслийн нэр томъёог ашиглан гишүүн улсад хийх айлчлалаас цааш гарч, хорих байгууллагуудад шалгалт хийхээр хязгаарлахгүй бүрэн хэмжээний томилолтод шилжин ажиллахад бэлэн байгааг батлан харуулж байна. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн айлчлал болон гишүүн улстай анхны холбоо тогтоох айлчлалыг зарласан нь энэ шинэ чиг шугамын тод илрэл болж буй бөгөөд талархан хүлээн авууштай юм.

Мэдээж энэхүү зарласан нэгдмэл төрлийн айлчлал бодит байдалд чухам ямар байдалтай болохыг хүн таахаас хэтрэхгүй. Учир нь 2012 онд айлчлахаар сонгон авсан

гурван улс болох Аргентин, Габон, Киргиз тийм жишээ болж харагдахгүй байна. Аргентин Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг 2004 оны 11 дүгэр сарын 15-нд соёрхон батласан бол Киргиз 2008 оны 12 дугаар сарын 29-нд батласан байна. Энэ бол эдгээр хоёр улс уг баримт бичгийн гишүүн болоод хэдэн жил өнгөрсөн гэсэн үг. Габон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг 2010 оны 11 дүгээр сарын 22-нд батласан байна. Тиймээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо яг хэзээ айлчлалаа хийхээс хамаараад соёрхон батласнаас хойш хоёр жилийн дотор айлчлал хийсэн болж болох юм. Энэ айлчлал шинэ гишүүн улстай холбоо тогтоох айлчлалын шалгуурыг хангаж болох ч Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг байгуулах үүргийг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг батласнаас нэг жилийн дотор гүйцэлдүүлэх ёстой гэдгийг санах хэрэгтэй. Энэ бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Габон улс Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах ёстой энэ чухал хугацааг хэдийн алдсан гэсэн үг.

Мөн Аргентин, Киргиз улсуудын тухайд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлалынхаа агуулгад ямар нэг учир холбогдолтой Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бүрэлдэхүүн шинжийг оруулж чадахгүй, учир нь Аргентин улсад айлчлал 2012 оны 4 дүгээр сарын сүүлээр болсон бөгөөд тухайн үед тус улсад үйл ажиллагаа бодитоор явуулсан

¹⁶⁸ Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para. 41.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгаагүй¹⁶⁹, харин Киргиз улс Урьдчилан сэргийлэх үндэсний механизмынхаа хуулийг дөнгөж 2012 оны 6 дугаар сард л батласан юм. Тиймээс санал болгосон хугацаа буюу 2012 оны 9 дүгээр сард Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлал хийх үед¹⁷⁰ тус улсад ажиллагаатай Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байхгүй байна гэсэн үг. Тиймээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо өмнөх ээлжит илтгэлдээ дурдсан нэгдмэл айлчлалын тухайд эдгээр улсын хувьд боломжгүй болж байна.

2012 онд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэж айлчлал хийхээр болсон 2006 оны 5 дугаар сарын 23, 2006 оны 7 дугаар сарын 24, 2006 оны 10 дугаар сарын 18-ны өдрүүдэд¹⁷¹ тус тус Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколыг соёрхон батлаж, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа тодорхойлсон¹⁷² Гондурас,¹⁷³ Молдавын Бүгд Найрамдах Улс, Сенегал гэсэн эхний гурван улсын хувьд арай өөр юм. Тиймээс болж байгаа хугацааныхаа хувьд тус бүр батлагдаж, Урьдчилан сэргийлэх үндэсний

механизм нь бий болсноос хойш Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлал болох хүртэл 5 жил өнгөрсөн байна. Энэ нь дор хаяж хоёр жилийн туршлагатай Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай ажиллах боломж байгаа нь үр дүн дуулгаж болох эхлэл юм. Харамсалтай нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо тиймэрхүү Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн айлчлалын хүрээнд юу оруулах гэж байгаа талаараа тодорхой зүйл огт мэдэгдэхгүй байгаа бөгөөд холбогдох нууцлалын шаардлагаар энэ хамтын ажиллагааны талаар цаашид нарийн тодорхой зүйл олж мэдье гэвэл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дараагийн Ээлжит илтгэл гарах хүртэл хүлээх болно.

Гэвч энд тэмдэглэх нэг сонирхолтой зүйл гэвэл 2012 оны 5 дугаар сард Гондурас хийсэн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн айлчлалын үеэр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо уг айлчлалыг 2009 онд хийсэн эхний айлчлалынхаа зөвлөмжийн¹⁷⁴ хэрэгжилтэд шалгалт хийх зорилгоор ашигласан учраас энэ айлчлал нь холимог айлчлалын шинжийг агуулж байлаа. Энэ туршлагыг цаашид баримтлах эсэх, баримтлавал ямар цар хүрээтэй дагах вэ гэдгийг мэдэхгүй ч эхний дохио урам өгмөөр харагдаж байна.

4. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ба Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд: бусад хамтын ажиллагаа

4.1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр

¹⁷⁴ See: UN, 'Press Release: Expertos de la ONU y organo hondureco en acciyn conjunta para prevenir la tortura' [UN experts and Honduran mechanism in joint action to prevent torture], 4 May 2012, available at: www.ohchr.org/SP/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=12121&LangID=S.

¹⁶⁹ Albeit at provincial level, an NPM was established in Chacho province: see Association for Prevention of Torture (APT), 'First provincial preventive mechanism set up in Argentina' (2012), available at: www.apr.ch/en/news_on_prevention/chaco-mechanism/.

¹⁷⁰ The SPT has announced that its visit to Kyrgyzstan took place from 19–28 September 2012. See: Subcommittee on Prevention of Torture, 'SPT Visits', available at: www2.ohchr.org/english/bodies/cat/opcat/spt_visits.htm.

¹⁷¹ United Nations Treaty Collection, available at: treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsq_no=IV-9-b&chapter=4&lang=en.

¹⁷² Honduras has designated the National Committee for the Prevention of Torture as its NPM; in Moldova it is the Ombudsman's Office in combination with the Consultative Council which are to carry out the NPM functions while Senegal established an entirely new institution for its NPM: the National Observer for Places of Deprivation of Liberty, Association for Prevention of Torture, 'List of Designated NPMs', available at: www.apr.ch/en/list-of-designated-npm/.

¹⁷³ The SPT carried out the 'NPM focused' visit to Honduras from 30 April to 4 May 2012. *Ibidem*.

төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын айлчлалаас гадуур Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай ажиллах нь

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны албан ёсны айлчлалаас Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах байдал нь хойрго, тохиолдлын шинжтэй харагдаж байсан бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо илүү ихийг хийж гүйцэлдүүлсэн ч тэдгээрийнх ихэнх нь хөшигний цаана үлдсэн гэдгийг хэлэх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай үндэсний хэмжээнд нь тодорхой харилцах ажиллагааны хувьд хамгийн онцгой ач холбогдолтой арга хэмжээ нь Европын Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын төсөл хэмээх үйл ажиллагаа юм.¹⁷⁵ Төслийн гол зорилго нь Европын Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад дэмжлэг үзүүлж, уулзаж, хамтран ажиллах боломж олгоход чиглэсэн байгаа юм. Энэ нийтлэг зорилгын хүрээнд төсөл мөн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хооронд хамтын ажиллагааг бэхжүүлсэн юм. Энэ хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад зориулсан сэдэвчилсэн семинарт ч,¹⁷⁶ хүсэлт гаргасан

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай газардээрх туршлага солилцох ажиллагаанд¹⁷⁷ ч оролцож чадсан юм. Эдгээр айлчлалын хүрээний харилцан ажиллагаанд жишээ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны гишүүд төсөлд оролцсон олон улсын шинжээчдийн хамтаар Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын шалгалтыг загварчлан үзүүлж, тийм шалгалтын загвар аргачлалын талаар практик зөвлөгөө өгсөн юм.¹⁷⁸ Эргэлзээгүй энэ нь өргөн мандатаа шүүрч аваад байгаа олон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хувьд тун чухал зөвлөгөө юм. Үр дүнд нь төсөл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд янз бүрийн сэдэвчилсэн асуудлаар Европын Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай нийтээрээ хамтран ажиллах боломж бөгөөд түүгээр ч үл барам зарим сонгон авсан Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай шууд ганцаарчлан ажиллах боломж олгосон байна. Эдгээр нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хомсхон төсөв хөрөнгийг харгалзан үзвэл таатай хүлээн авах боломж байв. Гэхдээ эдгээр бүх ажлыг тодорхой нэг төслийн хүрээнд хийж гүйцэлдүүлсэн болохоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороог хүндхэн нөхцөлд оруулаад байгаа түүний албан ёсны ажил үүрэгт хамаарахгүй билээ. Нөгөөтэйгүүр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд зөвлөгөө өгөхдөө харилцан уялдааг хангах ёстой. Гэтэл нөгөө талаар өөрийнхөөрөө төлөвшин хэрэгжсэн

¹⁷⁵ 'Description of the European NPM project'. A Council of Europe and European Commission Joint Programme 'Setting up an active network of national Preventive mechanisms against torture, an activity of the Peer-to-Peer Network', co-funded by the Human Rights Trust, Strasbourg, 12 January 2012, LHRCB/NPM (2010)2. For more project details, including Newsletters, see: www.coe.int/t/dghl/cooperation/capacitybuilding/nhrs_en.asp.

¹⁷⁶ Since the start of the project, there have been nine thematic workshops: on psychiatric institutions (Italy, March 2010); on the police (Albania, June 2010); on the preparation, structure and planning of strategies for NPMs (Armenia, October 2010); on security and dignity in places of deprivation of liberty (France, March 2011); on the methodology on information collection (Estonia, June 2011); inter-NPM discussion on monitoring deportation flights (UK, July 2011);

on the roles of doctors (Poland, December 2011); on the role of NPMs and deportation (Switzerland, March 2012); and on irregular migrants (Serbia, June 2012). *Ibidem*.

¹⁷⁷ There have been five such requests from NPMs from: Poland (May, 2010); Georgia (June, 2010); Spain (November, 2010); Albania (June, 2011); and Armenia (October, 2011). *Ibidem*.

¹⁷⁸ See for example, 'European NPM Project On-site Exchange of Experiences, Tirana, Albania, 28 June-1 July 2011' in *The European NPM Newsletter*, Vol. 17/18, June-July 2011, at p. 6.

тодорхой нэг төслийн хүрээнд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллах нь дээр дурдсан харилцан уялдааг хангах эрх зүйн хүрээг хүндрэлтэй болгож мэдэх юм.¹⁷⁹

4.2. Нууцлалын зарчим ба Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандат

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо-ноос Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллахад эхэн үед саад тотгор болж байсан нэг зүйл бол мандатад нь хамаарах нууцлалын зарчмаа тайлбарлаж байгаа арга байв.¹⁸⁰ Нууцлалын зарчим бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо мандатаа хэрэгжүүлэхэд хамгийн чухал ач холбогдолтой зарчим бөгөөд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын суурь болсон философийн мөн чанарт оршдог зүйл юм.¹⁸¹ Гишүүн улсад хийх айлчлалын илтгэлийг нийтлэх үед энэ нь бүр ч тодорхой болдог: Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зөвлөмж, дүгнэлтийг гишүүн улсад нууцлан хүргэх бөгөөд тухайн улс илтгэлийг хэвлэн гаргах хүсэлт гаргахгүй л бол утга агуулга нь нууц хэвээр үлддэг.¹⁸² Одоогоор айлчлал хүлээн авсан орнуудын тал хувь нь илтгэлийг хэвлэн гаргахыг хүсээд¹⁸³ байгааг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо-оос гишүүн улс, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо-ын

хоорондох харилцаа өсч байгаагийн бодит илрэл¹⁸⁴ хэмээн тодорхойлж байна.

Гэвч эхэндээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нууцлалын зарчмыг их холыг харсан байдлаар тайлбарлаж байсан бөгөөд өөрийн үйл ажиллагааны журмыг¹⁸⁵ нийтэд ил болгохгүй, өөртэй холбогдон ажилласан Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг зарладаггүй байсан юм.¹⁸⁶ Үнэндээ Хоёр дахь ээлжит илтгэл гаргал Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь тодорхойлогдсон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын жагсаалтыг цахим хуудсандаа¹⁸⁷ тавиагүй билээ. Энэ хойрго байдлыг тийм байдлаар нийтэд ил болгох нь аль нэг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг магадлан итгэмжлэлийн адилаар¹⁸⁸ хүлээн зөвшөөрч байгаагийн тэмдэг болгож болзошгүй юм гэсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны болгоомж гэж нэг талаас тайлбарлаж болох ч Нууцлалын зарчмыг хэтрүүлэн хэрэглэсэн нь энд гол үүрэг гүйцэтгэсэн гэхэд болно.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны ажилд юу нь нууц, юу нь нууц биш гэдэг дээр эргэлзсэн нь одоо ердөө л Дэд хороо нээлттэй, ил тод байдлаар ажиллана¹⁸⁹ гэж заасны түүхэн шинжтэй тусгал төдий юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо одоо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын талаарх мэдээллийг нийтэд ил болгож харилцсан Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ээлжит илтгэлийн

¹⁷⁹ Murray *et al.*, *op.cit.* note 21, at pp. 148–149.

¹⁸⁰ Art. 2(3) OPCAT.

¹⁸¹ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 45.

¹⁸² Art. 16 OPCAT. It should be noted that the SPT may publish the report if the State Party publishes part of a report (Art. 16(2)) and it may also request the CAT to make a public statement or publish a report if a State Party refuses to cooperate with the SPT (Art. 16 (4) OPCAT).

¹⁸³ These are: Sweden, the Maldives, Mexico, Paraguay, Honduras and Benin.

¹⁸⁴ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 46.

¹⁸⁵ *Ibidem*, at para. 47; see also Murray *et al.*, *op.cit.* note 21, at p. 96. These have now been made public: Subcommittee on Prevention of Torture, Rules of Procedure of the Subcommittee on Prevention of Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, UN Doc. CAT/OP/12/3 (2011).

¹⁸⁶ Murray *et al.*, *op.cit.* note 21, at p. 129; also Murray, *loc.cit.* note 18, at p. 493.

¹⁸⁷ Subcommittee on Prevention of Torture, Second Annual Report, *op.cit.* note 17, at para. 34.

¹⁸⁸ Murray, *loc.cit.* note 18, at p. 493.

¹⁸⁹ Statement by Mr Malcolm Evans, *loc.cit.* note 26.

талаар мэдээллээр хангадаг.¹⁹⁰ Түүнээс гадна Дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулах үүргээ бодит байдал дээр зөрчсөн гишүүн улсуудын жагсаалт¹⁹¹ хөтөлдөг бөгөөд хамгийн чухал нь айлчлалын дараах зөвлөмжийг тухайн улс руу төдийгүй холбогдох Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хүргүүлэх¹⁹² нь тодорхой болсон байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны илтгэлийг албан ёсоор хүлээн авагчдын тоонд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг оруулсан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг үндэсний хамтрагчаа болгон төлөвшүүлэхэд чиглэсэн шинэ чиг шугамын яриагүй нэг чухал шинж мөн.

4.3. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад удирдлага гарын авлагаар туслалцаа үзүүлэх нь

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд зааснаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хоорондын харилцаа айлчлах шалгах төдий шинжээр зогсохгүй Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд зөвлөгөө, арга зүйн туслалцаа санал болгох, мөн эрхээ хязгаарлуулсан хүмүүсийг зүй бус харьцаанаас хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэх хэрэгцээ, арга хэрэгслийг үнэлэхэд зөвлөгөө, туслалцаа үзүүлэх хүртэл

чухал харилцаа хамаарна.¹⁹³ Айлчлалаас гадуур Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны анхны чиг шугам нь зарим талаар туйлбаргүй байлаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг өөрийн чухал хамтрагч гэж хүлээн зөвшөөрөх эхний шинж тэмдэг байсан ч үүнийг чухам юу гэж ойлгох ёстой нь тодорхойгүй байв. Ядаж эхэндээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцахдаа хойрго байсан зарим талаар Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцсэн Урьдчилан сэргийлэх үндэсний механизм ямар байдалтай байх талаар мэдлэг ойлголт дутмаг байсан нь нөлөөлсөн гэж үзэж болох юм. Тэгээд ч Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол бол Урьдчилан сэргийлэх үндэсний механизм шиг тийм үндэсний байгууллага байгуулахыг тухайлан шаарддаг олон улсын хүний эрхийн анхны гэрээ байхаас гадна өмнө нь дурдсанчлан энэ нь хэрхэн бий болох талаар тун хомс заалт орсон юм.

Гишүүн улсад туслах, мөн ерөнхийдөө Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан яриа зохион байгуулах¹⁹⁴ оролдлогоор анхны ээлжит илтгэлдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудын одоо болж байгаа төлөвшилд зориулан Бэлтгэл зааварчилгааг нийтлэн

¹⁹⁰ Subcommittee on Prevention of Torture. 'Annual Reports Received by the SPT from National Preventive Mechanisms', available at: www2.ohchr.org/english/bodies/cat/opcat/annualreports.htm.

¹⁹¹ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at paras. 20–25; Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at paras. 19–21.

¹⁹² Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 47.

¹⁹³ Art. 11 (b) OPCAT.

¹⁹⁴ First Annual Report, *op.cit.* note 10, at paras. 28–29.

гаргасан юм. Гэхдээ эдгээр нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын бичвэрээс цааш нэг их хол гараагүй бөгөөд үнэндээ зарим асуудал дээр Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын зүйл заалтуудын утгыг тодруулж чадаагүйгээс¹⁹⁵ зорилго нь юу байсныг асуух нь зүй билээ.¹⁹⁶ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо засаж сайжруулсан эх гаргах¹⁹⁷ хүртэл хоёр жил болсон бөгөөд тэр нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын заалтуудыг нарийн гаргаж өгсөн юм. Эдгээр засаж сайжруулсан зааварчилгаа нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын мандатын илүү хүндрэлтэй талыг хэрхэн шийдвэрлэх талаар практик шинжтэй зөвлөгөө өгч, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах харилцаан дахь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын заалтууд дээр тулгуурлавал тун хэрэгтэй хэрэгсэл болж магадгүй юм. Түүнээс гадна Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны эдгээр нь эхлэл бөгөөд эдгээр зааварчилгаанд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын ажлын тодорхой асуудлыг нарийвчилан хөндөж шинэ хэсгүүдийг нэмж оруулахаар

¹⁹⁵ For example, the Guidelines do not discuss the mandate of NPMs as per Arts. 19–20 OPCAT, nor the provision encapsulated in Art. 35 OPCAT regarding the requisite privileges and immunities that should be accorded to NPM members.

¹⁹⁶ See: OPCAT Contact Group 'Letter to the UN Subcommittee on Prevention of Torture Commenting on the SPT's First Annual Report' (2008), available at: www.bristol.ac.uk/law/research/centresthemes/opcat/docs.html.

¹⁹⁷ Subcommittee on Prevention of Torture, Guidelines on National Preventive Mechanisms, *supra* note 79.

зорьж байгаа гэсэн билээ.¹⁹⁸

Саяхан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо “Урьдчилан Сэргийлэх Үндэсний Механизмд зориулсан өөрийгөө үнлэх задлан шинжилгээний аргачлал”-ыг хэвлэн гаргасан¹⁹⁹ нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд үйл ажиллагаанхаа аргачлалд шалгуур жагсаалт болгож ашиглахаар шинжтэй болсон байна. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын гарын авлагыг боловсруулсны нэгэн адилаар энэ аргачлал бол бас л нэг бэлтгэл ажлын шинжтэй бөгөөд бодит байдлын хувьд үүнд ээлжит болон улсын айлчлалын илтгэлүүдэд орсон нээлттэй домейнд байгаагаас илүү гарах зүйл багатай аж. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ирээдүйд энэ аргачлалыг илүү тодорхой, нарийвчилсан байдлаар сайжруулан бэлтгэх бизээ.

Эдгээр бүх санаачлага нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн зориггүй, туйлбаргүй хандлагаа орхиж гишүүн улс болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд аль алинд нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын зүйл заалтыг тайлбарласан заавар зөвлөгөө өгөх байдлаар ерөнхий түвшинд илүү зөвлөх үүрэгтэй ажиллахад бэлэн байгааг харуулж байна.

4.4. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын магадлан итгэмжлэл

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн хойрго байдалд гол нөлөө үзүүлсэн байж болох хүчин зүйл бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд

¹⁹⁸ *Ibidem*, at para. 4.

¹⁹⁹ Subcommittee on Prevention of Torture, Analytical Self-Assessment Tool for National Preventive Mechanisms (NPMs): A Preliminary Guide by the SPT Regarding the Functioning of an NPM, UN Doc. CAT/OP/12/8 (2011).

хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцсэн байгууллага эсэхийг нь магадлан итгэмжлэх эсэх дээр ойлгомжтой байр суурь баримтлахаас зайлсхийсэн явдал байлаа. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд дурдсан Парисын Зарчмын талаарх ойлголт²⁰⁰, дэлхий дээр байгаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын олонх нь Хүний эрхийн үндэсний байгууллагууд²⁰¹ байгаа зэргээс хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Олон Улсын Зохицуулах Хорооны хийдэг магадлан итгэмжлэл Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд холбогдолтой юу гэсэн асуулт урган гарч байна.²⁰² Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо эхнээсээ л илэрхий ойлгомжтой чиг шугам бий болгохоос зайлсхийсэн байдалтай байв. Гишүүн улсад хийсэн анхны айлчлалуудынхаа үеэр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбогдох гишүүн улсын үүргийн заалтуудыг биелүүлж байгаа эсэхийг үнэлнэ гэж мэдэгдэж байсан²⁰³ бөгөөд

Гурав дахь ээлжит илтгэлдээ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг үнэлэх дүн шинжилгээний аргачлал дээр ажиллаж байгаагаа илэрхийлжээ.²⁰⁴ Тухайлан яг тэр илтгэлдээ Парисын зарчимд нийцүүлэн магадлан итгэмжлэх нь нэмэгдэл механизм бөгөөд тодорхой хэргүүд тохиолдлууд дээр тийм үнэлгээ хийх нь Дэд хороо байх учраас урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг магадлан итгэмжлэх журам байдлаар хэрэглэх зохимжгүй гэж мэдэгдсэн нь улам эдрээтэй болгосон байна.²⁰⁵ Энэ бүхнээс Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Олон улсын зохицуулах хорооны хийдэг магадлан итгэмжлэх тогтолцоог батлан авахыг хүсэхгүй байгаа хэдий ч ямар нэг байдлаар Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг өөрөө үнэлж, магадлан итгэмжлэх эсэх, хэрэв тэгж үнэлвэл хэрхэн яаж гэдгээ дээр тодорхойлоогүй гэж ойлгож байна.

Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын магадлан итгэмжлэлийн тухай ойлголт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын тогтолцоонд томоохон асуудал үүсгэж болзошгүй байлаа. Магадлан итгэмжлэх тогтолцоог ил тод, найдвартай байдлаар зохион байгуулахын тулд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь үнэлгээний ойлгомжтой, тодорхой

²⁰⁰ Art. 18 (4) OPCAT.

²⁰¹ For a detailed analysis on NHRIs as NPMs, see Steinerte, E. and Murray, R. 'Same but Different? National Human Rights Commissions and Ombudsman Offices and National Preventive Mechanisms Under the Optional Protocol to the UN Convention against Torture', *Essex Human Rights Review*, Vol. 6, No. 1, 2009, pp. 77–101.

²⁰² For a detailed discussion on the relationship between the ICC accreditation and NPMs, see the Policy Paper 'The Relationship Between Accreditation by the International Coordinating Committee of National Human Rights Institutions and the Optional Protocol to the UN Convention Against Torture', Bristol OPCAT Research Team, November 2008, available at: www.bristol.ac.uk/law/research/centres-themes/opcat/index.html.

²⁰³ Subcommittee on Prevention of Torture Sweden Visit Report, *op.cit.* note 46, at para. 35.

²⁰⁴ Subcommittee on Prevention of Torture, Third Annual Report, *op.cit.* note 17, at para. 82.

²⁰⁵ Emphasis added. *Ibidem*, at para. 61. Further challenge was the call from NHRIs themselves for their designation as NPMs. See: The Nairobi Declaration, adopted at the Ninth International Conference of National Institutions for the Promotion and Protection of Human Rights, Nairobi, Kenya, 21–24 October 2008, at para. 39, available at: www.ohchr.org/Documents/Countries/NairobiDeclarationEn.pdf.

Some State Parties have also sought to use the accreditation of an NHRI by the ICC as a reason why that institution should also be a designated NPM under OPCAT: Murray *et al*, *op.cit.* note 21, at p. 130.

шалгууруудыг боловсруулж, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг байнгын нийцлийг хангахын тулд тодорхой ээлжээр үнэлж чаддаг байх хэрэгтэй юм. Жилд гурван удаа нэг нэг долоо хоногийн хугацаатайгаар уулзаж чуулдаг, санхүүжилтийн байнгын асуудалтай гэрээний байгууллагын хувьд албан ёсны магадлан итгэмжлэх журмыг баримтлах болно гэдэг нь “Пандорагийн хайрцагийг” нээсэнтэй агаар нэг ойлголт байсан юм.

Эдгээр бэрхшээлийг ойлгож Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцэж ажиллаж байгаа эсэхийг үнэлэхгүй, тийм зорилго байхгүй гэж тодорхой илтгэсэн билээ.²⁰⁶ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцаанд орох бүртгээ, ялангуяа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн айлчлал хийж эхэлсэн учраас тухайн Урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын шаардлагад нийцэж байгаа үнэлэх нь хэрэгцээ гарах нь гарцаагүй. Албан ёсны магадлан итгэмжлэх үйл явцаас зайлсхийснээр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн хомс нөөцийг хэрхэн хамгийн зохистойгоор зарцуулах вэ гэдэг дээр туйлын прагматик шийдэл гаргаад байна. Тийнхүү Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо уг асуудлыг нэг тийш болгосн бөгөөд энэ нь байгаа нөөцийг

илүү зорилтот, бүтээлчээр зарцуулснаар прагматик бөгөөд илүү үр дүн авчрах илүү Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд чиглэсэн чиг шугамын дохио болж байна.

5. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хоорондох харилцааны хувьсан өөрчлөгдөх шинж: Тэнцвэрийг олох нь

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо-ноос Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай харилцан ажиллахаар төлөвлөж байгаа арга барилд мэдэгдэхүйц өөрчлөлт гарч байгаагаас Дэд хороонд өөрчлөлт шинэчлэлийн салхи үлээж эхэлсэн болохыг хэдийн таамагласан билээ. Харин одоо Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо юуг яаж өөрчлөх гээд байна вэ?

5.1. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ба Урьдчилан сэргийлэх үндэсний механизм: Айлчлалын үеэр

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын төслийг боловсруулж байх үеийг эргэн санах шаардлагатай чухал зүйлсийн нэг бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны зарцуулах санхүүжилт нь хангалтгүй байгаад тэр нь Дэд хорооны айлчлал шалгалтыг тодорхой давтамжтайгаар хийх чадавхид сөргөөр нөлөөлөх вий гэсэн болгоомжлол байлаа. Бодит байдалд энэ айдас бүрэн үндэслэлтэй байсан нь нотлогдов. Үйл ажиллагааныхаа эхний жилдээ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо гуравхан айлчлал шалгалт хийсэн байна. Дараагийн жилүүдэд ч энэ тоо хэмжээ өссөнгүй. Эхний таван жил ажиллахдаа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо

²⁰⁶ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 64. See also Subcommittee on Prevention of Torture, Guidelines on National Preventive Mechanisms, *supra* note 79, at para. 2.

нийтдээ 18 айлчлал хийж, нэг удаагийн айлчлалын мөрөөр хийх айлчлал хийсэн атал Нэмэлт протоколыг соёрхон батласан улсын тоо 63-т хүрвэ.²⁰⁷ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны 2012 оны айлчлалын төлөвлөгөөнөөс харвал Дэд хороо айлчлал хийх чадавхиа хоёр дахин нэмэгдүүлсэн нь сайшаалтай хэдий ч ийнхүү хоёр дахин нэмэгдлээ гээд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны анх тогтоосон таван жил тутам бүх гишүүн улсад айлчлал шалгалт хийх²⁰⁸ жишигт хүрэхэд хол байна. Үнэндээ одоогийн байдлаар гишүүн улс бүр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо арван жил тутамд нэг ирнэ гэж тооцож хүлээж болохоор бөгөөд энэ нь ч Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны даргын мэдэгдэлд тусчээ:

[...] урьдаас харж болох ирээдүйгээр бол Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын онцлог шинж болсон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд урьдчилан сэргийлэх айлчлал шалгалтын тэргүүн эгнээний үүрэг чухамхүү газар дээр нь ажиллах учраас тэдний хувь хамгийн тохирох үүрэг оногдохоор байна.²⁰⁹

Нэмэлт Протоколын төслийг боловсруулж байх үед Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудын саналын цаана байх анхаарал татсан зүйлсийн нэг нь энэ асуудлыг шийдвэрлэх явдал байв. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд ажиллаж байгаа нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлалын давтамжийг тэнцвэржүүлэх бөгөөд үүгээрээ зохистой, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн

эсрэг конвенцын нэмэлт протоколд нийцсэн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай байхын ач холбогдлыг нэмэгдүүлж байгаа юм. Таван жил ажилласны дараа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо эцэст нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хандах хандлагаа эргэн харж Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үндэсний түвшинд болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлал шалгалтын мөрөөр авах арга хэмжээнд гүйцэтгэх үүрэг ролийг хүлээн зөвшөөрч байна. Хэрэг дээрээ мандатаа үр дүнтэйгээр хэрэгжүүлж байгаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизм бүр Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатаа биелүүлэхэд туслалцаа үзүүлж чадах агаад үүгээрээ гэрээний байгууллагад Урьдчилан сэргийлэх үндэсний механизм нь сайн ажиллаж чадахгүй байгаа улс орнуудад анхаарлаа хандуулах боломж олгох юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бие биеэ гүйцээн нөхөх байдал нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд заасан урьдчилан сэргийлэх тогтолцооны суурь болсон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын бие даасан хараат бус байдалд эн тэргүүний ач холбогдолтойгоос гадна Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо бол түүнийг бэхжүүлэхийн тулд онцгойлон бий болсон билээ. Түүгээр ч зогсохгүй Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны айлчлалын мандат үүнийг гүйцэлдүүлэхэд алдаж болохгүй боломж юм. Гэрээний байгууллагаас аливаа улсад айлчлах нь эрх баригчдын анхаарлыг ихээхэн татдаг бөгөөд үүний жишээнд Мальдивт Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо айлчлахыг урьдаас таамагласаны улмаас Мальдивын

²⁰⁷ For the list of ratifications see: United Nations Treaty Collection, available at: treaties.un.org/Pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=IV-9-b&chapter=4&lang=en.

²⁰⁸ Subcommittee on Prevention of Torture, First Annual Report, *op.cit.* note 10, at para. 15.

²⁰⁹ Casale, S., 'A System of Preventive Oversight', *Essex Human Rights Review*, Vol. 6, No. 1, 2009, pp. 9–19, at p. 19.

тал Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд тодорхойлж өгсөн билээ.²¹⁰ Тийм байдлаар ямар нэг улсад айлчлал шалгалт хийх нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизм, болон түүнийг үүсгэн байгуулалт, үйл ажиллагаа зэрэг газар дээрх нөхцөл байдлыг анхаарлын төвд авчрах маш сайхан боломж байдгийн дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний байгууллагаас өгсөн зөвлөмжөөс үүдэн гарсан дэмжлэг, эрх мэдлийг олгодог юм. Дэд хороо эцэст 2012 онд зарласан шинэ төрлийн айлчлалын хэлбэр болох “Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хандсан” хэмээх айлчлалыг нэвтрүүлэхдээ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг чадавхижуулахыг зорьж байна. Ийм айлчлал Гондурас, Молдав, Сенегалын Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудын чадавхийг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй байна гэдэгт найдлага тавьж байна.

Гэсэн хэдий ч энд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мэдэж байвал зохих, гэрээний байгууллагаас анхаарах тухайлан шаардлагатай хоёр зүйл байна. “Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд хандсан” айлчлал нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороонд өгсөн айлчлалын мандатаа ашиглан Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулахтай холбоотой асуудлыг хөндсөн ганц зорилгоор гишүүн улсад албан ёсоор айлчилсан анхны тохиолдол болох юм. Өмнө нь жишээ авах ийм айлчлал болсон туршлага огт байхгүй бөгөөд Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээний өөр аль ч байгууллага, мөн бүс нутгийн ямар ч байгууллага Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны энэхүү “Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд

чиглэсэн” айлчлалд анхны жишиг болж чадахгүй юм. Тиймээс Дэд хорооны хувьд арга зүйгээ хандуулах анхаарал, хичээл чармайлт онцгой ач холбогдолтой болж байгаа хийгээд үүнд харгалзан үзэх хоёр үндсэн асуудал байна.

Нэгд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо тухайн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын асуудал дээр аудиторын үүрэгтэй оролцож байгаа гэсэн ойлголт төрүүлэхээс зайлсхийвэл зохино. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын хувьд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандат нь эрх чөлөөгөө хасуулсан хүмүүсийг хамгаалах хамгаалалтыг бэхжүүлэх шаардлага, хэрэгцээтэй арга хэрэгслийг үнэлэхэд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад зөвлөх, туслах, сургалт, техникийн туслалцаа үзүүлэхэд оршино.²¹¹ Тиймээс Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбоотой Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандат нь гишүүн улстай харилцах талаарх Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандаттай харьцуулбал эрс ялгаатай юм. Гишүүн улстай холбоотой энэ мандатын хүрээнд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь тухайн гишүүн улсад эрх чөлөөгөө хязгаарлуулсан хүмүүсийг хамгаалахтай холбоотой асуудлаар мөн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын чадавхи, мандатыг бэхжүүлэх талаар зөвлөмж өгдөг.²¹² Ийнхүү Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд шууд, мөн гишүүн улсад зөвлөмж өгөх эсэхээ шийдэж болдог бол Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын

²¹⁰ Subcommittee on Prevention of Torture, Maldives Visit Report, *op.cit.* note 45, at para. 65.

²¹¹ Art. 11(b) OPCAT.

²¹² Art. 11(a)(b) OPCAT.

агуулгад гэрээний байгууллага болон түүний үндэсний түвшний хамтрагчийн хооронд их өөр харилцаа холбооны утга туссан байна.

5.2. Айлчлалаас гадуур Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай ажиллах нь

Урьд нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллахад хойрго байсан байдал нь мөн түүний Женевт өөрсдөө ирж уулзахад бэлэн байсан Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай хандах харьцаанаас илт харагдаж байлаа. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хуралдаан камерын өмнө болдог²¹³ гэсэн заалтын цаана нуугдсан Дэд хороо хүсээд ирэхэд бэлэн Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад уулзах боломж олгохдоо хойрго байв.²¹⁴ Эхний жилүүдэд хоёрхон уулзалт болсон²¹⁵ бөгөөд уулзалт ямар агуулгатай болсон талаар олон нийтэд ямар ч мэдээлэл өгөөгүй юм. Мэдээж энэ нь ямар нэг хэмжээнд Женев рүү аялах боломжтой Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудад таалалтай хандаж байна гэсэн ойлголт төрүүлэхгүй гэсэн Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны болгоомжоор тайлбарлаж болох юм. Гэсэн ч энэ нь тухайн үедээ айлчлал шалгалтаас бусад хэлбэрээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцан ажиллах цорын ганц боломж байсан учраас тийм хэт болгоомжлол цагаа олоогүй зүйл байсан гэж дүгнэхэд бэрх биш.

Тав дахь ээлжит тайлан бол эхэн үеийн иймэрхүү дадлаас салж байгаагийн илрэл болсон юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо илүү олон Урьдчилан

сэргийлэх үндэсний механизмтай уулзалт хийсэн болохоо зарласан нь цаашид тиймэрхүү уулзалтыг дуртай хийх болно гэсэн үг ажээ.²¹⁶ Мэдээж Дэд хорооны дарга Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудыг Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хуралдаануудад орж суухыг урих болсон нь бие биенийхээ ажлыг илүү ойлгодог болоход чиглэж байгаа бөгөөд энэ нь харилцан ашигтай гэж үзэж байна.²¹⁷

Түүнээс гадна Тав дахь ээлжит тайлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай харилцан ажиллахад гаргаж байгаа олон тооны санаачлагуудыг нийтэд ил болгов. Тийнхүү Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд заасан хугацаанд²¹⁸ Урьдчилан сэргийлэх үндэсний механизм байгуулж чадаагүй байгаа гишүүн улсуудтай яриа хэлэлцүүлэг зохион байгуулж, Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудын ээлжит илтгэлүүдийг хүлээн авч,²¹⁹ мөн тэдэнтэй холбоо тогтоон, харилцаж байна.²²⁰ Эдгээр үйл ажиллагаа олны сайшаалыг хүлээгээд байгаа бөгөөд үүнээс үүдээд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо өөрийн ажлын зохион байгуулалтыг эргэн харах болсон агаад Дэд хороо дотоод бүтэц зохион байгуулалтдаа хийх шинэчлэлийнхээ талаар зарласан байна.

5.3. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дотоод бүтэцийн өөрчлөлт:

²¹⁶ Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para. 22.

²¹⁷ Statement by Mr Malcolm Evans, *loc.cit.* note 26.

²¹⁸ Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para. 21.

²¹⁹ *Ibidem*, at para. 22. These are also published on the SPT's website: Subcommittee on Prevention of Torture, 'Annual Reports Received by the SPT from National Preventive Mechanisms', available at: www2.ohchr.org/english/bodies/cat/opcat/annualreports.htm.

²²⁰ *Ibidem*.

²¹³ Art. 10(2)(c) OPCAT.

²¹⁴ Murray *et al.*, *op.cit.* note 21, at p. 129.

²¹⁵ The SPT met with the Mexican NPM during its third session (Subcommittee on Prevention of Torture, First Annual Report, *op.cit.* note 10, at para. 26) and with the Estonian NPM during its fifth session (Subcommittee on Prevention of Torture, Second Annual Report, *op.cit.* note 17, at para. 37 and Third Annual Report, *op.cit.* note 17, at para. 45).

Бүсийн төвүүд ба Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын багууд

2011 онд гишүүдийнхээ тоог 10-аас 25 хүртэл өсгөснийхөө давуу талыг бүрэн ашиглаж²²¹ Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо дотоод бүтэц зохион байгуулалтаа дахин өөрчлөхөө зарлав. Энэ өөрчлөлтийн хүрээнд Товчоогоо өргөтгөөд²²² зогссонгүй мөн бүс нутгуудад (Африк, Ази, Европ, Латин Америкт) төвүүд байгуулсан бөгөөд үүнийгээ (...) бүс нутаг бүртээ Дэд хорооны харилцааг зохион байгуулж, хамтын ажиллагааны зохицуулалтыг хийх зорилготой гэж тайлбарлажээ.²²³

Тийнхүү бүсийн төвүүд нь бүсийн төвүүдийн удирдлага бүхий Бүсийн даалгавар биелүүлэх албаны үүрэг гүйцэтгэх агаад ажлын арга барилдаа нийтлэг түгээмэл байдлыг хангах зорилгоор бүхий л бүс нутгийн бүлэг бүрээс татсан гишүүдээс бүрдэх ажээ.²²⁴ Тав дахь ээлжит тайланд дурдсанаар:

... Дотоод ажлын зориулалтаар Дэд хороо гишүүн улсуудыг Африк, Латин Америк, Ази-Номхон Далай, Европ гэсэн дөрвөн өргөн бүс нутагт хуваав. Энэхүү даалгавар биелүүлэх хүчин бүрийг бүс нутгийн төв удирдах агаад тодорхой улс орнуудыг хариуцан авсан гишүүдээс бүрдэх Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын баг дэмжлэг үзүүлнэ. Урьдчилан сэргийлэх

үндэсний механизмын Баг бүр тухайн бүсээс гарсан Дэд хорооны гишүүн болон өөр бусад бүсээс гарсан гишүүдийн нэгдлээс бүрдэнэ. Гишүүдийг Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын багт хуваарилахдаа жендэр, туршлага, мэргэшил, боломжтой бол нийтлэг ажлын хэлийг нь харгалзан үздэг. Цашилбал Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын баг бүрийн гишүүдийн тоо тухайн бүс нутаг дахь гишүүн улсын тоо болон Дэд хорооны гишүүнчлэл, хүртээмжийн бодит байдлын тусгал болдог. Дэд хороо энэ өөрчлөлтийн үр дүнд Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтрах ажил илүү бүтээлч, идэвхтэй болно хэмээн найдаж байна. Багууд Дэд хорооны хуралдаан бүр дээр тус тусдаа уулзалдаж өөрсдийн бүс дэх Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай холбоотой нөхцөл байдлын талаар дэлгэрэнгүй авч үзэж, нэгдсэн хуралдаанд тэндээс гарсан саналаа оруулдаг юм.²²⁵

Энэхүү шинэчилсэн дотоод зохион байгуулалтын зорилго нь бүхэлдээ Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай илүү утга учиртай, зохион байгуулалттай хамтран ажиллах²²⁶ боломжийг бий болгоход орших бөгөөд мэдээж үүний эхний бодит үр дүн хэдийн гарчээ. Жишээ нь саяхан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо Киргиз, Казахстан улсуудад Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын тухай хууль батлан гаргах үйл явцад нь дэмжлэг үзүүлсэн байна. Тиймээс Бүс нутгийн төвүүд болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын багууд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны аливаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллах ажлыг тодорхойлох болон Дэд хороог өөр бусад оролцогчдын зохион байгуулсан олон янзын үйл ажиллагаанд оролцох оролцоонд чухал үүрэг гүйцэтгэх юм. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо нь эцэст нь

²²¹ This happened after the third Meeting of States parties to OPCAT which took place on 28 October 2010 when, as required by Art. 5(1), the membership was extended to 25 members as the number of OPCAT State Parties had reached 50. See: SPT, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 10.

²²² *Ibidem*, at para. 11. The Bureau is now composed of 5 members: the Chair and 4 Vice-Chairs, each of whom exercises direct responsibility for a discrete area of operational activity as set out in the SPT's mandate. Thus there is a Vice-Chair for (a) visits, (b) work with NPMs, and (c) engagement with international and regional bodies, all complemented by a Vice-Chair-Rapporteur with responsibility for developing 'jurisprudence'. See Statement by Mr Malcolm Evans, *loc.cit.* note 26. Previously the Bureau consisted of three members (the Chairperson and two Vice-Chairs); Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 11.

²²³ Subcommittee on Prevention of Torture, Fourth Annual Report, *op.cit.* note 17, at para. 12.

²²⁴ Statement by Mr Malcolm Evans, *loc.cit.* note 26.

²²⁵ Subcommittee on Prevention of Torture, Fifth Annual Report, *op.cit.* note 20, at para. 40.

²²⁶ *Ibidem*.

санхүүжилт хангалтгүйгээс болж мандагаа хэрэгжүүлэхэд тулгарч байсан бэрхшээлийг даван туулах тал дээр санаачлагтай бүтээлч хандах болжээ.

6. Дүгнэлт

Олон улсын хүний эрхийн эрх зүйд анх удаа гэрээгээр урьдчилан сэргийлэх бүтцийг бий болгоод байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо олон улсын тавцанд ажиллаж, Урьдчилан сэргийлэх үндэсний механизм үндэсний хэмжээнд үүрэг гүйцэтгэсэн давхар хяналтын тогтолцоо байгуулснаараа Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол нь гишүүн улсууд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үүрэг хариуцлагынхаа хэрэгжилтийг бодитоор хангах арга замыг бий болгосон Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн анхны гэрээ билээ. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор бий болсон урьдчилан сэргийлэх хоёр арга хэрэгслээс үндэсний механизм нь биет, бодит өөрчлөлт гаргахад хамгийн их боломжтой гэдэг нь маргашгүй юм. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд нь газар дээр шалгах байгууллагын хувиар хүний эрх чөлөөг хязгаарласан газруудад тогтмол очиж шалгалт хийх чадамжтай. Тэд хууль тогтоох болон институцийн хэмжээнд харилцан ажиллах боломжтойн дээр орон нутгийн нийгмийн болон геополитикийн хүрээнд шаардлагатай мэдлэг, ойлголттой учир үндэсний урьдчилан сэргийлэх тогтолцоонд учир утгатай хувь нэмэр оруулж чаддаг. Тиймээс энэ нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны мандатын ихээхэн хэсэг нь гишүүн улс бүрийн Урьдчилан сэргийлэх үндэсний механизм

зохих шаардлагын дагуу ажиллах баталгааг хангахад чиглэдэг байна.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол нь нэгдэн орсон улс бүртээ мэдэгдэхүйц нөлөө үзүүлээд амжсан бөгөөд Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын шалгалтаар дамжуулж хүний эрх чөлөөг хязгаарласан газрууд нь олны нүдэнд хаалттай байдаг улс орнуудын тийм газруудад ил тод байдал нэмэгдэх боломж олгож ирсэн байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны үүрэг роль ийм байх ёстой боловч олон улсын механизмын хувьд зөвхөн ээлжит байдлаар гишүүн улстай харилцан ажиллах боломжтой ажээ. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос явуулж чадах энэ ээлжит ажиллагаа нь Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын үүрэг роль яагаад ийм дээд ач холбогдолтой байгаагийн тайлбар болох юм. Тэд бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны заяамал туншүүд бөгөөд зохистой ажиллаж байгаа л бол Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны хангаж чадахгүй байнгын хүчин чармайлтыг үндэсний түвшинд ханган ажиллаж чадна.

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны ажлын анхны таван жилийн хугацаа нь хангалтгүй санхүүжилтээс ихээхэн сааталтай байсан ба ийм нөхцөл байдалд Дэд Хороо Урьдчилан сэргийлэх үндэсний механизмуудтай хэрхэн хамтран ажиллах бүтээлч арга замыг бий болгох тал дээр хойрго хандсан юм. Энэ эргэлзсэн тээнэгэлсэн байдал Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколоор бий болох ёстой онолын төсөөлөл болон түүний практик хэрэгжилтийн хооронд эрс ялгаа

бий болоход хүргэсэн байна.²²⁷

Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо өөрөө энэ харамсалтай гажуудал үүссэнийг ухаарч байлаа. Дөрөв дэх ээлжит тайлан нь Дэд хороо өөрийн мандат тэр дундаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай харилцах байдлаа эргэн дүгнэж байгаагийн илрэл болов. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны дарга Малькольм Эвансийн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн хуралдаан дээр хийсэн “Бие даасан, бүрэн ажиллагаатай, хангалттай нөөц бололцоо бүхий Урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын шалгуурын дагуу байгуулах нь гишүүн улс эрүү шүүлт, зүй бус харьцаа гарахаас урьдчилан сэргийлэхэд хамгийн чухал зүйл мөн” гэсэн мэдэгдэл тухайн үедээ урагш чиглэсэн тун зоримог алхам байв.²²⁸

Тав дахь ээлжит тайлан болон тухайлан зарласан 2012 оны ажлын хөтөлбөр нь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны Урьдчилан сэргийлэх үндэсний механизмтай хамтран ажиллахдаа баримтлах хандлагадаа өөрчлөлт хийх эргэлтийн цэг болсон бөгөөд үүнээс удаан хүлээхээргүй байв. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын гишүүн 63 орон байгаагийн дөнгөж тал нь л бодит байдал дээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмаа байгуулсан байна. Түүгээр ч барахгүй тэдгээр Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын заримынх нь ажиллаж байгаа байдал хангалтгүй бөгөөд өнөө үед дэлхий даяар байгаа Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд санхүүжилт хангалтгүй, бие

даасан байдал бүрэн баталгаажаагүй, зохих сургалт дутмаг зэрэг асуудалтай тулгарсаар байна. Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо бол Урьдчилан сэргийлэх үндэсний механизмд эдгээр хүндрэл бэрхшээлийг даван туулахад нь туслалцаа үзүүлэх мандат, эрх, үүрэг бүхий байгууллага юм. Дэд хорооны анхны үүрэг роль үйл ажиллагаан дахь хэвшсэн шинжтэй сонирхол ба механизмын ажил үүргийн гүйцэтгэл²²⁹ байсан бол дараагийн алхам нь Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд туссан урьдчилан сэргийлэх тогтолцоо ажиллахын тулд зайлшгүй шаардлагатай Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо болон Урьдчилан сэргийлэх үндэсний механизмын хоорондын харилцаан дахь бие даасан байдлыг хүлээн зөвшөөрөх явдал юм. Урьдчилан сэргийлэх үндэсний механизмууд Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх тогтолцоон дахь Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хорооны үндэсний хэмжээний түнш больё гэвэл Дэд хорооны дэмжлэгийг авах хэрэгтэй. Ийм учраас Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо ба Урьдчилан сэргийлэх үндэсний механизм бүрийн хоорондын харилцаанд хэв маягийн сонирхол ба бүрэн боловсорсон түншлэлийн хоорондох тэнцвэрийг олох шаардлагатай юм. Мөн таван жилийн дараа Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх дэд хороо одоо л нэг чухам түүнд чиглэсэн зам дээрээ гараад байна.

Орчуулсан: Хүний эрхийн Үндэсний Комиссын референт Ө. Ундрах

²²⁷ Egan, S. 'The Optional Protocol to the Convention Against Torture: Paying the Price for Prevention', *Irish Jurist*, December 2009, pp. 182–202, at p. 182.

²²⁸ Statement by Mr Malcolm Evans, *loc. cit.* note 26.

²²⁹ Evans, M. and Haenni-Dale, C., *loc. cit.* note 25, at p. 52.

Зочны яриа

Л.ЭРДЭНЭЧУЛУУН: ХҮНИЙ НАЙМААНЫ ЗОЛИОС БОЛСОН ХОХИРОГЧДОД ХАНДАХ ХАНДЛАГЫГ ӨӨРЧЛӨХ ЦАГ НЬ БОЛСОН



“Хүний эрх” сэтгүүл нь хүний эрхийн салбарт цөхрөлтгүйгээр тууштай, амжилттай ажиллан хийсэн бүтээснээ төдийлэн дөвийлгөж, сурталчлаад байдаггүй, ажлаа амжуулан чимээгүйхэн яваа эрхэм хүмүүсийг урьж оролцуулдаг билээ. Энэ удаагийн зочноороо Хүний аюулгүй байдлын судалгааны төвийн захирал, Элчин сайд Лувсангийн Эрдэнэчулууныг урьж, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох асуудлыг хөндөн ярилцлаа.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг Улсын Их Хурлаар батлуулчихлаа. Багагүй хугацаа өнгөрч байна. Эрх зүйн орчинг бүрдүүлэх нь чамлахааргүй том амжилт. Энэ нь танай төслийн үндсэн ажил байсан уу?

Бид 2008 оноос Швейцарийн Хөгжлийн агентлагтай гэрээ байгуулаад ажилласан. Ерөөсөө цогц төсөл хийе, асуудалд цогцоор хандъя гэсэн саналыг тэдэнд тавьсан, швейцариуд дэмжсэн. 4 чиглэлээр ажиллахаар болсон. Эхнийх нь мэдээж, хууль эрх зүйн орчинг сайжруулах. Бүр том асуудал. Хоёрдугаарт, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, ойлголттой болгох. Гурав дахь нь хохирогчдод дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамгаалах. Дөрөвдүгээрт, хууль эрх зүйн байгууллагын чадавхийг дээшлүүлэх. Ийм том төсөл.

Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохын тулд бие даасан хууль батлуулах ёстой гэсэн байр суурьтай байлаа. Анхнаасаа л тийм байр суурьтай байсан. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай олон

улсын баримт бичиг болох Палермогийн протоколд манай улс нэгдэж орох ёстой байлаа. Нэгдээд орсон. Бас энэ ажлыг зохион байгуулах хэрэгтэй байсан. Хоёрдугаарт, бие даасан хууль боловсруулахын тулд бүх үндэслэлийг гаргах, судалгаа хийх хэрэгтэй. Манайх 10 гаруй судалгаа хийсэн.

Гуравдугаарт, энэ нь зөвхөн дотоодынх биш, гадаад улстай холбогддог асуудал. Өөрөөр хэлбэл, хүн худалдаалах гэмт хэрэг хоёр чиглэлээр явагддаг. Аймаг, орон нутгаас хот руу орж ирэх, охидыг худалдаалах явдал гарч ирж байна. Зөвхөн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгтэй холбоотой ч биш, хөдөлмөрийн мөлжлөг, хүний эд эрхтэнг наймаалах асуудал байгаа.

Хуулийг батлуулах үндэслэл нь чухам юу байв. Нууцлагдмал, улс үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй холбоотой судалгаа явуулахад амаргүй байсан нь мэдээж. Шантарч байв уу?

Бид ажлаа үр дүнгээр тодорхойлдог. Тодорхой үр дүнд хүрсэн байх л чухал. Хууль бол нэг үр дүн. Гэхдээ зөвхөн манай байгууллага дангаар хийсэн ажил ч биш. Олон байгууллагын хамтын ажиллагаа, хөдөлмөрийн үр дүн. Хууль батлуулах хэд хэдэн үндэслэл байсан. Товчхондоо, нэгдүгээрт, Монгол Улсад хүний наймааны хэрэг албан ёсоор 2000 онд анх бүртгэгдсэнээс хойш хэргийн тоо жил бүр нэмэгдэж байгааг хууль сахиулах болон энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын судалгаа, тоо баримтаас харагдаж байсан. Манай судалгаанууд ч үүнийг давхар баталсан. Тухайн үед Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнээр ажиллаж байсан Ж.Дашдорж болон танай Ажлын албатай хамтран Монгол Улсад үйлчилж байгаа хүний наймаатай холбоотой 30 гаруй хууль, тогтоомжид судалгаа

хийж, хүн худалдаалах асуудлыг цогцоор шийдэхийн тулд тусгайлан хууль байх нь зайлшгүй бөгөөд зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээтэйг нотлон гаргасан.

Хоёрдугаарт, хүний наймааны хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэх эрх зүйн орчин байгаагүй. Нийгэмд хохирогчийг биеэ үнэлэгч хэмээн үзэж гадуурхах хандлага амь бөхтэй оршсоор байна. Ялангуяа манай хууль сахиулах байгууллагын ажилтнууд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хандах хандлагаа өөрчлөх цаг болсон.

Гуравдугаарт, хүн худалдаалах асуудлыг цогц байдлаар төрөөс төдийлөн анхаарахгүй явж ирсэн. 2008 оноос эхлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд Хүн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд орон тооны бус Үндэсний зөвлөл ажиллаж байсан ч энэ нь хязгаарлагдмал, тухайлбал зөвхөн бэлгийн мөлжлөгтэй холбоотой асуудлыг л хөнддөг байсан.

Гэтэл хүний наймаа нь хөдөлмөрийн мөлжлөг, цус, эд эрхтнийг авах, хүүхэд үрчлэх, хуурамчаар гэрлүүлэх, хүчээр гуйлга гуйлгах, хулгай хийлгэх зэрэг олон хэлбэртэй.

Өөрөөр хэлбэл, хүний наймааг зөвхөн гэмт хэрэгтэнг шийтгэх байдлаар Эрүүгийн хуулиар зохицуулах нь хангалттай бус, цогц байдлаар харж, олон нийтийг энэ хэргээс урьдчилан сэргийлэх, хохирсон иргэдийг хамгаалах, тусалцаа үзүүлэх, гадаад, дотоодын хамтын ажиллагааг хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Таны ярианы өнгөнөөс анзаарахад энэ асуудлууд одоо ч байгаа гэж ойлгогдохоор юм?

Хууль баталсан нь нэг том алхам, дэвшил. Хууль батлаад зогсохгүй, 8 хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байгаа. Өөрөөр хэлбэл, бид их том ажил хийсэн юм шүү. Их том, сайн эхлэлийг тавилаа. Одоо энэ сайн эхлэлийг засаг нь аваад явах ёстой. Мэдээж, төрийн бус байгууллагууд хамтран ажиллахад бэлэн байгаа.

Хуулийг боловсруулж, батлуулах үеийн туршлага, сургамж юу байв?

Юуны өмнө энэ хуулийг боловсруулж батлуулахад олон хүний хүч, хөдөлмөр орсон гэдгийг зориуд дахин тэмдэглэхийг хүсч байна. Дөрвөн жилийн хугацаанд давхардсан тоогоор 900 гаруй хүний оролцоотой 9 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл, олон хуульч, судлаачид оролцсон. 2008 онд тухайн үеийн УИХ, Засгийн газрын зарим гишүүдэд энэ хуулийн талаар танилцуулахад ийм хууль хэрэгтэй битгий хэл, “Ийм хэрэг Монголд байдаг юм уу” гэж асууж байсан тохиолдлууд бий. Тиймээс хуулийн талаар хэлэлцүүлэг, судалгаа хийхээс гадна хууль батлах субъектүүдтэй хамтран ажиллах, тэдэнд ойлгуулах, нөлөөлөх ажил чухал байсан. Энэ бол томоохон үргэлжилсэн ажил болсон.

Үүнийг нотлох нэг жишээ дурдахад, хуулийн төслийг УИХ-ын Байнгын хороогоор хэлэлцэх үед ч бид 2-3 заалтыг дэлгэрэнгүй болгон нэмж байлаа. Тухайлбал, “Хүний эрх хөгжил төв” Төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байсан АНУ-ын Өмгөөлөгчдийн холбооны хуульч, өмгөөлөгч ноён Крамер хохирогч болон хэвлэл мэдээллийн талаарх зүйл ангитай холбоотой санал ирүүлснийг дэмжиж, ажлын хэсгийнхэнд тодорхой баримт, судалгааг ойлгуулан танилцуулж богино хугацаанд тэдгээр заалтыг оруулж байсан. Хууль

боловсруулж батлуулах ажил хариуцлага өндөртэй байхыг шаарддаг, зүйл заалт бүрийн үг, үсэг, ойлголтыг байнга нягтлан харж, олон талаас нь дүн шинжилгээ хийх шаардлага тулгарч байлаа.

Нөгөөтэйгүүр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газраас гаргасан Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай загвар хууль энэ хуулийн төслийг боловсруулахад их дөхөм болсон.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн гол агуулга, ач холбогдлыг товчлон тайлбарлавал?

4 бүлэг, 18 зүйл, 100 гаруй заалттай Хүн худалдаалахтай тэмцэх тухай Монгол Улсын хууль нь хүний наймаанаас урьдчилан сэргийлэх, энэ төрлийн хэргийг таслан зогсоох, шалтгаан, нөхцөлийг тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалах, төрийн байгууллагуудын эрх үүргийг зохицуулж өгсөн цогц хууль юм.

Тухайлбал, хуулиар “хүний найма гэж юу вэ” гэдэг тодорхойлолтыг анх удаа олон улсын конвенцийн дагуу гаргасан. Тодруулбал, өмнө нь хүний наймааг “ашиг олох болон мөлжих” зорилгоор үйлдэгддэг гэж байсан бол шинэ хуулиар “ашиг олох” гэдгийг хасч, зөвхөн “мөлжих” буюу биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эд эрхтнийг нь авах гэсэн конвенцийн заалтыг тусгасан. Судалгаанаас үзэхэд, хүний наймааны нэлээд хэргүүд хуучин заалтаас болж хэрэгсэхгүй болох, өөр хөнгөн зүйл ангиар шийтгэгдэх боломжтой байсан. Жишээлбэл, хүний биеийг хүчээр болон хууран мэхлэх аргаар үнэлүүлж, тодорхой газар аваачсан ч хэрэг үйлдэгч хүн хэр хэмжээний ашиг мөнгө

олсон нь батлагдахгүй бол хүний наймааны хэрэг биш гэж шийддэг байсан тохиолдлууд бий.

Хуулийн нэг гол ач холбогдол нь Хууль зүйн яаманд Хүн худалдаалах асуудлыг зохицуулан ажиллах Дэд зөвлөл байгуулагдан ажиллаж байгаагаас гадна төрийн байгууллага, хэвлэл мэдээллийнхэнд тодорхой эрх үүргийг хуулиар тогтоож өгсөн.

Тухайлбал, Хил хамгаалах ерөнхий газарт хилээр гарч байгаа хүүхдэд хяналт тавих, гадаадад яваад эргэж ирээгүй бол шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллагаар шалгуулах бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл хохирогчийн бичгээр гаргаж өгсөн зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаар мэдээлэл гаргахыг хориглосон байгаа. Түүнчлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүний наймаа үйлдэгдэхэд хүргэхүйц ил болон далд бүх төрлийн зарыг гаргасан тохиолдолд 5 сая төгрөгөөр торгох зэрэг заалтууд орсон нь хариуцлагын тогтолцоог ч мөн чангатгаж өгсөн.

Мөн, энэ хуулийн 100 гаруй заалтын 40 гаруй нь хохирогч болон хохирогчийг хамгаалахтай холбоотой юм.

Хууль батлагдаад багагүй хугацаа өнгөрчээ. Хэрэгжилтийн явц ямархуу байгаа бол?

Сайхан хууль батлаад тэр нь хэрэгждэггүй бол ямар хэрэг байх билээ. Хуулийг хэрэгжүүлэх талаар төрөөс бодитой, үр дүн нь харагдахуйц ажил хийж буй эсэх талаар мэдээлэл надад алга. Учир нь манай байгууллага Хууль зүйн яаман дахь Дэд зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан хэдий ч өнгөрсөн жил гишүүнчлэлээс хассан байна лээ. Тиймээс мэдээллээс хол байна. Гэхдээ бид зүгээр суугаагүй. Манай байгууллагаас хуулийг хэрэгжүүлэх 3-5 жилийн цогц төлөвлөгөөг гарган санхүүгийн тооцооны

хамт Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Нэг жил өнгөрчихлөө. Ямар нэг хариу мэдээлэл алга.

Мөн хүний наймааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 6 төрийн бус байгууллагатай хамтран Хууль зүйн сайдад албан бичиг явуулсан. Хуультай холбоотой журам гаргах, хуулийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран хийхээр төлөвлөсөн ажил бий.

Хүн худалдаалахтай тэмцэх ажил нь бас хил дамнасан асуудал. Өөр улсын нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн хэргийг мөрдөж, шалгахад хүндрэл бэрхшээл гарна. Үүнийг ямар зохицуулалтаар шийдвэрлэж байгаа вэ?

Олон улсын гэрээ байгуулах хэрэгтэй. Гадаад харилцааны сайдад энэ талаар санал өгч байсан. Манай байгууллагын санаачлагаар Макао-тай Засгийн газар хоорондын гэрээ байгуулсан. Одоо ялангуяа хоёр хөрштэйгээ ийм гэрээ байгуулах хэрэгтэй. Цаашлаад манай охид залуучуудыг худалдаалж байгаа газар, улс орнуудыг бид олж авах хэрэгтэй. Жишээ нь, Гонконг, Малайз, Япон, Өмнөд Солонгос, Израил, Европын зарим улс орон байгаа. Казахстан бас Туркэд хөдөлмөрийн мөлжлөг байна. Монголчууд олноор очиж амьдарч байгаа, эрсдэлтэй газруудаар явж судалж, гэрээ байгуулах саналуудыг бид тавиад явж байна. Засгийн газар дорвитой ажиллахгүй байна. Гэхдээ нааштай зүйлүүд байна. Жишээлбэл, Эрээн, Замын-Үүд боомт дахь цагдаагийн газрууд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурсан байгаа. Бичгийг бид боловсруулалцсан. Харилцан мэдээллээ солилцдог, БНХАУ-ын Эрээн хотод 24 цагийн үйлчилгээтэй мэдээллийн цэг монгол хэлээр ажиллаж байна. Хэрвээ хүний наймааны хохирогч болсон байх магадлалтай бол утсаар яриад л тусламж

дэмжлэг авах боломжтой болсон.

Хууль зүйн туслалцаа авах улс хоорондын гэрээнд хүн худалдаалахтай тэмцэх асуудлыг тусгаж өгөөд явбал хоорондоо мэдээлэл солилцох, хохирогчийг эх оронд нь авчрах, нийгэмшүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг бууруулах олон талын ач холбогдолтой юм.

Хүний наймааны хохирогчдыг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулж байна вэ?

Хохирогч болсон хүмүүсийг эх оронд нь эгүүлэн авчрах, сэтгэл санаа, эд материалын туслалцаа үзүүлэх, нийгэмшүүлэх нь төрийн ч, төрийн бус байгууллагын ч хийх ажил. Бид “Хүйсийн тэгш эрхийн төв” Төрийн бус байгууллагагай гэрээ байгуулаад 4 өрөө байр худалдаж авч өгсөн. Улаанбаатар, Замын Үүдэд хохирогчдыг хамгаалах байртай болгосон. Бид дэмжлэг туслалцаа үзүүлсэн.

Одоо ажиллаж байгаа юу?

Байгаа, байгаа. Тэнд хохирогч хүмүүст хууль зүйн зөвлөгөө өгч байна, ажлын дөртэй болгож, ажлын байртай болгоход анхаарал хандуулж байна. Яг ийм төрлийн 20 хохирогчид, айл өрхөд 2 сая төгрөгийн тэтгэмж олгоод хувийн бизнес хийхэд нь тусалсан. Одоо тэдний 80 хувь нь үйл ажиллагаагаа явуулж байгаа. Энэ ажлыг “Хүйсийн тэгш эрхийн төв” хийгээд явж байгаа. Бид хянаад, зөвлөөд, хамтарч ажиллаж байсан.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр манай хууль хяналтын байгууллагууд хэр чадавхжсан бэ. Танай ажлын нэг зорилт байсан гэж Та ярилцлагын эхэнд дурдсан?

Хууль сахиулах байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх нь манай 4 дэх чиглэл байсан. Анхнаасаа цагдаагийн

байгууллагад нэгж байгуулах саналыг бид тавьсан. Өөрсдөө ч тийм бодолтой явж байсан юм байна лээ. Хэрэгжүүлж амжихгүй явсныг нь бид дэмжээд Улсын Мөрдөн Байцаах газарт тусгай тасаг байгуулахад нь тусалсан. Хүн худалдаалахтай тэмцэхээс гадна зохион байгуулалттай гэмт хэргийг хариуцдаг болсон байна лээ. Та нар бод доо, Улаанбаатарын 9 дүүрэг, орон нутагт 3 аймагт ийм нэгжтэй болсон байгаа. Энэ бол тодорхой үр дүн.

Ширээ сандал, тоног төхөөрөмж худалдан авах зэрэгт 40 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулсан. Дахиад ч сургалт хийнэ гэж бодож байгаа. Удахгүй шинэ төсөл хэрэгжүүлнэ. Европын холбоотой саявтар гэрээ байгуулаад байна. Том биш, жижгэвтэр төсөл юм. Энэ төслийн хүрээнд төрийн бус байгууллагуудын сүлжээг байгуулна, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудад сургалт явуулна, нарийн мэргэшлийн багшийг гадаадаас ирүүлнэ. Манай цагдаа, тагнуулын байгууллагуудад тусгай багш нараар хичээл заалгуулна. Мэргэжлийн гарын авлага гаргахыг үгүйсгэхгүй.

Таны бодлоор хүний наймаатай тэмцэх чиглэлээр цаашид ямар ажил хийх шаардлагатай вэ?

Хүний наймааны асуудлаар төрийн бус байгууллагууд нэлээд зүйл хийж, тодорхой үр дүнд хүрч, тэр хэрээрээ туршлагажиж байна. Өнөөдөр хүн худалдаалахтай тэмцэхэд эрх зүйн орчин бүрдлээ, тодорхой ахиц дэвшил байна. Гэвч үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд бид ч мөн зохион байгуулалттай, нэгдмэл нэг зорилгын төлөө хамтарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал, төрийн байгууллагаас төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах, тэднийг чадавхжуулах,

санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Эргээд төр засгийн зүгээс гэрээлсэн ажлыг бодит үр дүнгээр тооцож, хийсэн ажилд нь хяналтаа тавих хэрэгтэй. АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг хүний наймааны тайлан илтгэлд улс орнуудын Засгийн газар хүн худалдаалахтай тэмцэхэд хэрхэн үр дүнтэй ажиллаж байгаагаас шалтгаалан 3 зэрэглэлд оруулдаг. Энэ зэрэглэлд манай хөрш хоёр орон БНХАУ, ОХУ энэ жил Tier 3 буюу хамгийн муу гэсэн үнэлгээг авчээ. Иймээс олон монгол хүн, тэр

дундаа охид, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн хүүхдүүд хил дамнасан хүний наймааны хохирогч болох магадлал өндөр байгаа учраас бид урьдчилан сэргийлэх ажилд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

*Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа.
Амжилт хусье.*

Ярилцсан: Хүний эрхийн Үндэсний
Комиссын референт З.Бадмаараг

UIN.MN
СУДАЛГААНЫ САН



UIH.MN
СУДАЛГААНЫ САН